FRC

lendmn

Үнэт цаасны танилцуулга

2023 он

# Лэнд Бонд



Үндсэн Андеррайтер

RHINOS Investment

Туслах Андеррайтер

ULZII & Co CAPITAL

TENGER CAPITAL
Underwriting • Brokerage • Advisory

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР
ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ
ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД
ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ....13
1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА ....13
1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ, ХАЯГ ....14
1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ....15
1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ....18
1.1.4 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД ....19
1.1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА ....21
1.1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗӨВЛӨХ ....22
1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ ....23
1.2.1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ ....23
1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ ....23
1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ ....31
1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ ....38
1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАЙГУУЛСАН ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ ....49
1.5.1 ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ....50
1.6 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО ....52
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ ....56
2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ....56
2.1.1 БОДИТ СЕКТОР ....56
2.1.2 ГАДААД СЕКТОР ....58
2.1.3 ТӨСВИЙН СЕКТОР ....59
2.1.4 ИНФЛЯЦ ....60
2.1.5 ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ ....61
2.1.6 ВАЛЮТЫН ХАНШ ....61
2.1.7 ББСБ-ЫН ЗАХ ЗЭЭЛ ....62
2.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ ....65
2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА ....67
2.3.1 ДОТООД ОРЧНЫ ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА ....67
2.4 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТААМАГЛАЛ ....74

СЭХ
2023.08.11
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

2.5 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА....78
3. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ....93
3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....93
3.2ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БАРЬЦАА....94
3.3 ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ....97
3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН АНДДЕРРАЙТЕРИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН БОНДЫН ГЭРЭЭ....100
3.5 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ....101
3.6 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ....104
3.7 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ....104
4. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД....107
4.1 ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ....107
4.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ....113
4.3 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ....115
4.4 АУДИТЫН КОМПАНИЙН ТУХАЙ....117
4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТУХАЙ....121
5. ХАВСРАЛТУУД....124
5.1 АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ /2022 оны жилийн эцсийн байдлаар/....125
5.2 АУДИТЫН ДҮГНЭЛТ /2023 оны I улирлын байдлаар/....161
5.3 ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ....174
5.4 БУСАД....229

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257200

СЭХ
2023.08.11
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## ГРАФИК

График 1: ЛэндМН ББСБ ХК хувьцааны ханш 2023 ....32
График 2: Бүртгэлтэй харилцагчдын тоо ....39
График 3: 2022 оны үйл ажиллагааны үзүүлэлт ....42
График 4: 2023 оны I-р улирлын үйл ажиллагааны үзүүлэлт....48
График 5: МУ-ын ДНБ болон эдийн засгийн өсөлт /2010-2022/ ....56
График 6: Эдийн засгийн төсөөлөл 2023 он/....57
График 7: Экспорт, Импорт болон төлбөрийн тэнцэл....58
График 8: Экспортын гол нэр төрлийн бараа /тэрбум $ 2018 – 2023.I улирал/ ....59
График 9:Инфляцийн түвшин 2018-2023.I ....60
График 10: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /их наяд ₮/ болон ДНБ-д эзлэх хувь....61
График 11: Төгрөгтэй харьцах ам долларын ханш болон ГВАН-ын харьцуулалт /2010-2023.I/ ....62
График 12: Банк болон ББСБ-уудын зээлийн өсөлт....63
График 13: Банк болон ББСБ-уудын активын өсөлт....64
График 14: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /их наяд ₮/ болон ДНБ-д эзлэх хувь....65
График 15: Арилжааны дүн /2017-2022/....65
График 16: Актив болон нийт зээлийн  өсөлтийн хувь ....68
График 17: Финтекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь /2023.I/ ....69
График 18: Зээлийн харилцагчдын тоо....75
График 19: Нийт хөрөнгө ба нийт зээлийн хэмжээ ....76
График 20: Хөрөнгийн бүтэц ....77
График 21: Цэвэр ашиг....78
График 22: : Банкнуудын иргэдийн 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн хүү ....101
График 23: Хүүгийн харьцуулалт ....102
График 24: Нээлттэй үнэт цаасны өгөөжийн түвшингийн харьцуулалт....103

## ХҮСНЭГТ

Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн нээлттэй бондын жагсаалт....36
Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн халаасны хувьцаа....37
Хүснэгт 3: Сүүлийн 3 жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хураангуй ....47
Хүснэгт 4: 2023 оны I улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн хураангуй .... 49
Хүснэгт 5: Компанийн их хэмжээний хэлцэлийн хэмжээ....52
Хүснэгт 6: Хуваарилсан ногдол ашиг ....54
Хүснэгт 7: Эдийн засгийн өсөлт 2017-2021 /Салбарын бүтцээр/....57
Хүснэгт 8: Эдийн засгийн үзүүлэлт 2018-2022 /Салбарын бүтцээр/ ....67
Хүснэгт 9: Санхүүгийн тайлангийн төсөөлөл 2023-2025 оны (мянган төгрөг) ....76
Хүснэгт 10: Орлогын хураангуй тайлангын төсөөлөл (мянган төгрөг) ....77
Хүснэгт 11: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт .... 80
Хүснэгт 12: Эрсдэлийн удирдлагын хамгаалалтын бүс....81
Хүснэгт 13: Эрсдэлийн ангилал ....85
Хүснэгт 14: Эрсдэлийн удирдлага....85
Хүснэгт 15: Эрсдэлийн удирдлагын зарчим ....87
Хүснэгт 16: Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөл ....93
Хүснэгт 17: АНД Системс ХХК аудитлагдсан тайлан 2021-2022....97

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ф.1118267206

СЗХ
2023 оны долоо сар 1 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## ЗУРАГ

Зураг 1: Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал ..... 16
Зураг 2: Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт ..... 18
Зураг 3: АНД Глобал группийн түүхэн замнал ..... 27
Зураг 4: Lendpay зээлийн бүтээгдэхүүн ..... 39
Зураг 5: Lend-MSM зээлийн бүтээгдэхүүн ..... 40
Зураг 6: Эко автомашины зээл ..... 40
Зураг 7: Lend Flexi бүтээгдэхүүн ..... 40
Зураг 8: Мэдээллийн аюулгүй байдлын сертификат ..... 43
Зураг 9: Цахим хувьцаа эзэмшигчдийн хурал 2022 ..... 44
Зураг 10: Лэнд Бонд Транч II ..... 44
Зураг 11: Ногдол ашиг хуваарилав. ..... 45
Зураг 12:Эдийн засгийн төсөөлөл /2023 он ..... 58
Зураг 16: Ковид 19-ийн үеийн ОУ-ын зээлийн өсөлт ..... 71
Зураг 17: Финтект хэрэглэгчдийн датаг ашиглаж буй аргууд ..... 72
Зураг 18: АНУ-ын BNPL үйлчилгээний зах зээлийн хэмжээ ..... 73
Зураг 19: ААНБ-ын ажиллагчдын цалингийн судалгаа ..... 74
Зураг 20: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо ..... 80

## СХЕМ

Схем 1: Дотоод аудитын тогтолцоо ..... 20
Схем 2: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц ..... 23
Схем 3: Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон зэргэлдээ компанийн бүтэц ..... 24
Схем 4: Эрсдэлийн удирдлагын процесс ..... 87

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

"ЛэндМН ББСБ" ХК /цаашид "Үнэт цаас гаргагч", "Компани" гэх/ нь Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржийн холбогдох журмын дагуу 4 дэх удаагаа өрийн хэрэгслийг олон нийтэд нээлттэй санал болгохоор энэхүү танилцуулгыг бэлтгэсэн болно.

**ЭНЭХҮҮ ТАНИЛЦУУЛГАД ТУСГАСАН ЛЭНД БОНДЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БОЛОН САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСАНД ГАРГАСАН АЛИВАА БАТАЛГАА БИШ БӨГӨӨД ТҮҮНИЙ АГУУЛСАН АЛИВАА МЭДЭЭЛЛИЙН ҮНЭН ЗӨВ, БҮРЭН БҮТЭН БАЙДЛЫГ БИРЖ БОЛОН ХОРОО ХАРИУЦАХГҮЙ!**

**ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, БОНДЫН ТАНИЛЦУУЛГА, БОНД ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА.**

Тус үнэт цаасны танилцуулгад хөрөнгө оруулагч таны хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад шаардлагатай үнэт цаас гаргагчийн мэдээлэл, зах зээлийн таамаглал зэрэг бүхий л мэдээллийг агуулахыг зорьсон болно.

Хөрөнгө оруулагч таны шийдвэр гаргалтад танилцуулгад тусгагдсан мэдээллээс илүү дэлгэрэнгүй нэмэлт мэдээлэл шаардлагатай болох буюу лавлах тодруулах зүйл гарвал Үнэт цаас гаргагч "ЛэндМН ББСБ" ХК болон Андеррайтер "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК-д хандаж тодруулга авна уу.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ҮД.1118237206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК

## НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | Өрийн хэрэгслийг олон нийтэд худалдахаар санал болгож буй компани |
| Финтек | Санхүүгийн үйлчилгээг технологитой хамтатгасан бизнесийн төрөл |
| Бичил зээл | Бага хэмжээтэй хэрэглээний зээл |
| Аппликейшн | Гар утсанд суулгаж ашигладаг программ |
| Андеррайтер | Үнэт цаас гаргагчийн хувьцааг олон нийтэд санал болгох үйл ажиллагааг зохион байгуулагч компани |
| ЛэндМН аппликейшн | Гар утсанд суулгаж, зээлийн үйлчилгээ авахад ашигладаг программ |
| Их хэмжээний хэлцэл | Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасныг |
| Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасныг |
| Мерчант | Худалдааны төлөөлөгч |
| Анхдагч зах зээл | Анх удаа олон нийтэд үнэт цаас худалдаж байгаа арилжаа |
| Арилжаа | Үнэт цаас худалдах, худалдан авах ажиллагаа |
| Хиймэл оюун ухаан | Өөрийгөө хөгжүүлж байдаг төгс программ |
| Лиценз | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх |
| Анд Глобал Групп | Анд Глобал Пти.Лтд компанийн хараат болон охин компаниудыг хамтад нь |

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

| | |
|---|---|
| ББСБ | Банк бус санхүүгийн байгууллага |
| ХК | Хувьцаат компани |
| ХЭХ | Хувьцаа эзэмшигчдийн хурал |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| СЗХ | Санхүүгийн зохицуулах хороо |
| МХБ | Монголын хөрөнгийн бирж |
| ХАОАТ | Хүн амын орлогын албан татвар |
| ДНБ | Дотоодын нийт бүтээгдэхүүн |
| IT | Information Technology (Мэдээллийн технологи) |
| ҮСХ | Үндэсний статистикийн хороо |
| МБ | Монгол банк |
| ГВАН | Гадаад валютын албан нөөц |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| ГШХО | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |
| КтХ | Компанийн тухай хууль |
| IPO | Initial Public Offering (Олон нийтэд үнэт цаас анх удаа санал болгох) товчилсон үг |
| ЗГҮЦ | Засгийн газрын үнэт цаас |
| ХОС | Хөрөнгө оруулалтын сан |
| ХБҮЦ | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас |
| ААНБ | Аж ахуй нэгж, байгууллага |
| CAGR | Жилийн дундаж өсөлт |
| FPO | Follow-on Public Offer (Нэмэлтээр хувьцаа гаргаж хөрөнгийн биржээр дамжуулан санхүүжилт татах) |

2023.08.11
СЗХ
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 11

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



# ҮНЭТ ЦААС ГАРГАХ ТУХАЙ ТОГТООЛ

## "ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр № 23/20 Улаанбаатар хот

**Үнэт цаас нийтэд санал болгон гаргах, түүний нөхцөлийг тогтоох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам", "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" )-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ")-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/11 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөө", Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн эчнээ хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 95,000 (ерэн таван мянга) хүртэлх ширхэг, нийт 9,500,000,000 (есөн тэрбум таван зуун сая) хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий Компанийн өрийн хэрэгсэл (цаашид "Лэнд Бонд")-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар гаргасугай.
2. Нийтэд санал болгох Лэнд Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үнэт цаасны болон бусад нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Компанийн Лэнд Бондын эргэн төлөлтөд Компанийн толгой компани болох "АНД Системс" ХХК нь өөрийн эзэмшиж буй, 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцоход 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцааг барьцаалж, баталгаа гаргаж буйг дурдсугай.
4. Лэнд Бондын үндсэн андеррайтераар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийг, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийг, аудитораар "Нийслэл Аудит" ХХК-ийг тус тус сонгож, холбогдох гэрээг байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
5. Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Компанийн ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын 23/17 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
7. Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийн үйл явц, үр дүн болон хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА О.БОЛДБААТАР

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257205

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTSK LLC

СЗХ
2023.08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023-07-28
БҮРТГЭВ-02

**"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 07 дугаар сарын 24-ний өдөр № 23/22 Улаанбаатар хот

**Нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасны нөхцөлийг баталгаажуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам", "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" )-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ")-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/11 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөө", Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. **Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 90,000 (ерэн мянга) ширхэг, нийт 9,000,000,000.00 (есөн тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий Компанийн өрийн хэрэгсэл (цаашид "Лэнд Бонд")-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар гаргах болсныг баталгаажуулсугай.**
2. **Нийтэд санал болгох Лэнд Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үнэт цаасны нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралт №1-ээр шинэчлэн батлсугай.**
3. **Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой ажлын үйл явц, үр дүн болон энэхүү тогтоолын хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.**
4. **Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоолын хавсралтыг хүчингүй болгосугай.**

**ТУЗ-ИЙН ДАРГА**

**О.БОЛДБААТАР**

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118207206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023 .08. 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн
23/22 тоот тогтоолын хавсралт

## НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ

| | | |
|---|---|---|
| 1. | Үнэт цаас | Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл "Лэнд Бонд" |
| 2. | Арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| 3. | Лэнд Бондын нэрлэсэн үнэ | 100.000 (нэг зуун мянга) төгрөг |
| 4. | Тоо ширхэг | 90.000 (ерэн мянга) ширхэг |
| 5. | Олон нийтэд санал болгох нийт дүн | 9.000.000.000 (есөн тэрбум) төгрөг |
| 6. | Хүү (жилийн буюу 365 хоног) | 18.0% (арван найман хувь) |
| 7. | Бондын төрөл | Энгийн хүүтэй бонд |
| 8. | Лэнд Бондын хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| 9. | Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| 10. | Үндсэн төлбөр төлөх хугацаа | Лэнд Бондын хугацааны эцэст (24 сарын дараа) |
| 11. | Лэнд Бондын барьцаа/Баталгаа | "АНД Системс" ХХК-ийн эзэмшиж буй 13.600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцаа |
| 12. | Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаар санхүүжүүлнэ |
| 13. | Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2023 оны III улирал (Зохицуулагч байгууллагаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой) |
| 14. | Лэнд Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-аар дамжуулан гүйцэтгэнэ |
| 15. | Үндсэн андеррайтер | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК |
| 16. | Туслах андеррайтер | Гүйцэтгэх захирал нь үндсэн андеррайтер "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай харилцан тохиролцож, нэмэлтээр туслах андеррайтер ажиллуулж болно |

~oOo~

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039794 ★ 1116267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.08 сарын 11 өдөр
БҮРТГЭВ
№

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



# ҮНЭТ ЦААС ГАРГАХАД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ

**ЛЭНДМН ББСБ ХК**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төвийн байр

contact@lend.mn

+976 7707 0101

## ҮНДСЭН АНДЕРРАЙТЕР

**РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК**

Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1308Б тоот

info@rhinosinvest.mn

+976 7510 0575

## ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

**ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити Тауэр, 25 давхар, 2506 тоот

info@ucc.mn

+976 7777 6377

## ТУСЛАХ АНДЕРРАЙТЕР

**ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК ХХК**

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж 18/2, Меру Тауэр, 10 давхар, 1003 тоот

admin@tengercapital.mn

+976 7011 0637

## ХӨНДЛӨНГИЙН ХУУЛИЙН ЗӨВЛӨХ

**ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ХХН**

Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 13 давхар, 1301 тоот

info@mdsa.mn

+976 11 330048

## АУДИТЫН КОМПАНИ

**НИЙСЛЭЛ АУДИТ ХХК**

Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮБ-ын гудамж, 44-р оффисын байр

info@niislelaudit.mn

+976 7011 0095

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЗХ 2023.08 сар 11 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02



# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ ТАНИЛЦУУЛГА

| | |
|---|---|
| **ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ** | **ЛэндМН ББСБ ХК** |
| **ҮНЭТ ЦААСНЫ НЭР** | Лэнд Бонд |
| **ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖАА** | Нээлттэй |
| **ҮНЭТ ЦААСНЫ ТӨРӨЛ** | Энгийн хүүтэй бонд |
| **ҮНЭТ ЦААСНЫ НЭРЛЭСЭН ҮНЭ** | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| **ҮНЭТ ЦААСНЫ ТОО, ШИРХЭГ** | 90,000 (ерөн мянга) ширхэг |
| **ОЛОН НИЙТЭД САНАЛ БОЛГОХ НИЙТ ДҮН** | 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг |
| **ҮНЭТ ЦААСНЫ ХУГАЦАА** | 24 сар (365 хоног * 2) |
| **ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ /ЖИЛИЙН/** | 18% (арван найман хувь) |
| **ХҮҮ ТӨЛӨГДӨХ ДАВТАМЖ** | Улирал тутам (3 сар тутам) |
| **ҮНЭТ ЦААСНЫ ҮНДСЭН ТӨЛБӨР ТӨЛӨЛТ** | Лэнд Бондын хугацааны эцэст (24 сарын дараа) |
| **ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ** | Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ |
| **ҮНЭТ ЦААСНЫ БАРЬЦАА/БАТАЛГАА** | "АНД Системс" ХХК-ийн эзэмшиж буй 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцаа |
| **ҮНЭТ ЦААСНЫ ХАДГАЛАЛТ** | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| **АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА** | Монголын Хөрөнгийн Бирж |
| **АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ АРГА** | Тогтоосон үнэ (өгөөж)-ээр санал болгоно. |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 ... 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК ... УЛААНБААТАР ХОТ

СЗХ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE



# I. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

## 1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

ЛэндМН ББСБ ХК нь Монгол улсын санхүүгийн зах зээлд цахим зээлийн үйлчилгээг гар утасны LendMN аппликейшнээр дамжуулан хэрэглэгчдэд хурдан шуурхай, барьцаагүй, хямд өртгөөр хүргэсэн анхдагч финтек компани юм.



2018 онд үнэт цаас гаргагч нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийт хувьцааны 25 хувийг олон нийтэд санал болгон гаргах замаар нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн билээ.

Өнгөрсөн 3 жилийн хугацаанд ЛэндМН ББСБ ХК нь Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нээлттэй өрийн хэрэгслийг нийт гурван удаа, 2022 онд анх удаа хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон амжилттай арилжиж нийт 20.45 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн бөгөөд цаашид хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, хамтрагч байгууллага, хэрэглэгчдийнхээ итгэлийг даан, тогтвортой, найдвартай, тасралтгүй үйл ажиллагаагаар хангах, бизнесийн ёс зүй, цар хүрээгээ улам өргөжүүлэн тэлэх зорилго тавин ажиллаж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## 1.1.1 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУУЛИЙН ЭТГЭЭД, АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГЫН БҮРТГЭЛ, ХАЯГ

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр | ЛэндМН ББСБ ХК |
| Байгуулагдсан огноо | 2006 оны 1-р сарын 13 өдөр |
| Улсын бүртгэлийн дугаар | 9010002001 |
| Регистрийн дугаар | 5039754 |
| Компанийн хэлбэр | Хувьцаат компани |
| Үйл ажиллагааны чиглэл | Зээл олгох<br>Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга<br>Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах<br>Гадаад валютын арилжаа эрхлэх<br>Итгэлцлийн үйлчилгээ<br>Факторингийн үйлчилгээ |

### МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

### ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ

| | |
|---|---|
| Бүртгэлтэй нэр: | ЛэндМН ББСБ ХК |
| Симбол: | LEND |
| Бүртгэгдсэн огноо: | 2018 оны 3-р сарын 14 өдөр |
| Бүртгэлийн ангилал: | I ангилал |
| Гаргасан хувьцааны хувь | 25 хувь |
| Бүртгэлтэй хувьцааны тоо | 800,000,000 ширхэг |

### ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХАЯГ

| | |
|---|---|
| Хаяг: | Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төвийн байр |
| Утас: | +976 7707 0101 |
| Э-шуудан: | contact@lend.mn |
| Цахим хуудас: | www.lend.mn |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754



ХХК
INVESTMENT UTSK

СЭХ 2023.08.01 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

### 1.1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

ЛэндМН ББСБ ХК /"Үнэт цаас гаргагч"/ нь 2017 онд Монгол улсын санхүүгийн зах зээлд анх удаа хиймэл оюун ухаанд суурилсан санхүүгийн зээлжих зэрэглэлийг тогтоогч дэвшилтэт технологийг амжилттай нэвтрүүлсэн билээ. Энэхүү технологийн дэвшил болох гар утсанд суурилсан барьцаагүй, түргэн шуурхай хэрэглээний бичил цахим зээлийн үйлчилгээг өөрийн ЛэндМН аппликейшнээрээ дамжуулан хэрэглэгчиддээ үзүүлдэг байна.

Үнэт цаас гаргагч нь өнгөрсөн хугацаанд харилцагчид болон хөрөнгө оруулагчидтайгаа хамтран нийгэм, эдийн засгийн тодорхой бус цаг үеийг хамтдаа даван туулахад чиглэсэн олон боломжуудыг эрэлхийлж, харилцагчдадаа учирсан бэрхшээлүүдийг илүү уян хатан байдлаар түргэн шуурхай шийдэхийг зорин, харилцагчдадаа чиглэсэн шинэ үйлчилгээ нэвтрүүлэн ажиллаж байна.

## *ДЭЛХИЙН ЭН, ҮНЭНЧ СЭТГЭЛ, ЭВИЙН ХҮЧ*

**Эрхэм зорилго:**

Хиймэл оюун ухаанд суурилсан шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ санхүүгийн салбарт шинэ жишиг тогтоогч таны АНД байна.

**Алсын хараа:**

Дэлхийн энтэй бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ Монголын санхүүгийн зах зээлд манлайлна.

**Үнэт зүйлс:**

Инноваци, хурд, хариуцлага, мэргэшсэн өндөр чадвар, зогсолтгүй суралцах зарчим, хүн төвт зарчим

ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ҮЦК LLC УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ




*Зураг 1: Үнэт цаас гаргагчийн түүхэн замнал*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

СЭХ
2023.08.11
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОЛОЛТ, АМЖИЛТУУД



Монголын арилжаа эрхлэгчдийн холбооноос зохион байгуулсан Хөрөнгийн зах зээлийн дээд шагнал гардуулах ёслол "Grand Bull Awards"-аас **"Шилдэг IPO"** шагнал, Банк бус санхүүгийн байгууллагын холбооноос 2018 оны **"Шилдэг бүтээгдэхүүн"** шагналыг тус тус гардан авлаа.




Банк санхүүгийн салбарын хөгжлийн түвшинг тодорхойлогч "**Asia Money**" сэтгүүлээс 2019 оны **Монголын шилдэг дижитал санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчээр** ЛэндМН ББСБ ХК-ийг тодрууллаа.

mintos

**Mintos Financial Platform** олон улсын санхүүгийн байгууллагаас **B+ үнэлгээ** авлаа. Энэхүү платформоор дамжуулан санхүүжилт татдаг 65 олон улсын санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч компаниудаас 13-т бичигдсэн ба уг байгууллагатай хамтын ажиллагаа эхлүүлсэн.




Дэлхийн хөрөнгийн зах зээл, банк санхүүгийн байгууллагуудын хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг бие даасан хараат бус байдлаар тэнцвэртэйгээр дэлхийн 200 гаруй улс оронд зэрэг нэгтгэн хүргэдэг **GLOBAL BANKING & FINANCE AWARDS®**-аас 2020 оны Монголын Шилдэг Финтек компаниар "ЛэндМН ББСБ" ХК-ийг тодруулан өргөмжиллөө.




Монголын Финтек салбарын анхны нээлттэй бонд болох "**ЛэндБонд**"-ыг 2020 онд хөрөнгийн зах зээлд амжилттай гаргаж, олон нийтээс **5.0 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн ба 2021 онд дахин нээлттэй бонд гаргаж олон нийтээс **5.0 тэрбум** төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэв.




Нийгмийн даатгалын хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж даатгуулагчдын нийгмийн баталгааг хангаж, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсаныг үнэлэн 2022 оны **"Шилдэг ажил олгогч"** -оор шалгарав.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

## 1.1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ




*Зураг 2: Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт*

## 1.1.4 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД



**О.БОЛДБААТАР**
ТУЗ-ийн Дарга
Аудитын хорооны гишүүн
"АНД Глобал" Пти.Лтд-ийн
ТУЗ-ийн гишүүн



**С.ЭНХ-АМГАЛАН**
ТУЗ-ийн ердийн гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх болон
цалин урамшууллын хорооны дарга
Эрсдэлийн удирдлагын хорооны
гишүүн
"Мэргэн инвестмент" Пти.Лтд-ийн
ТУЗ-ийн гишүүн



**В.БАЯРСАЙХАН**
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны гишүүн
"Томъёо Эд Тек" ХХК-ийн
Ерөнхий захирал



**Б.ХОС-ЭРДЭНЭ**
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны гишүүн
"АНД Глобал" Пти.Лтд-ийн
Гүйцэтгэх захирал
"АНД Системс" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



**Ц.УУГАНБАЯР**
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны гишүүн
"АНД Глобал" Пти.Лтд-ийн
Санхүү эрхэлсэн захирал
"ЛэндМН ББСБ" ХК-ийн
Гүйцэтгэх захирал



**Б.ИТГЭЛ**
ТУЗ-ийн ердийн гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны дарга
"АНД Глобал" Пти.Лтд-ийн
Гадаад харилцаа хариуцсан
Дэд захирал



**Д.ГАЛХҮҮ**
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх
болон цалин урамшууллын
хорооны гишүүн
Эрсдэлийн удирдлагын
хорооны гишүүн



**С.БОРГИЛ**
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Засаглал, нэр дэвшүүлэх
болон цалин урамшууллын
хорооны гишүүн
Аудитын хорооны гишүүн
"Сэргэлт Консалтинг групп"-
ийн Гүйцэтгэх захирал



**Ж.ЖАРГАЛСҮРЭН**
ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга
"Далайван Аудит" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

СЗХ 2023.08.11 бүртгэв
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь ердийн 6, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй ба Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар тодорхойлсон, тодорхой чиг үүрэг, байнгын ажиллагаа бүхий 3 хороодтойгоор үйл ажиллагаа явуулж байна.

| Аудитын хороо | Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо | Эрсдэлийн удирдлагын хороо |
|---|---|---|
| Ж.Жаргалсүрэн (Хорооны дарга)<br>О.Болдбаатар<br>С.Боргил | С.Энх-Амгалан (Хорооны дарга)<br>Б.Боргил<br>Д.Галхүү | Б.Итгэл (Хорооны дарга)<br>С.Энх-Амгалан<br>В.Баярсайхан<br>Д.Галхүү<br>Ц.Ууганбаяр<br>Б.Хос-Эрдэнэ |

## Дотоод аудит

Дотоод аудитын тогтолцоо: ЛэндМН ББСБ ХК нь Хамгаалалтын гурван бүс /Three lines of defense/ бүхий эрсдэлийн удирдлага, хяналтыг тогтолцоог бүрдүүлэн бүх нэгжийн үйл ажиллагаанд хэрэгжүүлж, тасралтгүй, сайжруулан ажилладаг.




*Схем 1: Дотоод аудитын тогтолцоо*

Дотоод аудитор нь хамгаалалтын гуравдугаар бүсэд хамаардаг бөгөөд нэг ба хоёрдугаар хамгаалалтын бүсийн хүрээнд хяналтын шаардлагууд биелж байгаа эсэхийг хараат бус, бодитой үнэлж дүгнэн баталгаажуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Төлөөлөн удирдах

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ÜTSK LLC

зөвлөлийн дэргэдэх аудитын хороонд тайлагнаж, гүйцэтгэх удирдлагад зөвлөгөө өгч хамтран ажиллах үүрэг хүлээдэг.

### 1.1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА



**Ц.УУГАНБАЯР**
"ЛэндМН ББСБ" ХК
Гүйцэтгэх захирал

"АНД Глобал" Пти.Лтд-д 6 жил ажилласан.



**Д.БААСАНДОРЖ**
"ЛэндМН ББСБ" ХК
Бизнес хөгжлийн газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 2 жил, "АНД Глобал" Пти.Лтд-д 2 жил ажилласан.



**М.ТҮВШИНЖАРГАЛ**
"ЛэндМН ББСБ" ХК
Санхүү, үйл ажиллагааны газрын захирал

Банк, санхүүгийн салбарт 17 жил ажилласан.



**Г.ЗОЛЖАРГАЛ**
"ЛэндМН ББСБ" ХК
Ерөнхий нягтлан бодогч

Банк, санхүүгийн салбарт 13 жил ажилласан.

## 1.1.6 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗӨВЛӨХ



**К.МАДОНО**
Ерөнхийлөгч

Банк, санхүүгийн салбарт 41 жил, "АНД Глобал" Пти.Лтд-д 4 жил ажилласан.

**ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:**

**ACOM, EASY BUY** **1982-2009 он**

Бизнесийн стратеги, брэндинг, маркетинг, хүний нөөцийн хөгжил, менежмент, мэдээллийн технологийн системийн стратегийн чиглэлээр 27 жилийн туршлагатай.

**EASY BUY (ТАЙЛАНД)** **1998-2009 он**

1998 онд EASY BUY компанийн гүйцэтгэх захирлаар томилогдон анх 45 ажилтантай байсан ба 10 жилийн дараа Тайланд даяар 2500 ажилтантай, 100 гаруй салбартай болсон.

2020 оны байдлаар EASY BUY цэвэр зээлийн үлдэгдэл: 1,576 сая ам. доллар, цэвэр ашиг: 2020 оны байдлаар 144 сая ам. доллар)

**AIFUL, AIRA & AIFUL (ТАЙЛАНД)** **2014-2019 он**

2014 онд Aira & Aiful-ийн гүйцэтгэх захирлаар томилогдсон (AIFUL Corp. [Японы харилцагчын санхүүгийн хамгийн том компануудын нэг] болон AIRA Capital Plc.-ийн хамтарсан хамтарсан компани)

**"АНД ГЛОБАЛ" Пти.Лтд зөвлөх** **2019 оноос хойш**

К.Мадоно нь толгой компанийн санал болгосноор Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон Ерөнхийлөгч нь гадаадын хөрөнгө оруулалт татах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи хөгжүүлэхэд Компанид зөвлөх чиг үүрэгтэй ба компанийн үйл ажиллагааг удирдах, шийдвэр гаргахад оролцдоггүй.

СЗХ
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



## 1.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

### 1.2.1 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ

Үнэт цаас гаргагч нь нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 800,000,000 (найман зуун сая) ширхэг энгийн хувьцаатай бөгөөд нийт 8,000,000,000 (найман тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болно.

2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-аас ирүүлсэн үнэт цаас гаргагчийн дэлгэрэнгүй судалгааны дагуу үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц дараах байдалтай байна.

*Эх сурвалж: ҮЦТХТ ХХК-ийн тархалтын мэдээ*




*Схем 2: Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10.5.4-т заасны дагуу үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь 2023 оны 05 сарын 17-ны байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн дараах хувьцааг эзэмшиж байна.

| № | Овог, нэр | Албан тушаал | Эзэмшиж буй хувьцааны эзлэх хувь |
|---|---|---|---|
| 1 | Ц.Ууганбаяр | Гүйцэтгэх захирал | 0.002% |
| 2 | М.Түвшинжаргал | Санхүү, үйл ажиллагааны газрын захирал | 0.004% |

### 1.2.2 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН НӨЛӨӨ БҮХИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

Үнэт цаас гаргагчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 75%-ийг эзэмшиж буй Монгол улсын хуулийн этгээд АНД Системс ХХК бөгөөд тус компанийн 100 хувийн хувьцаа эзэмшигч буюу толгой компани нь Сингапур улсын хуулийн этгээд АНД Глобал Пти.Лтд компанийн 100%-ын охин компани АНД Эф Эс Жи Пти.Лтд юм.




*Схем 3: Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид болон зэргэлдээ компанийн бүтэц*

## АНД СИСТЕМС ХХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

### ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

| | |
|---|---|
| Компанийн нэр | АНД Системс ХХК |
| Улсын бүртгэлийн дугаар | 9019084069 |
| Регистрийн дугаар | 6005861 |
| Үйл ажиллагааны чиглэл | Менежментийн зөвлөгөө өгөх |

СЭХ 2023.08.11 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02



| | |
|---|---|
| Хаяг | Мэдээлэл технологийн үйл ажиллагаа Монгол улс, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд групп ХХК-ийн байр |
| Холбоо барих дугаар: | 77242244 |

АНД Системс ХХК нь АНД Глобал Пти.Лтд компанийн охин компани болох АНД Эф Эс Жи Пти.Лтд -ийн охин компани бөгөөд 2015 оны 9-р сарын 24-ний өдөр үүсгэн байгуулагдан хамгийн сүүлийн үеийн технологид суурилсан хүртээмжтэй санхүүгийн үйлчилгээний шийдлийг хэрэглэгчиддээ хүргэх эрхэм зорилгыг тавин үйл ажиллагаагаа явуулж байна.

АНД Системс ХХК нь ЛэндМН ББСБ ХК, Дижитал Молл ХХК, Супер Ап ХХК, Супер Ап Хэтэвч ХХК, АНД Дэнөүд ХХК гэх Монгол улсад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй охин компаниудыг эзэмшиж буй санхүүгийн холдинг компани юм.









ЛэндМН аппликейшнийг хөгжүүлэгч АНД Системс ХХК-ийн дараагийн гол бүтээгдэхүүнүүдийн нэг болох SuperUp аппликейшнээр дамжуулан орчин үеийн дэвшилтэт технологид суурилан, хүн бүрийн өдөр тутмын амьдралын хэв маягт нийцсэн бүхий л хэрэгцээг хялбар, аюулгүй, найдвартай, хурдан шуурхай байдлаар товчлуур дараад л шийдэх боломжтой төлбөр тооцоо болон 30 гаруй худалдаа, үйлчилгээг багтаасан цогц дижитал эко систем бүрдүүлэн хэрэглэгчдэд хүргэн ажиллаж байна.

ЛэндМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
RHINOS INVESTMENT ҮЦК

### 1.2.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ЗЭРГЭЛДЭЭ КОМПАНИУД

**Супер Ап ХХК** нь SuperUp аппликейшнийн оюуны өмчийн албан ёсны эзэмшигч бөгөөд тус аппликейшн нь орчин үеийн технологийн шийдлийг дижитал цогц экосистем бүхий хүн бүрийн амьдралын хэв маягт тохирсон лайфстайл аппликейшн юм. Гар утасны ганцхан аппликейшнээр дамжуулан санхүүгийн төрөл бүрийн үйлчилгээгээр өөрийн хэрэгцээт худалдаа, үйлчилгээг түргэн шуурхай авах, олон сонирхолтой нэмэлт боломжийг ашиглах давуу тал бүхий залуусын шинэ цахим хэрэглээний ухаалаг шийдэл юм. Супер Ап ХХК-ийн харилцагч байгууллага өөрсдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг зорилтот хэрэглэгчдэд тодорхой тоо ширхгээр, богино хугацаанд хөнгөлөлттэй үнээр сурталчлах маркетингийн үйлчилгээ юм.

**Супер Ап Хэтэвч ХХК** нь 2020 оны 1 сард байгуулагдсан бөгөөд 2020 оны 5 сард Монголбанкнаас цахим төлбөр тооцооны тусгай зөвшөөрлөө аван цахим төлбөр тооцооны шинэ шийдлүүдийг нэвтрүүлж, цахим хэтэвчинд суурилсан санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдэд хялбар, түргэн шуурхай нийлүүлэхээр ажиллаж байна.

**Дижитал Молл ХХК**-ийн **Банана Молл** нь SuperUp болон ЛэндМН аппликейшнд суурилсан залуусын амьдралын хэв маягт нийцсэн хамгийн хялбар, сонирхолтой худалдан авалтын үйлчилгээ үзүүлэгч онлайн дэлгүүр юм. “Банана Молл” онлайн дэлгүүрт одоогийн байдлаар 400 гаруй албан ёсны борлуулагч, аж ахуйн нэгжийн 12,000 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж байна.

**АНД Дэнөүд ХХК** нь виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар 2021 оны 11 дүгээр сард үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 653 тоот тогтоолоор Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр бүртгүүлсэн болно. Тус компани нь дэлхий дахинд виртуал хөрөнгө болон блокчэйн технологийн хөгжилд хувь нэмрээ оруулахаар ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд блокчэйн технологид суурилсан Denode (https://denode.io) платформыг хөгжүүлээд байна.

## АНД ГЛОБАЛ Пти.Лтд КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

### "АНД ГЛОБАЛ"

**Монгол улсыг Дэлхийд технологиор дахин тодорхойлно.**

АНД Глобал групп нь анх 2017 онд үүсгэн байгуулагдсан ба технологид суурилсан санхүүгийн олон төрлийн шийдлүүд болон хиймэл оюун ухаанд суурилсан бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлэн олон улсад экспорт хийдэг үндэсний тэргүүлэгч технологийн компани юм.

Монгол залуусын бүтээсэн технологийн шийдлүүдийг өнөөдрийн байдлаар Тайланд, Япон, Камбож, Филиппин, Австрали зэрэг улсын компаниуд хэрэглэж эхлээд байна.

### "АНД ГЛОБАЛ"– ГРУППИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ




*Зураг 3: АНД Глобал группийн түүхэн замнал*

АНД Глобал групп нь финтек бизнес модель, тэдгээртэй холбоотой тусламж үйлчилгээ зэргийг нэгтгэсэн Финтек Цогц Үйлчилгээний ("FaaS") нээлттэй платформоор дамжуулан хиймэл оюун ухаанд суурилсан зээлжих зэрэглэлийн үнэлгээ, цахим хэтэвч, худалдаа, төлбөр тооцоо, цахим зээлийн систем болон блокчейнд суурилсан платформ зэрэг үйлчилгээг санхүүгийн байгууллагууд бизнестээ нэвтрүүлэн ашиглах боломжийг санал болгодгоос гадна тус үйлчилгээнд тулгуурлан бусад




салбарын харилцагч байгууллагууд нь бие даасан цахим экосистемийг бүрдүүлэх боломжийг хангаж ажилладаг болно.

## "АНД ГЛОБАЛ"– ХАМТЫН АЖИЛЛАГАА БОЛОН БИЗНЕСИЙН ТЭЛЭЛТ

Дэлхийн зах зээлд бизнесээ тэлж Монгол улсыг олон улсад технологиор дахин тодорхойлох зорилготой **АНД Глобал** группийн зорилгын хүрээнд олон жилийн бизнесийн туршлагатай Японы тэргүүлэгч компани **"Марубени"** корпорацтай стратегийн хамтын ажиллагааг 2020 оны 4 дүгээр сараас эхлүүлэн ажиллаж байна.

Энэхүү хамтын ажиллагааны зорилго нь АНД Глобал группийн бүтээсэн дата шинжилгээ, дижитал хөрөнгийн бирж, корпорацын инновац, финтекийн цогц үйлчилгээг "Марубени" корпорацын санхүү, лизингийн

СЭХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



салбар дахь арвин их туршлага мөн уг корпорацийн дэлхийн олон орныг хамарсан бизнесийн сүлжээнд холбон, санхүү болон бусад салбарын байгууллагуудын үйл ажиллагаанд тус үйлчилгээг нэвтрүүлэн ажиллаж байна.

Түүнчлэн тус стратегийн түншлэлийн хүрээнд шинэлэг бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхэд шаардлагатай судалгаа, хөгжүүлэлт болон хэрэгжүүлэлтийн үйл ажиллагаа АНД Глобал групп Марубени корпорацитай хамтран хийж гүйцэтгэн дэлхий даяар түгээх бизнесийн шинэ боломжуудыг нээн ажиллаж байна.

## “АНД ГЛОБАЛ” – ГРУППИЙН ИННОВАЦИ




2020 оны 11-р сард АНД Глобал групп нь Марубени корпораци болон АНУ-ын TechStars компаниудаас Series A шатны нийт 10.3 сая ам.долларын хөрөнгө оруулалт татаж чадсан бахархам үйл явдал болсон. Энэ нь АНД Глобал группийн хувьд үйл ажиллагаагаа өргөжүүлж, бүтээгдэхүүнээ хөгжүүлэхэд зориулсан Series A шатны хөрөнгө оруулалт бөгөөд

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK LLC

Монголын старт-ап компаниуд дунд анхдагч болж буй үйл явдал юм. Түүгээр ч зогсохгүй, БНХАУ, БНЭУ-ын компаниудыг эс тооцвол 2000 оноос хойш Ази тивд хийгдсэн Series A шатны ТОП-20 хөрөнгө оруулалтын тоонд орж байгаа (компанийн үнэлгээгээр) юм.

Гадаадын хөрөнгө оруулалт гэдэг бол Монгол улсад ус агаар шиг хэрэгтэй зүйлийн нэг билээ. Хөрөнгө оруулалтыг дагаад шинэ технологи, ноу-хау нэвтрэх, бүтээмж нэмэгдэж, шинэ ажлын байр бий болох гэх мэтчилэн микро болон макро түвшний олон эерэг нөлөөлөл тухайн улсад үүсдэг. Манай улсын хувьд голлох хөрөнгө оруулалт татах нөөц нь газар доорх байгалийн баялаг буюу уул уурхайн бүтээгдэхүүн байгаа нь эдийн засгийг нэг салбараас хэт хамааралтай болгох эрсдэлтэй байдаг. Гэхдээ хэдхэн жилийн өмнөөс старт-ап компаниуд маань өөрсдийн ур ухаанаас гарсан бүтээлээ дэлхийд гаргахаар хичээж эхэлсний дотор АНД Глобал группийн залуус түүчээлэгч нь байж 12 улсад технологийн бүтээгдэхүүнээ нэвтрүүлж эхлээд байгаа билээ.

АНД Глобал группийн Series A шатны хөрөнгө оруулалт үүгээр ч зогсохгүй Эс Би Ай Холдингс (SBI Holdings) буюу дэлхий даяар 9,000 ажилтантай, 30 сая гаруй харилцагч, 290 охин компанитай дэлхийн хэмжээний том компаниас 2021 оны 7-р сард 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт татаж чадсан байна.

Монгол улсын газрын баялаг хязгаартай бол Монгол хүний оюуны чадавхыг ашиглан бүтээсэн технологийн баялагт хязгаар үгүй гэдэгт бид итгэдэг.

### 1.2.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ОХИН КОМПАНИ

**ЛэндМН Актив ТЗК** ХХК нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилготойгоор үүсгэн байгуулагдсан тусгай зориулалтын компани юм. Энэхүү компанийг ЛэндМН ББСБ ХК-ийн автомашины зээлийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зорилгоор 2022 оны 07 сарын 03-ний өдөр байгуулсан ба тусгай шаардлагыг хангасан зээлийн багцыг худалдах, худалдан авах гэрээний үндсэн дээр зээлийн хөрөнгийн багцыг тусгай зориулалтын компанид шилжүүлсэн. 2022 оны 10 сард 4.85 тэрбум төгрөгийн ХБҮЦ-ийг МХБ-ээр дамжуулан олон нийтэд санал болгон, амжилттай арилжаалсан. Тус компани нь гурван ТУЗ-ийн гишүүнтэй ба хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээг “Юнайтэд Айр Файнэнс” ХХК үзүүлж байна.

## 1.3 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГАРГАСАН ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

### Гаргасан хувьцааны тухай




Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 01 сарын 19-ний өдрийн хурлаас Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооны бусад холбогдох журмын дагуу компанийн 25 хувьтай тэнцэх хэмжээний нийт 200 сая ширхэг энгийн хувьцааг олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад Монголын хөрөнгийн биржээр дамжуулан санал болгон арилжаалахаар шийдвэрлэсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 02 сарын 07-ны өдрийн 60 дугаар тогтоолоор нээлттэй хувьцаат компани болохыг зөвшөөрсөн юм.

Ийнхүү ЛэндМН ББСБ ХК нь 2018 оны 02 сарын 21-ний өдрөөс 2018 оны 03 сарын 07-ны өдрийн 13 цаг хүртэл хувьцааны анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг олон нийтээс хүлээн авах ажиллагааг явуулсан бөгөөд энэхүү хугацаанд нийт давхардсан тоогоор 6,000 гаруй хөрөнгө оруулагчдаас нийт 43.98 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг хүлээн авсан.

2023 он 05 сарын 26-ны байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн хувьцааны ханш оны эхнээс 33.6%-иар өсч нэгж хувьцааны ханш 40.31 төгрөгт хүрсэн байна. Мөн хугацаанд Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын үнэт цааснуудийн үнийн ерөнхий өөрчлөлтийг илэрхийлдэг ТОП 20 индекс 5.79%-иар, MSE B индекс 1.37%-иар тус тус буурсан бол MSE A индекс 10.34%-иар өссөн байна. Үүнээс харахад үнэт цаас гаргагчийн хувьцааны ханш нь хөрөнгийн зах зээлийн индексээс эсрэг болон илүү өсөлттэй, хөрөнгө оруулагчдын итгэлийг хүлээсэн, тогтмол ногдол ашиг хуваарилдаг давуу талуудтай байна. Үнэт цаас гаргагч нь Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн дагуу хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргийг тогтмол биелүүлэн ажиллаж байна.

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*




*График 1: ЛэндМН ББСБ ХК хувьцааны ханш 2023*

## ГАРГАСАН ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТУХАЙ

### Өрийн хэрэгсэл I

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2020 оны 04 сарын 29-ний өдрийн № 20/17 тоот тогтоолоор Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор нийт 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 17%-ийн хүүтэй 1 жилийн хугацаатай компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн юм.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 06 сарын 10-ны өдрийн 482 дугаар тогтоолоор ЛэндМН ББСБ ХК-ийн нийтэд санал болгон гаргах 12 сарын хугацаатай, жилийн 17%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000 (тавин мянга) ширхэг "Лэнд бонд" өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх болон "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д бүртгэж нийтэд санал болгохыг зөвшөөрсөн юм.

Энэхүү нээлттэй бонд гаргах үйл ажиллагаанд Андеррайтераар "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" болон "Ард Капитал ҮЦК" ХХК, Аудитын компаниар "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК, Хуулийн зөвлөх

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
УЛААНБААТАР ХОТ

компаниар “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” хуулийн фирм, Синдикат компаниар "Райнос Инвестмент ҮЦК” ХХК, Үнэлгээний компаниар “Итгэлт-Эстимэйт” ХХК нар хамтран ажилласан юм.

“Лэнд Бонд”-ын арилжааг хүн бүрт хүртээмжтэй байлгах зорилгоор ухаалаг гар утастай хүн бүр бондын анхдагч зах зээлийн арилжаанд оролцох боломжийг бүрдүүлж, андеррайтер болон үнэт цаасны компаниудаас гадна SuperUp аппликейшнээр дамжуулан бондын захиалгыг хүлээн авч, бага үнийн дүнтэй захиалгыг тэргүүн ээлжинд хуваарилахаар зохицуулалт хийснээрээ онцлогтой.




Ийнхүү Монголын хөрөнгийн зах зээл дээр финтек компанийн анхны нээлттэй бондын анхдагч зах зээлийн арилжаа 2020 оны 06 сарын 15-ны өдрөөс эхлэн 2020 оны 06 сарын 19-ний өдрийн хооронд буюу 5 хоногийн турш үргэлжилсэн бөгөөд нийт 541 хөрөнгө оруулагчдаас 6,742,400,000 төгрөгийн захиалга хүлээн авснаар татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 34.8% -иар давж биелсэн нь тухайн үеийн Монголын хөрөнгийн зах зээлд хамгийн олон захиалагчтай компанийн бонд болсон юм.




Монголын Хөрөнгийн бирж дээр хийгдсэн анхдагч зах зээлийн хуваарилалтаар 28.8 сая төгрөг хүртэлх үнийн дүнтэй захиалгыг 100% биелүүлж, түүнээс дээш давсан дүнтэй захиалгыг 58.8%-иар хувь тэнцүүлэн хуваарилсан бөгөөд Санхүүгийн Зохицуулах Хорооноос анхдагч зах зээлийн арилжаа амжилттай болсон шийдвэр гармагц хөрөнгө оруулагч нарт захиалга биелээгүй зөрүү мөнгөн хөрөнгийг захиалга өгсөн үнэт цаасны компаниудаар дамжуулан буцаан олгосон билээ.

СЗХ
он сар өдөр
2023.08.11 ЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



## Өрийн хэрэгсэл II

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн №21/18 тоот тогтоолоор Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 2 дахь жилдээ дахин 5 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 14%-ийн хүүтэй 2 жилийн хугацаатай компанийн өрийн хэрэгслийг нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 23-ны өдрийн 258 дугаар тогтоолоор ЛэндМН ББСБ ХК-ийн нийтэд санал болгон гаргах 24 сарын хугацаатай, жилийн 14%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 50,000 (тавин мянга) ширхэг "ЛэндБонд" өрийн хэрэгслийг үнэт цаасны бүртгэлд бүртгэх болон "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д бүртгэж нийтэд санал болгохыг зөвшөөрсөн юм.

Энэхүү нээлттэй бонд гаргах үйл ажиллагаанд Андеррайтераар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, Аудитын компаниар "Эрнст энд Янг Монголия Аудит" ХХК, Хуулийн зөвлөх компаниар "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН, Синдикат компаниар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, Үнэлгээний компаниар "Итгэлт-Эстимэйт" ХХК нар хамтран ажилласан юм.

"ЛэндБонд"-ын арилжааг хүн бүрт хүртээмжтэй байлгах зорилгоор ухаалаг гар утастай хүн бүр бондын анхдагч зах зээлийн арилжаанд оролцох боломжийг бүрдүүлж, андеррайтер болон үнэт цаасны компаниудаас гадна SuperUp аппликейшнээр дамжуулан бондын захиалгыг хүлээн авсан.

Монголын финтек салбарын тэргүүлэгч компани болох ЛэндМН ББСБ ХК нь 2 дахь удаагаа гаргасан нээлттэй өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжааны захиалгыг 2021 оны 06 сарын 25-ны өдрөөс 2021 оны 06 сарын 30-ны өдрийн хооронд авсан бөгөөд нийт 505 хөрөнгө оруулагчдаас 7,583,500,000 төгрөгийн захиалга хүлээн авснаар татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 51.7% -иар давж биелсэн. 2020 онд олон нийтэд нээлттэй санал болгосон "ЛэндБонд" нь татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүнгээс 34.8%-иар давж биелсэн бол 2 дахь жилдээ нээлттэй санал болгосон "ЛэндБонд" нь 51.7%-иар давж биелсэн нь хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг хүлээсэн, үнэт цаасны зах зээлд өөрийн байр суурийг эзэлсэн брэнд БОНД болж чадсан байна.

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

## Өрийн хэрэгсэл III

Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 08-ны өдрийн №21/38 тоот тогтоолоор Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 2 дахь жилдээ дахин 5.6 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 14-15%-ийн хүүтэй 2 жилийн хугацаатай компанийн өрийн хэрэгслийг хөтөлбөрийн дагуу олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 11-р сарын 24-ний өдрийн 533 тоот тогтоолоор олон нийтэд нээлттэй санал болгохоор "Лэндбонд" өрийн хэрэгслийг хөтөлбөрийн хүрээнд жилийн 14%-ийн хүүтэй, нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 56,000 ширхэг буюу нийт 5.6 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй бонд гаргахаар бүртгүүлж тус зөвшөөрлийн хүрээнд 2021 оны 11-р сарын 29-ний өдөр "Лэндбонд Транч I"-ээр 14%-ийн хүүтэйгээр, 25,000 ширхэг Лэндбондыг олон нийтэд нээлттэй арилжиж, 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлсэн.




Уг үнэт цаасны Транч II-ын анхдагч зах зээлийн арилжааг 2022 оны 03 сарын 28-ны өдөр эхлүүлсэн ба энэхүү Транчийн онцлог нь зах зээлийн нөхцөл байдалтай уялдуулан хүүг жилийн 15% болгож нэмэгдүүлсэн нь онцлог байсан. Нийт 3.1 тэрбум төгрөгийг 188 хөрөнгө оруулагчдаас татан төвлөрүүлсэн ба Дижитал бонд гэсэн уриан дор зохион байгуулагдаж хөрөнгө оруулагчдын захиалгыг ЛэндМН аппликейшнээр татан төвлөрүүлсэн байна.

### Үнэт цаас гаргагчийн гаргасан нээлттэй бондын жагсаалт

| № | Бондын нэр | Анхдагч арилжааны хугацаа | Татан төвлөрүүлсэн хөрөнгө /тэр.төг/ | Бондын хугацаа | Бондын дуусах хугацаа |
|---|---|---|---|---|---|
| 1 | Лэнд Бонд | 2020.06.15 | 5 | 1 жил | Дууссан |
| 2 | ЛэндБонд | 2021.06.25 | 5 | 2 жил | 2023.06.30 |

СЗХ
он сар өдөр
2023 ... 8
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 2 8
БҮРТГЭВ-02



| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | ЛэндБонд Транч I | 2021.11.29 | 2.5 | 2 жил | 2023.12.02 |
| 4 | ЛэндБонд Транч II | 2022.03.28 | 3.1 | 2 жил | 2024.04.03 |

*Хүснэгт 1: Үнэт цаас гаргагчийн нээлттэй бондын жагсаалт*

## Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай

Үнэт цаас гаргагч нь Хөрөнгөөр Баталгаажсан Үнэт Цаасны тухай хуульд заасны дагуу тусгай зориулалтын компани буюу "ЛэндМН Актив ТЗК" ХХК-ийг үүсгэн байгуулан, СЗХ-оос 2022 оны 09 сарын 21-ний өдөр Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлийн дагуу зээлийн хөрөнгийн багцыг ЛэндМН Актив ТЗК ХХК-д худалдсан.

ЛэндМН Актив ХБҮЦ-ыг зах зээлд санал болгох, үнэт цаасжуулах хэлцэлд Анхны үүрэг гүйцэтгүүлэгч /Үүсгэн байгуулагчаар ЛэндМН ББСБ ХК, Андеррайтераар Райнос Инвестмент ҮЦК ХХК болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК, Хөндлөнгийн хуулийн дүгнэлт гаргагчаар Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс ХХН, Зээлийн шинжилгээ гаргагчаар Нийслэл Аудит ХХК, Хөрөнгө итгэмжлэн удирдагчаар Юнайтед Айр Файнэнс ХХК нар ажилласан ба үнэт цаасны ерөнхий нөхцөл дараах байдалтай байна.

- Нийт татан төвлөрүүлэх дүн: 4.85 тэрбум төгрөг
- Жилийн хүү: 17%
- Хугацаа: 24 сар
- Хүүгийн төлөлт: Сар бүр
- Үндсэн төлбөр төлөгдөх хугацаа: Хугацааны эцэст

Энэхүү үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа 2022 оны 10 дугаар сарын 20-ны 10 цагт эхэлсэн ба Лэнд ХБҮЦ нь нийт 299-н хөрөнгө оруулагчаас 4.85 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээр зорьсон үнийн дүн 100% амжилттайгаар, татан төвлөрүүлэхээр зорьсон өдрөөс 1 хоногийн өмнө биелсэн. "Мөнгөний үнээ цэнээ өсгөе" гэсэн уриан дор дээрх үнэт цаасыг олон нийтэд санал болгосон ба энэхүү үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа андеррайтер төвтэйгээр явагдсанаараа онцлог байсан юм.

2022 оны 12 дугаар сараас эхлэн ХБҮЦ-ны хүүгийн төлөлтийг үнэт цаасны ерөнхий нөхцөлийн дагуу сар бүр үнэт цаас эзэмшигчдийн дансанд байршуулан ажиллаж байгаа ба 2023 оны эхний улирлын байдлаар нийт 291.6 сая төгрөгийн хүүгийн эргэн төлбөрийг шилжүүлсэн байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTSK LLC

## Халаасны хувьцааны тухай

Үнэт цаас гаргагчаас 2019, 2020 болон 2021 онуудад нийт 3 удаа хувьцаа халааслах шийдвэр гаргасан ба нийт 60,698,317 ширхэг хувьцааг халаасласан байна.

| Халаасны хувьцаа | 2019 он | 2020 он | 2021 он |
|---|---|---|---|
| Үнэт цаасны төрөл | Халаасны хувьцаа | Халаасны хувьцаа | Халаасны хувьцаа |
| Хувьцаа халааслах тухай шийдвэр | ТУЗ-ийн 2019 оны 03 сарын 23-ны өдрийн №05 тогтоол | ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн №20/37 тогтоол | ТУЗ-ийн 2021 оны 04 сарын 23-ны өдрийн №21/17 тогтоол |
| Халаасны хувьцааны хувь хэмжээ | Компанийн нийт гаргасан хувьцааны 0.5 хувьтай тэнцэх хувьцаа | Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас ихгүй хувьцаа | Компанийн нийт гаргасан хувьцааны 5 хувиас хэтрэхгүй хувьцаа |
| Халаасласан хувьцааны нийт тоо | 4 сая ширхэг энгийн хувьцаа | 40 сая ширхэг энгийн хувьцаанаас хэтрэхгүй | 40 сая ширхэг энгийн хувьцаанаас хэтрэхгүй |
| Хувьцаа халааслах зорилго | - "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх удирдлага болон ажилтнуудын дунд хугацааны урамшууллын бодлогыг хэрэгжүүлэх<br>- Хувьцааг хүний нөөцийн бодлогын хүрээнд зөвхөн Гүйцэтгэх удирдлага болон үндсэн ажилтанд эзэмшүүлэх нөхцөлтэй | - Хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах<br>- Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалах<br>- Хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлэх<br>- Хувьцааны ханшийг тогтворжуулах | - Хувьцааны хөрвөх чадварыг сайжруулах<br>- Хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг хамгаалах<br>- Хөрөнгийн зах зээлийн идэвхжлийг нэмэгдүүлэх<br>- Хувьцааны ханшийг тогтворжуулах |

*Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн халаасны хувьцаа*

## Компанийн бусад эд хөрөнгийн тухай

Компани нь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 409 тээврийн хэрэгслийг өмчилдөг бөгөөд "ЛэндМН Актив ТЗК" ХХК-тай байгуулсан 2022 оны 09-р сарын 13-ны өдрийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээгээр 285 ширхэг автомашин барьцаалагдсан ба үүнээс Компани

нь өөрийн өмчлөлийн 2 тээврийн хэрэгсэлтэй, бусад нь фидуцийн гэрээний дагуу өмчилж байгаа болно.

Оюуны өмчийн газрын 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн анхдагч огноотой, 40-0018383 тоот улсын бүртгэлийн дугаар, 201800613 тоот гэрчилгээний дугаартай 2027 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хүчинтэй 1 барааны тэмдгийн гэрчилгээ бүртгэлтэй болно.

Компани нь "LendMN" /application, core system/ бүтээлийг 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 2017/19 тоот "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ", 2017 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн L_002 тоот "LendMN" Программ хангамж, түрээсээр ашиглуулах, ашиглах гэрээ болон 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/20 тоот "Үйлчилгээний гэрээ"-ний үндсэн дээр ашигладаг бөгөөд мөн "LendMN" аппликейшн, түүний системийг ашиглах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, хэрэглэгчид хүргэх, дагалдах засвар үйлчилгээг авах, мэдээллийн нууцлал, системийг төлбөр тооцоо хийх зэрэг үйлчилгээг өөрийн толгой компани буюу АНД Системс ХХК-аас авдаг.

Үнэт цаас гаргагч нь аливаа газар болон үл хөдлөх хөрөнгө эзэмшдэггүй болно.

## 1.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МЭДЭЭЛЭЛ

ЛэндМН ББСБ ХК нь 2016 оны 12 дугаар сараас технологийн дэвшлийг санхүүгийн үйлчилгээтэй хамтатгасан финтек бизнесийг ЛэндМН аппликейшнээр дамжуулан дотоодын санхүүгийн зах зээлд амжилттай нэвтрүүлэн даруй 7 жил болсон байна.

Өнгөрсөн хугацаанд харилцагч бүрийн санхүүгийн асуудлыг шийдэхийн тулд зөвхөн тогтмол цалингийн орлоготой харилцагчдад зээл олгох бус тогтмол орлогын эх үүсвэртэй харилцагчдад зээл олгох боломжийг өөрсдийн толгой компанийн боловсруулж олон улсад туршигдсан зээлийн эрх тогтоох програм хангамжийг ашиглан барьцаагүй зээлийг олгож ирсэн.

2023 оны I улирлын байдлаар бүртгэлтэй харилцагчдын тоо өмнөх оны мөн үеэс 14%-иар өсч 1,161 мянгад хүрсэн ба 65% нь Улаанбаатар хотод, 35% нь хөдөө орон нутагт амьдарч байна. Үнэт цаас гаргагч нь харилцагчиддаа өөрийн Улаанбаатар хотод байрлах үйлчилгээний төв болон 21 аймаг, 9 дүүрэгт гэрээ байгуулах боломжийг нотариатуудаар дамжуулан олгон ажиллаж байна.

**Бүртгэлтэй харилцагчдын тоо**
/өссөн дүнгээр, мянга/




*График 2: Бүртгэлтэй харилцагчдын тоо*

## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭ

Үнэт цаас гаргагч нь харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад тулгуурлан зээлийн бүтээгдэхүүний нэр төрлийг LendPay (BNPL), Lend-MSM мерчантын зээл, Lend Auto-Эко автомашины зээл, Flexi (дунд хугацааны зээл) зэрэг зээлүүдээр нэмэгдүүлснээс гадна хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүд болох нээлттэй бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас, хувьцаа, итгэлцэл, Lend Plus үйлчилгээг санал болгож байна.

### LENDPAY




*Зураг 4: Lendpay зээлийн бүтээгдэхүүн*

Олон улсад BNPL (Buy Now Pay Later) гэж танигдсан "Одоо аваад дараа төл" гэсэн концепт бүхий хэрэглээний зээлийг ЛэндМН ББСБ ХК-тай гэрээ байгуулсан мерчантуудаас харилцагч өөрийн зээлийн эрхийн хэмжээнд бараа, үйлчилгээг урьдчилгаагүйгээр худалдан авч 2 сарын хугацаанд дөрөв хуваан, хүү, шимтгэлгүй төлөх боломжтой зээл юм.

## LEND - MSM ЗЭЭЛ




*Зураг 5: Lend-MSM зээлийн бүтээгдэхүүн*

Бизнес эрхлэгчдийн бараа, үйлчилгээний борлуултад үүсч буй санхүүгийн асуудлыг хялбар шийдэхэд зориулж зээлийн эрхийн хүрээнд 60 хоног хүртэлх хугацаатай зээлийг бараа, үйлчилгээг худалдан авахад зориулсан зээлийн бүтээгдэхүүн юм. MSM компаниас худалдан авалт хийж буй жижиг дунд бизнес эрхлэгчид ЛэндМН ББСБ ХК-иар дамжуулан уг зээлийг авах боломжтой байна.




*Зураг 6: Эко автомашины зээл*

## LEND AUTO-ЭКО АВТОМАШИНЫ ЗЭЭЛ

ЛэндМН ББСБ ХК нь энэ цаг үеийн хамгийн тулгамдсан байгаль орчин, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах үүднээс байгаль орчинд ээлтэй, хагас цахилгаан мотортой эко автомашиныг хиймэл оюун ухаанд суурилан харилцагчийн зээлийн эрхийг тогтоон зээл олгож байгаагаараа онцлог юм.

## LEND FLEXI




*Зураг 7: Lend Flexi бүтээгдэхүүн*

Lend Flexi нь харилцагчийн зээлийн эрх болон хугацааны дээд хэмжээг тодорхойлж харилцагч өөрийн зээлийн эрхийн хэмжээнд олон

давтамжтайгаар зээл авах, эргүүлэн төлөх буюу зээлийн шугам хэлбэрээр ашиглах боломжтой зээлийн бүтээгдэхүүн юм. Компани өөрсдийн хэрэглэгчдийн дунд хугацааны санхүүгийн хэрэглээг хангах зорилгоор энэхүү бүтээгдэхүүнийг санал болгон ажиллаж байгаа ба Flexi зээлийн онцлог, давуу талууд дараах байдалтай байна.

- Зээлийн хэмжээ өндөр: (5-50 сая төгрөг)
- Зээлийн шугамаа тогтмол ашиглаж, олон давтамжтай зээл авах
- Уян хатан, урт хугацааны эргэн төлөлтийн боломж
- Хугацаандаа хийсэн эргэн төлөлтөд хүүгийн хөнгөлөлт хүртэх
- Зээл олголтын шимтгэл болон торгуулийн хүүгүй

## LEND ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ЛэндМН ББСБ ХК нь харилцагчдын мөнгөн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалах, өсгөх зорилгоор хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүнүүдийг өөрийн аппликейшнээрээ дамжуулан харилцагчидаа олгодог.

## 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2022 онд ЛэндМН аппликейшнээр дамжуулан харилцагч нартаа нийт 561.8 тэрбум төгрөгийн дүнтэй 2,650 мянган зээлийг олгосон байна. Зээлийн голлох үзүүлэлтүүдийг 2021 онтой харьцуулахад гэрээт харилцагчдын тоо **7%**, олгосон зээлийн тоо **37%**, олгосон зээлийн дүн **48%**, зээлийн багц **110%**-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Энэ өсөлт нь компанийн зээлийн үйл ажиллагаа улам бүр тэлж байгааг илэрхийлэх бөгөөд зээлийн багцын дүнгийн үзүүлэлтээр 7 жилийн түүхэнд хамгийн дээд хэмжээнд хүрсэн амжилттайгаар 2022 оныг өндөрлөсөн байна.

Эх сурвалж: ЛэндМН ББСБ 2022 оны жилийн тайлан




*График 3: 2022 оны үйл ажиллагааны үзүүлэлт*

ЛэндМН ББСБ ХК нь байгуулагдсан цагаас эхлэн зээлийн багцын чанарыг үнэлэн, эрсдэлийн санг байгуулахдаа СТОУС 9-ыг ашигладаг ба 2022 онд **3.3** тэрбум төгрөгийн сан байгуулж зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ **115.7%**-д хүрсэн байна. Зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хувь 2022 онд 4.0% хүрч өмнөх оноос 23%-иар, 2021 оноос 56%-иар тус тус буурсан байна.




*График 4: Зээлийн багцад эзлэх чанаргүй зээл*

## 2022 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЛэндМН ББСБ ХК нь Мэдээллийн аюулгүй байдлын Менежментийн Тогтолцоо ISO/IEC 27001:2013 олон улсын стандартад нийцэн, 2022 онд баталгаажуулалтын аудит хийлгэж, албан ёсоор баталгаажуулалтын гэрчилгээг хүлээн авсан байна. ЛэндМН нь Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартад нийцсэнээр харилцагчийн мэдээллийн нууцлал, түүний хадгалалт, аюулгүй байдлыг хангаж ажиллаж байгаагийн нэг илрэл болсон юм.


Certificate of Registration
(Information Security Management System)
QFS MANAGEMENT SYSTEMS LLP
This is to Certify that the Information Security Management System of
LENDMN NBFI JSC
"PEARL TOWER" BUILDING, TOURIST STREET-34, 3RD KHOROO, CHINGELTEI DISTRICT ULAANBAATAR, MONGOLIA
has been found to meet the requirements of the Information Security Management System standard
ISO/IEC 27001:2013
This certificate is valid for the following product or service range
PROVISION OF FINTECH BASED LENDING SERVICE.
Ref. - Central Set Source-HIS-SOA-001, Version: 1.0; dated:15.08.2022
Certificate Number: INT/22121.B/3627
Surv. Audit on or Before: 23.11.2023
Initial Date of Certification: 24.12.2022
Re-certification Due on: 23.12.2025
Date of Certificate: 24.12.2022
Date of Expiry: 23.12.2023
Director:
Date: 24.12.2022
IAF
IAS ACCREDITED
QFS MANAGEMENT SYSTEMS LLP
Accredited by International Accreditation Service, Inc

*Зураг 8: Мэдээллийн аюулгүй байдлын сертификат*

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02




*Зураг 9: Цахим хувьцаа эзэмшигчдийн хурал 2022*

2022 оны 3 дугаар сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа цахим хэлбэрээр амжилттай зохион байгуулж хурлыг компанийн фэйсбүүк пэйж хуудсаар шууд дамжуулсан. 2022 оны хувьцаа эзэмшигчдийн хуралд нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 84.28% нь оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг хэлэлцэн баталсан байна.

Үнэт цаас гаргагч нь 2022 онд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаатай холбоотой дараах ажлуудыг зохион байгуулж ажилласан байна.

- 2022 оны 3 дугаар сарын 28-ны өдрөөс 3 дугаар сарын 31-ний өдрүүдэд “ЛэндБонд”-ын Транч II-ын анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулж нийт 188 хөрөнгө оруулагчдаас 3.1 тэрбум төгрөгийг зарлагдсан хугацаанаас өмнө татан төвлөрүүлсэн.

- Өнгөрсөн онд үнэт цаас гаргагч нь өөрийн охин компани болох “ЛэндМН Актив” ТЗК ХХК нь 2022 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах зөвшөөрлөө авч, улмаар 4.85 тэрбум төгрөгийг олон нийтээс амжилттай татан төвлөрүүлсэн байна. Уг үнэт цаас нь сар бүр өгөөж хуртээхэй онцлогтой ба 2022 он 12 дугаар сараас эхлэн сар бүр хөрөнгө оруулагчдын дансанд өгөөжийг байршуулан ажиллаж байна.



*Зураг 10: Лэнд Бонд Транч II*

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK

- ЛэндМН ББСБ ХК-ийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу 2021 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 1.5 төгрөг буюу нийт 1,108,952,525.50 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчиддээ мөнгөн хэлбэрээр хуваарилсан байна.




*Зураг 11: Ногдол ашиг хуваарилав.*

Монгол улс Тогтвортой хөгжлийн зорилгын хүрээнд Монгол улсын ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" төслийг дэмжин СЗХ-нд мод тарих үүрэг амлалтаа хүргүүллээ.

Мөн үнэт цаас гаргагч нь МББСБХ-оос гишүүн байгууллагуудаа уриалж СЗХ, Банк бус санхүүгийн байгууллагуудтай хамтарч "Монгол улсад нийгэм, байгаль орчинд ээлтэй тогтвортой санхүүжилтийн тогтолцоог хөгжүүлж, ногоон зээлийн дэмжихийн төлөөх хамтарсан тунхаг бичиг"-ийг байгууллаа.




Нийгмийн хариуцлагын хүрээнд ногоон ирээдүй, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилтоор Монголын ББСБ-ын нэрэмжит "Цэцэрлэгт хүрээлэн"-ийн шав тавих их үйлсэд нэгдэж хамт олноороо Гачууртын минж үржүүлгийн газар болон Чингэлтэй дүүргийн засаг даргын тамгын газар болон Ургуулахад учир бий клубтэй хамтран Чингэлтэй дүүргийн Хайрхан хөгжлийн төвд 150 ширхэг модыг тус тус тарьсан байна.

## 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

### ХУРААНГУЙ

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компаниуд (цаашид "Групп" гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК нь аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар группийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагнлалын Олон Улсын Стандарт-уудын дагуу үнэн зөв толилуулсан байна гэж дүгнэжээ.

Хараат бус аудиторын тайлангийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

## СҮҮЛИЙН 3 ЖИЛИЙН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Санхүү байдлын хураангуй тайлан /аудитлагдсан, тэрбум төгрөг/

| ХӨРӨНГӨ | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө* | 10.35 | 4.90 | 5.22 |
| *Зээлийн багц (цэвэрээр)* | 25.43 | 32.43 | 69.59 |
| *Бусад хөрөнгө* | 3.44 | 0.77 | 1.06 |
| *Үндсэн хөрөнгө* | 1.11 | 0.76 | 0.59 |
| *Биет бус хөрөнгө* | 0.40 | 0.45 | 0.40 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **40.73** | **39.31** | **76.86** |
| **ӨР ТӨЛБӨР** | **23.02** | **16.64** | **49.79** |
| *Эх үүсвэр* | 21.11 | 15.17 | 45.96 |
| *Бусад өглөг* | 1.91 | 1.47 | 3.83 |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **17.71** | **22.66** | **27.07** |
| *Хувьцаат капитал* | 9.77 | 8.42 | 8.42 |
| *Бусад* | 0.05 | 0.05 | 0.05 |

СЗХ
2023 он 08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



| | | | |
|---|---|---|---|
| *Хоёрдогч өглөг* | - | 2.85 | 2.85 |
| *Хуримтлагдсан ашиг* | 7.89 | 11.34 | 15.75 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **40.73** | **39.31** | **76.86** |

Орлого, үр дүнгийн хураангуй тайлан / аудитлагдсан, тэрбум төгрөг /

| ***ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ*** | **2020** | **2021** | **2022** |
|---|---|---|---|
| *Нийт орлого* | 16.37 | 12.49 | 20.22 |
| *Хүүгийн зардал* | (4.72) | (2.80) | (3.95) |
| **ЦЭВЭР ОРЛОГО** | **11.65** | **9.69** | **16.27** |
| *Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал* | (2.36) | 0.73 | (1.44) |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО** | **9.29** | **10.42** | **14.83** |
| *Удирдлага болон ҮА-ны зардал* | (6.54) | (5.95) | (8.29) |
| **ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ** | **2.75** | **4.47** | **6.54** |
| *Татварын зардал* | (0.32) | (0.47) | (1.01) |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР АШИГ** | **2.43** | **4.00** | **5.53** |
| *Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)* | - | (0.11) | - |
| **ЦЭВЭР АШИГ** | **2.43** | **3.89** | **5.53** |

*Хүснэгт 3: Сүүлийн 3 жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн хураангуй*

## 2023 ОНЫ I УЛИРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУРААНГУЙ

2023 оны I улиралд ЛэндМН харилцагч нартаа нийт 219.0 тэрбум төгрөгийн дүнтэй 838.8 мянган зээлийг олгосон байна. Зээлийн голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад гэрээт харилцагчдын тоо **5.7%**, олгосон зээлийн тоо **70.6%**, зээлийн багц **118.9%**-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: ЛэндМН ББСБ 2023 оны I улирлын тайлан







ЛЭНДМН ББСБ ХХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
6039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ







*График 4: 2023 оны I-р улирлын үйл ажиллагааны үзүүлэлт*

## 2023 ОНЫ I УЛИРЛЫН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

Санхүү байдлын хураангуй тайлан (аудитлагдсан,тэрбум төгрөг)

| ХӨРӨНГӨ | 2021 | 2022 | 2023.I |
|---|---|---|---|
| *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө* | 4.90 | 5.22 | 4.25 |
| *Зээлийн багц (цэвэрээр)* | 32.43 | 69.59 | 75.85 |
| *Бусад хөрөнгө* | 0.77 | 1.06 | 0.39 |
| *Үндсэн хөрөнгө* | 0.76 | 0.59 | 0.52 |
| *Биет бус хөрөнгө* | 0.45 | 0.40 | 0.39 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **39.31** | **76.86** | **81.39** |
| **ӨР ТӨЛБӨР** | **16.64** | **49.79** | **50.68** |
| *Эх үүсвэр* | 15.17 | 45.96 | 46.61 |
| *Бусад өглөг* | 1.47 | 3.83 | 4.07 |
| **ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **22.66** | **27.07** | **30.72** |
| *Хувьцаат капитал* | 8.42 | 8.42 | 8.42 |
| *Бусад* | 0.05 | 0.05 | 0.05 |
| *Хоёрдогч өглөг* | 2.85 | 2.85 | 2.85 |
| *Хуримтлагдсан ашиг* | 11.34 | 15.75 | 19.40 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР, ӨӨРИЙН ХӨРӨНГӨ** | **39.31** | **76.86** | **81.39** |

СЭХ
2023 .08 р 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



Орлого, үр дүнгийн хураангуй тайлан (аудитлагдсан, тэрбум төгрөг)

| ОРЛОГЫН УЗҮҮЛЭЛТ | 2021 | 2022 | 2023.I |
|---|---|---|---|
| *Нийт орлого* | 12.49 | 20.22 | 9.69 |
| *Хүүгийн зардал* | (2.80) | (3.95) | (2.05) |
| **ЦЭВЭР ОРЛОГО** | **9.69** | **16.27** | **7.64** |
| *Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал* | 0.73 | (1.44) | (0.68) |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР ОРЛОГО** | **10.42** | **14.83** | **6.96** |
| *Удирдлага болон ҮА-ны зардал* | (5.95) | (8.29) | (2.44) |
| **ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ** | **4.47** | **6.54** | **4.52** |
| *Татварын зардал* | (0.47) | (1.01) | (0.87) |
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР АШИГ** | **4.00** | **5.53** | **4.52** |
| *Татварын дараах алдагдал (Зогсоосон үйл ажиллагаа)* | (0.11) | - | - |
| **ЦЭВЭР АШИГ** | **3.89** | **5.53** | **3.65** |

*Хүснэгт 4: 2023 оны I улирлын байдлаарх санхүүгийн тайлангийн хураангуй*

## 2023 ОНЫ I УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

### ХУРААНГУЙ

ЛэндМН ББСБ ХК болон түүний охин компанид (цаашид “Групп” гэх)-ийн 2023 оны 03 сарын 31-ээрх Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан бусад нэмэлт тайлбар тодруулгыг багтаасан санхүүгийн тайланд “Нийслэл-Аудит” ХХК аудит хийж гүйцэтгэлээ.

Бид энэхүү аудитыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв. Бидний үзэж байгаагаар 2023 оны 03 сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлангаа Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын хувьд үнэн зөв толилуулсан байна гэж дүгнэжээ.

Хараат бус аудиторын тайлангийн дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.

## 1.5 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БАЙГУУЛСАН ГЭРЭЭ ХЭЛЦЭЛ

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд дор дурдсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан бөгөөд бондын танилцуулга гаргах өдрийн байдлаар эдгээр гэрээтэй холбоотой ямар нэгэн зөрчил маргаан гаргаагүй болно.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

СЗХ
2023 08 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

| Статус | Их хэмжээний хэлцэл | Сонирхлын зөрчилтэй хэлцэл |
|---|---|---|
| Нийт хийгдсэн хэлцлийн тоо | 0 | 19 |
| Хэрэгжиж дууссан хэлцэл | 0 | 8 |
| Одоо хэрэгжиж буй хэлцэл | 0 | 11 |

*Хүснэгт 5: Их хэмжээний болон Сонирхоын зөрчилтэй хэлцэл*

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд 19 сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулсан бөгөөд эдгээрээс 11 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа, бусад нь хэрэгжиж дууссан.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд их хэмжээний хэлцэл байгуулаагүй болно.

ЛэндМН ББСБ ХК нь зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн болон шүүхийн шийдвэрээр гүйцэтгэх өр төлбөргүй болно.

Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь хуульд заасан журмын дагуу байгуулагдсан эсэх талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хууль зүйн үйлчилгээ үзүүлэгч "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн дүгнэлтээс үзнэ үү.

## 1.5.1 ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ

### Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:

Компани нь сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 19 хэлцэл хийсэн бөгөөд эдгээрээс 8 нь бүрэн хэрэгжиж дууссан, 11 хэлцэл нь хэрэгжиж байна. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журам болон Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна.

### Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:

Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8,000,000,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 400,000,000 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн нийт 21 гэрээ байгуулсан. Тэдгээрээс их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцлээс гадна

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257208

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

2021 оны 2 гэрээ, 2022 оны 12 гэрээ, 2023 оны 4 гэрээ буюу нийт 18 тус тус хэвийн хэрэгжиж байна. Бусад 3 гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан.

### Их хэмжээний хэлцлийн талаар:

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор хуульчилж заасан. Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлогдсон их хэмжээний хэлцэлд тооцогдох өндөр үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг байгуулах нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн байдал, үйл ажиллагаанд томоохон ач холбогдол бүхий нөлөө үзүүлдэг тул Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйлийн дагуу их хэмжээний хэлцлийг байгуулахад холбогдох этгээдийн зөвшөөрлийг заавал авсан байхыг шаарддагаараа онцлог хэлцэл юм.

Хуулийн зөвлөх нь Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 (гурав) жилийн балансын активыг тогтоохдоо Үнэт цаас гаргагчийн аудитын компаниар баталгаажсан санхүүгийн тайланг үндэслэн, доорх байдлаар тооцсон байна.

Эх сурвалж: Хууль зүйн дүгнэлт

| № | Санхүүгийн тайлан/ хэлцлийн хугацаа | Тухайн жилийн балансын актив (төгрөгөөр) | Тухайн жилийн балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1. | 2019 оны жилийн эцэс (2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш байгуулсан хэлцэл) | 58,100,953,000 | 14,525,238,250 |
| 2. | 2020 оны жилийн эцэс (2021 оны хэлцэл) | 40,735,460,000 | 10,183,865,000 |

СЗХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 3. | 2021 оны жилийн эцэс (2022 оны хэлцэл) | 39,306,562,000 | 9,826,640,500 |
| 4. | 2022 оны жилийн эцэс (2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх байгуулсан хэлцэл) | 76,858,757,000 | 19,214,689,200 |

*Хүснэгт 5: Компанийн их хэмжээний хэлцэлийн хэмжээ*

**Илүү дэлгэрэнгүй мэдээллийг Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгчээс гаргасан “Хууль зүйн дүгнэлт”-ээс уншиж танилцана уу.**

## 1.6 НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2017 оны 12 сарын 01-ний өдрийн 17/02 тоот тогтоолоор “Ногдол ашгийн бодлого”-ыг баталж, тус бодлогод заасан нөхцөл, журмаар хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилж байна. Тухайлбал:

### Ногдол ашиг хуваарилах нөхцөл

- Нэг төрлийн нэгж хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна;
- Компанийн тухайн жилийн цэвэр ашгийг тухай жилийн дундаж өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаа 20 хувиас багагүй байх;
- Шийдвэр гаргах өдрийн байдлаарх зээлийн багцын чанар сайн байх;
- Ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх;
- Ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгө нь давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, татан буулгах үед төлөх дүн, компанийн дүрэмд заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээний нийлбэрээс илүү байх;
- Компани хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцаагаа эргүүлэн авах нөхцөл байдал үүссэн, өрийн хэрэгслээ эргүүлэн худалдан авах хугацаа болсон бол эдгээр үнэт цаасыг бүрэн эргүүлэн авсан, эсвэл бүрэн худалдан авахад шаардагдах хөрөнгөтэй байх;

### Ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр

- Ногдол ашиг хуваарилах шийдвэрийг тухайн жилийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитаар баталгаажуулснаас хойш 50 хоногийн дотор компанийн ТУЗ гаргана. ТУЗ шийдвэртээ нэг хувьцаанд ногдох ашгийн хэмжээ, ногдол ашиг олгох хэлбэр, ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр

УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206

RHINOS INVESTMENT ҮЦК

болон ногдол ашиг төлөх өдрийг тогтоож, энэ талаар хувьцаа эзэмшигчдийн хуралд зориулсан мэдээлэлтэй хамт мэдээлэл хүргүүлнэ.

- Ногдол ашгийг бэлэн мөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасны хэлбэрээр төлж болно.
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг нийтэд мэдээлж, хувийг Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржийн мэдээллийн нэгдсэн санд хүргүүлнэ.
- Жилийн тайланд тусгах мэдээлэлд ногдол ашгийн хэмжээг тодорхойлсон үндэслэл, төлөх журмын талаар бүрэн тусгасан байх бөгөөд ногдол ашиг хуваарилахгүйгээр шийдвэрлэсэн бол түүний үндэслэлийг энэ журмын дагуу тайлбарласан байна.
- Компани ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн бол энэ тухайгаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд заавал тайлагнах бөгөөд тайлбартаа ногдол ашиг хуваарилах боломжгүй байдалд хүрсэн шалтгаан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тайлбар зэргийг тусгасан байна.

## Ногдол ашиг хуваарилах, тайлагнах

- Ногдол ашиг төлөх хэлбэр, олгох хугацаа, журам нь хувьцаа эзэмшигчдэд аль болох тохиромжтой байна.
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ногдол ашгийг ТУЗ-өөс тогтоосон хугацаанд төлөөгүйгээс компанид учирсан хохирлыг гүйцэтгэх захирал болон холбогдох бусад албан тушаалтнууд хариуцна.
- Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэр гарсан бол төлбөл зохих ногдол ашгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдэд төлөх өр болгон нягтлан бодох бүртгэлд тусгах бөгөөд ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын эцэст ногдол ашгаа аваагүй байгаа хувьцаа эзэмшигч бүрийн нэрээр тусгайлан өглөгийн бүртгэл хөтөлнө. Ногдол ашгийг "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хувьцаа эзэмшигч бүрийн дансанд шилжүүлэх бодлого баримтална.
- Ногдол ашиг хуваарилж эхэлсэн улирлын санхүүгийн тайлан гаргах үед "Ногдол ашгийн хуваарилалтын тайлан"-г гаргаж Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн жилийн ээлжит хуралд өмнөх жилийн ногдол ашиг хуваарилалтын тайланг танилцуулна.

### Ногдол ашиг хуваарилсан тухай

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан "Ногдол ашгийн бодлого"-ын хүрээнд 2018-2023 оны хооронд жилийн эцсийн цэвэр ашгаас жил бүр дараах байдлаар ногдол ашиг хуваарилж, хувьцаа эзэмшигчдийнхээ өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллаж байна.

| Ногдол ашиг | 2019 он | 2020 он | 2021 он | 2022 он | 2023 он |
|---|---|---|---|---|---|
| *Ногдол ашиг хуваарилсан нийт дүн* | 800,000,000 төгрөг | 1,200,000,000 төгрөг | 447,843,215 төгрөг | 1,108,952,525 төгрөг | 1,293,778,000 төгрөг |
| *Ногдол ашгийн эзлэх хувь хэмжээ* | 31.24% /2018 оны цэвэр ашгаас/ | 24.44% /2019 оны цэвэр ашгаас/ | 20% /2020 оны цэвэр ашгаас/ | 27.5% /2021 оны цэвэр ашгаас/ | 23.4% /2022 оны цэвэр ашгаас/ |
| *Нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг /төгрөг/* | 1.00 | 1.50 | 0.58 | 1.50 | 1.75 |
| *Суутгал* | Хувь хүн бол ХХОАТ, хуулийн этгээд бол ААНОАТ | | | | |
| *Олгогдох хэлбэр* | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр | Мөнгөн хэлбэрээр |
| *Олгогдсон огноо* | 2019.04.30 | 2020.04.30 | 2021.04.30 | 2022.04.30 | 2023.04.30 |

*Хүснэгт 6: Хуваарилсан ногдол ашиг*

СЗХ

lendmn

Үнэт
цаасны
танилцуулга

# II. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ

## 2.1 МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

### 2.1.1 Бодит сектор

Өнгөрсөн хугацаанд цар тахал, Оросын Холбооны Улс, Украйн Улсын дайны хямралаас үүдэн олон улсад амаргүй нөхцөл байдал учирч түүний үр дүнд улс орнуудын эдийн засгийн өсөлт удаашихрч хөл хорио, нийлүүлэлтийн гинжин хэлхээ тасалдахад хүрсэн нь нийлүүлэлтийн чанартай инфляцыг өдөөж олон улсад инфляцаас үүдэлтэй тогтворгүй байдал үргэлжилж байгаа нь тулгамдаад буй гол асуудал хэвээр байна. Олон Улсын Валютын Сан 2023 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөллийг 0.1 нэгж хувиар бууруулан 2.8 хувь болгосон байна. Дэлхийн эдийн засгийн өсөлт 2023 онд өмнө нь тооцоолж байснаас илүү удаашрна гэж Олон Улсын Валютын Сан мэдээлсэн байна.

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




*График 5: Монгол Улсын ДНБ болон эдийн засгийн өсөлт /2010-2022/*

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

| | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| Хөдөө аж ахуй | 0.72 | 0.79 | (0.83) | 1.70 |
| Уул уурхай | (0.25) | (1.44) | 0.12 | (1.60) |
| Боловсруулах үйлдвэрлэл | 0.30 | 0.27 | (0.07) | 0.50 |
| Цахилгаан | 0.15 | 0.05 | 0.22 | 0.10 |
| Барилга | 0.71 | (0.13) | (0.92) | 0.20 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Бөөний, жижиглэн худалдаа | 1.19 | (1.43) | 0.61 | 0.90 |
| Тээвэр | 0.25 | (1.01) | (0.35) | 0.10 |
| Мэдээлэл, холбоо | 0.24 | 0.11 | 0.47 | 0.20 |
| Бүтээгдэхүүний цэвэр татвар | 1.04 | (1.06) | 1.31 | 1.40 |
| Санхүү, даатгалын үйл ажиллагаа | 0.26 | 0.06 | 0.47 | 0.10 |
| Үйлчилгээ | 1.01 | (0.78) | 0.61 | 1.20 |
| **Нийт Э/З-ийн өсөлт** | **5.60** | **(4.56)** | **1.64** | **4.80** |

*Хүснэгт 7: Эдийн засгийн өсөлт 2017-2021 /Салбарын бүтцээр/*

- Сүүлийн 5 жилд бий болсон эдийн засгийн өсөлтийг бий болгож буй салбар тус бүрээр нь ангилан харвал 2022 оны байдлаар 4.80% ийн өсөлтийн дийлэнх хэсгийг хөдөө аж ахуйн салбар 1.70%, үйлчилгээний салбар 1.20% , бөөний, жижиглэн худалдааны салбар 0.9% болон бүтээгдэхүүний цэвэр татвар 1.40% тус тус нөлөөлсөн байгаа бол үндсэн салбар болох уул уурхайн салбар нь эдийн засгийн өсөлтийг 1.60%-иар бууруулсан байна. 2022 оны байдлаар Covid-19 цар тахалтай холбоотой хөл хорио дуусаж Монгол Улсын эдийн засгийн голлох дээрх салбарууд (уул уурхайн олборлолтын салбараас бусад) өсөлт үзүүлсэн байна.

*Эх сурвалж: ОУ-ын Э/З-ийн институт*

- Олон улсын эдийн засаг, судалгааны институтийн тооцоолсноор манай орны энэ оны эдийн засгийн төсөөллийг 4.5% болгон бууруулсан ба энэ нь өмнөх оны 4.8%-ийн гүйцэтгэлтэй харьцуулахад 0.3%-иар бууруулсан төсөөлөл юм.

- 2023 оны 4-р сарын 4-ний өдөр хийсэн Азийн Хөгжлийн Банкны мэдэгдлээр 2023 оны эдийн засгийн төсөөллийг 5.4% болгон өсгөсөн байна. Үүнд БНХАУ-ын эдийн засаг дахин нээлттэй болж, ашигт малтмалын бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэн, дотоодын эргэлт сайжирна гэсэн хүлээлттэй байна.




*График 6: Эдийн засгийн төсөөлөл 2023 он/*

- Монгол Улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг Азийн Хөгжлийн Банкнаас 6.1% хэмээн төсөөлсөн байна. Үүнд БНХАУ-тай худалдаа явуулдаг томоохон боомтуудын үйл ажиллагаа, ОХУ болон

2023 .08. 11 он сар өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

Украйн улсын хоорондын мөргөлдөөн зэрэг сөрөг нөлөө байгаа хэдий ч Экспортын эрэлт байгаа нь томоохон нөлөө үзүүлэх юм.

- Харин Монгол Улсын 2023 оны инфляцын төсөөллийг 10.9%-д хүрэхээр төсөөлсөн ба бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт доголдох, гадаад худалдаа тасалдах эрсдэл буурах хандлагатай байгааг онцолсон.
- Мөн Монгол банкны хувьд нийлүүлэлтийн гаралтай инфляцтай бодлогын хүүг өсгөх байдлаар арга хэмжээ авч үе шаттайгаар нэмэгдүүлсэн хэдий ч хамгийн сүүлийн шийдвэрээр хэвээр хадгаллаа. /2023 оны 3-р сарын 15-ны өдөр Монгол Банк бодлогын хүүг 13% болгон хэвээр хадгалсан/

| Монгол Улсын Эдийн засгийн төсөөлөл /2022 он/ | |
|---|---|
| Дэлхийн Банк | 5.2% |
| Азийн Хөгжлийн Банк | 5.4% |
| Олон улсын валютын сан | 4.5% |
| Монгол Банк | 4.7% |
| **Дундаж** | **4.95%** |

*Зураг 12:Эдийн засгийн*

## 2.1.2 Гадаад сектор

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




*График 7: Экспорт, Импорт болон төлбөрийн тэнцэл*

2023 оны I улирлын байдлаар Монгол Улсын экспортын хэмжээ 3.8 тэрбум ам доллар, импорт 1.9 тэрбум долларт хүрч цэвэр экспорт 1.8 тэрбум ам доллар хүрсэн байна. Covid-19 цар тахлын нөлөө дуусч хөл хорио тавигдсанаар нийлүүлэлтийн систем аажмаар сэргэж биет бараа бүтээгдэхүүний үнэ дэлхий зах зээл дээр өсч инфляц эрчимжиж байна. Манай орны хувьд экспортын голлох бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал, нүүрс, алт, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний ханш өсч БНХАУ цар тахлын хөл хориог сулруулж нээлттэй болсноор худалдааны тэнцэл сэргэсэн үзүүлэлттэй байна.

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




*График 8: Экспортын гол нэр төрлийн бараа /тэрбум $ 2018 – 2023.I улирал/*

2022 онд нийт экспортын орлогын тал болох 6.7 тэрбум ам доллар нүүрсний экспорт дангаар эзэлж байна. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын зүгээс "Эрдэнэс Таван толгой" ТӨХК дээр онцгой дэглэм тогтоосонтой холбоотой нүүрсний экспорт өнгөрсөн жилээс 3 дахин өндөр үзүүлэлттэй гарахад нөлөөлсөн байна. Онцгой дэглэмийн хугацааг сунгаснаар 2023 онд энэхүү үзүүлэлт хэвээр хадгалагдах төлөвтэй байна. 2023 оны I улиралд Оюу толгойн гүний уурхайн олборлолтыг эхлүүлсэн нь зэсийн экспортыг нэмэгдүүлэн Гадаад худалдааны тэнцэл болон ГВАН-д эерэг нөлөө үзүүлнэ гэсэн хүлээлттэй байна.

## 2.1.3 Төсвийн сектор

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




*График 9: Төсвийн орлого, зардал, тэнцэл /2017 - 2022 он/*

2022 оны байдлаар Монгол Улсын нийт төсвийн орлого 17.20 их наяд төгрөг, зардал 18.18 их наяд төгрөгт хүрч төсвийн алдагдал 0.98 их наяд төгрөгт хүрсэн байна. 2020 онд дэлхий нийтийг хамарсан COVID-19 цар тахал нь төсвийн алдагдал нэмэгдэх суурь шалтгаан болсон. 2022 онд экспортын гарц нэмэгдэж тэр дундаа

нүүрсний экспорт нэмэгдсэн нь татварыг орлогыг нэмэгдүүлэх томоохон нөлөө үзүүлсэн байна. Мөн далд эдийн засгийн нөлөөг бууруулах зарим арга хэмжээ болон Ханшийн өсөлт нь татварын орлого нэмэгдэхэд түлхэц үзүүлсэн байна. Гадаад худалдаа идэвхжиж БНХАУ нь хилээ бүрэн нээснээр Импортын гол нэр төрлийн барааны эргэлт сайжирч гаалийн орлого нэмэгдэхэд нөлөө үзүүлсэн байна. Засгийн газар цаашид Төсвийн алдагдлыг хамгийн бага байлгах, нэмэлт шаардлагагүй зардлыг танах, ТӨХК-н үйл ажиллагаанд төрийн оролцоог багасгах бодлого баримталж үе шаттайгаар төсвийн алдагдлыг 0 болгох боломжтой талаар мэдэгдэж байна.

### 2.1.4 Инфляц

*Эх сурвалж: ОУ-ын Э/З-ийн институт*




*График 9:Инфляцийн түвшин 2018-2023.I*

2023 оны I-р улирлын байдлаар улсын инфляци 12.2%-д хүрч Монгол банкны зорилтоос 6.2+/-2%-иар өндөр түвшинд байна. Инфляцын суурь шалтгаан нь нийлүүлэлтийн гинжин хэлхээ саатаж, импортын дийлэнх хувийг бий болгодог бараа бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өсч байгаатай холбоотой юм.

Инфляцыг бүрэлдэхүүнээр задалж харвал хүнсний бараа, ундаа, ус, хувцас бөс бараа, орон сууц цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт гол нөлөө үзүүлсэн байна. Цаашид инфляци тогтвортой төвшинд очих нь хил гааль болон олон улсад өрнөөд буй хямрал, улс төрийн тодорхойгүй байдлаас хамааралтай байна.

Олон улсын байгууллагуудын Монгол Улсын 2023 оны инфляцыг дунджаар 11.5%-иар төсөөлж байгаа ба 2023 онд эхний улирлын байдлаарх 12.2%-ийн инфляц энэ төвшиндөө тогтворжих магадлалтай юм.

2022 оны 4-р сарын 4-ний АХБ-ны мэдэгдлээр инфляц дунд хугацаанд төгрөгийн гадаад валюттай харьцах ханш сулрах болон дотоод эрэлт

нэмэгдэх нөлөөгөөр инфляц төв банкны зорилтот түвшин болох 6 хувиас өндөр байх төсөөлөлтэй байна.

### 2.1.5 Төлбөрийн тэнцэл

*Эх сурвалж: Монгол Банк*




*График 10: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /их наяд ₮/ болон ДНБ-д эзлэх хувь*

Монгол улсын төлбөрийн тэнцэл 2023 оны I-р улирлын байдлаар 79.6 сая ам.долларын ашигтай гарсан байна. Үүнээс урсгал данс 237.5 сая ам.долларын ашигтай, хөрөнгийн данс 22.3 сая ам.долларын ашигтай, санхүүгийн данс 3.97 сая ам.долларын ашигтай гарсан байна.

### 2.1.6 Валютын Ханш

2022 онд Монгол улсын гадаад валютын албан нөөц 3,399.6 сая ам.долларт хүрч импортын 4-5 сарын хэрэглээтэй тэнцэж байсан бөгөөд Монгол Улсын экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн дэлхийн зах зээл дээрх ханш өсч, Монгол Улсын засгийн газрын зүгээс нүүрсний экспортыг нэмэгдүүлэх замаар ГВАН-ийг 2022 оны 8-н сарын хамгийн доод түвшин болох 2.6 тэрбум ам.доллароос 36.9%-иар нэмэгдүүлэн 3.6 тэрбум ам долларт хүргэснээр валютын ханшийг буулгалаа.

*Эх сурвалж: Монгол банк*




*График 11: Төгрөгтэй харьцах ам долларын ханш болон ГВАН-ын харьцуулалт /2010-2023.I/*

2022 оны II улирлыг 2023 оны эхний улиралтай харьцуулахад төгрөг ам долларын эсрэг 12.8%-иар суларч 1 ам.доллар 3,524.98₮ хүрсэн байна. Ийнхүү ам.долларын ханш суларсан нь олон улсад худалдааны эргэлт саарах, иргэд олон нийтийн хүлээлт, ОХУ болон Украйн хоорондын мөргөлдөөнөөс үүдэлтэй нөлөөлөл, олон улсад бий болоод буй инфляцийн өндөр төвшин нөлөөлсөн байна.

Монгол улсын гадаад валютын албан нөөц 2023 оны I-р улирлын байдлаар 3,438.46 сая ам.долларт хүрч импортын 5-6 сарын хэрэгцээтэй тэнцэж байна.

## 2.1.7 ББСБ-ын зах зээл

Монгол Улсын хэмжээнд 2023 оны I-р улирлын байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны тусгай зөвшөөрөлтэй 514 банк бус санхүүгийн байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс 4.8 хувь нь гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ, финтек шийдэл бүхий ББСБ-уудын тоо 39 хүрээд байна.

ББСБ-уудын харилцагчдын тоо давхардсан байдлаар 2023 оны эхний улиралд 3.8 саяд хүрсэн ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 16.8 хувиар

буурсан байна. Үүнээс зээлдэгчдийн тоо нь 2023 оны эхний улирлын байдлаар 1.3 сая буюу өмнөх оны мөн үеэс 10.8 хувь буурсан дүнтэй байна.

ББСБ-уудын нийт активын хэмжээ 2022 оны эхний улиралд 2.9 их наяд төгрөгтэй тэнцэж байсан бол 2023 оны эхний улирлын байдлаар 24.5 хувиар өсч 3.7 их наяд төгрөгт хүрч Банкны салбарын 8.0%-тай тэнцэж байна. ББСБ-уудын нийт актив Монгол Улсын ДНБ-ийн 7 хувьтай тэнцэхүйц хэмжээтэй байна.

Сүүлийн 10 жилийн хугацаанд банкны салбарын нийт зээл жилд дунджаар 15.3 хувь өссөн бол ББСБ-ын олгосон зээлийн үлдэгдэл 32.5 хувь өссөн ба үүнд ББСБ-ын зээлийн цахим үйлчилгээ, финтек шийдэл нэвтэрч эхлсэнтэй холбогдуулан иргэдийн хэрэглээний зээл өссөн болон Ковид-19 цар тахлын нөлөөгөөр 2020 онд банкны салбарын иргэд болон байгууллагад олгосон зээл буурсан зэрэг нөхцөл байдал нөлөөлсөн байна.

*Эх сурвалж: Үндэсний Статистикын Хороо, Санхүүгийн Зохицуулах Хороо*




*График 12: Банк болон ББСБ-уудын зээлийн өсөлтийн хувь*

2013-2023 оны хооронд банкны салбарын нийт актив дунджаар 16.6 хувь өсч 2023 оны эхний улирлын байдлаар 46.4 их наяд төгрөгт хүрсэн бол ББСБ-уудын нийт актив жилд дунджаар 30.1%-иар өсч улмаар 2023 оны I улиралд 3.7 их наяд төгрөгт хүрээд байна.

*Эх сурвалж: Үндэсний Статистикын Хороо, Санхүүгийн Зохицуулах Хороо*




*График 13: Банк болон ББСБ-уудын активын өсөлтийн хувь*

Нийт зээлийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 24.5% буюу 570.4 тэрбум төгрөгөөр өсч 2023 оны I улирлын байдлаар 2,864.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 165.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,698.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй гарсан байна. Нийт зээлийн үлдэгдлийн 87.6 хувийг буюу 2.5 их наяд төгрөгийг хэвийн зээл, 4.4 хувийг буюу 125.9 тэрбум төгрөгийг анхаарал хандуулах зээл, 8.0 хувийг буюу 228.0 тэрбум төгрөг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна.

2023 оны I улирлын байдлаар эдгээр ББСБ-ууд зөвхөн цахим зээлийн (аппликэйшнээр дамжуулан) 985,521 зээлдэгчийн 551.8 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байгаа нь нийт зээлдэгчийн 76.0%, нийт зээлийн үлдэгдлийн 19.3%-ийг бүрдүүлж байна.

## 2.2 ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж, ҮЦХ*




*График 14: Хөрөнгийн зах зээлийн үнэлгээ /их наяд ₮/ болон ДНБ-д эзлэх хувь*

Монгол улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2022 оны эцсийн байдлаар 6.89 их наяд төгрөгт хүрч энэ нь 2022 оны ДНБ-ийн 13.0%-ийг эзэлж байна.

Дотоодын санхүүгийн бүтээгдэхүүнүүдийн хувьд арилжааны банкинд харилцах, хадгаламж хэлбэрээр 27.5 их наяд төгрөг байршиж байгаа буюу ДНБ-ны 52.2%-г эзэлж байгаа нь төвлөрөл өндөр байна.

*Эх сурвалж: ОУ-ын Э/З-ийн институт*

2022 оны 5-р сарын байдлаар хөрөнгийн зах дээр нийтдээ 433.5 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 31%-ийг бүрдүүлээд байна.

Сүүлийн жилүүдэд хөрөнгийн зах зээл дээрх арилжаа идэвхжиж олон компаниуд IPO, FPO, нээлттэй, хаалттай бонд болон бусад төрлөөр санхүүжилт татаж хөрөнгийн зах зээлд боломж байгааг таниулж байна.




*График 15: Арилжааны дүн /2017-*

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
№
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

*Эх сурвалж: ОУ-ын Э/З-ийн институт*




*График 15: Анхдагч зах зээлийн арилжаа /тэрбум төгрөг, 2021 он/*

2021 онд хөрөнгийн зах зээлд 1.4 их наяд төгрөгийн арилжаа хийгдэж түүхэн дээд түвшинд хүрээд байсан ба үүний 846.3 тэрбум төгрөгийн арилжаа нь анхдагч зах зээл дээр явагдаж компаниуд дээрх хэмжээгээр шинээр эх үүсвэр татан төвлөрүүлсэн байна. Энэ нь арилжааны 60%-ийг эзэлж байна.

Анхдагч зах зээлд шинээр эх үүсвэр татан төвлөрүүлсэн дүнг санхүүгийн бүтээгдэхүүний ангиллаар илэрхийлбэл хамгийн өндөр буюу 85%-ийг бонд эзэлж байгаа бөгөөд энэ нь нийт арилжааны 51%-ийг эзэлж байна. Үүнд хөрөнгийн зах зээл дээр хамгийн олон удаа нээлттэй бонд гаргасан компани нь ЛэндМН ББСБ ХК бөгөөд 2020 онд анхны Финтек компанийн бондыг гаргаж байсан бөгөөд үүнээс хойш нийт 3 удаа нээлттэй бонд гаргаж, бондын төлбөрийг хуваарийн дагуу төлж ажиллаж байна. Бусад бүтээгдэхүүний хувьд дээрх үр дүнг үзүүлсэн байна.

Дээрх үр дүнгээс харахад хөрөнгө оруулагчдын хувьд харьцангуй тогтмол өгөөжтэй, 1-2 жилийн хугацаатай, барьцаатай хөрөнгө оруулалтын хэрэгсэл эрэлт өндөр байгааг харж болох юм.

*Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж*

| Тэрбум ₮ | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|---|
| Анхдагч зах зээл | **637.5** | **31.4** | **42.4** | **15.1** | **846.3** | **360.51** |
| Хувьцаа | 1.3 | 31.4 | 42.4 | 5.3 | 74.7 | 175.79 |
| ХБҮЦ | - | - | - | - | 4 | 85 |
| ЗГҮЦ | 630.2 | - | - | - | - | - |
| Компанийн бонд | 6 | - | - | 5 | 720.1 | 99.72 |
| ХОС | - | - | - | 4.8 | 47.5 | - |

Лэндмн ББСБ
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTSK LLC

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Хоёрдогч зах зээл** | **221.6** | **212.7** | **100.8** | **50.3** | **568** | **220.01** |
| Хувьцаа | 75.1 | 178.6 | 91.1 | 48.6 | 230.2 | 167.57 |
| ХБҮЦ | - | - | - | - | 0.2 | 13.93 |
| ЗГҮЦ | 142.3 | 33.5 | 9.7 | 0.6 | - | - |
| Компанийн бонд | 4.2 | 0.6 | - | 0.8 | 328.2 | 34.34 |
| ХОС | - | - | - | 0.3 | 9.3 | 4.17 |
| Нийт | **859.1** | **244.1** | **143.2** | **65.3** | **1,414.20** | **580.52** |

*Хүснэгт 8: Эдийн засгийн үзүүлэлт 2018-2022 /Салбарын бүтцээр/*

Сүүлийн 6 жилд бий болсон хөрөнгийн зах зээл дээрх хоёр удаагийн том өсөлт үзүүлсэн жил болох 2017 он болон 2021 онд үнэт цаасны арилжааны дийлэнх хэсгийг тогтмол өгөөжтэй бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

Тухайлбал 2017 оны 859.1 тэрбум төгрөгийн арилжааны 90%-ийг ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч арилжаа бүрдүүлсэн. Харин 2021 оны хувьд 1.4 их наяд төгрөгийн арилжааны 74%-ийг компанийн бондын арилжаа бий болгосон байна. Харин 2022 онд тогтмол хүүтэй бүтээгдэхүүн болох компанийн бонд, ХБҮЦ нийт анхдагч зах зээлийн арилжааны 51%-ийг бүрдүүлсэн.

2022 онд хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа 175.79 тэрбум төгрөгт хүрснээс 82%-ийг Голомт банк болон Төрийн банкны IPO бүрдүүлсэн байна. Үүнээс дүгнэхэд хөрөнгө оруулагчид өмнөх жилүүдэд тогтмол өгөөжтэй, эрсдэл багатай хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн болох компанийн бонд, ХБҮЦ-ны арилжаанд идэвхтэй оролцдог байсан бол 2022 онд энэхүү хандлага өөрчлөгдөн компанийн хувьцаанд хөрөнгө оруулах хандлагатай болсон байна.

## 2.3 ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

### 2.3.1 ДОТООД ОРЧНЫ ӨРСӨЛДӨГЧИЙН СУДАЛГАА

Монгол Улсын хувьд эдийн засаг экспорт, уул уурхайн салбарын сэргэлт, түүний тээвэр болон бусад салбаруудад үзүүлж буй эерэг нөлөөгөөр 2022 оны өсөлт 4.8%-тай байсан бол 2023 онд 5.4%, 2024 онд 6.1%-иар тус тус өсөх төлөвтэй байна гэж АХБ мэдээлсэн. Гадаад эрсдэл, тодорхой бус байдал өндөр байгаа өнөөгийн нөхцөлд Монгол банкнаас бодлогын хүүг 13 хувьд

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02
СЗХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ
ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5928754 1118267206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ҮЦК

СЗХ
2023 оны 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



хэвээр нь хадгалахаар 2023 оны 03 сарын 15-ны өдрийн хурлаар шийдвэрлэсэн. 2023 оны I улирлын байдлаар банкны системийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 5.2%-иар нэмэгдэж 23.01 их наяд төгрөгт хүрсэн байна.

2017-2022 онд ББСБ салбарын нийт активын CAGR 38%-тай байсан байна. ББСБ-ийн салбарын активын өсөлт 2023 оны I улирлын байдлаар 24.5% байсан бол Үнэт цаас гаргагчийн активын өсөлт 100%-д хүрсэн байна.

Эх сурвалж: СЗХ ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэл




*График 16: Актив болон нийт зээлийн  өсөлтийн хувь*

Банк бус санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 24.9%-иар өсч 2023 оны I улирлын байдлаар 2,864.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүнд 165.4 тэрбум төгрөгийн эрсдэлийн сан байгуулж, 2,698.6 тэрбум төгрөгийн цэвэр зээлийн үлдэгдэлтэй байна.

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлтийг салбарын үзүүлэлттэй харьцуулахад 2023 оны I улиралд нийт активийн өсөлтийн хувь салбарын үзүүлэлтээс 4 дахин, нийт зээлийн өсөлтийн хувь 4.8 дахин илүү байна.

Харин финтек зээлийн үлдэгдэл 2023 оны I улиралд 551.8 тэрбум төгрөгт хүрч оны эцсээс 19.7%-иар харин 2021 оны эцэстэй харьцуулахад 79.1%-иар өссөн нь хэрэглэгчид санхүүгийн хэрэгцээ шаардлагыг хялбараар шийдэх шийдлийг сонгох хандлагатай болсоныг илэрхийлж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5339754 1118267208



RHINOS INVESTMENT ҮЦК

СЗХ 2023.08.11
2023-07-28 БҮРТГЭВ-02

Эх сурвалж: СЗХ ББСБ-уудын санхүүгийн тайлангийн нэгтгэл




2023 оны I улирлын байдлаар ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үлдэгдэл финтек салбарын 14.1%-ийг бүрдүүлж байна. Финтек салбарын зээлийн үлдэгдэл сүүлийн жилүүдэд хурдацтай өсч байгаа ба салбарын харилцагчдын хэрэгцээ шаардлага, бүтцийн өөрчлөлт, финтекийн үйлчилгээний тэлэлтээс харахад ирэх жилүүдэд дээрх өсөлтийн хурд хэвээр хадгалагдах төлөвтэй байна.

*График 17: Финтекийн зээлийн үлдэгдэлд эзлэх хувь /2023.I/*

Үнэт цаас гаргагчийн хувьд 2023 онд технологийн давуу байдал болон аппликейшныг илүү ойлгомжтой хялбар болгох замаар зээлийн үйлчилгээг хурдан шуурхай, уян хатан болгож хүүгийн урамшуулалт хөтөлбөрийг үргэлжлүүлэн харилцагчидтайгаа урт хугацааны хамтын ажиллагаагаа улам бэхжүүлж ажиллахаар төлөвлөж байна.

2017 онд анх ЛэндМН аппликейшныг олон нийтэд танилцуулснаас хойш энэхүү салбарын өрсөлдөөн ширүүсч 2023 оны I улирлын байдлаар технологид суурилан санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй ББСБ-ын тоо 39 хүрч өмнөх оны мөн үеэс 22%-иар өссөн үзүүлэлттэй байна.

СЗХ-д бүртгэлтэй финтек компанийн тоо нь хэр ирээдүйтэй салбарыг онилон харж зах зээлд түүчээлэн нэвтрүүлж чадсан байна вэ гэдгийг харуулж байна. Мөн түүнчлэн өрсөлдөгчдийн цар хүрээ нэмэгдэх нь хэрэглэгчдэд цаашид өндөр өрсөлдөөн дундаас чанартай үйлчилгээг хүртэх, улам илүү давуу талуудыг олж авах таатай боломжуудыг нээж өгч байна.

Цахим зээлийн үйлчилгээ үзүүлж буй аппликейшнуудын Playstore-оос таталтын тоогоор Pocket, LendMN, Sono, Monpay, Ard гэх зээлийн аппликейшнууд тэргүүлж байна. Эдгээр аппликейшнууд нь үйл ажиллагаа явуулан олон нийтэд аль хэдийн танигдсан боловч зах зээлд шинээр түрэн

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ №
2023-07-28 БҮРТГЭВ-02

орж ирж буй цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгч нар өрсөлдөөнийг илүү хүчтэй болгож байна.

**Өрсөлдөөний үнэлгээгээр ЛэндМН ББСБ ХК-ийн өрсөлдөх чадварыг дурдвал:**

**Хувь хүнд тохирсон үйлчилгээ:** Хиймэл оюун ухаан (AI) нь хэрэглэгчдийн зээлийн үнэлгээг тооцоолж, зээлдэгчийн төлбөрийн чадварт таарсан зээлийг олгоно.

**Үнэнч хэрэглэгчид зориулсан урамшууллын систем:** Урамшууллын систем нь хэрэглэгчдэд илүү их зээлийг бага шимтгэлээр авах боломжийг олгодог. Тиймээс шимтгэл бууруулалт нь дахин зээл авахад хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмж, зээлээ хугацаанд нь төлөх хандлагыг дэмжиж, санхүүгийн сахилга батад суралцуулж байна.

**Зардлын хэмнэлт**: Финтек компанийн хувьд нэг харилцагчид ногдох үйл ажиллагааны зардал нь банктай болон бусад банк бус санхүүгийн байгууллагатай харьцуулахад бага байна. ЛэндМН ББСБ ХК-ийн зэргэлдээ компани буюу АНД Солюшнс Пти.Лтд нь систем хөгжүүлэлтийг хийдэг ба зээл олголт бүрт төлөх үйлчилгээний хөлс нь тогтмол байдгаараа давуу талтай.

**Онцгой нөөц:** Хиймэл оюун ухаан /AI/ ашиглан харилцагч тус бүрийн зээлжих зэрэглэлийг тогтоож, оновчтой стратегийн хүрээнд чанаргүй зээл нь салбарын дунгээс бага байна. Компани нь зах зээлд хүчтэй хоногшуулалт хийж байгаа ба өрсөлдөгч гарч ирэхээс өмнө үнэнч хэрэглэгчдийг татаж чадсан гэдгээрээ давуу талтай байна.

## ФИНТЕКИЙН ЧИГ ХАНДЛАГА ОЛОН УЛСАД

Санхүүгийн үйлчилгээнд дижитал технологи ашиглах явдал нь санхүүгийн үйлчилгээний ирээдүйг тодорхойлж байгаа өнөө цагт финтек компаниуд төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, даатгал болон бусад санхүүгийн бүтээгдэхүүнд технологийн дэвшлийг нэвтрүүлэн ажиллаж байна. Санхүүгийн үйлчилгээ болон мөнгийг цахимжуулснаар харилцагчдад тэгш боломжийг бүрдүүлж байгаагаас гадна эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байна.

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ



RHINOS INVESTMENT ҮЦК

Эх сурвалж: Дэлхий банк: Финтек болон ирээдүйн санхүү судалгааны тайлан




*Зураг 13: Ковид 19-ийн үеийн ОУ-ын зээлийн өсөлт*

Дэлхийн банкны 2022 онд хийгдсэн Финтек болон Ирээдүйн Санхүү гэх судалгаанд дурдсанаар "Финтекийн зээлийн үйлчилгээ нь төлбөр тооцооны хөгжлийн хурдыг гүйцээгүй хэдий ч ач холбогдол нь өссөөр байна. 2020 оны эцсээр дэлхийн финтек салбарын зээлийн үлдэгдэл 125 тэрбум ам.доллар байсан бол банкны салбарын зээл 637 тэрбум ам.долларт хүрсэн ба салбарын судалгаагаагаар финтек салбарийн зээлийн үйлчилгээ 2023 онд 4.9 их наяд ам.долларт хүрнэ" гэсэн байна.

Финтек салбарт хийгдсэн санхүүжилтийг хамгийн өндөр байсан 2021 оны IV улирлыг 2022 оны II улиралтай харьцуулахад 39%-иар буурч, өмнөх таван улиралтай харьцуулахад хамгийн доод түвшинд хүрсэн байна. Харин 2022 оны II улиралд дэлхий дахинд хамгийн их хөрөнгө оруулалт буюу 21.5 тэрбум ам.долларыг татаж чадсан байна.

Олон улсад Ковид 19 цах тахлаас үүдэлтэй хөл хорионы үеэр дижитал санхүүгийн үйлчилгээг харилцагч төвтэй болгож чадсанаар одоогийн байдлаар АНУ-ын хүн амын 90% нь финтекийн үйлчилгээг ашиглаж байна.

Финтекийн зах зээлийн хэмжээ 2030 онд 698.48 тэрбум ам.долларт хүрэх буюу 2020 онтой харьцуулахад даруй 6 дахин өснө гэж шинжээчид үзэж байна. Финтек старт-апууд болон олонд танигдсан компаниуд дээрх өөрчлөлттэй холбоотойгоор өөрсдийн үйл ажиллагааг өөрчлөн зах зээлтэй хөл нийлүүлэн алхаж байна.

Ирээдүйн финтекийн трендүүд

- Нээлттэй банк
- BNPL
- Хууль зүйн технологи
- Хиймэл оюун ухаан
- Блокчэйн

СЗХ
2023 .08.11 өдөр
БҮРТГЭВ

2023 -07- 28
БҮРТГЭЭ-02

Statista компанийн судалгаагаар 2024 он гэхэд 63.8 сая хүн нээлттэй банкны үйлчилгээг ашиглана гэж таамагласан ба энэ нь 2020 оноос ойролцоогоор 5 дахин өссөн үзүүлэлт юм.

Нээлттэй банкны зах зээлийн хэмжээ 2021 онд 15.13 тэрбум ам.доллар байсан ба энэхүү үзүүлэлт нь жилд 25.7%-иар өсч 2025 онд 37.77 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн тооцоолoлтой байна.

*Эх сурвалж: Tech Magic (2023 оны Финтек тренд)*




*Зураг 14: Финтект хэрэглэгчдийн датаг ашиглаж буй аргууд*

McKinsey & Company-ийн мэдэгдсэнээр нээлттэй банкны үйл ажиллагааны зөвхөн 10% нь харилцагчдад хүрээд байна гэсэн байна. Энэ нь финтек салбарын үйл ажиллагаа цаашид өсөн нэмэгдэж, илүү олон боломжийг харилцагчдад үзүүлэхээр байна.

## ОДОО АВААД ДАРАА ТӨЛ (BNPL)

BNPL үйлчилгээ нь дэлхий дахинд 2021 онд 120 тэрбум ам.доллар байсан бол худалдан авалтын хэмжээ өсч 2026 онд 576 тэрбум ам.долларт хүрнэ гэсэн төсөөлөлтэй байна.

Финтек салбарын ирээдүйн чиг хандлага нь хиймэл оюун ухаан ашиглан харилцагчдад санхүүгийн үйлчилгээг хялбараар үзүүлэхэд оршиж байна. Энэхүү салбарт хийгдэж буй хөрөнгө оруулалтын хэмжээ жил бүр нэмэгдэж байгаа ба дээр дурдсанаар одоогийн бидний авч буй финтекийн үйлчилгээ нь боломжит үйлчилгээний зөвхөн 10%-тай тэнцэж байна.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

RHINOS INVESTMENT ҮЦК LLC

*Эх сурвалж: Tech Magic (2023 оны Финтек тренд)*




*Зураг 15: АНУ-ын BNPL үйлчилгээний зах зээлийн хэмжээ*

## ЛЭНДМН ББСБ ХК-ИЙН ХЭРЭГЛЭГЧДИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

ЛэндМН ББСБ ХК-ийн санал болгож буй бичил хэрэглээний зээлийн зах зээлийн зорилтот хэрэглэгчид нь дундаж орлоготой мобайл болон интернет банк ашигладаг, технологийн дэвшилд идэвхтэй 20-39 насны интервалд хамаарах хэрэглэгчид байна. Эдгээр хэрэглэгчид нийт харилцагчдын 65%-ийг эзэлдэг ба нийт харилцагчдын 60 гаруй хувь нь тогтмол аппликэйшнээр дамжуулан зээл авдаг байна.

Зээлийн гэрээ байгуулсан идэвхтэй харилцагч нар 2017 онд 19 мянга гаруй харилцагч байсан бол 2023 оны I улирлын байдлаар 198.6 мянга болж 10 дахин өссөн байна. ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчдыг насны бүлгээр задалж харвал 39-өөс дээш насны харилцагч нар нийт зээлдэгч нарын 26%-ийг эзэлж байгаа нь компанийн анхны зорилтот насны түвшин болох 24-34 насны хэрэглэгчдээс тэлж байгаа нь зах зээлийн хэмжээ бизнесийн цар хүрээнд эерэгээр нөлөөлж байна.

Цаашид хугацаа өнгөрөх тусам карт ашиглан төлбөр тооцоо хийдэг үеэс интернет болон мобайл банк ашиглан үйлчилгээ авах сонирхолтой хэрэглэгч өсөх хандлагатай ба финтек шийдэл хүн амын дунд нас харгалзахгүйгээр тархаж эрэлт хэрэгцээ нэмэгдэхээр байна.

**ЛэндМН ББСБ ХК-ийн харилцагчдын хүрээ хэрэглээний зээлийн эрэлт өндөртэй, дундаж насны харилцагчаар хүрээгээ тэлсэн байна.**

Монгол Улсын Үндэсний Статистикийн Хорооны гаргасан ААНБ-ын ажиллагсдын сарын медиан цалин 2022 оны IV улирлын байдлаар 1,285.3 мянган төгрөгт хүрч өмнөх улирлаас 127.9 (11.1%) мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*




*Зураг 16: ААНБ-ын ажиллагчдын цалингийн судалгаа*

2022 оны эцсийн байдлаар нэг ажилтанд ногдох сарын дундаж цалин 1.7 сая төгрөг болж өмнөх оны мөн үеэс 312.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийн 38.1% нь 700,000 төгрөгөөс 1,500,000 төгрөг хүртэл цалингийн орлоготой хүн ам эзэлж байна. Нөгөө талаас 2022 оны эцсийн байдлаар өрхийн сарын дундаж орлого өмнөх оны мөн үеэс 204.1 мянган төгрөгөөр нэмэгдэж 1.8 сая төгрөгт хүрсэн байна.

Нийт өрхийн 53.7% нь өрхийн зээлтэй байгаа ба үүний 20%-ийг өрхийн хэрэглээний зээл эзэлж байна. Өрхийн хэрэглээний зээлийн дундаж хэмжээ өмнөх оны мөн үеэс 20%-иар өсч 11.4 сая төгрөгт хүрсэн нь цалин болон өрхийн орлого нэмэгдэхийн хирээр өрхийн хэрэглээ нэмэгдэж энэхүү өсөн нэмэгдэж буй хэрэгцээг зээлээр санхүүжүүлэх хандлагатай байна. Үүнтэй холбоотойгоор СЗХ-д бүртгэлтэй финтекийн зээлийн үлдэгдэл 2022 онд 49.6%-иар өссөн нь өрхийн санхүүгийн хэрэгцээг аппликейшийн зээлийн бүтээгдэхүүнээс авч буй харилцагчдын тоо өсөн нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

## 2.4 БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТААМАГЛАЛ

ЛэндМН ББСБ ХК-ийн гэрээт харилцагчдын тоо 2022 оны эцэст 196.5 мянга хүрч өнгөрсөн оны мөн үеэс 7.4%-иар, бүртгэлтэй харилцагчдын тоо 1.1

саяд хүрч 14.5%-иар тус тус өссөн байна. Салбарын харилцагчдын тоо мөн үед 4.8 саяаас 4.6 саяд хүрсэн буюу 3.9%-иар буурсан нь үнэт цаас гаргагчийн хувьд салбарын дундаж үзүүлэлтээс илүү харилцагчдын тоог нэмэгдүүлсэн байна.

2020-2022 онуудад гэрээт харилцагчдын дундаж өсөлт Ковид 19-ээс шалтгаалан 5.6% байсан ба бид эдийн засгийн сэргэлт, өсөн нэмэгдэж буй өрхийн хэрэглээ зэргийг үндэслэн 2023-2025 оны гэрээт харилцагчдын жилийн дундаж өсөлтийг 8.1%-тай байхаар таамаглав.




*График 18: Зээлийн харилцагчдын тоо*

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТААМАГЛАЛ

| ХӨРӨНГӨ | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|
| *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө* | *4,689,624* | *7,201,890* | *8,395,521* |
| *Зээлийн багц (цэвэрээр)* | *94,151,254* | *131,515,636* | *162,650,164* |
| *Бусад хөрөнгө* | *2,973,201* | *2,903,304* | *3,863,168* |
| *Үндсэн хөрөнгө* | *685,647* | *351,357* | *41,216* |
| *Биет бус хөрөнгө* | *364,137* | *306,055* | *247,973* |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **102,863,862** | **142,278,243** | **175,198,042** |

| ӨР ТӨЛБӨР | 61,416,781 | 83,711,163 | 94,999,352 |
|---|---|---|---|
| *Эх үүсвэр* | *56,611,705* | *78,720,846* | *88,720,846* |
| *Бусад өглөг* | *4,805,076* | *4,990,317* | *6,278,506* |

| ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН | 41,447,080 | 58,567,080 | 80,198,690 |
|---|---|---|---|
| *Хувьцаат капитал* | *8,471,660* | *8,471,660* | *8,471,660* |
| *Хоёрдогч өглөг* | *2,850,000* | *2,850,000* | *2,850,000* |
| *Хуримтлагдсан ашиг* | *30,125,420* | *47,245,420* | *68,877,030* |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ** | **102,863,862** | **142,278,243** | **175,198,042** |

*Хүснэгт 9: Санхүүгийн тайлангийн төсөөлөл 2023-2025 оны (мянган төгрөг)*

Үнэт цаас гаргагч нь өөрсдийн бүтээгдэхүүн үйлчилгээн дээр тулгуурлан 2023-2025 оны компанийн санхүүгийн үйл ажиллагааг дээрх байдлаар таамаглав. 2025 оны эцэст нийт хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж 175.2 тэрбум төгрөгт, цэвэр зээлийн багцыг 162.7 тэрбум төгрөг хүртэл нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна. 2021-2022 онуудад цэвэр зээлийн багцын жилийн дундаж өсөлт 71%-тай байсан ба дээрх санхүүгийн тайлангийн таамаглал түүхэн үзүүлэлтээс бага хэдий ч зах зээлийн нөхцөл байдалд уялдуулан бодитоор төсөөлсөн нь харагдаж байна.




*График 19: Нийт хөрөнгө ба нийт зээлийн хэмжээ*

Нийт хөрөнгө ба зээлийн өсөлтийг санхүүжүүлэхэд эздийн өмч болон өр төлбөрийг ижил хэмжээгээр нэмэгдүүлэн үйл ажиллагаа санхүүжүүлэн ажиллахаар байна. 2022 оны эцэст өр төлбөр 49.7 тэрбум төгрөг байсныг 2025 оны эцэст 95.0 тэрбум төгрөгт хүргэхээр төсөөлсөн байна. Дээр дурдсанчлан салбарын өрсөлдөөн нэмэгдэхийн хирээр эх үүсвэрийн зардлыг бага байлгаж зээлийн хүүг банктай өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх нь чухал ач холбогдол бүхий үйл ажиллагаа болсон байна.

СЭХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ

2023-07-28 БҮРТГЭВ-02




*График 20: Хөрөнгийн бүтэц*

## Орлогын хураангуй тайлангийн төсөөлөл (мянган төгрөг)

*Хүснэгт 10: Орлогын хураангуй тайлангын төсөөлөл (мянган төгрөг)*

| ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | 2023 F | 2024 F | 2025 F |
|---|---|---|---|
| *Нийт орлого* | *44,609,339* | *53,921,119* | *64,886,387* |
| *Хүүгийн зардал* | *(10,887,008)* | *(14,697,951)* | *(17,695,192)* |
| ***Цэвэр орлого*** | ***33,722,331*** | ***39,223,168*** | ***47,191,195*** |
| *Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал* | *(3,032,184)* | *(4,332,517)* | *(3,733,853)* |
| ***Үйл ажиллагааны цэвэр орлого*** | ***30,690,147*** | ***34,890,651*** | ***43,457,342*** |
| *Удирдлага болон ҮА-ны зардал* | *(11,344,328)* | *(11,957,118)* | *(13,421,490)* |
| ***Татварын өмнөх ашиг*** | ***19,345,819*** | ***22,933,533*** | ***30,035,852*** |
| *Татварын зардал* | *(3,679,862)* | *(4,581,364)* | *(7,172,072)* |
| **ЦЭВЭР АШИГ** | **15,665,957** | **18,352,169** | **22,863,780** |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267205



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTsK LLC

Үнэт цаас гаргагч нь нийт орлогын хэмжээг жил бүр 20%-иар өсгөж 2025 оны эцэст 65 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөж байгаа ба 2022 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 3.2 дахин өссөн үзүүлэлттэй байна. Харин үнэт цаас гаргагч нь ашигт ажиллагааг нэмэгдүүлэн цэвэр ашгийг 4.2 дахин нэмэгдүүлэхээр төсөөлсөн байна.




*График 21: Цэвэр ашиг*

## 2.5 ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлагын соёл, сайн засаглалыг бий болгохыг зорин ажилладаг бөгөөд эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийг зохистой түвшинд удирдах зорилгоор Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2021 оны 12 сарын 23-ны өдрийн 21/45 тоот тогтоолоор "Эрсдэлийн удирдлагын бодлого"-ыг баталсан. Тус бодлогоор эрсдэлийн "Гурван шатлалт хамгаалалтын бүс"-ийг тодорхойлж үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллаж байгаа төдийгүй компанийн бизнесийн үйл ажиллагаа, стратегийг хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаарыг тогтоож, тогтмол хяналт тавин, Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд улирал бүр тайлагнадаг.

Мөн зээлийн эрсдэлийн хүрээнд зээл түүнтэй адилтгах, активыг ангилах, зээлийн эрсдэлээс хамгаалах сан байгуулах, зарцуулах бодлогыг ТУЗ-ийн 2021 оны 12 сарын 23-ны өдрийн 21/45 тоот тогтоолоор баталж үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байгаа.

Харин компанийн үйл ажиллагаа зохистой, үр ашигтай байх, санхүүгийн тайлагнал үнэн зөв, бодитой байх, хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж, дагаж мөрдөж хэвшүүлэхэд чиглэсэн "Дотоод хяналтын бодлого"-ыг ТУЗ-ийн 2020 оны 12 сарын 23-ны өдрийн 20/38 тоот тогтоолоор баталсан байна.

2023.08.11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, түүний хэрэгжилт, Компанийн эрсдэлийн төлөв байдалд ТУЗ-ийг төлөөлөн хараат бусаар хяналт тавих, болон Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-өөр шийдвэрлүүлэхээр санал болгосон эрсдэлийн удирдлага болон эх үүсвэр санхүүжилттэй холбоотой асуудлыг хянаж, дүгнэлт гаргах, ТУЗ-д тайлагнах чиг үүрэгтэй ажиллана. Энэ нь эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, эдийн засаг, зохицуулалтын орчин, өрсөлдөөн дэх хөгжил, хариу үйлдэл, өөрчлөлтөд бэлэн байх зэрэг төлөвлөгөөг боловсруулахад гол үүрэг гүйцэтгэдэг. Тэр ч утгаараа ЛэндМН ББСБ ХК нь эдийн засаг нийгмийн тодорхойгүй байдал их, санхүүгийн хүндрэлтэй цаг үед харилцагчид, хувьцаа эзэмшигчид болон компанид ирээдүйд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд тухай бүр хариу арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлж, эрсдэлийн удирдлагын үр дүнтэй нэгдсэн тогтолцоог бүрдүүлж ажиллажээ.

ЛэндМН ББСБ ХК зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээлийн үнэ цэнийн бууралтыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-9 (IFRS-9) дагуу тооцдог. Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам"-д заасны дагуу 2022 оны жилийн эцэст 1.9 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц сан байгуулахаар байсан боловч СТОУС-9 (IFRS-9)-ын стандартын дагуу 3.3 тэрбум төгрөгийн зээлийн эрсдэлийн нөөц санг байгуулсан. Энэ нь санхүүгийн зохицуулах хорооны дээрх журмаар тооцвол зээлийн эрсдэлийн нөөц санг хангалттай түвшинд буюу нийт чанаргүй зээлийн багцын 116%-тай тэнцэх хэмжээнд байгуулжээ.

ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо нь улирал бүр компанийн эрсдэлийн хүлээн зөвшөөрөгдөх хэм хэмжээг хэлэлцдэг бөгөөд улирал бүр зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг гарган ажилладаг.

Доорх хүснэгтээс 2020-2023 оны I улирал хүртэлх хугацаанд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласныг харж болно.

| *Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт* | *2020* | *2021* | *2022* | *2023.I* |
|---|---|---|---|---|
| *Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа>10%* | 52.10% | 48.60% | 28.15% | 29.8% |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

| | | | | |
|---|---|---|---|---|
| *Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активийн харьцаа>20%* | 52.10% | 55.50% | 31.45% | 32.8% |
| *Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт>8%* | 43.20% | 29.40% | 12.00% | 8.6% |
| *Нэг зээлдэгч, түүний холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <30%* | 0.02% | 0.10% | 0.12% | 0.10% |
| *ББСБ-ийн холбогдох этгээдэд олгох зээл, актив, баталгаа <10%* | 0.01% | 0.10% | 0.07% | 0.10% |
| *Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт)<±40%* | 0.50% | (11.1%) | (39.8%) | (38.1%) |

*Хүснэгт 11: Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт*

## Эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичгээс...

### ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАСАГЛАЛ, БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

ЛэндМН ББСБ ХК-ийн эрсдэлийн удирдлага нь засаглалын дараах бүрэлдэхүүнтэй байна.

1. Хамгаалалтын 3 бүс;
2. Засаглалын хороод;
3. Засаглалын бичиг баримт-Бодлого, журам, заавар.

ЛэндМН ББСБ ХК нь эрсдэлийн удирдлагыг дараах бүтцээр хэрэгжүүлнэ:




*Зураг 17: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо*

ЛэндМН ББСБ ХК нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ дараах гурван (3) давхар хамгаалалтын бүсийн хяналтыг хэрэгжүүлнэ.

| Хамгаалалтын бүс | Хамаарах нэгж | Чиг үүрэг |
|---|---|---|
| I бүс<br>Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлнэ. | Бизнесийн болон тэдгээрт дэмжлэг үзүүлэх нэгж | - Эрсдэлийг хариуцаж, удирдах эзэн буюу нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой гарах эрсдэлийг тодорхойлох, илрүүлэх, хариу арга хэмжээ авах, хяналтад байлгах, удирдах. |
| II бүс<br>Эрсдэлийн удирдлагын хяналтыг хэрэгжүүлнэ. | Эрсдэлийн хариуцсан нэгж | - Эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, эрсдэлийн удирдлагын бодлого, журам, зааврыг боловсруулах, хянах, шинэчлэх, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээ, хязгаарыг тодорхойлох, батлуулах, хянах, мониторинг хийх;<br>- Хамгаалалтын I бүсийн эрсдэлийн удирдлага, хяналтын зохион байгуулалт, үйл ажиллагаанд мониторинг хийх, заавар, зөвлөмжөөр хангах. |
| III бүс<br>Хараат бус баталгаажуулалтаар хангана. | Дотоод аудитын нэгж | - Хамгаалалтын I бүсийн хэрэгжүүлж буй хяналтын тогтолцоо, түүний гүйцэтгэлийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналтын тогтолцоонд сайжруулах шаардлагатай сул талуудыг тодорхойлох;<br>- Хамгаалалтын II бүсийн тавьж буй хянан нийцүүлэлт, үнэлгээ, тайлагналын үр дүнтэй байдалд хараат бус үнэлэлт, дүгнэлт өгөх;<br>- Эрсдэлд суурилсан үнэлгээ хийх, эрсдэлийн удирдлага, түүний засаглал, дотоод хяналтыг баталгаажуулж үнэлэх, ТУЗ-д тайлагнах. |

*Хүснэгт 12: Эрсдэлийн удирдлагын хамгаалалтын бүс*

## ЭРСДЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

ЛэндМН ББСБ ХК-ийн үйл ажиллагаа, бизнесийн зорилтод сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлийг, тэдгээрийн хүчин зүйл, үр дагавраас хамааруулан дараах төрөлд хуваана.

| Эрсдэлийн төрөл | Үүсгэх хүчин зүйл | Эрсдэлийн үйл явдал, үр дагавар |
|---|---|---|
| Зээлийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Бодлого, журам, стандартууд, бүтээгдэхүүний нөхцөл;<br>▪ Зээлийн скоринг, зээлдэгчийн үнэлгээний загвар, аргачлал;<br>▪ Зээлийн төвлөрөл;<br>▪ Зээлийн хяналтын тогтолцоо;<br>▪ Зээл төлүүлэх ажиллагаа;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Эдийн засгийн тогтворгүй байдал;<br>▪ Зээлдэгчийн төлбөрийн чадвар алдагдах. | ▪ Зээлийн багцын чанар буурах;<br>▪ Зээл төлөгдөхгүй байх магадлал (PD) болон зээлийн алдагдал үүсэх (LGD) магадлал нэмэгдэх;<br>▪ Зээлийн болзошгүй эрсдэлийн сангийн хэмжээ өсөх;<br>▪ Зээл төлүүлэх ажиллагааны зардал нэмэгдэх. |
| Зах зээлийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Гадаад валютын нээлттэй позицийг зохистой түвшинд барихгүй байх;<br>▪ Эх үүсвэр, активын удирдлага (хүүнд мэдрэг хөрөнгө, өр төлбөрийн зөрүү сөрөг байх);<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлтөөс үүдэх алдагдал;<br>▪ Гадаад валют, үнэт цаасны ханшийн хэлбэлзэл;<br>▪ Зах зээлийн хүүгийн түвшин өөрчлөгдөх, Зохицуулагч байгууллагаас зохицуулалт хийх. | ▪ Гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс санхүүгийн алдагдал хүлээх;<br>▪ Эх үүсвэр болон активын хүүгийн зөрөөгээс санхүүгийн алдагдал хүлээх. |
| Хөрвөх чадварын эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Төлөвлөлт хангалтгүй байх;<br>▪ Тайлагналт хангалтгүй байх;<br>▪ Дотоод хяналт сул байх;<br>▪ Эх үүсвэр, активын удирдлага-эргэн төлөгдөх хугацааны хуримтлагдсан зөрөө сөрөг байх;<br>▪ Эх үүсвэрийн төвлөрөл;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлт. | ▪ Зохистой харьцаа алдагдах;<br>▪ Төлбөрийн чадвар алдагдах буюу зээлдүүлэгч болон харилцагчийн мөнгөн хөрөнгийг анхны шаардлагаар буцаан төлөх боломжгүй болох;<br>▪ Зээлийн эрэлт, өсөлтийг хангахгүй болох. |
| Өөрийн хөрөнгийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Төлөвлөлт хангалтгүй байх;<br>▪ Тайлагналт хангалтгүй байх;<br>▪ Дотоод хяналт сул байх;<br>▪ Үйл ажиллагааны ашиг, алдагдал;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Эдийн засаг, зах зээлийн өөрчлөлт;<br>▪ Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдал;<br>▪ Хөрөнге оруулагчдын ашиг, сонирхол. | ▪ Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа үзүүлэлт алдагдах;<br>▪ Активын, ялангуяа зээлийн эрэлт, өсөлтийг хязгаарлах. |

СЗХ
2023 .08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



| | | |
|---|---|---|
| Үйл ажиллагааны эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Дотоод үйл ажиллагааны тохиромжгүй, доголдолтой байдал (бодлого, журам, заавар, стандартгүй, эсхүл тохиромжгүй байх);<br>▪ Дотоод хяналтын тогтолцоо тохиромжгүй, эсхүл сул байх;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээний алдаа;<br>▪ Ажлын байр, хөдөлмөрийн аюулгүй байдлын зөрчил;<br>▪ Дотоод ашиглан;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Байгалийн гамшиг;<br>▪ Үймээн самуун;<br>▪ Хууль эрх зүйн өөрчлөлт;<br>▪ Гадны залилан;<br>▪ Гэмт халдлага;<br>▪ Хамтрагч, хангах нийлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа (Банк, ЗМС, Оператор, Цахилгаан, Интернет, бусад). | ▪ Биет эд хөрөнгийн зардал;<br>▪ Бизнесийн үйл ажиллагааны тасалдал;<br>▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй). |
| Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, тогтолцоо, түүний хэрэгжилт алдагдах;<br>▪ Програм болон техник хангамж дээр эмзэг байдал бий болох;<br>▪ Ажилтнуудын ёс зүйн зөрчил, мэдлэг, санаатай болон санамсаргүй алдаа дутагдал;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Нийлүүлэгчийн эрсдэл (програм хөгжүүлэгч, интернет, үүрэн холбооны оператор, цахилгаан эрчим хүч, сервер);<br>▪ Цахим халдлага. | ▪ Мэдээлэл алдагдах, түүнийг буруугаар ашиглах;<br>▪ Мэдээллийн бааз гэмтэх, устах, мэдээлэлд хандах боломжгүй болох;<br>▪ Систем алдаатай ажиллах;<br>▪ Системийн онгорхой, эмзэг байдлыг ашиглах;<br>▪ Бизнесийн үйл ажиллагаа тасалдах зэргийн улмаас Компанид Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй) учрах. |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5639758 1116267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UBSK

| | | |
|---|---|---|
| Комплаенсийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Монгол Улсын хууль, тогтоомж, эрх зүйн акт, Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк болон бусад зохицуулагч байгууллагын шаардлагыг хангаж ажиллаагүй;<br>▪ Харилцагч, гуравдагч этгээдэд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх;<br>▪ Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хангалтгүй хийх;<br>▪ Гүйлгээнд тавих хяналт алдагдах;<br>▪ Сэжигтэй гүйлгээ болон мөнгө угаалтын шинж чанар бүхий эрсдэл;<br>▪ Алдаатай бүтээгдэхүүн, үйлчилгээ;<br>▪ Ажилтны ёс зүйн зөрчил, алдаа дутагдал;<br>▪ Ажилтан дотоод бодлого, журам, заавар, стандартыг мөрдөхгүй байх, зөрчих;<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Монгол Улсын хууль, тогтоомж, эрх зүйн актын ойлгомжгүй, зөрчилтэй байдал, эрх бүхий байгууллагын тайлбар;<br>▪ Зохицуулагч байгууллага, шүүхийн үйл ажиллагаа. | ▪ Дотоод хяналт, дотоод болон хөндлөнгийн аудит, зохицуулагч байгууллагын хяналт шалгалт, харилцагчийн гаргасан гомдол, гэрээт байгууллагаас тавьсан шаардлагын дагуу Компанид:<br>▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал, хохирол, нөхөн олговор, торгууль, анз, алданги, шийтгэл);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй) учрах. |
| Нэр хүндийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Компанийн засаглал, удирдлага болон ажилтнуудын үйл ажиллагаа, нэр хүнд;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ;<br>▪ Бизнесийн үйл ажиллагааны доголдол буюу Хөрвөх чадвар, Үйл ажиллагаа, Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн хүчин зүйлээс хамаарч Компанийн нэр хүндэд сөрөг нөлөө учрах.<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Сөрөг сэтгэгдэл, нийтлэл, үнэлгээ;<br>▪ Гуравдагч этгээдийн санаатай довтолгоо;<br>▪ Зохицуулалтын өөрчлөлт;<br>▪ Хэрэглэгчээс өөрөөс хамаарсан хүчин зүйл. | ▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал+Хувьцааны ханш, үнэлгээ буурах, унах);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй). |

СЭХ 2023.08 сар 11 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

| | | |
|---|---|---|
| Стратегийн эрсдэл | Дотоод хүчин зүйл:<br>▪ Компанийн засаглал, Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт;<br>▪ Хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх;<br>▪ Бүтээгдэхүүн, үйлчилгээ;<br>▪ Нэгдэх, нийлэх үйл ажиллагаа.<br>Гадаад хүчин зүйл:<br>▪ Өрсөлдөгчдийн үйл ажиллагаа;<br>▪ Технологийн өөрчлөлт;<br>▪ Зах зээлийн хандлага, хэрэглэгчийн зан төлөв;<br>▪ Сонирхогч талуудын шаардлага, хэрэгцээ;<br>▪ Хууль, эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт. | ▪ Санхүүгийн хохирол (мөнгөн алдагдал- Орлого буурах, зардал өсөх, ашигт ажиллагаа буурах, алдагдал өсөх, борлуулалтын хэмжээ, зах зээлд эзлэх хувь хэмжээ, харилцагчийн тоо, хэрэглээ буурах гэх мэт);<br>▪ Санхүүгийн бус хохирол (мөнгөн дүнгээр хэмжих боломжгүй-алдагдсан боломжийн зардал өсөх гэх мэт). |

*Хүснэгт 13: Эрсдэлийн ангилал*

ЛэндМН ББСБ ХК-д учирч болзошгүй эрсдэлийг хамгаалалтын I болон II дугаар бүсийн түвшинд дараах албан тушаалтан, нэгж хянаж, удирдана.

| Эрсдэлийн төрөл | I бүс | II бүс |
|---|---|---|
| Зээлийн эрсдэл | ▪ Бүтээгдэхүүн хариуцсан нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Зах зээлийн эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Хөрвөх чадварын эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага |
| Өөрийн хөрөнгийн эрсдэл | ▪ Санхүүгийн менежер | ▪ Эрсдэлийн удирдлага, Гүйцэтгэх захирал |
| Үйл ажиллагааны эрсдэл | ▪ Бүх нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага (үйл ажиллагааны эрсдэл) |
| Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл | ▪ Мэдээллийн технологи хариуцсан нэгж | ▪ Аюулгүй байдал хариуцсан ажилтан |
| Хянан нийцүүлэлтийн эрсдэл | ▪ Бүх нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага (эрх зүй, хянан нийцүүлэлт) |
| Нэр хүндийн эрсдэл | ▪ Бизнесийн нэгж | ▪ Эрсдэлийн удирдлага, Гүйцэтгэх захирал |
| Стратегийн эрсдэл | ▪ Гүйцэтгэх захирал | ▪ Төлөөлөн удирдах зөвлөл |

*Хүснэгт 14: Эрсдэлийн удирдлага*

Эрсдэлийн төрөл тус бүрийн хамгаалалтын I болон II дугаар бүст хамаарах нэгж, албан тушаалтныг "ЛэндМН ББСБ" ХК-ийн Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж, түүний удирдлага нь бусад эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулан, жилд нэгээс доошгүй удаа хянаж, шаардлагатай тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг Эрсдэлийн удирдлагын хороогоор хянуулж, хэлэлцүүлсний үндсэн дээр ТУЗ-д танилцуулж, батлуулна.

lendmn УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ЗАРЧИМ

| Эрсдэлийн удирдлагын зарчим | Агуулга |
|---|---|
| Үнэ цэнийг бий болгох: | Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн үнэт зүйлийг сахин хамгаалах, хууль ёсыг дээдлэн, сайн засаглалыг бүрдүүлэх, стратегийн зорилгыг хэрэгжүүлж, өрсөлдөх чадвартай, үр ашиг бүхий, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй байгууллагыг бий болгох хувь нэмрээ оруулдаг байх ёстой. |
| Харилцагчийн өмнө хүлээх үүрэг: | ЛэндМН нь өөрийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тооцоолохоос гадна хувьцаа эзэмшигч болон нийт харилцагч, түншүүдийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийг эрмэлзэж ажиллана. |
| Бүхий л үйл ажиллагааны салшгүй хэсэг байх: | Эрсдэлийн удирдлага нь ЛэндМН-ийн Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтнуудын хариуцах ажил байхын зэрэгцээ өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөх, хянах үүрэгтэй байна. |
| Шийдвэр гаргах үйл явцын нэг хэсэг байх: | Эрсдэлийн удирдлага нь ажилтнуудад мэдрэмжээрээ бус мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах, эрсдэлийг эрэмбэлэн, нэн чухал эсвэл нэн эрсдэлтэйг эхлэн шийдэх боломжийг олгоход чиглэнэ. |
| Шат дараалсан, уялдаа холбоотой, цаг хугацааны хэмжүүртэй байх: | тууштай, найдвартай бөгөөд эерэг үр дүнг бий болгоход чиглүүлж ажиллана |
| Бодит байдалд суурилах: | Эрсдэлийн удирдлага нь түүхэн мэдээлэл, бусад нэгжийн санал, ажиглалт, урьдчилсан таамаг болон, эрсдэлийн ажилтны дүгнэлт зэрэг бодит мэдээллийг үндэслэх ба хэрэгжих боломжтой байна. |
| Уялдан зохицох: | Гадаад болон дотоод орчны нөхцөл байдлаас шалтгаалж үйл явдал, эрсдэл өөрчлөгдөх магадлалтай. Иймд эрсдэлийг удирдах арга барилаа шинэчилж, сайжруулж ажиллана. |
| Ил тод байх: | ЛэндМН ирээдүйд гарч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцоолж, мэдэгдэж буй бүх эрсдэлийн талаар ажилтан бүр мэдэж байгаа эсэхийг баталгаажуулна. |
| Бүх талуудын оролцоог хангах: | Эрсдэлийн удирдагыг хэрэгжүүлэхэд Компанийн бүхий л ажилтнуудыг зохих байдлаар оролцуулна. Эрсдэлийн удирдлагыг Компанийн гишүүн бүрт хамаатай болгох нөхцөлийг бүрдүүлэн, эрсдэлийг тодорхойлоход ажилтан бүр санал бодол, дуу хоолойгоо илэрхийлэх нөхцөлийг бий болгоно. |
| Эрсдэл, өгөөжийг тэнцвэржүүлэх: | ЛэндМН нь бүхий л үйл ажиллагаандаа эрсдэл, өгөөжийн оновчтой харьцааг хадгалан, хяналт тавьж ажиллана. |

СЭХ 2023.08.11 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02



| | |
|---|---|
| Хараат бус, бие даасан байх: | Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ хараат бус, хөндлөнгийн байр сууринаас үнэлж, дүгнэнэ. |
| Тайлагнах: | Нэгжийн ажилтан бүр олж илрүүлсэн эрсдэлийг шууд удирдлагадаа шуурхай мэдээлдэг байна. Бүх шатны удирдлагууд өөрийн хариуцсан нэгж болон түүнд хамаарах үйл ажиллагаанд хамаарах эрсдэлийн тайланг Хамгаалалтын II бүс болон Эрсдэл хариуцсан нэгжид тогтмол, үнэн зөв тайлагнана. |
| Эрсдэлийн соёл: | ЛэндМН-ийн нийт ажилтнууд нь эрсдэлийн удирдлагын бодлого, журам зааврыг дагаж мөрдөн* эрсдэлийн талаарх мэдлэг мэдээлэлтэй байх ба өөрийн хариуцсан ажил, чиг үүргийг хэрэгжүүлэхдээ учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх, үнэлэх, удирдах үүрэгтэй. ЛэндМН нь эрсдэлийн соёлыг бий болгоход нийт ажилтнуудад эрсдэлийг удирдах техникийн арга барилаас гадна эрсдэлд хандах хандлагыг өөрчлөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулна. |

*Хүснэгт 15: Эрсдэлийн удирдлагын зарчим*

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ЛэндМН ББСБ ХК нь эрсдэлийн удирдлагыг дараах процессоор хэрэгжүүлнэ.




*Схем 4: Эрсдэлийн удирдлагын процесс*

Чиг хүрээг тодорхойлох (Establish Context): Эрсдэлийн удирдлагын чиг хүрээг тодорхойлж, эрсдэлийн төрөл, үйл ажиллагаанаас хамаарч эрсдэлийг хэрхэн илрүүлэх, үнэлэх, хариу арга хэмжээ авах, хянах төлөвлөгөө, чиг, хүрээг хамгаалалтын I болон II бүс хамтран тодорхойлно.

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 ду 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ÜTK LLC

СЭХ 2023 .08 .11 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

Эрсдэлийг илрүүлэх/тодорхойлох (Risk Identification): Хамгаалалтын I бүс өөрийн хариуцсан үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаанд учирч болох эрсдэлийг тодорхойлох ба энэхүү үе шатанд i) Эрсдэлийн бүртгэл, ii) Эрсдэлийн тайлан гэсэн хоёр төрлийн бичиг баримтыг үйлдэнэ. илрүүлсэн эрсдэл бүрийг Эрсдэлийн бүртгэлд бүртгэж, Хамгаалалтын II бүсэд тухай бүр мэдээлж, тайлагнана.

Эрсдэлийн үнэлгээ (Risk assessment-Analysis and Evaluation): Илрүүлсэн буюу тодорхойлсон эрсдэл бүрийг Компани удирдах боломжгүй тул Эрсдэлийг чанарын шинжилгээ болон тоон үзүүлэлтээр үнэлэн, Эрсдэлийн түвшинг тогтоож, Эрсдэлийг эрэмбэлэн, хариу арга хэмжээ авах зэрэглэлийг тогтооно.

Эрсдэлийн түвшин (Risk ranking): Илрүүлсэн эрсдэл тус бүрийг эрсдэл тохиолдох магадлал болон түүний бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө, ашигт ажиллагаанд нөлөөлөх үр дагавраас хамааруулан дараах 4 ангилалд тодорхойлно.

| Эрсдэлийн Түвшин | | Үр дагавар, нөлөөлөл | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Маш бага | Бага | Дунд | Өндөр | Ноцтой |
| Магадлал | Маш өндөр | Бага | Дунд | Өндөр | Өндөр | Аюултай |
| | Өндөр | Бага | Дунд | Дунд | Өндөр | Өндөр |
| | Боломжтой | Бага | Бага | Дунд | Дунд | Өндөр |
| | Бага | Бага | Бага | Бага | Дунд | Дунд |
| | Маш бага | Бага | Бага | Бага | Бага | Дунд |

Эрсдэлийг эрэмбэлэх (Prioritising risk): Эрсдэлийн түвшинг үндэслэн, Хавсралт 3-т заасны дагуу эрсдэлийн оноог тодорхойлох ба тухайн эрсдэлд хариу арга хэмжээ авах шаардлага, эрэмбийг эрсдэлийн оноон дээр үндэслэн дараах байдлаар тодорхойлно.

| Эрэмбэ | Оноо | Шаардлагатай арга хэмжээ | Нөөцийн шаардлага |
|---|---|---|---|
| Ноцтой | 20-25 | Нэн даруй шуурхай арга хэмжээ авах шаардлагатай (Гүйцэтгэх удирдлага) | Эрсдэл хариуцагчийг томилох |
| Өндөр | 10-19 | Төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх, Гүйцэтгэх удирдлага анхаарал тавих шаардлагатай | Эрсдэл хариуцагчийг томилох |
| Дунд | 5-9 | Тусгай хяналт, журмын зохицуулалт шаардлагатай ба удирдлагын үүрэг, оролцоо, хариуцлагыг тодорхой болгох шаардлагатай (Эрх бүхий албан тушаалтан) | Эрсдэл хариуцагчийн томилох |

ЛЭНДМН БЕСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTSK LLC

СЗХ
2023.08.11
БҮРТГЭЛ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭЛ-02



| | | | |
|---|---|---|---|
| Бага | 0-4 | Компанид мөрдөгдөж буй зохицуулалтын дагуу үйл ажиллагаа явуулах ба тусгай нөөц шаардлагагүй (Эрх бүхий албан тушаалтан болон түлхүүр ажилтнууд) | Хэвийн үйл ажиллагаа |

Хяналтыг үнэлэх (Evaluate existing controls): Эрсдэл хариуцагч өөрийн нэгжийн үйл ажиллагаанд тогтмол хийгддэг дотоод хяналт, тэдгээрийн үр ашигтай байдлыг Олон Улсын COSO-ийн дараах 5 Бүрэлдэхүүн хэсгээр үнэлнэ. Шаардлагатай тохиолдолд Компанийн Дотоод аудитын нэгж дотоод хяналтын үр ашигтай байдлыг үнэлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Дотоод хяналтын орчин / Control Environment /;
- Эрсдэлийн үнэлгээ / Risk Assessment /;
- Дотоод үйл ажиллагааны хяналт / Control Activities /;
- Мэдээлэл харилцаа холбоо;
- Хяналт тавих / Monitoring Activities /;

Эрсдэлийн үнэлгээг хянаж, батлах: Эрсдэл хариуцсан нэгж, түүний удирдлага Эрсдэл хариуцагчийн хийсэн эрсдэлийн үнэлгээг 7.4.3-т заасан Хяналтын үнэлгээтэй харьцуулан хянаж, эрсдэлийн түвшин, түүний эрэмбэ, авах арга хэмжээний зэрэглэлд шаардлагатай засварыг оруулан, Эрсдэлийн хороонд танилцуулж, эрсдэлийн үнэлгээ, түүний эрэмбийг батална.

Хариу арга хэмжээ (Risk Treatment): ЛэндМН нь олж илрүүлсэн эрсдэл, түүний үнэлгээнд үндэслэн эрсдэлээс хамгаалах хариу арга хэмжээг дараах чиглэлээр төлөвлөж, хэрэгжүүлнэ.

- Урьдчилан сэргийлэх (preventive actions) буюу эрсдэл гарахаас хамгаалах, учрах магадлалыг бууруулах, сааруулахад чиглэсэн арга хэмжээ
- Эрсдэлийг бууруулах (contingent actions) буюу эрсдэл учрахад түүний үр дагаврыг бууруулахад чиглэсэн арга хэмжээ.

Эрсдэлийг удирдахад эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг харгалзан үзсэний үндсэн дээр дараах арга хэмжээний аль нэгийг эсхүл хэд хэдийг хамтад нь хэрэгжүүлж болно.

| Хариу арга хэмжээ | Хэрэгжүүлэх арга хэмжээ |
|---|---|
| Эрсдэлээс хамгаалах | Эрсдэлээс зайлсхийх бус, Эрсдэлийг удирдах; |

lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 11182[illegible]



RHINOS INVESTMENT ҮЦК ХХК
УЛААНБААТАР ХОТ

| | |
|---|---|
| | Үр дүн нь ижил байх арга хэмжээ, эсхүл бусад арга замыг сонгож хэрэгжүүлэхгүй байхад анхаарах; |
| Эрсдэлийг бууруулах | Удирдлагын хяналт, үйл ажиллагаа сайжруулж, тохиолдох магадлалыг бууруулах; |
| | Сөрөг үр дагаврыг боломжит бага түвшинд хүргэж бууруулах стратегийг боловсруулж, хэрэгжүүлэх-Жишээлбэл, Нөөц төлөвлөгөө, Бизнесийн тасралтгүй ажиллагааны төлөвлөгөө, гэрээний хариуцлагын хамгаалалт; |
| Эрсдэлийг шилжүүлэх | Гэрээний үндсэн дээр хариуцлагыг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн нөгөө талд/гуравдагч этгээдэд, эсхүл даатгалд шилжүүлэх; |
| Эрсдэлийг зөвшөөрөх | Дотоод хяналт зохистой гэж үзсэн тохиолдолд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх ба хяналтыг тогтмолжуулж, нөөц төлөвлөгөөг шаардлагатай хэсэгт зориулан боловсруулах. |

Эрсдэлийн хариу арга хэмжээг төлөвлөх, түүнийг хянаж, баталгаажуулах ажлыг дараах этгээдүүд хэрэгжүүлнэ:

| Эрсдэлийн түвшин | Төлөвлөх | Хянаж баталгаажуулах |
|---|---|---|
| Аюултай | Эрсдэл хариуцагч нэгж болон, Эрсдэл хариуцсан нэгжийн эрх бүхий албан тушаалтан | Эрсдэлийн удирдлагын хороо, ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороо (шаардлагатай тохиолдолд) |
| Өндөр | | |
| Дунд | Эрсдэл хариуцагч нэгжийн эрх бүхий албан тушаалтан | Эрсдэл хариуцсан нэгж |
| Бага | | |

**ЭРСДЭЛИЙН ХЯНАЛТ, ТАЙЛАГНАЛ**

Хамгаалалтын II бүс буюу Эрсдэл хариуцсан нэгж нь эрсдэлийн хяналт болон тайлагналыг үр ашигтай бөгөөд үр дүнтэй зохион байгуулах үүрэгтэй.

<u>Эрсдэлийн шинжилгээ болон хяналт:</u> Хамгаалалтын I болон II бүс нь өөрийн хяналтад байх эрсдэлд хяналт тавих, шинжилгээ хийх үүрэгтэй. Эрсдэлийн төрөл тус бүрээр эрсдэлийн шинжилгээ, хяналтыг хийх аргачлал, давтамжийг тусад нь холбогдох бодлого, журам, заавраар зохицуулна.

ЛэндМН ББСБ ХК нь дараах төрлийн хяналт, үнэлгээ, шинжилгээг хийж, үр дүнг тайлагнана:

1. Эрсдэлийн нөхцөл байдлын үнэлгээ (Contingent risk analysis)

2. Урьдчилан төлөвлөөгүй эрсдэлийн үнэлгээ (Ad-hoc assessment)
3. Шийдвэр гаргахад эрсдэлийн бүрэн хэмжээний үнэлгээ шаардлагатай эсэхийг Эрсдэлийн хариуцсан нэгжийн удирдлага, эсхүл Гүйцэтгэх захирал шийдвэрлэх ба эрсдэлийн хяналт/үнэлгээний үр дүнг холбогдох эрх бүхий этгээд, эсхүл хороо шийдвэр гаргахдаа харгалзан үзнэ.
4. Тогтмол хяналт (Periodic assessment)
5. “ЛэндМН ББСБ” ХК нь төсөв боловсруулахдаа төлөвлөсөн санхүүгийн болон бусад тоон үзүүлэлт, зорилтууд нь эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хэмжээг хангах хэмжээнд төлөвлөх ба Эрсдэл болон Санхүү хариуцсан удирдлагууд хянаж, баталгаажуулна.
6. Эрсдэлийн тогтмол үнэлгээг Эрсдэл хариуцсан нэгжийн удирдлага, Санхүүгийн менежер, эсхүл Санхүү хариуцсан захиралтай хамтран хариуцан зохион байгуулах ба үр дүнг эрсдэлийн тайлангийн хамт Эрсдэлийн удирдлагын  хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тогтмол тайлагнана.

Эрсдэлийн тайлан (Risk report): Эрсдэл хариуцсан нэгжийн удирдлага Компанийн эрсдэлийн тайлан цаг хугацаандаа, үнэн зөв, бүрэн гүйцэд бэлтгэгдэн, Эрсдэлийн хороо болон ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хороонд тайлагнах асуудлыг хариуцан, хэрэгжүүлж ажиллана.

Компанийн эрсдэлийн тайлан нь зөвхөн эрсдэлийн хэмжигдэхүүн, тоон үзүүлэлтээр хязгаарлагдахгүй ба дараах бүтэцтэй байна:

1. Эрсдэлийн хянах самбар (Risk dashboard)
2. Эрсдэлийн онцлох сэдэв (Risk theme)
3. Эрсдэлийн дэлгэрэнгүй тайлан (Detail risk report)

# III. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

СЗХ
2023 .08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

lendmn



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02

## 3.1 НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 3.1.1 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ** | ЛэндМН ББСБ ХК |
| **ҮНЭТ ЦААС** | Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл "Лэнд Бонд" |
| **АРИЛЖАА ЭРХЛЭХ БАЙГУУЛЛАГА** | Монголын хөрөнгийн бирж ХК |
| **ХҮҮГИЙН ТӨРӨЛ** | Энгийн хүүтэй бонд |
| **ЛЭНД БОНДЫН НЭРЛЭСЭН ҮНЭ** | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| **ЛЭНД БОНДЫН ТОО, ШИРХЭГ** | 90,000 (ерэн мянга) ширхэг |
| **ЛЭНД БОНДЫН НИЙТ ҮНИЙН ДҮН** | 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг |
| **ЛЭНД БОНДЫН ХУГАЦАА** | 24 сар /365 хоног * 2/ |
| **ЛЭНД БОНДЫН ХҮҮ** | 18 хувь /жилийн/ |
| **ХҮҮ ТӨЛӨГДӨХ ХУГАЦАА** | Улирал тутамд /3 сар тутам/ |
| **ҮНДСЭН ТӨЛБӨР ТӨЛӨХ ХУГАЦАА** | Лэнд Бонд хугацааны эцэст (24 сарын дараа) |
| **ТАТАН ТӨВЛӨРҮҮЛСЭН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ** | Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаа санхүүжүүлэх |
| **БОНДЫН БАРЬЦАА/БАТАЛГАА** | "АНД Системс" ХХК-ийн эзэмшиж буй 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцаа |
| **БОНДЫН ХАДГАЛАЛТ, БҮРТГЭЛ, ТӨЛБӨР ТООЦОО** | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК |
| **НИЙТЭД САНАЛ БОЛГОН ГАРГАХ ХУВЬЦАА** | 2023 оны III улирал (Зохицуулагч байгууллагаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой) |

*Хүснэгт 16: Өрийн хэрэгслийн ерөнхий нөхцөл*

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 23/22 тоот тогтоолоор Лэнд Бондыг нийт 90,000 (ерэн мянга) ширхэг, 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг, жилийн 18 хувийн хүүтэй нийтэд санал болгон

СЗХ
2023.08.11
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
-02

арилжаалахаар баталгаажуулсан. Тус үнэт цаасны ерөнхий нөхцөлд өөрчлөлт оруулсантай холбогдуулан ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны 23/20 тоот тогтоолын хавсралтыг хүчингүй болгосон болно.

ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны 23/20 тоот тогтоолыг бондын танилцуулгын хавсралтаас харна уу.

## 3.2 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙН БАРЬЦАА

Үнэт цаас гаргагч нь 2018 онд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан нийт хувьцааны 25 хувийг олон нийтэд санал болгон гаргах замаар нээлттэй хувьцаат компани болж хэлбэрээ өөрчилсөн. Санхүүгийн Зохицуулах Хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.6-д "Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан дааж болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны **50 хувиас дээшгүй** байна" гэж заасны дагуу компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 75 хувийг эзэмшигч "АНД Системс" ХХК нь өөрийн эзэмшлийн хувьцаанаас 400,000,000 ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн энгийн хувьцааг барьцаалуулахаар шийдвэрлэсэн.

Мөн журмын 2.7-д "батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний **70 хувиас илүүгүй** байна" гэж тусгасан ба Монголын Хөрөнгийн биржээс ирүүлсэн нэгж хувьцааны сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханш 34 төгрөг байгаа ба барьцаа хөрөнгийн үнэлгээ дараах байдалтай байна.

| | |
|---|---|
| Компанийн нийт гаргасан хувьцааны тоо | 800,000,000 ширхэг |
| Сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш | 34 төгрөг /2023 оны 06 сарын 23-ны байдлаар/ |
| "АНД Системс" ХХК-ийн эзэмшиж буй хувьцааны тоо | 600,000,000 ширхэг |
| Барьцаалагдаж буй хувьцааны тоо | 400,000,000 ширхэг /Нийт гаргасан хувьцааны * 50%/ |
| Барьцаа хөрөнгийн үнэлгээ | 400,000,000 ширхэг * 34 төгрөг = 13,600,000,000 төгрөг |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
RHINOS INVESTMENT SECURITIES LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



ЛэндМН ББСБ ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 27-ний өдрийн 23/20 тоот тогтоол, АНД Системс ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 27-ний өдрийн 23/09 тоот тогтоолын дагуу Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй Лэнд Бондын эргэн төлөлтөд толгой компани болох "АНД Системс" ХХК нь өөрийн эзэмшиж буй 13,6 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий ЛэндМН ББСБ ХК-ийн 400,000,000 ширхэг хувьцааг барьцаалж, баталгаа гаргахаар шийдвэрлэсэн. Уг тогтоолыг хавсралтаас харна уу.

Үнэт цаас гаргагчийн толгой компани болох "АНД Системс" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 27-ний өдрийн 23/09 тоот тогтоолын дагуу охин компани болох "ЛэндМН ББСБ" ХК-ийн Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нээлттэй өрийн хэрэгсэл гаргахтай холбогдуулан Лэнд Бонд болон түүний хүүг эргэн төлөх үүргийн гүйцэтгэлийг өөрийн эзэмшиж буй 400,000,000 ширхэг, 2023 оны 6 сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцоход 13.6 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий энгийн хувьцааг барьцаалуулахаар шийдвэрлэсэн.

Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлж үндсэн андеррайтер Райнос инвестмент ҮЦК ГХО ХХК (цаашид "барьцаалагч" гэх), ЛэндМН ББСБ ХК (цаашид "үүрэг гүйцэтгэгч" гэх) болон АНД Системс ХХК (цаашид "барьцаалуулагч" гэх) нар нь 2023 оны 06 сарын 27-ны өдөр 2023/44 тоот "Хувьцааны барьцааны гурван талт гэрээ" байгуулсан. Энэхүү гэрээний ерөнхий нөхцөлийг "Анд Системс" ХХК-ийн ТУЗ-ийн "Хувьцаа барьцаалах, гэрээ байгуулах эрх олгох тухай" 23/09 тоот тогтоолын хавсралтаар баталсан. Энэхүү тогтоол болон "Хувьцааны барьцааны гурван талт гэрээ"-г бондын танилцуулгын хавсралтаас харна уу.

Үүрэг гүйцэтгэгч нь Анддеррайтерийн гэрээ болон өрийн хэрэгслийн дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, хүү, алданги болон Анддеррайтерийн гэрээтэй холбоотой бий болсон бусад төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд Барьцаалагчийн барьцааны эрх хүчинтэй байна.

Уг барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буурч Лэнд Бондын үндсэн төлбөрийн зээл үнэлгээний харьцаа (Loan to Value) үзүүлэлт 70% (далан хувь)-аас хэтэрсэн тохиолдолд шаардлагатай хэмжээгээр хувьцаа нэмж барьцаалах нөхцөлтэйгээр гурван талт гэрээ байгуулагдсан болно.

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК

Санхүүгийн Зохицуулах Хорооны "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-д заасны дагуу барьцааны зүйл болох үнэт цаас гаргагчийн хувьцааны үнэлгээг 2023 оны 06 сарын 23-ний өдрийн байдлаар сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар баталгаажуулахад нэгж хувьцааны ханш 34 төгрөг, нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ 13.6 тэрбум төгрөг байна.

## АНД СИСТЕМС ХХК-ИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол улсын хуулийн этгээд "АНД Системс" ХХК (Улсын бүртгэлийн дугаар: 9019084069, Регистрийн дугаар 6005861) нь 2015 оны 09 сарын 24-ний өдөр үүсгэн байгуулагдсан ба ЛэндМН ББСБ ХК-ийн Монголын биржид бүртгэлтэй 600,000,000 ширхэг энгийн хувьцааг эзэмшдэг.

Үйл ажиллагааны чиглэл: Менежментийн зөвлөгөө өгөх, Мэдээлэл технологийн үйл ажиллагаа явуулах

Хаяг: Монгол улс, Сүхбаатар дүүрэг, 5-р хороо, Нью Майнд групп ХХК-ийн байр

## АНД СИСТЕМС ХХК-ИЙН САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАН

Нэгтгэсэн санхүү байдлын хураангуй тайлан /тэрбум төгрөг/

| **ХӨРӨНГӨ** | **2021 /аудитлагдсан/** | **2022** |
|---|---|---|
| *Мөнгө болон түүнтэй адилтгах хөрөнгө* | *7.45* | *7.65* |
| *Зээлийн багц (цэврээр)* | *32.43* | *69.59* |
| *Бусад хөрөнгө* | *9.83* | *11.03* |
| *Урьдчилж төлсөн тооцоо* | - | *0.09* |
| *Үндсэн хөрөнгө* | *0.57* | *0.98* |
| *Биет бус хөрөнгө* | *0.66* | *0.88* |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **50.94** | **90.22** |
| | | |
| **ӨР ТӨЛБӨР** | **35.91** | **73.75** |
| *Эх үүсвэр* | *32.41* | *62.28* |
| *Бусад өглөг* | *3.49* | *11.47* |
| **ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН** | **15.03** | **16.46** |
| *Хувьцаат капитал* | *13.00* | *13.00* |
| *Хуримтлагдсан ашиг/алдагдал* | *(2.71)* | *(2.54)* |
| *Хяналтын бус оролцоо* | *4.74* | *6.00* |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ** | **50.94** | **90.22** |

Нэгтгэсэн орлого, үр дүнгийн хураангуй тайлан (тэрбум төгрөг)

| ОРЛОГЫН ҮЗҮҮЛЭЛТ | 2021 /аудитлагдсан/ | 2022 |
|---|---|---|
| *Нийт орлого* | *13.33* | *21.51* |
| *Хүүгийн зардал* | *(5.23)* | *(4.80)* |
| ***Цэвэр орлого*** | ***8.10*** | ***16.71*** |
| *Зээлийн болзошгүй эрсдэлийн нөөцийн зардал* | *0.73* | *(1.44)* |
| ***Үйл ажиллагааны цэвэр орлого*** | ***8.83*** | ***15.27*** |
| *Удирдлага болон ҮА-ны зардал* | *(7.99)* | *(12.89)* |
| ***Татварын өмнөх ашиг*** | ***0.83*** | ***2.38*** |
| *Татварын зардал* | *(0.60)* | *(1.15)* |
| **ЦЭВЭР АШИГ** | ***0.23*** | **1.23** |

*Хүснэгт 17: АНД Системс ХХК аудитлагдсан тайлан 2021-2022*

## 3.3 ҮНЭТ ЦААСААР ГЭРЧЛЭГДЭХ ЭРХ, ҮҮРЭГ

Өрийн хэрэгсэл эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн хэрэгслийг эзэмшихтэй холбоотой харилцааг Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журам (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам), Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам, ҮЦТХТ-ийн Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг бүртгэх үйл ажиллагааны журмын холбогдох зүйл заалтаар тус тус зохицуулна.

**Өрийн хэрэгсэл нь түүний эзэмшигчийн дараах эрхийг гэрчилнэ:**

1. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь компанийн санхүүгийн тайлан, үнэт цаасны танилцуулгыг хөрөнгө оруулалтын зорилгоор судлан үзэж, бүрэн танилцсаны үндсэн дээр өрийн хэрэгслийг худалдан авч, хөрөнгө оруулалт хийх шийдвэрийг бие даан гаргах эрхтэй;
2. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь өрийн хэрэгслийн хоёрдогч зах зээлийн үнийн мэдээлэлтэй танилцах эрхтэй;
3. Өрийн хэрэгслийг бирж дээрээс үнэт цаасны компаниараа дамжуулан чөлөөтэй худалдан авах, хоёрдогч зах зээл дээр худалдах эрхтэй;

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭЛ-02



4. Өрийн бичиг эзэмшигч, түүний хамтран эзэмшигч нь хугацааны эцэст өрийн хэрэгслийг нэрлэсэн үнээр Үнэт цаас гаргагчид эргүүлэн худалдах, худалдан авахыг шаардах, хүүг улирал тутам, үндсэн төлбөрийг Лэнд Бондын хугацааны эцэст төлөхийг шаардах эрхтэй;
5. Үнэт цаас гаргах тухай шийдвэрт зааснаар үнэт цаасны хүүг улирал тутамд төлөхийг шаардах эрхтэй;
6. Хэрэв үнэт цаас гаргагч нь дээрх 4, 5-д дурдсан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол андеррайтераар дамжуулан барьцаалуулагчаар үүргийн гүйцэтгэлийг хангуулах арга хэмжээ авахыг шаардах эрхтэй;
7. Өрийн бичиг гаргагч төлбөрийн чадваргүй болсон буюу үүргийн гүйцэтгэлийг хангах эд хөрөнгийн хэмжээ багассан, эсхүл эд хөрөнгөгүй болсон бол өрийн бичиг эзэмшигч нь тогтоосон хугацаанаас өмнө үүргээ нэн даруй гүйцэтгэхийг түүнээс шаардах (Иргэний хуулийн 208.6) эрхтэй;
8. Үнэт цаасаар хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар хувьцааны барьцааны гэрээ байгуулсан гуравдагч этгээдийн талаарх мэдээлэлтэй танилцах (Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам);
9. Холбогдох хууль тогтоомж, гэрээгээр тодорхойлогдох бусад эрх.

**Өрийн хэрэгсэл нь түүний эзэмшигчийн дараах үүргийг гэрчилнэ:**

1. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн хэрэгслийн төлбөрийг төлөх;
2. Мөнгөн хөрөнгөө урьдчилан байршуулах нөхцөлөөр өөрийн захиалсан өрийн хэрэгслийн төлбөрийг төлөөгүй бол захиалсан өрийн хэрэгслийг ҮЦК худалдах эрхтэйг хүлээн зөвшөөрөх;
3. Үнэт цаас эзэмшигч, түүний хамтран эзэмшигчийн өрийн хэрэгслийн төлбөрт төлсөн мөнгөн хөрөнгө нь түүний хууль ёсны үйл ажиллагаанаас олсон орлого бөгөөд "Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль"-ийн дагуу холбогдох шалгуурыг хангасан, эрх зүйн аливаа доголдолгүй, маргаангүй мөнгөн хөрөнгө болохыг бүрэн баталж, эрсдэл болон өгөөжийг бүрэн тооцоолж хөрөнгө оруулалтын шийдвэрийг бие даан гаргасан талаар баталгаа гаргаж ҮЦК-аас гаргасан анхан шатны маягтыг үнэн зөв мэдээлэх болон түүнд орсон өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй;

4. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасны дагуу татвар төлөх үүрэгтэй.

**Үнэт цаас гаргагчийн үүрэг**

1. Үнэт цаас гаргагч нь өөрийн санхүү болон бусад бодит байдлын талаар үнэн зөв мэдээлэх үүрэгтэй;
2. Өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал үүссэн тохиолдолд барьцааны гэрээний дагуу зохих арга хэмжээг авч үнэт цаас эзэмшигчийн хүү болон үндсэн төлбөрийг барагдуулах;
3. Татан төвлөрүүлсэн хөрөнгийг үнэт цаасны танилцуулгад тусгагдсан зориулалтын дагуу үр ашигтай захиран зарцуулах;
4. Үнэт цаасны танилцуулгад тусгагдсаны дагуу улирал тутамд хүүгийн төлбөрийг төлөх, хугацааны эцэст үндсэн төлбөрийг төлөх үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллах;
5. Үнэт цаас гаргагч нь холбогдох гэрээнүүдээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас үнэт цаас эзэмшигчид учруулсан аливаа хохирлыг төлж барагдуулах үүрэгтэй;
6. Үнэт цаас гаргагч нь үндсэн болон хүүгийн төлбөрийг Т+2 нөхцөлөөр ҮЦТХТ-д байрших өөрийн дансанд шилжүүлнэ. Шилжүүлсэн дүнг ҮЦТХТ нь хөрөнгө оруулагчийн үнэт цаасны данс руу үндсэн болон хүүгийн төлбөр хийгдэх өдөр татна;
7. Холбогдох хууль тогтоомж болон журамд заасны дагуу мэдээллийн ил тод байдлыг тогтмол хангах, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлж ажиллах;
8. Баталгаа гаргагчийн талаар хөрөнгө оруулагчдад тодорхой үнэн зөв мэдээллийг өгөх;
9. Үнэт цаас гаргагч нь компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг үнэн зөв, агуулгын хувьд хоёрдмол утгагүй, бүрэн гүйцэд, тодорхой байх зарчмаар буюу хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад хангалттай байдлаар ил тод болгож мэдээлэх;

СЭЗ
2023 .. сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



10. Үнэт цаас гаргагч нь бондын үнэ ханшид нөлөөлж болохуйц аливаа үйл явдлын мэдээллийг зохих журамд заасны дагуу нэн даруй олон нийт, Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх;

11. Үнэт цаас гаргагч буюу нээлттэй бонд гаргагч нь дараах тохиолдолд зохих мэдээллийг Хороо, арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлж, олон нийтэд тухайн үйл явдал болсноос хойш ажлын гурван өдрийн дотор мэдээлнэ.

    - Бондын танилцуулгад заасан үйл ажиллагааны чиглэл, төсөл болон төслийн хэрэгжилтийн явцад өөрчлөлт орсон;
    - Бусад санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагчаас зээл авсан, тэдний өмнө хүлээсэн нэмэлт үүрэг үүссэн;
    - Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүтцэд өөрчлөлт орсон;
    - Хяналтын багц бүхий хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орсон;
    - Эрх бүхий байгууллагын шийдвэрээр бонд гаргагчийн хөрөнгийг битүүмжилсэн, эсхүл хураасан;
    - Бонд гаргагч тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэх болсон, хугацааг сунгуулсан, эсхүл түүнийг түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон;
    - Бонд гаргагч нь гуравдагч этгээдийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргасан.

## 3.4 ҮНЭТ ЦААС ГАРГАГЧ БОЛОН АНДДЕРРАЙТЕРИЙН ХООРОНД БАЙГУУЛСАН БОНДЫН ГЭРЭЭ

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн хөрөнгө оруулагчдын өмнө хүлээх үүрэг, бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох арга, худалдах, худалдан авах нөхцөлийг тусгасан Бондын 2023/43 тоот гэрээг 2023 оны 06 сарын 27 өдөр байгуулсан. Уг гэрээгээр үнэт цаас гаргагч нь бондыг хугацаанаас нь өмнө эргүүлэн худалдан авах болон энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлгүй болохыг тусгасан.

Үнэт цаас гаргагчийн бонд нь толгой компанийн эзэмшиж буй ЛэндМН ББСБ ХК-ийн энгийн хувьцааг барьцаалахаар “Хувьцааны барьцааны гурван талт гэрээ”-г байгуулсан. Үнэт цаас гаргагч нь төлбөрөө

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

хугацаандаа гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүсэх тохиолдолд төлбөрийн тасалдал (дефолт) болсонд тооцно. Дефолт үүссэн тохиолдолд Андеррайтер нь барьцааны эрх хэрэгжүүлж үнэт цаас гаргагчийн төлбөл зохих төлбөрийг барагдуулахыг шаардах ба бондын гэрээний дагуу бусад шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Үнэт цаас гаргагч нь СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 8 дугаар бүлэгт заасны дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг Хороо болон арилжаа эрхлэх байгууллага, олон нийтэд хүргүүлж ажиллана.

## 3.5 ҮНЭТ ЦААСНЫ ХҮҮ ТОГТООСОН ҮНДЭСЛЭЛ

Үнэт цаас гаргагч нь өрийн хэрэгслийн хүүгийн түвшинг тогтоохдоо зах зээлийн нөхцөл байдал, инфляц, эдийн засгийн тодорхой бус байдал, ижил төстэй өрийн хэрэгслийн хүү, бодлогын хүү ба хөрөнгө оруулагчдын хүлээлтэд үндэслэн жилийн 18 хувийн хүүтэй өрийн хэрэгслийг санал болгож байна.

### Инфляц, Хадгаламжийн хүүгийн түвшинтэй харьцуулахад

2023 оны I улирлын байдлаар системийн нөлөө бүхий 5 арилжааны банкнуудын 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн дундаж хүү 12.8% байгаа бөгөөд Лэнд Бонд-ийн хүү даруй 5.2%-иар өндөр байна. Мөн Монгол банкны статистик мэдээллийн дагуу банкнуудын төгрөгийн нийт хадгаламжийн үлдэгдэлд жигнэж тооцсон хүү 19-24 сартай хадгаламжинд жилийн 13.34% байна.

*Эх сурвалж: Арилжааны банкнуудын вэб хуудас*




*График 22: : Банкнуудын иргэдийн 24 сарын хугацаатай хадгаламжийн жилийн хүү*

Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцын төвшин 2023 оны I улирлын байдлаар жилийн 12.2%, оны эхнээс 3.4%-д хүрсэн байна. Төрөөс хэрэглээний үнийн индексээр илэрхийлсэн инфляцыг 2023 онд нэг оронтой тоонд, дунд хугацаанд (+-2) нэгж хувийн интервалд 6 хувийн орчим тогтворжуулахаар зорин ажиллаж байна. Хөрөнгө оруулагчдын хувьд инфляцийн төвшнөөс өндөр өгөөжөөр хөрөнгөө удирдах нь илэрхий бөгөөд үнэт цаас гаргагчийн санал болгож буй хүү тогтоох үндсэн нэг үндэслэл нь инфляцын төвшин билээ.




*График 23: Хүүгийн харьцуулалт*

Лэнд Бондын хүү нь 24 сарын хугацаатай банкны хадгаламжийн хүү болон инфляцийн төвшнөөс 41%-ийн өндөр байгаа нь хөрөнгө оруулагч нарт хөрөнгийн үнэ цэнээ өсгөх, эрсдэл багатай аргыг санал болгож байна.

## Нээлттэй үнэт цаасны өгөөжийн түвшинтэй харьцуулахад

Олон нийтэд нээлттэй санал болгосон үнэт цааснуудын дундаж хүүгийн төвшин 16.93%-ийн өгөөжтэй байгаа ба өнөөгийн нөхцөл байдал болон инфляцийн өсөн нэмэгдэж буй өнөө үед хөрөнгө оруулагч, олон нийтийн хөрөнгийн үнэ цэнийг хамгаалахын тулд харьцангуй өндөр өгөөжөөс гадна богино хугацаанд хүү төлөгдөх нөхцөлтэй, эрсдэл багатай бүтээгдэхүүн зах зээлд шаардлагатай байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж




График 24: Нээлттэй үнэт цаасны өгөөжийн түвшингийн харьцуулалт

Үнэт цаас гаргагчийн санал болгож буй Лэнд Бондын нэрлэсэн хүү 18% байгаа нь зах зээл дээрх бусад нээлттэй үнэт цааснуудын хүүгийн хувьд өрсөлдөхүйц, эрсдэл багатай бүтээгдэхүүн гэж дүгнэж болохоор байна.

## Лэнд Бондын давуу талууд

### Хугацааны дундуур арилжих боломж

Лэнд Бонд нь барьцаалагдах зэргээр гуравдагч этгээдийн эрхээр хязгаарлагдаагүй, битүүмжлэгдээгүй бөгөөд хөрөнгө оруулагч нь анхдагч зах зээлээс үнэт цаасны арилжаанд оролцсоныхоо дараа өөрийн хэрэгцээтэй үедээ хоёрдогч зах зээл дээр үнэт цаасаа чөлөөтэй арилжих, элэглэх, худалдах болон хууль тогтоомжид заасны дагуу эрх залгамжлал хэрэгжих бүрэн боломжтой юм.

### Татварын хөнгөлөлт

Нээлттэй өрийн хэрэгслийн хувьд хөрөнгө оруулагч нь хүүгийн орлогоос 5%-ийн албан татвар төлөх зохицуулалттай байгаа ба хөрөнгө оруулагч нь татварын хувьд өгөөжөө нэмэгдүүлэх боломжтой гэж үзнэ.

### Ханшийн зөрүүгээр ашиг хүртэх боломж

Нээлттэй өрийн бичиг эзэмшиж байх хугацаанд зах зээл дээр хадгаламжийн хүү буурах юм уу эсвэл бондын эргэн төлөлтийн хугацаа

2023 ОН 11 САР ӨДӨР БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

дөхөх тусам бондын үнэ өссөнөөр бонд эзэмшигч нарын хувьд арилжааны зөрөөний ашиг олох боломж бий болдог.

## 3.6 ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Үнэт цаас гаргагч нь нээлттэй санал болгож буй 90,000 (ерэн мянга) ширхэг, нэг бүр нь 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн үнэтэй, тогтмол хүүтэй, энгийн өрийн хэрэгслээр нийт 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр ажиллаж байгаа билээ. Энэхүү олон нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийг Үнэт цаас гаргагч нь үндсэн үйл ажиллагаа болох зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

Өрийн хэрэгслээр татан төвлөрүүлэх санхүүжилтийг зөвхөн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд тус санхүүжилтийн зардлыг татан төвлөрүүлэх хөрөнгөөс гаргахгүй болно.

## 3.7 ӨРИЙН ХЭРЭГСЛИЙГ АНХДАГЧ ЗАХ ЗЭЭЛД БАЙРШУУЛАХ ТУХАЙ




*Схем 6: Анхдагч зах зээлд байршуулах тухай*

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 12.1-т заасны дагуу нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл болон Монголын хөрөнгийн биржид бүртгэгдсэн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдана.

Мөн хуулийн 12.2-т заасныар Үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг арилжих зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо олгох бөгөөд Хороо уг зөвшөөрлийг Монголын хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгэсэн болон холбогдох бэлтгэлийг хангасан тухай тус хөрөнгийн биржээс гаргасан тодорхойлолт, үнэт цаас гаргагчийн хүсэлтэд үндэслэн олгох бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 10

СЭХ 2023 .08 сар 11 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ -02

сарын 25-ны өдрийн 15 тоот тогтоолоор баталсан "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-д /ТУЗ-ийн 2021 оны 03 сарын 26-ны өдрийн 05 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан/ заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер компаниуд өрийн хэрэгслийг анхдагч зах зээлд байршуулах дэлгэрэнгүй төлөвлөгөөг танилцуулах болно.

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 23/22 тоот тогтоолын дагуу нийт 90,000 /ерэн мянган/ ширхэг нэг бүр нь 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий компанийн өрийн хэрэгслийг олон нийтэд нээлттэй санал болгон арилжаалах бөгөөд Монголын хөрөнгийн биржийн Анхдагч зах зээлийн арилжааны системээр дамжуулан олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн олон нийтэд санал болгож буй бонд нь хөтөлбөрөөр хэрэгжихгүй тул худалдан авах захиалгын хугацааг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөл олгосноор Үнэт цаас гаргагч болон Андеррайтерийн компаниуд харилцан зөвшилцсөний үндсэн дээр зохион байгуулна.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

lendmn

Үнэт
цаасны
танилцуулга

# IV. ҮНЭТ ЦААС ГАРГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦСОН БАЙГУУЛЛАГУУД

Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоолоор Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаанд мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг дараах байдлаар сонгон, гэрээг байгуулан ажилласан.

| № | Байгууллагын нэр | Үзүүлэх үйлчилгээ | Гэрээний дугаар |
|---|---|---|---|
| 1 | Райнос Инвестмент ҮЦК ГХО ХХК | Үндсэн андеррайтер | 2023/24 |
| 2 | Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК | Туслах андеррайтер | 2023/24 |
| 3 | Тэнгэр Капитал ҮЦК ХХК | Туслах андеррайтер | 2023/24 |
| 4 | Нийслэл Аудит ХХК | Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ | 2023/22 |
| 5 | Өмгөөллийн Эм Ди Эс Хаанлекс ХХН | Хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч | 2023/19 |

Дээрх оролцогч байгууллагуудын товч танилцуулгыг доор хавсаргав.

## 4.1 ҮНДСЭН АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ГХО ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, номинал данс эзэмших, гадаад улсад үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2019/10 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9019097033 |
| Регистрийн дугаар | 6481299 |
| Хаяг | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг-8, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр, 13 давхар, 1308б тоот |
| Утас | 7510-0575 |
| Цахим шуудан | info@rhinosinvest.mn |

Райнос Инвестмент ҮЦК ГХО ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол Улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулахаар зорин ажиллаж байна. Райнос Инвестмент ҮЦК ГХО ХХК нь Брокер, Дилер, Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч Райнос Инвестмент ҮЦК ГХО ХХК нь гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын болон дотоодын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлан ажиллаж байна.

| | |
|---|---|
| 2019.01 | Үүсгэн байгуулагдсан |
| 2019.12 | Брокер, гадаад арилжааны зуучлал, номинал данс эзэмших үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө авсан |
| 2020.06 | ЛэндМН компанийн 5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын төсөлд Синдикатаар оролцсон |
| 2020.12 | Дилерийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлөө авсан. |
| 2021.01 | Дүрмийн сангаа $200,000-р нэмэгдүүлсэн |
| 2021.03 | МҮЦКлирингийн төвийн гишүүн болсон |
| 2021.06 | ЛэндМН компанийн 5 тэрбум төгрөгийн нээлттэй бондын төсөлд Синдикатаар оролцсон |
| 2021.07 | Дүрмийн сангаа $200,000-р нэмэгдүүлсэн |
| 2021.09 | Биржийн Бус Зах Зээлийн шууд оролцогч болсон |
| 2021.12 | Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө авсан |

Райнос Инвестмент ҮЦК ГХО ХХКболон толгой компани болох Райнос Эссет Менежмент компанийн Монголд хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болон ЛэндМН ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалтыг гадаадын мэргэжлийн хөрөнгө оруулагчийн хувиар хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа АНД Системс ХХК-ийн санхүүжилтэд зориулж хувьцаа барьцаалсан солилцох бондын 7 тэрбум төгрөгийн санг амжилттай байгуулсан.
- 2017 оноос хойш БНСУ-ын хөрөнгө оруулалтын сантай хамтран нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Монголын компаниудыг өсөлт үзүүлэхэд нь дэмжиж ажилласаар ирсэн.
- Монголын Хөгжлийн Банкны гаргасан хадгаламжийн сертификатын (CD) бүтээгдэхүүнд 2017-2019 онуудад хуримтлагдсан дүнгээр нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийжээ.
- 2021 онд Технологийн салбарын старт-ап компанид 2.0 сая ам.долларын хөрвөх бондын санхүүжилт хийсэн байна.

- 2022 онд Олон улсын мөнгөн гуйвуулгын үйлчилгээг гар утасны аппликейшнээр дамжуулан хялбар, түргэн шуурхай хэрэглэгчдэд хүргэж буй Сэндли ББСБ ХК-ийн 10.05 тэрбум төгрөгийн IPO-д туслах андеррайтераар ажилласан.
- ЛэндМН ББСБ ХК-ийн 4.8 тэрбум төгрөгийн Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгож, анх удаа андеррайтер төвтэй анхдагч зах зээлийн арилжааг амжилттай зохион байгуулсан.
- 2023 оны 1 дүгээр улиралд Сэндли ББСБ ХК-ийн анх удаа нээлттэй санал болгон гаргасан 8.5 тэрбум төгрөгийн өрийн хэрэгслийг арилжаалах үйл ажиллагаанд туслах андеррайтераар ажилласан.
- 2023 оны 2 дугаар улиралд ХасБанк ХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргасан 35.7 тэрбум төгрөгийн хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах үйл ажиллагаанд Үндсэн андеррайтераар ажилласан.

Өнөөгийн байдлаар “Райнос Инвестмент ҮЦК” ГХО ХХК нь:

- "Анд Глобал" ХХК
- "Анд Системс" ХХК
- “ОНДО” ХХК
- "Хас Банк" ХХК
- “ЛэндМН ББСБ” ХХК
- "Капитрон банк" ХХК
- “Гарнетон” ХХК
- "Эрхэт Монгол"
- "Ган Хийц"
- "Beauty Secrets"
- "Томъёо" ХХК

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 45 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтыг татан төвлөрүүлээд байна.

## Андеррайтерийн гэрээний тухай

### Андеррайтерийн үйлчилгээ

- Андеррайтер нь Гэрээний 2.1.2-т заасан Үйлчилгээг Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.3-д заасан Хөрөнгө оруулагчид тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулна.

**Андеррайтерийн хүлээх үүрэг**

- Андеррайтер нь Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хороо болон Биржийн холбогдох журам болон үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахад дагаж мөрдөх шаардлагатай холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн мэргэжлийн өндөр түвшинд зохион байгуулах;
- Андеррайтер нь Гэрээний дагуу гүйцэтгэвэл зохих үүрэг болон үзүүлэх үйлчилгээг нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн болон бодит жишигт нийцүүлэн үр ашигтай, хэмнэлттэй байдлаар гүйцэтгэх бөгөөд үр дүнтэй арга зүйг ашиглан үйл ажиллагааны шуурхай удирдлагыг хангаң ажиллана;
- Гэрээ болон үйлчилгээтэй холбоотой ямарваа нэгэн асуудлаар ямагт Үнэт цаас гаргагчийн Андеррайтерийн хувиар хандан ажиллаж, гуравдагч этгээдтэй харилцах аливаа харилцаанд Үнэт цаас гаргагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавих бөгөөд өөр төсөл арга хэмжээ болон өөрийн байгууллагын эрх ашигтай сонирхлын зөрчилд орохоос зайлсхийх;
- Гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан олж авсан Үнэт цаас гаргагчийн аливаа мэдээллийн нууцлалыг хадгалах, энэхүү үүргээ зөрчсөнөөс Үнэт цаас гаргагч болон аливаа гуравдагч этгээдэд учирсан бодит хохирлыг бүрэн хариуцах;
- Бондын анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулах, анхдагч зах зээлийн тайланг Үнэт цаас гаргагч, эрх бүхий этгээдүүдэд хүргүүлэх, эрх бүхий этгээдийн зөвшөөрлийн дагуу хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулах;
- Хөрөнгө оруулагч нарт бондын нөхцөл, түүний дэлгэрэнгүй мэдээллийг өгөх, бондыг олон нийтэд сурталчлах;
- Хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн Бондын гэрээ болон бондын үүргийн гүйцэтгэл хангуулах баталгаа болгон хувьцаа барьцаалах гэрээ байгуулах;
- Гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад.

**Андеррайтерийн эрх**

- Андеррайтерийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлэхэд шаардлагатай байж болох зааварчилгаа, удирдамжийг Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан болон удирдлагад гарган өгөх;
- Үнэт цаас гаргагчаас томилсон ажилтан нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд уг ажилтныг өөр чадвартай ажилтнаар солихыг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас гаргагч, түүний эрх бүхий этгээд нь нийтэд санал болгох үнэт цаасны үнийг үндэслэлгүйгээр тогтоосон эсхүл тус үнэ нь үнэт цаас гаргах үйл ажиллагааг амжилтгүй болгоход хүргэнэ гэж Андеррайтер үзсэн тохиолдолд Андеррайтер нь андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээс татгалзах;
- Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, хуваарилалт хийх зарчмыг тогтоох, хуваарилалтыг зохих ёсоор хийх;
- Өөрийн хэрэгсэлтэй холбоотой үнэн зөв мэдээлэл гаргаж өгөхийг Үнэт цаас гаргагчаас шаардах;
- Үнэт цаас гаргагчаас хууль болон Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн гүйцэтгэхийг шаардах;
- Гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад.

**Үнэт цаас гаргагчийн хүлээх үүрэг**

- Үнэт цаас гаргагч нь Андеррайтер ажил, үүргээ гүйцэтгэхэд шаардагдах аливаа зөвшөөрөл, түүнчлэн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий этгээдийн тогтоол шийдвэр, мэдээ мэдээлэл, баримт бичгүүдийг Андеррайтераас тогтоосон хугацаанд түргэн шуурхай, бүрэн гүйцэд гаргаж өгөх бөгөөд Андеррайтерийг гагцхүү үнэн зөв мэдээллээр хангах;
- Үнэт цаас гаргагч нь Андеррайтертай харилцах үнэт цаас гаргах бэлтгэл ажлыг хангахтай холбоотой ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтан, мэргэжилтэнг томилон ажиллуулах ба тэдгээр ажилтнууд нь удирдамжийн дагуу холбогдох ажил үүргийг зохих ёсоор гүйцэтгэж чадаагүй тохиолдолд түүнийг солих шаардлагыг Андеррайтерийн зүгээс тавьж болох бөгөөд Үнэт цаас гаргагч энэхүү шаардлагыг биелүүлэх;

- Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай анхан шатны баримт бичиг, мэдээлэл, үйлчилгээ үзүүлэх явцад шаардсан бусад баримт бичиг, мэдээллийг Андеррайтерийн санал болгосон хугацаанд, хугацаа заагаагүй бол 14 хоногийн дотор гаргаж өгөх;
- Стратегийн хөрөнгө оруулагчид танилцуулга хийх болон Бондыг нийтэд санал болгохтой холбоотойгоор танилцуулах аянд оролцох, танилцуулга хийх удирдах албан тушаалтан болон шаардлагатай мэргэжилтнүүдийг тодорхойлж, Андеррайтертай хамтран ажиллуулах;
- Бонд гаргах үйл ажиллагааны маркетинг сурталчилгаа, танилцуулах аяны ажлыг Андеррайтертай хамтран боловсруулсан маркетингийн төлөвлөгөөний дагуу саадгүй явуулах бүх шаардлагатай нөхцөлийг хангах;
- Андеррайтерийг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай өөрийн байр, барилгад үнэ төлбөргүй, ямар нэгэн саадгүйгээр нэвтрэх, зорчих баталгааг гаргах ба Андеррайтерийн ажилтнуудыг Бонд гаргагчийн ажлын байранд ажиллах хугацаанд шаардлагатай оффисын тоног төхөөрөмж болон эд хөрөнгийг үнэ төлбөргүйгээр ашиглуулах;
- Гэрээг хэрэгжүүлэх явцад Андеррайтераас Бонд гаргагчид хүргүүлсэн нийтэд ил болоогүй бүх төрлийн мэдээлэл, зөвлөмж, тайлан мэдээ, төсөл төлөвлөгөөний загвар, агуулга, мэдээлэл зэргийг Бонд гаргагч нь зөвхөн өөрийн дотоод хэрэгцээнд, үнэт цаас гаргах бэлтгэл ажил хангахад ашиглах ба эдгээр мэдээлэл, баримт бичиг болон Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх арга барил, ноу хау зэргийн нууцлалыг хадгалж, Андеррайтерийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр аливаа гуравдагч этгээдэд дамжуулахгүй байх;
- Гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад.

**Үнэт цаас гаргагчийн эрх**

- Андеррайтер нь Үйлчилгээг доголдолтой гүйцэтгэсэн бол доголдлыг өөрийн зардлаар арилгахыг шаардах;
- Андеррайтераас томилсон ажилтан нь үүргээ зохих ёсоор гүйцэтгэж чадахгүй байгаа тохиолдолд уг ажилтныг өөр чадвартай ажилтнаар солихыг Андеррайтераас шаардах;
- Андеррайтер нь Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол Үнэт цаас гаргагч нь Гэрээг түдгэлзүүлэх

мэдэгдлийг бичгээр үйлдэж, түүнд төлбөл зохих төлбөрийг түдгэлзүүлж болох бөгөөд энэхүү мэдэгдэлд (a) биелүүлээгүй үүргийн шинж чанарыг тодорхойлох ба (b) энэхүү мэдэгдлийг хүлээн авснаас хойш 30 хоногт багтаан тухайн зөрчлийг арилгах арга хэмжээ авахыг Андеррайтераас шаардах;

- Андеррайтерийн буруутай үйл ажиллагааны улмаас Бонд гаргагчийн нууц мэдээлэл задарсан бөгөөд Бонд гаргагчид бодит хохирол учирсан нь тогтоогдсон тохиолдолд тухайн бодит хохирлыг нөхөн төлөхийг Андеррайтераас шаардах;
- Гэрээ болон хууль тогтоомжид заасан бусад.

## 4.2 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | ӨЛЗИЙ ЭНД КО КАПИТАЛ ҮЦК ХХК |
|---|---|
| **Үйл ажиллагааны чиглэл** | Андеррайтер, Брокер, Дилер, номинал данс эзэмших, гадаад улсад үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээ үзүүлэх |
| **Үүсгэн байгуулагдсан огноо** | 2017/12/06 |
| **Улсын бүртгэлийн дугаар** | 9011125147 |
| **Регистрийн дугаар** | 5283855 |
| **Хаяг** | Монгол Улс, Улаанбаатар 14200 Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Сити тауэр, 25 давхар, 2506 тоот |
| **Утас** | 7777-6377 |
| **Цахим шуудан** | info@ucc.mn |

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын тэргүүний үнэт цаасны компаниудын нэг бөгөөд хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг үзүүлэх үндсэн зорилготойгоор 2007 онд байгуулагдсан билээ. Тус компани нь Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер болон андеррайтерийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн байгууллага юм.

Өлзий энд Ко капитал ҮЦК ХХК нь Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нарт олгож, мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажилладаг ба дотоодын үнэт цаасны арилжаа төдийгүй Хонгконг, Лондон, Австрали, НьюЙоркийн хөрөнгийн биржийн арилжаанд бодит цагийн горимоор хувьцаа болон бусад үнэт цаасыг

худалдах, худалдан авахад зуучилдаг ба энэхүү үйлчилгээг Монголд анх удаа нэвтрүүлсэн.

Хөгжлийн цоо шинэ шатандаа гарч байгаа Монголын компаниудад хөрөнгийн зах зээлээс хөрөнгө оруулалт татаж бизнесээ өргөжүүлэх боломжийг таниулан, бизнес болон санхүүгийн мэргэжлийн зөвлөгөө өгч хамтран ажилладаг. Мөн түүнчлэн салбартаа тэргүүлэгч томоохон компаниудын үнэт цаас гаргах үйл ажиллагаанд андеррайтерийн мэргэжлийн үйлчилгээг үзүүлж байна.

| | |
|---|---|
| 2008 он | Брокер дилер андеррайтерийн тусгай зөвшөөрөл авсан. |
| 2009 он | Лондонгийн хөрөнгийн бирж болон АНУ-н банк Bank New York Mellonтой хөрөнгө босгох боломжтийн талаарх форумыг анх удаа зохион байгуулсан |
| 2010 он | Монголд анх удаа HKEX, LSE, ASX, NYSE зэрэг биржүүдийн гадаадын арилжаанд оролцох үйлчилгээг нэвтрүүлсэн. |
| 2010 он | Bank of China International-тай түншлэв. |
| 2011 он | Шилдэг брокерийн компани |
| 2011 он | Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн |
| 2013 он | Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шинийг санаачлагч байгууллага” |
| 2015-2018 он | Япон улсын JICA хамтын ажиллагааны байгууллагад макро эдийн засгийн зөвлөх |
| 2016 он | Австралийн CPS Capital ҮЦК-ийн Монгол дахь төлөөлөгч |
| 2018 он | МҮОНТ-ийн “Ногоон сум” реалити шоуны ялагч |
| 2018 он | Гүйцэтгэх захирал Б.Өлзийбаяр нь Монголын хөрөнгийн зах зээлийн дээд шагнал Grand Bull Awards “Шилдэг Мэргэжилтэн” |
| 2019-2020 он | Үнэт цаасны арилжаанд голлох байр суурьтай оролцож, МХБ-ийн ТОП-5 ҮЦК-д багтсан |
| 2019 он | “Ард Кредит ББСБ” ХК-ийн IPO-д үндсэн андеррайтераар ажиллаж хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа захиалгын бүртгэлийн аргыг ашиглан, эрэлтэд үндэслэн хувьцааны үнийг тогтоов. |
| 2020 он | “ЛэндМН” ББСБ ХК-ийн нээлттэй бондын үндсэн андеррайтер |
| 2020 он | Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн шууд гишүүн |
| 2020 он | МҮОНТ-н “Цагийн хүрдийн баатар” |
| 2020 он | Европын сэргээн босголт хөгжлийн банкны брокер |
| 2021 он | Биржийн бус зах зээл /OTC/-ийн анхны гишүүн байгууллага |
| 2021 он | Монгол банк, СЗХ, Сангийн яамны хамтарсан тушаалаар батлагдсан “Sandbox” төслийн анхны бүтээгдэхүүн болох “Монпэй” бондын андеррайтер |
| 2021 он | Биржийн бус зах зээлийн /OTC/-ийн анхны “БИД” бондын андеррайтер |

| | |
|---|---|
| 2022 он | Биржийн бус зах зээл /OTC/-д гаргасан "Ашид капитал ББСБ" ХХК хаалттай бондын үндсэн андеррайтер |
| 2022 он | МҮОНТ-ийн орон даяарх "Ногоон сум" аянд хамтрагч компани |
| 2022 он | "Төрийн банк "ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтераар ажиллаж, системийн нөлөө бүхий банкууд нээлттэй хувьцаат болох эхлэлийг тавьсан. |
| 2022 он | "Сэндли ББСБ" ХК-ийн IPO-д Үндсэн андеррайтер |
| 2022 он | "ЛэндМН" ХБҮЦ-д хамтрагч андеррайтер |
| 2023 он | "Сэндли нээлттэй бонд"-д Үндсэн андеррайтер |
| 2023 он | Биржийн бус зах зээл (OTC)-д гаргасан "Үйзэн-Ивээлт ББСБ" ХХК хаалттай бондын Үндсэн андеррайтер |

Өнөөгийн байдлаар "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь:

- "Мобифинанс ББСБ" ХХК
- "Бэрс финанс ББСБ" ХХК
- "Бичил Глобус ББСБ" ХХК
- "Ард Кредит ББСБ" ХХК
- "Соно финтек ББСБ" ХХК
- "ЛэндМН ББСБ" ХХК
- "Микрокредит ББСБ" ХХК
- "БИД ББСБ" ХХК
- "АБТС ББСБ" ХХК
- "Ашид Капитал ББСБ" ХХК
- Капитрон банк
- "Хүлэгү Инженеринг" ХХК
- "Монголчех Метал" ХХК
- "Ай Си Ти групп"
- "Монголиан мючуал финанс групп"
- "Эрхэт Монгол групп"
- "Монголын финтек групп"
- "ОНДО" ХХК
- "Мишээл лайф стайл" ХХК
- "Гарнетон" ХХК
- "Шарын гол" ХК
- "Сүү" ХК
- "Говь экуйпмент рентал флийт"

зэрэг дотоодын тэргүүлэгч банк, банк бус санхүүгийн байгууллагууд болон уул уурхай, үйлдвэрлэл, харилцаа холбоо, барилга, технологийн салбарын компаниудад андеррайтерийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлэн нийт 200.0+ тэрбум төгрөгийн санхүүжилтыг татан төвлөрүүлээд байна.

## 4.3 ТУСЛАХ АНДЕРРАЙТЕРИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | ТЭНГЭР КАПИТАЛ ҮЦК ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2007/08/10 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011117009 |
| Регистрийн дугаар | 5157234 |
| Хаяг | Монгол Улс, Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Жамьян гүний гудамж 18/2, Мэру тауэр барилга, 10 давхар, 1003 тоот |
| Утас | 7011-0637 |
| Цахим шуудан | admin@tengercapital.mn |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ
2023 -07- 28

"Тэнгэр Капитал ҮЦК" ХХК нь 2007 онд байгуулагдсан ба Санхүүгийн зохицуулах хорооны үнэт цаасны зах зээл дээр Андеррайтер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй. Монголын хөрөнгийн бирж болон Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны гишүүн, Биржийн бус зах зээлийн шууд оролцогч байгууллага юм.

Монголын хөрөнгийн биржийн арилжаанд онлайнаар оролцох боломжийг харилцагч нартаа олгож, мэдээ мэдээллийг хүргэж ажилладаг ба Биржийн бус зах зээлийн арилжаанд үнэт цаас худалдан авах, худалдахад зуучилдаг.

"Тэнгэр Капитал ҮЦК" ХХК нь тогтвортой, ногоон санхүү, хөрөнгө оруулалт, үнэт цаасны андеррайтерийн үйлчилгээ, төслийн хөгжүүлэлтийн чиглэлээр мэргэшсэн чадварлаг баг, хамт олон бүхий байгууллага бөгөөд үүсэн байгуулагдсан цагаасаа хойш банк санхүү, эрүүл мэнд, худалдаа, үйлдвэрлэл, барилга, технологийн салбарууддад хэрэгжсэн томоохон хэлцлүүдэд оролцсоор ирсэн.

Үүнд:

- Эрүүл мэндийн салбарт 15.3 сая ам долларын өөрийн хөрөнгийн санхүүжилт
- Мэдээллийн технологийн салбарт 14.0 сая ам долларын өрийн санхүүжилт
- Цементийн зах зээлд 30.0 тэрбум төгрөгийн нэгдэн нийлэлт
- Үл хөдлөх хөрөнгийн зах зээлд 2.0 тэрбум төгрөгийн компанийн бонд
- Үл хөдлөхийн зах зээлд 10.0 сая ам долларын төслийн санхүүжилт
- Групп компанийн 2.5 тэрбум төгрөгийн үнэлгээтэй бизнес худалдах
- Даатгалын салбарт 6.0 тэрбум төгрөгийн нэгдэн, нийлэлт
- Уул уурхайн салбарт 2.5 тэрбум төгрөгийн татан буулгалт дээр тус тус ажилласан.

Тус компани нь дунд хугацааны стратеги төлөвлөлтөө Байгаль орчин, нийгэм, засаглалын стандартад нийцсэн тогтвортой ногоон санхүүгийн бүтээгдэхүүн хөгжүүлэх, харилцагчдыг тус чиглэлээр соён гэгээрүүлэх чиглэлд нийцүүлэн ажиллахаар тодорхойлсон бөгөөд байгаль орчин нийгэмд ээлтэй, эерэг нөлөөлөл үзүүлэхүйц төслүүдэд хөрөнгө татан төвлөрүүлэх, төслийн хөгжүүлэлтийг "ногоон, тогтвортой байдалд" нийцүүлэн гүйцэтгэх, харилцагчдын Байгаль орчин, нийгэм, засаглалын

стратеги төлөвлөлт, тайлагнал, үйл ажиллагааны гарыг авлагыг бэлтгэх, чадавх бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, бизнесийн нэгдэлт, нийлэлт (M&A)-ийн хэлцлийн хүрээнд бүх талын дэмжлэг үзүүлэх, санхүү, хөрөнгө оруулалт, үнэт цаасны андеррайтерийн үйлчилгээг тус тус үзүүлэн ажиллана.

## 4.4 АУДИТЫН КОМПАНИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | НИЙСЛЭЛ-АУДИТ ХХК |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Аудитын үйл ажиллагаа, Хөрөнгийн үнэлгээ, Үнэт цаасны зах зээлд оролцогчдод үйлчилгээ үзүүлэх |
| Үүсгэн байгуулагдсан огноо | 2005 |
| Улсын бүртгэлийн дугаар | 9011005110 |
| Регистрийн дугаар | 5009766 |
| Хаяг | Сүхбаатар дүүрэг, 6-р хороо, НҮБ-ын гудамж, 44-р байр 1 тоот |
| Утас | 318918, 70110095, 70120095 |
| Цахим шуудан | info@niislelaudit.mn |

Нийслэл-Аудит ХХК нь 2005 онд санхүүгийн тайлангийн аудит, баталгаажуулалт, нягтлан бодох бүртгэл, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх чиглэлээр байгуулагдсан. Нийслэл-Аудит ХХК нь үйл ажиллагаагаа Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай хууль, Санхүүгийн тайлагнал ба Аудитын олон улсын стандартыг мөрдлөг болгон мэргэжлийн ёс зүйн шаардлагад нийцүүлэн бие даасан, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулдаг үндэсний томоохон аудитын байгууллагуудын нэг юм.

**Тусгай зөвшөөрлүүд**

- Аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл № 052-2005;
- Хөрөнгийн үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл № 081100093;
- Үнэт цаасны зах зээлд оролцогчдод аудитын үйлчилгээ үзүүлэх эрх (СЗХ-ны 2015 оны 4 сарын 1-ний өдрийн 157 дугаар тогтоол)

**Үйл ажиллагааны чиглэлүүд**

*Аудитын үйлчилгээ*

- Санхүүгийн тайлангийн аудит ба баталгаажуулалт;
- Тусгай зориулалтын хүрээнд бэлтгэсэн санхүүгийн тайлангийн аудит;
- Салангид санхүүгийн тайлан, санхүүгийн тайлангийн тусгай бүрдэл хэсэг, данс, үзүүлэлтийн аудит;

- Гүйцэтгэлийн аудит;
- Санхүүгийн тайлангийн нягтлах үйлчилгээ;

*Зөвлөх үйлчилгээ*

- Санхүү нягтлан бодох бүртгэл хөтлөх зөвлөгөө;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах арга зүй;
- Татвар, нийгмийн даатгалын тайлан гаргахад туслах;
- Татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогчийн зөвлөгөө;
- Байгууллагын дотоод хяналтын системийг боловсронгуй болгох;

*Аутсорсингийн үйлчилгээ*

- Байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх;
- Татвар, нийгмийн даатгалын тайлан бэлтгэх;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт боловсруулах;
- Бизнес төлөвлөгөө, төсөл боловсруулах;
- Санхүүгийн тайланд шинжилгээ хийх;
- Байгууллагын хөрөнгийн тооллого хийх;
- Санхүүгийн баримтыг цэгцлэх; “Нийслэл Аудит” ХХК

*Хөрөнгийн үнэлгээ*

- Бизнесийн үнэлгээ;
- Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ;
- Эд хогшил, машин тоног төхөөрөмжийн үнэлгээ;

Нийслэл-Аудит ХХК нь эзэмшиж буй тусгай зөвшөөрлийн дагуу 2022 оны 12 сарын 31-ний байдлаар давхардсан тоогоор өмчийн бүх төрлийн 4200 гаруй аж ахуй нэгж байгууллагад санхүүгийн тайлангийн аудит, баталгаажуулалт, 22 аж ахуй нэгжид хөрөнгийн үнэлгээ, 28 байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримтыг боловсруулж өгснөөс томоохныг нь дурдвал:

НЭГ. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ, БАТАЛГААЖУУЛАЛТЫН АЖИЛ

А. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД (үйл ажиллагааны чиглэлээр):

Зам , барилга, тээврийн салбар

Зорчигч Тээврийн Нэгтгэл ОНӨААТҮГ;
Нийслэлийн Нийтийн Тээврийн Газар;
Иргэний Нисэхийн Ерөнхий Газар;
Эрдэнэ Зам ХХК;
Улаанбаатар АЗЗА ХК

Банк, санхүү, даатгалын салбар

Төрийн Банк;
Капитрон Банк;
Ард Даатгал;
Монре Даатгал;
Монгол Даатгал;
Соёмбо Даатгал;
Улаанбаатар Даатгал;
Нийслэлийн Нийгмийн Даатгалын Газар;

Боловсролын салбар

Монгол Улсын Их Сургууль;
Улаанбаатар Их Сургууль;
Сант Бүрэн Дунд Сургууль;
Монголын Хүүхдийн Ордон;
Улаанбаатар дахь Олон Улсын Дунд Сургууль;
Жет Дунд Сургууль;

Мэдээлэл холбоо, шуудангийн салбар

Монгол Шуудан ТӨХК;
Мэдээлэл Харилцаа Холбоо Технологийн Газар;
Улаанбаатар Телевиз ХХК;
Ситинэтворкс ХХК

Эрчим хүч, уул уурхайн салбар

Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц ТӨХК;
ТЭЦ II ТӨХК;
ТЭЦ III ТӨХК;
Цайрт Минерал ХХК;

Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний салбар

Илч Түлш ХХК
Магнай трейд групп;
Ус Сувгийн Удирдах Газар;
Орон Сууц Нийтийн Аж Ахуйн Удирдах Газар;
Оол-Эм Групп;
Жагар интернэшнл ХХК;
Монтээвэр ХХК;
Хүрд ХХК;
Монгол Базальт ХХК;

## Б. ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖ БОЛОН ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГААС САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСЛҮҮД:

- Дэлхийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжсэн төслүүд:
- Засаглалыг Дэмжих, Эдийн Засгийн Чадавхийг Хөгжүүлэх Төсөл;
- Хувийн Хэвшилийг Дэмжих Зээлийн Төсөл;
- Санхүүгийн Чадавхийгхөгжүүлэх Төсөл;
- Хөдөөгийн Цахилгаан Хангамжид Сэргээгдэх Эрчим Хүчийг Ашиглах Төсөл;
- Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлыг Сайжруулах Төсөл;
- Шувууны Томуугийн Төсөл;
- Хөдөөгийн Боловсролыг Дэмжих Төсөл;
- Бүх Нийтийн Боловсролыг Дэмжих Төсөл;
- Олон Салбарыг Хамарсан Техник Туслалцааны Төсөл;
- Уул Уурхайн Техник Туслалцааны Төсөл;
- Боловсролын Чадавхийг Сайжруулах Төсөл;
- Хөдөө Аж Ахуйн Маркетинг, Бодлогын Дүн Шинжилгээ Мониторингийг Сайжруулах Төсөл;

- Алслагдсан Хөдөөгийн Малчдын Хүүхдүүдийн Бага Боловсролын Үр Дүнг Сайжруулах Төсөл;
- Боловсролын Чанарын Шинэчлэлийн Төсөл;
- Цахим Эрүүл Мэндийн Төсөл;
- Бодлогын Дүн Шинжилгээ, Мониторингийн Чадавхийг Бэхжүүлэх Төсөл;
- Улаанбаатар Хотын Цэвэр Агаар Төсөл;
- Орон Нутгийн Дулаан Хангамжийг Сайжруулах Төсөл;
- Улаанбаатар Хотын Эмзэг Бүлгийн Эрүүл Мэндийг Сайжруулах Төсөл;
- Хот Хөгжүүлэх Төсөл;
- НҮБ-ийн санхүүжилтээр Монгол улсад хэрэгжсэн төслүүд:
- Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах төсөл;
- Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Монгол Улсад хэрэгжсэн төслүүд:
- Баруун бүсийн автозам сайжруулах төсөл;
- Боловсролын III төсөл;
- Эрүүл мэндийн III төсөл;
- Хот хөгжүүлэх төсөл;
- Иргэдийн оролцоонд тулгуурласан дулааны нийлүүлэлтийн үр ашгийг нэмэгдүүлэх төсөл;
- Улаанбаатар хотын эмзэг бүлгийхэнд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээний төсөл;
- Монгол улсын Засгийн газар, Япон улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжсэн төслүүд:
- Тогтвортой амжиргаа-II төсөл;
- Алслагдсан хөдөөгийн малчдын хүүхдүүдийн бага боловсролын үр дүнг сайжруулах төсөл;

ХОЁР. ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц;
Онцгой Байдлын Ерөнхий Газар;
Патрикейн ХХК;
Эр И Эй Б ХХК;
Шижир Алт ХХК;
Сити Инвест ХХК;
Саусгоби Сэндс ХХК;
Кино Урлагийн Дээд Сургууль;

ГУРАВ. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГЫН БИЧИГ БАРИМТ

Нийслэлийн Хөрөнгө Оруулалтын Газар
Хөдөө Аж Ахуйн Давхар Даатгал
Сант Дунд Сургууль
Гадаадын Иргэн Харьяатын Газар

## Аудитын үйлчилгээний гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Энэхүү гэрээний зорилго нь Монгол улсын “Иргэний хууль”, “Нягтлан бодох бүртгэл”, “Аудитын тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, олон улсын хэмжээнд дагаж мөрддөг санхүүгийн тайлагналын болон аудитын стандарт (“СТОУС”)-ын дагуу үнэт цаас гаргагчийн 2023 оны 03 сарын 31-ны өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлан, тэнцэлд аудит хийж, тайлан дүгнэлт гаргахад оршино.

- Аудитын явцад илэрсэн бүртгэл хөтлөлтийн болон санхүүгийн тайлантай холбоотой алдаа, зөрчлийг залруулах эсэх талаар зөвлөмж, санал өгөх үүрэгтэй.
- Аудитаар олж авсан хангалттай, зохистой нотлох баримтад үндэслэн хараат бус аудиторын тайлан, дүгнэлт гаргах, шаардлагатай бол нэмэлт тайлбар бичих;
- Аудитын үйл ажиллагааны гэрээнд заасан ажил үүргийг гүйцэтгэхтэй холбогдсон баримт, мэдээллийг гаргуулж авах, ажиглалт, асуулга, ярилцлага, тулган баталгаажуулалт хийх эрхтэй.
- Аудитор нь аудитын ажлыг хийж, гүйцэтгэхдээ Нягтлан Бодогчдын Олон Улсын Холбооны Аудит ба Баталгаажуулалтын Олон Улсын Стандартын Зөвлөл-өөс батлан гаргасан Аудитын Олон Улсын Стандарт, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл-өөс батлан гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд болон Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартууд, Монгол Улсын Их Хурлаас баталсан Аудитын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжууд, Аудит, Нягтлан бодох бүртгэлийн талаарх Сангийн сайдын тушаалаар батлагдсан, бусад заавар журам, аргачлалуудыг мөрдлөг болгож ажиллана.

## 4.5 ХУУЛИЙН КОМПАНИЙН ТУХАЙ

| Байгууллагын нэр | ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС ХХН |
|---|---|
| Үйл ажиллагааны чиглэл | Хууль зүйн зөвлөх үйлчилгээ |
| Улсын бүртгэлийн дугаар | 9022001010 |
| Регистрийн дугаар | 5495997 |
| Хаяг | Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай гудамж, Сентрал Тауэр, 13 давхар, 1301 тоот |
| Утас | 11-330048 |
| Цахим шуудан | info@mdsa.mn |
| Байгууллагын нэр | “Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс” ХХН |

Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН нь Монгол Улсын томоохон хуулийн фирмүүдийн нэг бөгөөд “Илүү сайн үйлчилгээ үзүүлэх” зорилготойгоор 2011 онд байгуулагдсан цагаасаа хойш гадаад, дотоодын бизнесийн байгууллагуудад дэлхийн стандартад нийцсэн хууль зүйн үйлчилгээг дотоодын туршлага, ур чадвартай хослуулан хүргэдэг.

Өмгөөллийн Эм Ди Эс энд ХаанЛекс ХХН нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2.1-д заасан үнэт цаасны зах зээлд хууль зүйн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр бүртгэгдсэн, үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээд бөгөөд тус зах зээлээс санхүүжилт татаж буй компаниудтай хамтран ажиллаж байсан арвин туршлагатай. Үүнд, тухайлбал:

- "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн Монгол, Хонг Конг, Лондонгийн хөрөнгийн биржүүд дээр хувьцааг нийтэд анх удаа санал болгох Wolf Төслийн Монголын хууль тогтоомжтой холбоотой зөвлөгөөг өгөх, эрх зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлтийн төсөл боловсруулах;
- Монгол Улсын Хөрөнгийн Бирж дээр гаргасан анхны 100% даатгагдсан Эрчим бонд гаргах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, хууль зүйн магадлан шалгалт хийх, хууль зүйн дүгнэлт гаргах болон
- "ЛэндМН ББСБ" ХК-ийн IPO, 3 удаа бонд гаргаж олон нийтэд санал болгох, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг олон нийтэд санал болгон гаргах төслүүд;
- "Инвескор ББСБ" ХК-ийн IPO, бонд, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган олон нийтэд санал болгох, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох төслүүд, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах, үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах, биржийн бус зах зээлд компанийн өрийн хэрэгсэл гаргах төслүүд;
- "Түмэн шувуут" ХК-ийн IPO;
- "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- "Сүү" ХК-ийн нэмэлт хувьцаа гаргах төсөл;
- Монголын ипотекийн корпорацийн 1-13, 21, 23, 24, 28, 29 дэх орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан үнэт цаас гаргах төсөл;
- "Сэндли ББСБ" ХК-ийн IPO, олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргах төсөл;
- "Бэрс Финанс ББСБ" ХХК-ийн 2 удаагийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гарган олон нийтэд санал болгох төсөл;
- "Төрийн банк" ХК-ийн IPO;
- "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн IPO төсөлд хууль зүйн судалгаа шинжилгээ хийж, хууль зүйн дүгнэлт гаргах ажлуудыг тус тус гүйцэтгэсэн туршлагатай.

Хуульч, хуулийн фирмүүдийн чансаа тогтоодог Asia Law сэтгүүлээс "Өмгөөллийн Эм Ди Эс Энд Хаанлекс" ХХН-ийг 2021, 2022 оны "Монгол улсын шилдэг хуулийн фирм"-ээр шалгаруулсан бөгөөд тус фирмийн хөрөнгийн зах зээлд үзүүлсэн үйлчилгээг онцлон тэмдэглэсэн байдаг.

## Хууль зүйн зөвлөхтэй байгуулсан гэрээний тухай

### Хууль зүйн зөвлөхийн гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг

Хуулийн зөвлөх дараах эрх эдэлнэ.

- Гэрээнд заасан үүргээ гүйцэтгэхийг Үйлчлүүлэгчээс шаардах,
- Гэрээний төлбөрөө Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэхийг шаардах,
- Үйлчлүүлэгч нь Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Гэрээг цуцлах,
- Гэрээнд заасан Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор тухай бүрт шаардлагатай мэдээ мэдээлэл, баримт бичгийг Үйлчлүүлэгчээс шаардан авах.

Хуулийн зөвлөх дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

- Хуулийн зөвлөх нь Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор, Гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх,
- Хуулийн зөвлөх нь гаргасан хөндлөнгийн шинжилгээний тайлан, хуулийн дүгнэлттэй холбогдуулан шаардлагатай тохиолдолд зөвлөмж гаргах, шалгасан материалын хүрээнд тайлбар, тодруулга өгөх, танилцуулга хийх,
- Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэхдээ үнэн бодит мэдээллэр хангах, үйлчилгээ үзүүлсэн талаар бүртгэл хөтлөх, тайлан гаргах, Үйлчлүүлэгчийн нууцыг чандлан хадгалах.

### Хариуцлага

- Үйлчлүүлэгч нь Хуулийн зөвлөхөд Зөвлөх үйлчилгээтэй холбоотой байж болох аливаа бүх мэдээллийг бүрэн бөгөөд үнэн зөвөөр өгөх үүрэгтэй. Энэ зүйлд заасан "Мэдээлэл" гэдэгт бичгийн, аман, дуу, дүрс, ам дамжсан яриа, бодит таамаг гэх мэт үйлчилгээ авах асуудалтай холбоотой бүх хэлбэр, төрлийн мэдээ, мэдээлэл, мэдүүлэг зэрэг үйлчилгээ үзүүлэхэд ач холбогдолтой болон ач холбогдолтой байж болох Үйлчлүүлэгч, түүний ажилтан, албан хаагч, төлөөлөгч, Холбоотой этгээдийн мэдэж байгаа аливаа зүйлийг ойлгоно.
- Үйлчлүүлэгч дээрх заалтад заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд үүсэх хариуцлагаас Хуулийн зөвлөх чөлөөлөгдөнө.

lendmn

Үнэт цаасны танилцуулга

# V. ДҮГНЭЛТҮҮД

## 5.1 АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ /2022 оны жилийн эцсийн байдлаар/



MNR MONGOLIAN NATIONAL REPORTING AUDIT | АУДИТ БАТАЛГААЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ

# АУДИТОРЫН ТАЙЛАН

**ЛЭНДМН ББСБ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУДЫН 2022 ОНЫ 12 САРЫН 31-ЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, Ж.Самбуугийн гудамж-24, M Plaza, 607 тоот

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**

---

**АГУУЛГА** **ХУУДАС**


| | |
|---|---|
| КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 |
| ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3-4 |
| НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 5 |
| НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 7 |
| НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 8-9 |
| НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 10-33 |


ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023.08.11
БҮРТГЭВ

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

"ЛэндМН ББСБ" ХК /цаашид "Компани" гэх/ мөн түүний охин компани (хамтран "Групп" гэх)-ийн Гүйцэтгэх захирал Цэрэндорж овогтой Ууганбаяр би группийн гүйцэтгэх удирдлагын хувьд, ерөнхий нягтлан бодогч Ганболд овогтой Золжаргал би гүйцэтгэх удирдлагын хувьд ард хавсаргасан 1-ээс 31 хуудас дахь группийн санхүүгийн тайлангуудыг холбогдох Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон холбогдох тодруулгуудыг шударгаар үзүүлж байна гэдгийг үүгээр мэдэгдэж байна. Энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.

| | |
|---|---|
| **Ц. Ууганбаяр**<br>Гүйцэтгэх захирал | **Г. Золжаргал**<br>Ерөнхий нягтлан бодогч |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

**“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ**

| | |
|---|---|
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: | О. Болдбаатар |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД: | Б. Хос-Эрдэнэ<br>В. Баярсайхан<br>Ц. Ууганбаяр<br>Б. Иттэл<br>С. Энх-Амгалан |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД: | С. Боргил<br>Ж. Жаргалсүрэн<br>Д. Галхүү |
| ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ | Ц. Ууганбаяр |
| АЛБАН ХАЯГ | Монгол улс, Улаанбаатар хот , Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34, Сувд төв |
| ХАРИЛЦАГЧ БАНКУУД | Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банк,Төрийн банк, Хас банк, Хаан банк, Капитрон банк |
| АУДИТОР | “Монголын Үндэсний Тайлагнал Аудит” ХХК |

1 MNR-AUDIT

СЗХ 2023.08.11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

**“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД**

---

| АГУУЛГА | ХУУДАС |
|---|---|
| КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ | 1 |
| ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ | 2 |
| ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3-4 |
| НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН | 5 |
| НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН | 6 |
| НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН | 7 |
| НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН | 8-9 |
| НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД | 10-33 |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1116267206
RHINOS INVESTMENT ҮЦК

MNR MONGOLIAN NATIONAL REPORTING AUDIT

"ЛЭНДМН ББСБ"ХК-ийн
хувьцаа эзэмшигчдэд

**МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ТАЙЛАГНАЛ АУДИТ ХХК**
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо, Самбуугийн гудамж, М Плаза
оффис 6 давхар, 607 тоот
Утас: 99117121; 89601000
И-мэйл: info@mnraudit.mn

2023.02.06 дугаар 23-01/30

Танай _______ - ны дугаар _______ -т

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### Дүгнэлт

Бид "ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН ГРУППУУДАД ('Групп' гэх)-ийн 2022 оны 12 сарын 31-нээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангүй багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний үзэж байгаагаар эдгээр санхүүгийн тайлангууд нь бүхий л материаллаг асуудлаар Группийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн нэгтгэсэн санхүүгийн гүйцэтгэл болон нэгтгэсэн мөнгөн гүйлгээг Монгол Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-уудын дагуу үнэн зөв толилуулж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын олон улсын стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэхүү тайлангийн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид Нягтлан бодогчдын Ёс зүйн олон улсын стандартын зөвлөл (НБЁЗОУСЗ)- өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Аудитын тухай Монгол улсын хуулиар санхүүгийн тайлангийн аудитад тавигддаг ёс зүйн шаардлагын дагуу группээс хараат бус бөгөөд хууль болон НБЁЗОУСЗ-өөс гаргасан дүрмийн шаардлагын дагуу тавигддаг ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний гаргасан тайланд томоохон хэмжээний аудитын гол асуудал байхгүй гэж тодорхойлж байна.

### Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

3 MNR-AUDIT

ЛЭНДМН ББСБ ХК Хараат бус аудиторын тайлангийн (үргэлжлэл)

**Удирдлага болон Засаглах Эрх Мэдэл Бүхий Этгээдүүдийн Санхүүгийн тайлангийн талаар хүлээх үүрэг хариуцлага (Үргэлжлэл)**

Нэгтгэсэн санхүүгийн тайлант гаргахдаа удирдлага Группийн үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр аргагүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах Группийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Группийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлага хүлээдэг.

**Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага**

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлнэ гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилангаас эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудитын хэсэг болгон мэргэжлийн үнэлэмж ашиглаж, аудитын турш мэргэжлийн үл итгэх байр суурийг баримталдаг. Түүнчлэн бид:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг үл ойшоох явдлууд багтсан байж болно.
- Нягтланд бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Группийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Групп тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ болон хугацаа, аудитын томоохон илрүүлэлт, аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын томоохон дутагдал болон холбогдох бусад асуудлаар засаглах удирдлагатай харилцдаг

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Монгол Улсын "Группийн тухай хууль" -ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох "ЛЭНДМН ББСБ"ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК
Улаанбаатар хот, Монгол Улс
2023 оны 02 дугаар сарын 06

Г. ГАНБОЛД
Мэргэшсэн нягтлан бодогч, Партнер

4 MNR-AUDIT

СЭХ 2023 .08. 11 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

**“ЛЭНДМН ББСБ ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН АШИГ АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

| | Тодруулга | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| **Үргэлжилж буй үйл ажиллагаа** | | | |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 15 | 12,491,742 | 20,214,948 |
| Хүүний зардал | 15 | (2,798,653) | (3,949,884) |
| **Цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого** | | **9,693,089** | **16,265,064** |
| Зээлийн үнэ цэнийн бууралтын зардал | 16 | 725,556 | (1,438,655) |
| **Үнэ цэнийн бууралтын зардлын дараах цэвэр хүү болон түүнтэй адилтгах орлого** | | **10,418,645** | **14,826,409** |
| Удирдлага болон үйл ажиллагааны зардал | 17 | (5,843,135) | (7,656,249) |
| Бусад орлого/(зардал), цэвэр | 18 | (104,039) | (637,914) |
| **Татварын өмнөх ашиг** | | **4,471,471** | **6,532,246** |
| Орлогын албан татварын зардал | 19 | (469,564) | (1,007,265) |
| **Үргэлжилж буй үйл ажиллагааны тайлант жилийн цэвэр ашиг** | | **4,001,907** | **5,524,981** |
| **Зогссон үйл ажиллагаа** | | | |
| Татвар төлсний дараах үйл ажиллагаа зогссон жилийн алдагдал | | (110,996) | - |
| **Тайлант жилийн цэвэр ашиг буюу толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд ногдох нийт дэлгэрэнгүй орлого** | | **3,890,911** | **5,524,981** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг** | | | |
| **Толгой компанийн хувьцаа эзэмшигчид** | | **төг** | **төг** |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг | 22 | 5.17 | 7.47 |
| Үргэлжилж буй үйл ажиллагааны нэгж хувьцаанд ногдох үндсэн болон шингэрсэн ашиг | 22 | 5.31 | 7.47 |

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
5 MNR-AUDIT
RHINOS INVESTMENT LLC

**"ЛЭНДМН ББСБ " ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

| | Тодруулга | 2021 | 2022 |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө | 4 | 4,903,678 | 5,217,581 |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 5 | 31,817,691 | 64,586,683 |
| Бусад хөрөнгө | 6 | 713,788 | 768,409 |
| Хөрөнгө оруулалт | | - | 172,230 |
| Урьдчилж төлсөн төлбөр | 7 | 18,796 | 45,437 |
| Орлогын албан татварын авлага | | - | - |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | 37,453,953 | 70,790,340 |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа | 5 | 608,356 | 4,999,597 |
| Биет бус хөрөнгө | 8 | 447,838 | 401,095 |
| Үндсэн хөрөнгө | 9 | 392,047 | 373,470 |
| Ашиглах эрхтэй хөрөнгө | | 371,235 | 217,592 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 21 | 33,133 | 76,663 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **1,852,609** | **6,068,417** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **39,306,562** | **76,858,757** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Зээл | 10 | 6,745,667 | 33,066,256 |
| Түрээсийн өр төлбөр | 11 | 243,626 | 285,772 |
| Бусад өр төлбөр | 12 | 956,227 | 2,622,414 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүр | | - | - |
| Орлогын албан татварын өглөг | 20 | 38,221 | 815,146 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | 7,983,741 | 36,789,588 |
| Зээл | 10 | 11,275,923 | 15,839,268 |
| Түрээсийн өр төлбөр | 11 | 233,025 | - |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **11,508,948** | **15,839,268** |
| **Нийт өр төлбөрийн дүн** | | 19,492,689 | 52,628,856 |
| **Эздийн өмч** | | | |
| Хувьцаат капитал | 13 | 10,756,859 | 10,756,859 |
| Халаасны хувьцаа | 14 | (2,337,547) | (2,337,547) |
| Бусад нөөц | | 57,348 | 57,348 |
| Хуримтлагдсан ашиг | | 11,337,213 | 15,753,241 |
| **Нийт цэвэр эздийн өмч** | | **19,813,873** | **24,229,901** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БОЛОН ЭЗДИЙН ӨМЧ** | | **39,306,562** | **76,858,757** |

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ

6 MNR-AUDIT

2023 .08. 11
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

/мян.төг/

| | Хувьцаат капитал | Халаасны хувьцаа | Бусад нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт Эздийн өмч |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар** | **10,756,859** | **(988,939)** | **57,348** | **7,888,550** | **17,713,818** |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | 3,890,911 | 3,890,911 |
| Ногдол ашиг | - | - | - | (442,248) | (442,248) |
| Халаасны хувьцаа | - | (1,348,608) | - | – | (1,348,608) |
| **2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **10,756,859** | **(2,337,547)** | **57,348** | 11,337,213 | 19,813,873 |
| Тайлант жилийн цэвэр ашиг болон тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого | - | - | - | 5,524,981 | 5,524,981 |
| Ногдол ашиг | - | - | - | (1,108,953) | (1,108,953) |
| **2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | 10,756,859 | (2,337,547) | 57,348 | 15,753,241 | 24,229,901 |

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK
ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206
MNR-AUDIT

СЗХ
2023 .08 сар 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

**“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Татварын өмнөх ашиг | 4,471,471 | 6,532,246 |
| Татвар төлсний дараах үйл ажиллагаа зогссон жилийн алдагдал | (97,818) | - |
| Тохируулга: | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын зардал | (741,499) | 1,381,057 |
| Охин компани борлуусны олз | (9,538) | - |
| Ашиглах эрх бүхий хөрөнгө болон үндсэн хөрөнгийн элэгдэл | 356,141 | 386,554 |
| Биет бус хөрөнгийн хорогдуулга | 51,851 | 46,743 |
| Олгогдохоор батлагдсан зээлийн үүргийн үнэ цэнийн бууралт/(буцаалт) | 15,943 | 57,598 |
| Түрээсийн хөнгөлөлтийн олз | (21,855) | - |
| Түрээсийн өглөгийн хуримтлагдсан хүү | 106,206 | 80,761 |
| Зээлийн хүүний зардал | 2,692,447 | 3,869,123 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүрийн бодит үнэ цэнийн (олз)/гарз | (124,549) | - |
| Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн бодит бус зардал | 79 | 385,521 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны алдагдал | - | 4,419 |
| **Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны ашиг** | **6,698,879** | **12,744,022** |
| Үйл ажиллагааны хөрөнгө, өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны цэвэр (өсөлт)/бууралт | (6,253,588) | (38,541,290) |
| Бусад хөрөнгийн цэвэр (өсөлт)/бууралт | 305,016 | (54,621) |
| Урьдчилж төлсөн төлбөрийн цэвэр (өсөлт)/бууралт | (13,959) | (26,641) |
| Бусад өр төлбөрийн цэвэр өсөлт/(бууралт) | 1,907,320 | 1,608,589 |
| **Үйл ажиллагаанаас орсон/(-ид зарцуулсан) мөнгөн гүйлгээ** | **2,643,668** | **(24,269,941)** |
| Орлогын албан татварын төлөлт | (359,823) | (269,808) |
| Гуравдагч этгээдийн суутгаж авсан албан татвар | - | (4,062) |
| Түрээсийн өглөгийн хүүгийн төлөлт | (106,206) | (80,761) |
| Хүүний төлбөр | (3,057,793) | (3,857,595) |
| **Үйл ажиллагаанаас орсон/(-ид зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | **(880,154)** | **(28,482,167)** |

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039424 № 1118257286

MNR-AUDIT

RHINOS INVESTMENT ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ** | | |
| Санхүүгийн хэрэгсэл худалдан авалт | - | (172,230) |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | (97,983) | (112,435) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | (169,604) | - |
| Үндсэн хөрөнгийн борлуулалт | 10,422 | - |
| Охин компанийн борлуулалт | 2,650,158 | - |
| Охин компанийн борлуулахатай холбоотой мөнгөн урсгал | (1,409,167) | - |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | **983,826** | **(284,665)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| Халаасны хувьцааны худалдан авалтын төлөлт | (1,348,608) | - |
| Хаалттай бонд гаргаснаас орсон мөнгө | 7,500,000 | 7,779,662 |
| Зээлийн эх үүсвэрээс орсон мөнгө | 6,443,500 | 13,717,978 |
| Итгэлцлийн үйлчилгээнээс орсон мөнгө | 5,561,095 | 17,864,887 |
| Хаалттай бондын эргэн төлөлт | (7,361,459) | (20,000) |
| Зээлийн эх үүсвэрийн эргэн төлөлт | (6,458,500) | (4,881,238) |
| Итгэлцлийн үйлчилгээний эргэн төлөлт | (8,413,380) | (3,974,404) |
| Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт | (181,911) | (297,197) |
| Төлсөн ногдол ашиг | (442,248) | (1,108,953) |
| **Санхүүгийн үйл ажиллагаанаас орсон/(-нд зарцуулсан) цэвэр мөнгөн гүйлгээ** | **(4,701,511)** | **29,080,735** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)** | **(4,597,839)** | **313,903** |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 9,501,517 | 4,903,678 |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **4,903,678** | **5,217,581** |

9 MNR-AUDIT

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 1. КОМПАНИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**"ЛЭНДМН ББСБ" ХК** (цаашид "Компани" гэх) нь Монголын Хөрөнгийн Биржид (цаашид "МХБ" гэх) бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, хувь нийлүүлсэн хувьцаат компани. Компани нь 2018 оны 3 дугаар сарын 14-ний өдөр МХБ дээр бүртгэлтэй болсноор нээлттэй хувьцаат компани болсон. Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос (цаашид "СЗХ" гэх) 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдөр олгосон 1/493 тоот банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа мөн онлайн төлбөр тооцоо гүйцэтгэх үйл ажиллагаа явуулдаг. . Түүнчлэн Компани нь СЗХ-оос 2019 оны 3 дугаар сарын 20-ны өдөр олгогдсон 45 тоот дугаартай Итгэлцлийн болон Факторингийн үйлчилгээ, 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдөр олгогдсон 128 тоот дугаартай Гадаад валютын арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрлүүдийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна

**Компанийн албан ёсны хаяг нь:** Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34, Сувд төв

**Компанийн үндсэн үйл ажиллагааны чиглэл нь:** Компани болон түүний охин компани (хамтад нь "Групп" гэх) нь зэргэлдээ охин компани болох Монгол Улсад үүсгэн байгуулагдсан Анд Системс Тех ("АНД Системс Тех") -ийн хөгжүүлэн гаргасан ЛэндМН технологийг ашиглан зээлийн үйлчилгээ огт/хангалттай хэмжээнд авч чаддаггүй хүмүүст гар утсанд суурилсан санхүүгийн үйлчилгээ буюу 24/7 цахим зээлийн үйлчилгээг үзүүлдэг. ЛэндМН технологи нь Анд Системс Тех-ийн хөгжүүлэн гаргасан "финтек" шийдэл бүхий технологи бөгөөд технологийн лицензийг Анд Системс Тех эзэмшдэг. 2018 онд Компани нь ЛэндМН технологиор дамжуулан төрөл бүрийн төлбөр тооцоо, санхүүгийн гүйлгээ хийх "Лэнд Хэтэвч" шинэ бүтээгдэхүүнийг нэвтрүүлэн үйл ажиллагааны цар хүрээгээ өргөжүүлсэн.

**Компанийн эцсийн толгой компани** нь Сингапур Улсад бүртгэлтэй, финтек компани болох Анд Глобал Пти.Лтд.

Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасныас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөг ("төг")-өөр тайлагнасан.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД

### 2.1 Тайлан бэлтгэх үндэслэл

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланг түүхэн өртгийн зарчмаар бэлтгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр заасныас бусад тохиолдолд мянганы орноор, Монгол төгрөгөөр тайлагнасан.

**Нийцтэй байдлын мэдэгдэл**

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗХ)-өөс баталж гаргасан санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

10 MNR-AUDIT

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**2.1 Тайлан бэлтгэх үндэслэл (үргэлжлэл)**

**Нэгтгэлийн үндэслэл**

Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлан нь Компани болон түүний охин компанийн санхүүгийн тайлангуудаас бүрдэнэ.

**Нэгтгэгдсэн охин компани**

| Компанийн нэр | Эзэмшил % |
|---|---|
| "Лэндмн Актив ТЗК" ХХК | 100% |

Охин компани нь Групп хяналт тавьсан өдрөөс эхлэн уг хяналтыг зогсоох хүртэлх хугацааны тайланг бүрэн нэгтгэсэн байна. Түүнчлэн Охин компанийн санхүүгийн тайлангууд нь түүний толгой компанийн санхүүгийн тайлантай ижил хугацааг хамарсан байх бөгөөд нягтлан бодох бүртгэлийн ижил төстэй бодлогуудыг баримтлан бэлтгэсэн байна. Групп хоорондын бүх баланс, гүйлгээ, орлого, зардлуудыг бүрэн хассан байна.

**2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо**

**a. Эргэлтийн болон эргэлтийн бус ангилал**

Компани хөрөнгө болон өр төлбөрүүдийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд эргэлтийн болон эргэлтийн бус ангиллын дагуу толилуулна. Дараах тохиолдолд хөрөнгө эргэлтийн хөрөнгө болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад хэрэгжих болон борлуулах хандлагатай эсвэл хэрэглэхээр хүлээгдэж байгаа
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор хэрэгжихээр хүлээгдэж байгаа эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сарын дотор солилцох эсвэл өр төлбөр барагдуулахыг хязгаарлаагүй бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Бусад бүх хөрөнгө нь эргэлтийн бус хөрөнгө болно.
Өр төлбөр нь дараах тохиолдлуудад богино хугацаат өр төлбөр болно:

- Хэвийн үйл ажиллагааны явцад төлөгдөхөөр хүлээгдэж буй
- Худалдах үндсэн зорилгоор эзэмшиж байгаа
- Тайлант хугацаанаас хойш 12 сарын дотор төлөх хугацаатай, эсвэл
- Тайлант хугацаанаас хойш хамгийн багадаа 12 сар өр төлбөр барагдуулалтыг хойшлуулах нөхцөлгүй

Компани бусад бүх өр төлбөрүүдийг эргэлтийн бус гэж ангилдаг.

MNR-AUDIT

2023.08.11
2023-07-28
БҮРТГЭЛ-02

“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### б. Гадаад валютын хөрвүүлэлт

Компанийн нэгтгэсэн санхүүгийн тайлант Компанийн үйл ажиллагааны мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр илэрхийлнэ. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээг хүлээн зөвшөөрөх шаардлага хангасан өдрийн ханшаар мөнгөн нэгжрүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэгдсэн мөнгөн хөрөнгө, төлбөрүүдийг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн ханшаар дахин хөрвүүлдэг. Бүх зөрүүг орлого, зардлын дансанд бүртгэнэ.

Түүхэн өртгөөр хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг тэдгээрийн анхны гүйлгээ хийгдсэн өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнэ нь гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ.Бодит үнэ цэнээр хэмжигдэх, мөнгөн зүйлсийн хөрвүүлэгээс үүссэн олз, гарзыг бодит үнэ цэнийн өөрчлөлтийн олз, гарзыг хүлээн зөвшөөрөхтэй адилаар хүлээн зөвшөөрнө(өөрөөр хэлбэл бодит үнэ цэнийн зөрүү нь бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд хүлээн зөвшөөрөгдсөн зүйлийн ханшийн зөрүүнээс үүссэн олз, гарзыг мөн адил бусад дэлгэрэнгүй орлого, олз гарзын тайланд бүртгэнэ).

### в. Орлого болон зардлын хүлээн зөвшөөрөлт

Хүүний орлого эсвэл хүүний зардлыг чанаргүй төлөвт орсон хэрэглүүрээс бусад санхүүгийн хэрэглүүрийн хувьд үр ашигт хүүний аргыг ашиглан аккруэл сууриар бүртгэнэ. Энэ аргын дагуу гэрээний талуудын хооронд тохирогдсон эсвэл хүлээн авсан бүх хураамж, гүйлгээний зардал болон бүх урамшуулал, хөнгөлөлтийг үр ашигт хүүнд оруулан тооцож, цаг хугацааны хувьд хойшлуулан хүүний орлого эсвэл зардалд бүртгэдэг. Үр ашигт хүүний бүрэлдэхүүн хэсэг болох хураамжид санхүүгийн хөрөнгийг худалдан авах эсвэл санхүүгийн өр төлбөрийг үүсгэхтэй холбоотойгоор нэмэгдэн гарсан, Группийн төлсөн эсвэл хүлээн авсан хураамжууд багтдаг ба жишээлбэл үүнд төлбөрийн чадварыг үнэлэх, санхүүгийн хэрэглүүрийн нөхцөл тохиролцох, холбогдох баримт бичиг боловсруулахтай холбоотойгоор нэмэгдэн гарсан аливаа хураамжууд орно. Зээлийн олголт бүрд ногдуулж буй ЛэндМН хураамжийн орлого нь хүүний орлого гэж нэрлэгдэхгүй боловч үр ашигт хүүний нэг хэсэг юм.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 Д.1119257208
12 MNR-AUDIT
RHINOS INVESTMENT ҮЦК

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)**

**в. Орлого болон зардлын хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)**

Санхүүгийн хөрөнгө нь чанаргүй төлөвт орж, ЗҮЦХА-ын загварын 3-р шатлалын хөрөнгөөр ангилагдсан тохиолдолд Групп нь хүүний орлогыг санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртгөөс үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцдог. Хэрэв санхүүгийн хөрөнгийн чанар сайжирч, чанаргүй төлвөөс гарсан тохиолдолд хүүний орлогыг эргээд нийт дансны үнээс тооцно. Групп нь худалдаж авахад эсвэл анх олгоход үнэ цэнийн бууралттай байсан (ХАОҮЦБ) санхүүгийн хөрөнгийн хүүний орлогыг хөрөнгийн хорогдуулсан өртгөөс зээлийн тохируулсан үр ашигт хүүний түвшинг ашиглан тооцно. Зээлийн тохируулсан үр ашигт хүү гэдэг нь анхлан хүлээн зөвшөөрөлтийн өдрөөр тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг (зээлийн алдагдлыг оруулсан) ХАОҮЦБ хөрөнгийн хорогдуулсан өртөг рүү дискаунтлах хүүний хувь юм.
Бусад бүх шимтгэл, хураамж болон бусад орлого, зардлын зүйлүүдийг нийтлэг байдлаар нь аккруэл сууриар тухайн ажил гүйлгээний гүйцэтгэлтэй уялдуулан хүлээн зөвшөөрөх бөгөөд гүйцэтгэлийг нийт үзүүлэх үйлчилгээнд эзлэх бодитоор үзүүлсэн үйлчилгээний хэсэгт үндэслэн тооцдог.

**г. Ажиллагсдын зардал болон холбогдох шимтгэлүүд**

Цалин хөлс болон цалинтай холбоотой бусад зардлуудыг Группийн ажиллагсад холбогдох ажил үйлчилгээ үзүүлсэн жилд зардлаар хүлээн зөвшөөрдөг. Цалинтай ээлжийн амралт гэх мэт богино хугацааны, хуримтлагдах цалинтай чөлөөг ирээдүйд цалинтай чөлөө авах эрхээ нэмэгдүүлэн, ажил үйлчилгээ үзүүлсэн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрнө.

**д. Татвар**

*Тайлант хугацааны орлогын албан татвар*
**Тайлант жилийн болон өмнөх хугацааны албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсвэл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан болно.**

Эдгээр зүйлд холбоотой тайлант жилийн орлогын албан татварыг орлого үр дүнгийн тайланд биш шууд өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрнө. Удирдлага НББ-ийг хэрхэн хөтлөхийг холбогдох татварын хууль, журмуудад тодорхой зааж өгөөгүй, нэмэлт тайлбар тодруулга шаардлагатай тийм шинэ нөхцөл байдал үүссэн эсэхийг тодруулахын тулд тодорхой хугацаа тутамд татварын тайлангаа хянаж үздэг ба шаардлагатай бол сан байгуулдаг.

13 MNR-AUDIT

"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**д. Татвар (үргэлжлэл)**

*Хойшлогдсон албан татвар*
Нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татвар ногдох дүн ба тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн тайлан дээрх бүртгэлийн хооронд гарах түр зөрүүнд "Тайлан тэнцлийн арга"-ыг ашиглан хойшлогдсон албан татварыг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон албан татварын өр төлбөрийг дор дурдсанаас бусад бүх түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хойшлогдсон албан татварын өр төлбөр нь гүүдвилийг анх хүлээн зөвшөөрөх үед эсвэл бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээнээс үүссэн, уг гүйлгээ нь НББ-ийн ашиг (алдагдал), татвар ногдох ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед,
- Түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхол зэрэгтэй холбоотойгоор үүссэн, түр зөрүүг хэзээ арилгахыг толгой компани, хөрөнгө оруулагч эсвэл хамтрагч тал хянаж байгаа, түр зөрүү нь ойрын хугацаанд арилахгүй байх магадлалтай байгаа үед

Дор дурдсанаас бусад тохиолдолд хойшлогдсон орлогын албан татварын хөрөнгийг татвар ногдох орлогоос хасагдах бүх түр зөрүүнүүд, ирээдүйд шилжүүлэн тооцох, ашиглаагүй татварын бүх хөнгөлөлт ба алдагдлуудад (эдгээр түр зөрүү, хөнгөлөлт, алдагдлуудыг хасаж болох татвар ногдох орлогын ирээдүйд орж ирэх нь тодорхой болсон үед) хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлогдсон албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн бус хөрөнгө, өр төлбөрийн гүйлгээг анх хүлээн зөвшөөрөх үед үүссэн ба гүйлгээ гарах үед, НББ-ийн болоод татварын ашиг (алдагдал) - ийн аль алинд нөлөө үзүүлэхгүй байгаа үед;

- Татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү нь охин болон холбоотой компаниудад оруулсан хөрөнгө оруулалт ба хамтарсан компани дахь ашиг сонирхолтой холбоотойгоор үүссэн бол хойшлогдсон албан татварын хөрөнгийг, түр зөрүү нь ойрын хугацаанд арилах магадлалтай, түр зөрүүг хасаж болох татвар ногдох орлого орж ирэх нь тодорхой болсон үед зөвхөн хүлээн зөвшөөрнө.

14 MNR-AUDIT

СЗХ 2023 .08р 11 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**д. Татвар(үргэлжлэл)**

Хойшлогдсон татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг тайлант хугацаа бүрийн эцэст хянаж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг хэсэгчлэн эсвэл бүхлээр нь нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхойгүй болсон үед харгалзах хэмжээгээр хөрөнгийн дүнг бууруулна.

Хүлээн зөвшөөрөөгүй хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант хугацаа бүрийн эцэст дахин үнэлж үзэх ба хойшлогдсон татварын хөрөнгийг нөхөн олж авахад хүрэлцэхүйц хэмжээний татвар ногдох орлого цаашид орж ирэх нь тодорхой болсон үед харгалзах хэмжээгээр хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийн тайлант хугацааны эцсийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй татварын хувь хэмжээнүүд дээр үндэслэн хөрөнгийг борлуулах, өр төлбөрийг барагдуулах тайлант хугацаанд хэрэглэгдэхээр хүлээгдэж буй татварын хэмжээгээр хойшлогдсон татварыг тооцно.
Хэрэв өнөөгийн татварын хөрөнгийг татварын өр төлбөрт суутгуулах хууль ёсны эрхтэй бөгөөд хойшлогдсон татварууд нь нэг татвар төлөгч аж ахуйн нэгж ба нэг татварын байгууллагатай холбоотой байгаа бол хойшлогдсон албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлж болно.

*Нэмэгдсэн өртгийн албан татвар*
Орлого, зардал болон хөрөнгүүд нь доорхоос бусад тохиолдолд Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар (НӨАТ)-гүй цэвэр дүнгээр хүлээн зөвшөөрөгддөг:

- Хөрөнгө эсвэл үйлчилгээг худалдан авахад төлсөн НӨАТ-ыг татварын байгууллагаас буцаан авах боломжгүй үед уг НӨАТ-ыг хөрөнгө худалдан авалтын өртгийн нэг хэсгээр эсвэл зардлын нэг хэсгээр (аль тохиромжтойгоор) хүлээн зөвшөөрнө.

- НӨАТ-ын дүн орсон дүнгээр илэрхийлэгдэх авлага ба өглөг.

Татварын байгууллагаас авах эсвэл татварын байгууллагад өгөх өглөгийн цэвэр дүнг нэгтгэсэн санхүүгийн байдлын тайланд авлага эсвэл өглөгийн нэг хэсэг болгон толилуулна.

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
15 MNR-AUDIT
RHINOS INVESTMENT ҮЦК LLC

СЗХ
2023.08.11
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**е. Бэлэн мөнгө болон банкин дахь данс**

Бэлэн мөнгө болон банкин дахь дансанд банкинд байршуулсан мөнгө орно.

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, дээр тодорхойлсноор бэлэн мөнгө болон банкин дахь харилцах, хадгаламж дахь бэлэн мөнгө болон богино хугацаатай хадгаламжийг оруулсан дүнгээр харин банкны овердрафтын үлдэгдлийг оруулаагүй. .

**ё. Санхүүгийн хөрөнгө**

(i) *Анх хүлээн зөвшөөрөх болон хэмжилт*

Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагаас бусад санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүдийг анхлан хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Компани тухайн хэрэглүүрийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Үүнд "хэвийн нөхцөлтэй арилжаа" буюу санхүүгийн хөрөнгө худалдан авах, худалдахад холбогдох хөрөнгийг зах зээлийн журам, хэлцлээр тогтоосон хугацаанд зайлшгүй шилжүүлэхийг шаардах арилжаа орно. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад авлагыг харилцагчдын дансанд мөнгө шилжсэн үед хүлээн зөвшөөрнө.

Анхлан хүлээн зөвшөөрч буй санхүүгийн хэрэглүүрийн ангилал нь тэдгээрийн гэрээний нөхцөл болон уг санхүүгийн хэрэглүүрийг зохицуулж буй бизнес загвараас хамаардаг. Санхүүгийн хэрэглүүрийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрөөс бусад тохиолдолд ажил гүйлгээний зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр анхлан бүртгэнэ.

(ii) *Дараах үеийн хэмжилт*

*Зээл ба авлага*
Анхны хэмжилтээс хойш санхүүгийн хөрөнгийг дараах үеүдэд үнэ цэнийн бууралтыг хассаны дараах үр ашигт хүүгийн арга (ҮАХА) ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох худалдан авалтын урамшуулал, хөнгөлөлт болон зардал, шимтгэлийг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад орлого"-д багтана. Үнэ цэнийн бууралтаас үүссэн алдагдлыг дэлгэрэнгүй орлогын тайлангийн "Бусад зардал" хэсэгт хүлээн зөвшөөрнө.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
MNR-AUDIT
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC

“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### ё. Санхүүгийн хөрөнгө(үргэлжлэл)

*(iii) Үл хүлээн зөвшөөрөлт*

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Групп нь тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл (а)Групп нь хөрөнгийн бараг бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл(б)Групп нь тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Групп хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл,өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Групп уг хөрөнгөнд үргэлжлүүлэн оролцоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Групп холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө.

Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Группийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан суурьтаар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Группийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

MNR-AUDIT

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**ё. Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)**

*(iv) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт*

Групп санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгүүд нь үнэ цэнийн бууралтад орсныг нотлох бодит нотолгоо байгаа эсэхийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр үнэлж үзнэ.

Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ. Үнэ цэнийн бууралтын нотолгоонд зээлдэгч эсвэл бүлэг зээлдэгчид нь санхүүгийн томоохон хүндрэлд орсон, зээлийнхүү болон үндсэн төлбөр зөрчилд орсон, дампуурах эсвэл санхүүгийн өөр бусад дахин зохион байгуулалтад орох магадлалтай болсон, зөрчилтэй холбоотой эдийн засгийн нөхцөл байдалд гарсан өөрчлөлт гэх мэт тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд хэмжиж болохуйц бууралт байгааг харуулсан бодит өгөгдөл бий болох зэрэг орно.

*Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд*

Үнэ цэнийн бууралтын алдагдал гарсан талаар бодит нотолгоо байгаа бол алдагдлыг тухайн хөрөнгийн бүртгэлийн дүн ба ирээдүйд орж ирэхээр тооцоолсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн (бодитоор тохиолдоогүй ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг оруулахгүй) зөрүүгээр хэмжинэ. Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах байх нөхцөлд үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр Шатлал 3-т байгаа зээлүүдээс бусад зээлүүдэд хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүг ашиглан хуримтлуулна. Хүүний орлогыг санхүүгийн орлогын нэг хэсэг болгон орлого, зардлын дансанд бүртгэнэ. Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл бусдад шилжүүлсэн үед зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна.

Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон үнэ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Данснаас

18 MNR-AUDIT

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

СЗХ
2023.08.01 өдөр
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-03



хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардал дансны кредитэд бүртгэнэ.

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**ж. Санхүүгийн өр төлбөр**

(i) *Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт*

Санхүүгийн өр төлбөрийг аль зохистой ангилалд нь бодит үнэ цэнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх, зээл ба зээллэг, эсвэл үр нөлөөтэй хейджингийн хэрэглүүрээр анх хүлээн зөвшөөрнө

Бүх санхүүгийн өр төлбөрүүдийг анх бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба зээл, зээллэг болон өр төлбөрийн хувьд шууд хамааралтай гүйлгээний зардлыг хассаны дараах дүнгээр хүлээн зөвшөөрнө.

Группийнсанхүүгийн өр төлбөрүүдэд дансны болон бусад өр төлбөр ба урьдчилж орсон орлого орно. Санхүүгийн өр төлбөрүүдийн хэмжилт дор дурдсан ангиллаас хамаарна:

*Зээл, зээллэг ба хойшлогдсон орлогын өр төлбөр*
Анх хэмжсэний дараа, зээллэгүүд, хойшлогдсон орлогын өр төлбөр, хүүгийн өглөг, дансны болон бусад өглөгийг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүний аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх үед болон үр ашигт хүүг ашиглан хорогдуулах үеийн олз, гарзыг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

Хорогдуулсан өртгийг үр ашигт хүүний салшгүй хэсэг болох зээл олголтын урамшуулал, хөнгөлөлт болон шимтгэл, холбоотой зардлуудыг оролцуулан тооцдог. Үр ашигт хүүгийн хорогдуулалт нь дэлгэрэнгүй орлогын тайлангийн санхүүгийн зардалд багтана.

(ii) *Үл хүлээн зөвшөөрөлт*

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол энэгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзэх ба бүртгэлийн дүнгийн зөрүүг орлого, зардлын дансанд хүлээн зөвшөөрнө.

**з. Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх**

Хэрэв байгууллага хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 д.1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК

СЗХ
2023 оны 08 сарын 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02



"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**н. Бодит үнэ цэнээрх хэмжилт**

Хэмжилтийн өдөр зах зээлийн оролцогчдын хооронд зохих журмын дагуу хийгдэж буй гүйлгээний үед хөрөнгө борлуулахад хүлээн авч буй эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ цэнэ гэнэ. Бодит үнэ цэнийн хэмжилт нь дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах болон өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээний таамаглалд үндэслэдэг. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээлд эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй үед хөрөнгө, өр төлбөрийн хамгийн давуу зах зээлд

Групп үндсэн болон давуу зах зээлд оролцох боломжтой байх ёстой.

Зах зээлийн оролцогчид нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоох үед өөртөө эдийн засгийн хувьд хамгийн ашигтай байхаар оролцоно гэсэн төсөөллийг ашиглан хөрөнгө болон өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжинэ.

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтэд хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглаж эсвэл хөрөнгийг хамгийн үр ашигтайгаар ашиглах зах зээлийн өөр нэг оролцогчид хөрөнгийг борлуулснаар эдийн засгийн өгөөжийг бий болгох зах зээлийн оролцогчийн чадварыг харгалзаж үзнэ.

Групп тухайн нөхцөлд тохирох үнэлгээний техникүүдийг ашиглах ба уг нөхцөл нь бодит үнэ цэнийг хэмжихэд шаардагдах хангалттай мэдээлэлтэй, холбогдох ашиглаж болохуйц орцуудыг дээд зэргээр, ашиглах боломжгүй орцуудыг хамгийн багаар ашиглана.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод үндэслэсэн:

- Түвшин 1 - хөрөнгө, өр төлбөрийн хоршсийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхтэй зах зээл дээрх үнэ.
- Түвшин 2 - шууд болон шууд бусаар ашиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нөлөө үзүүлэх үнэлгээний техникүүд
- Түвшин 3 - ашиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

Групп нэгтгэсэн санхүүгийн тайланд байнгын сууриар хүлээн зөвшөөрдөг хөрөнгө болон өр төлбөрүүдийн хувьд тайлант үе бүрийн эцэст ангиллыг дахин үнэлж (бүхлээрээ бодит үнэ цэнийн хэмжилтэд томоохон нөлөөтэй хамгийн бага түвшний орцод суурилан) үзсэнээр түвшний хоорондын шилжилт гарсан эсэхийг тодорхойлдог.

ЛЭНДМН ББСБ ХК
ҮЕРГИЙН
УЛААНБААТАР ХОТ
5029754 1118267206

20 MNR-AUDIT

СӨХ
2023.08.11
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

#### й. Урьдчилж төлсөн төлбөрүүд

Урьдчилж төлсөн төлбөр нь урьдчилж бэлэн мөнгө төлсөн боловч бодитоор гараагүй байгаа зардлуудыг хэлнэ. Урьдчилж төлсөн төлбөрүүд нь эхлээд хөрөнгө хэсэгт бүртгэгдэх ба төлсөн бэлэн мөнгөний дүнгээр хэмжигдэнэ. Үүний дараа үйл ажиллагаанд хэрэглэгдсэн буюу хугацаа нь дуусахад орлогын тайланд тусгагддаг.

#### к. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр илэрхийлдэг. Үндсэн хөрөнгөөр хүлээн зөвшөөрөх шаардлагууд хангагдсан тохиолдолд тухайн үндсэн хөрөнгийн сольсон хэсгийн өртөг болон засварын өртгийг тухай бүрд нь энэ өртөгт оруулна. Бусад бүх засвар үйлчилгээний зардлыг гарсан үед нь ашиг алдагдлыг тайланд тусгана.

Хөрөнгийн ашиглалт дууссан эсвэл өртөг болон холбогдох хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралт нь данснаас хасагдахад үүсэх олз болон гарз нь ашиг алдагдалд кредитлэгдэнэ.
Хүлээн зөвшөөрсний дараах үед үндсэн хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан бодит үнэ цэнээр илэрхийлдэг.

Үндсэн хөрөнгийн элэгдлийг татварын зорилгоор шулуун шугамын аргаар, дараах ашиглалтын хугацаанд элэгдүүлнэ. Үүнд:

| Ангилал | Жил |
|---|---|
| Тавилга, оффисын тоног төхөөрөмж болон тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Компьютер ба техник тоног төхөөрөмж | 3 жил |
| Оффисийн түрээсийн сайжруулалт | 5 жил |

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбогдон үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгө борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) хөрөнгийг үл хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн арга нь өмнө хийгдсэн тооцоолол ба үндсэн хөрөнгөнд агуулагдаж буй ирээдүйн эдийн засгийн үр ашгийн хүлээгдэж буй хэрэглээний хэв загварт нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс үндсэн хөрөнгийн үлдэх өртөг, ашиглалтын хугацаа, элэгдлийн аргыг санхүүгийн жилийн эцэс бүрд хянаж үздэг.

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

31 MNR-AUDIT

"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

## 2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)

**л. Биет бус хөрөнгө**

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Бизнес нэгдлийн үед авсан биет бус хөрөнгийг авсан өдрийн бодит үнэ цэнээр бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнэ бууралтын алдагдлыг хассан өртгөөр нь тайланд тусгадаг.

Дотоодоо хөгжүүлсэн биет бус хөрөнгийн хувьд хөгжүүлэлтийн зардлаас бусад зардал өртгийг нэмэгдүүлэхгүй. Харин холбогдох зардлуудыг зардал гарсан тайлант хугацаанд олз, гарзаар бүртгэнэ.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсвэл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Группийн эзэмшиж байгаа бүх биет бус хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг тодорхойлсон.

Тодорхой ашиглалтын хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулах ба үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрсэн тухай бүрд үнэ цэнийн бууралтын үнэлгээ хийнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсвэл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсвэл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийг үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой үүссэн аливаа олз, гарзыг (хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого ба бүртгэлийн дүн хоёрын зөрүүгээр тооцно) тухайн тайлант жилийн орлого, үр дүнгийн тайланд тусгана.

Группийн биет бус хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн програм хангамж болон бусад хөрөнгөөс бүрдэх ба эдгээрийг шулуун шугамын аргаар хорогдуулна.

**м. Өөрийн хөрөнгө**

Энгийн хувьцааг өөрийн хөрөнгөд ангилна. Энгийн хувьцааны ногдол ашгийг зарласан үедээ өөрийн хөрөнгөд хүлээн зөвшөөрдөг. Өөрийн хөрөнгийн гүйлгээтэй холбоотой гүйлгээний зардлыг татвар суутгасан дүнгээр нь өөрийн хөрөнгөнөөс хасна. Өөрийн хөрөнгийн гүйлгээний өртөг зөвхөн өөрийн хөрөнгийн гүйлгээнд шууд холбоотой гадны нэмэгдүүлсэн өртгөөс бусад өртгийг оруулахгүй.

22 MNR-AUDIT

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

**2. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГУУД (ҮРГЭЛЖЛЭЛ)**

**2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо (үргэлжлэл)**

**н. Холбоотой талуудын гүйлгээ**

Холбоотой тал гэдэг нь холбоотой хувь хүн эсвэл байгууллага байна.

(а) Хувь хүн эсвэл тухайн хүний гэр бүлийн ойрын гишүүн доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Группийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

(i) Группийн хяналт болон хамтын хяналт байдаг бол;
(ii) Группэд томоохон нөлөөлөл байдаг бол;
(iii) Группийн гол удирдах ажилтан эсвэл Группийн толгой компанийн гишүүн бол.

(б) Аж ахуйн нэгж байгууллага нь доорх шаардлагуудыг хангасан тохиолдолд Группийн холбоотой талд тооцогдоно. Үүнд:

(i) Групп болон аж ахуйн нэгж нь нэг группын гишүүд бол (өөрөөр хэлбэл толгой компани, охин компани ба зэргэлдээ охин компани бүр нь хоорондоо холбоотой юм)
(ii) нэг байгууллага нь нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, өөр байгууллага нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
(iii) хоёр компани хоёулаа нэг гуравдагч талын хамтын үйлдвэр бол;
(iv) нэг тал нь нөгөө талын хараат компани эсвэл хамтын үйлдвэр бол (эсвэл, нөгөө тал нь гишүүн байх компанийн хараат компани эсвэл хамтын үйлдвэрийн гишүүн бол);
(v) Группийн эсвэл Групптэй холбоотой талын ажилчдын тэтгэмжтэй холбоотой ажлаас гарсны дараах тэтгэмжийн хөтөлбөр бол. Хэрвээ Групп өөрөө тэр хөтөлбөр бол, ажил олгогчийн спонсор нь мөн Групптэй холбоотой тал болно;
(vi) (а)-д заасан хувь хүнд байгууллагын хяналт эсвэл хамтын хяналт байдаг бол;
(vii) (а)(i)-д заасан хувь хүнд байгууллагын томоохон нөлөө байх эсвэл тухайн хүн нь группийн гол удирдах ажилтан бол
(viii) Групп эсвэл Группийн толгой компанид гол удирдах ажилтанаар хангах үйлчилгээ үзүүлдэг байгууллага эсвэл группийн ямарваа гишүүн бол.

23 MNR-AUDIT

**"ЛЭНД МН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

## 3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ ҮНЭЛЭМЖ БА ТООЦООЛОЛ

Нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх ажил нь удирдлагаас тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр, тайлант үеийн орлого, зардалд тайлагнасан дүнд нөлөө үзүүлэх үнэлэмж, ойролцоолсон тооцоолол, төсөөллүүдийг хийхийг шаарддаг.Эдгээр төсөөлөл, тооцооллуудын тодорхой бус байдал нь ирээдүйд хөрөнгө, өр төлбөрийн бүртгэлийн дүнд материаллаг дүнтэй залруулга хийхэд хүргэж болно. Тухайлбал, нэгтгэсэн санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлагын авч үзсэн томоохон тооцооллын тухай мэдээллийг дор үзүүлэв:

*Бусад авлагын үнэ цэнийн бууралтыг тооцоолох*
Компани нь ирээдүйд авлагаас учрах боломжит алдагдлын хэмжээгээр үнэ цэнэ бууралтын сан байгуулдаг. Энэхүү сангийн дүн нь удирдлагын түүхэн туршлага болон бусад эргэн төлөлтөд нөлөөлөхүйц хүчин зүйлүүдийн үнэлэмжээс шалтгаална. Тиймээс аль ч тайлант хугацаанд бүртгэсэн үнэ цэнийн бууралтын зардал нь тухайн жилийн үнэлэмж, тооцоолол болон төсөөллөөс хамааран өөрчлөгдөж байдаг.

24 MNR-AUDIT

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

**4. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ**

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Касс дахь мөнгө | 29 | 330 |
| Банкин дахь мөнгөн хөрөнгө | 4,903,649 | 5,217,251 |
| | **4,903,678** | **5,217,581** |

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө нь Голомт банк, Худалдаа хөгжлийн банк, Хаан банк, Төрийн банк, Хас банк, Капитрон Банкны харилцах дахь монгол төгрөг болон ам. доллараас бүрдэж байна.

**5. ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ БОЛОН УРЬДЧИЛГАА**

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Хэрэглээний зээл | 31,719,389 | 65,442,582 |
| Байгууллагын зээл | 773,797 | 22,656 |
| Машины зээл | 2,129,621 | 7,418,168 |
| Хасах нь: ЗҮЦХА-ын сан | (2,196,760) | (3,297,126) |
| | 32,426,047 | 69,586,280 |

**6. БУСАД ХӨРӨНГӨ**

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Бусад авлага | 690,080 | 747,803 |
| Хангамжийн материал | 23,708 | 20,606 |
| | 713,788 | 768,409 |

**7. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТӨЛБӨР**

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Урьдчилж төлсөн тооцоо | 18,796 | 44,957 |
| Хөрөнгө худалдан авалтын УТТ | - | 480 |
| | 18,796 | 45,437 |

25 MNR-AUDIT

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

СЗХ 2023 оны 08 сарын 11 БҮРТГЭВ

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

## 8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Өртөг** | | |
| 1-р сарын 1-нээр | 571,413 | 610,818 |
| Нэмэгдсэн | 312,070 | - |
| Охин компанийг борлуулсантай холбоотой данснаас хасалт | (272,665) | - |
| **12-р сарын 31-нээр** | **610,818** | **610,818** |
| **Хуримтлагдсан хорогдол** | | |
| 1-р сарын 1-нээр | 168,268 | 162,980 |
| Тайлант жилийн хорогдол | 51,851 | 46,743 |
| Охин компанийг борлуулсантай холбоотой данснаас хасалт | (57,139) | - |
| **12-р сарын 31-нээр** | **162,980** | **209,723** |
| **Цэвэр дүн** | **447,838** | **401,095** |

## 9. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

| | 2021 | Өсөлт | Бууралт | 2022 |
|---|---|---|---|---|
| **Анхны өртөг** | | | | |
| Тавилга, оффисын хэрэгсэл | 292,486 | 15,095 | (34,058) | 273,523 |
| Компьютер,тоног төхөөрөмж | 313,174 | 97,340 | (7,754) | 402,760 |
| Оффисын сайжруулалт | 203,636 | | | 203,636 |
| | **809,296** | **112,435** | **(41,812)** | **879,919** |
| **Хуримтлагдсан элэгдэл** | | | | |
| Тавилга, оффисын хэрэгсэл | 70,989 | 29,964 | (33,872) | 67,081 |
| Компьютер,тоног төхөөрөмж | 242,536 | 55,944 | (3,521) | 294,959 |
| Оффисын сайжруулалт | 103,724 | 40,685 | - | 144,409 |
| | **417,249** | **126,593** | **(37,393)** | **506,449** |
| **Цэвэр дүн** | | | | |
| Тавилга, оффисын хэрэгсэл | 221,497 | (14,869) | (186) | 206,442 |
| Компьютер,тоног төхөөрөмж | 70,638 | 41,396 | (4,233) | 107,801 |
| Оффисын сайжруулалт | 99,912 | (40,685) | - | 59,227 |
| | **392,047** | **(14,158)** | **(4,419)** | **373,470** |

26 MNR-AUDIT

ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ

RHINOS INVESTMENT ҮЦК ХХК

**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

**10. ЗЭЭЛ**

**2021 оны 12 дугаар сарын 31**

| | Жилийн хүү | Богино хугацаат | Урт хугацаат | Нийт |
|---|---|---|---|---|
| Бонд | 14% | 27,808 | 7,272,847 | 7,300,655 |
| Хаалттай бонд | 20% | 20,997 | - | 20,997 |
| Зээл | 14% | 101,544 | 2,845,000 | 2,946,544 |
| Итгэлцлийн үйлчилгээ | 6%-20% | 6,595,318 | 1,158,076 | 7,753,394 |
| **Нийт зээл** | | **6,745,667** | **11,275,923** | **18,021,590** |

**2022 оны 12 дугаар сарын 31**

| | Жилийн хүү | Богино хугацаат | Урт хугацаат | Нийт |
|---|---|---|---|---|
| Бонд | 14%-15% | 7,740,064 | 3,029,518 | 10,769,582 |
| Зээл | 12%-21.8% | 7,923,024 | 3,845,000 | 11,768,024 |
| Итгэлцлийн үйлчилгээ | 6-21% | 17,403,168 | 4,285,089 | 21,688,257 |
| Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас | 17% | - | 4,679,661 | 4,679,661 |
| **Нийт зээл** | | **33,066,256** | **15,839,268** | **48,905,524** |

**11. ТҮРЭЭСИЙН ӨР ТӨЛБӨР**

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **1-р сарын 1-нээр** | 573,727 | 371,235 |
| Нэмэгдэл | - | 106,318 |
| Элэгдлийн зардал | (202,492) | (259,961) |
| **12-р сарын 31-нээр** | 371,235 | 217,592 |

Тайлан хугацааны түрээсийн өглөг болон хөдөлгөөнийг доорх хүснэгтэд харуулав:

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **1-р сарын 1-нээр** | 680,417 | 476,651 |
| Хүүгийн зардал | 106,206 | 80,761 |
| Нэмэгдэл | - | 106,318 |
| Түрээсийн төлбөр | (288,117) | (377,958) |
| Түрээсийн хөнгөлөлт | (21,855) | - |
| **12-р сарын 31-нээр** | 476,651 | 285,772 |
| | | |
| Богино хугацаат | 243,626 | 285,772 |
| Урт хугацаат | 233,025 | - |

27 MNR-AUDIT

“ЛЭНДМН ББСБ” ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31

/мян.төг/

12. БУСАД ӨР ТӨЛБӨР

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Бусад санхүүгийн өр төлбөр** | | |
| Хувь хүн, байгууллагад өгөх өглөг | 609,367 | 1,978,802 |
| Бусад өглөг | 187,568 | 341,578 |
| **Нийт** | **796,935** | **2,320,380** |
| **Бусад санхүүгийн бус өр төлбөр** | | |
| Бусад татварын өглөг/орлогын татвараас бусад/ | 130,231 | 215,375 |
| Олгохоор баталсан зээлийн үүргийн үнэ цэнэ бууралтын сан | 29,061 | 86,659 |
| **Нийт** | **159,292** | **302,034** |
| **Нийт бусад өр төлбөр** | **956,227** | **2,622,414** |

13. ХУВЬЦААТ КАПИТАЛ

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Хувьцаат капитал | 10,756,859 | 10,756,859 |
| | 10,756,859 | 10,756,859 |

Хувьцаа эзэмшигчид:

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Анд Системс ХХК | 75.0% | 75.0% |
| Олон Нийт | 17.4% | 17.4% |
| Халаасны хувьцаа | 7.6% | 7.6% |
| | **100.0%** | **100.0%** |

14. ХАЛААСНЫ ХУВЬЦАА

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| Халаасны хувьцаа | 2,337,547 | 2,337,547 |
| | **2,337,547** | **2,337,547** |

28 MNR-...

СХХ
2023 .08. 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

## 15. ХҮҮГИЙН ОРЛОГО, ЗАРДАЛ

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Хүүний орлого** | | |
| Банкинд байршуулсан харилцах, хадгаламжийн хүү | 101,141 | 40,619 |
| Аж ахуй нэгжид олгосон зээл | 247,726 | 10,626 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 12,142,875 | 20,163,703 |
| **Нийт хүү болон түүнтэй адилтгах цэвэр орлого** | **12,491,742** | **20,214,948** |
| **Хүүний зардал** | | |
| Зээлийн хүүний зардал | (2,692,447) | (3,869,123) |
| Түрээсийн өглөгийн хүүний зардал | (106,206) | (80,761) |
| **Нийт хүү болон түүнтэй адилтгах зардал** | **(2,798,653)** | **(3,949,884)** |

## 16. ЗЭЭЛИЙН ҮНЭ ЦЭНИЙН БУУРАЛТЫН АЛДАГДАЛ

Дараах хүснэгтэнд ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрөгдсөн, санхүүгийн хэрэгслийн үнэ цэнийн бууралтын алдагдлын зардлыг үзүүлэв:

| | 2021 | 2022 |
|---|---|---|
| **Үнэ цэнийн бууралтын алдагдал** | | |
| Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдал | (741,499) | 1,381,057 |
| Олгохоор баталсан зээлийн үүргийн үнэ цэнийн бууралтын алдагдал | 15,943 | 57,598 |
| **Нийт үнэ цэнийн бууралтын алдагдал** | **(725,556)** | **1,438,655** |

MNR-AUDIT

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

СЗХ
2023 .08. 11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02



**"ЛЭНДМН ББСБ" ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИ**

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД**
**2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31**

*/мян.төг/*

даалттай байж болох бөгөөд бонд гаргагч компанийн хувьд энэ журмын 2.6-д зааснаас бусад тохиолдолд барьцаа хөрөнгө нь бонд гаргагчийн гаргасан, энгийн хувьцаа эсхүл түүнд хөрвөх нөхцөлтэй үнэт цааснаас бусад төрлийн эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хэлбэртэй байна", 2.6-д "Бонд гаргагч нь нээлттэй хувьцаат компани бол тухайн компанийн хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцаагаар батлан даалт болох бөгөөд батлан даах хувьцаа нь бонд гаргагчийн нийт гаргасан энгийн хувьцааны 50 хувиас дээшгүй байна", 2.7-д "Энэ журмын 2.6-д заасны дагуу батлан даасан хувьцааны үнэлгээг тогтоохдоо арилжаа эрхлэх байгууллагын албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзах бөгөөд барьцаалах үнэлгээ нь тухайн хувьцааны үнэлгээний 70 хувиас илүүгүй байна" гэж тус тус заасан.

Үүний дагуу "Анд системс" ХХК нь ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/09 тоот тогтоол (Хавсралт 1.9)-оор өөрийн эзэмшиж буй, 2023 оны 06 сарын 26-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханш (Хавсралт 1.10)-аар тооцоход 13,600,000,000 төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 ширхэг "Лэндмн ББСБ" ХК-ийн хувьцааг бондын үндсэн болон хуримтлагдсан хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл хугацаагаар барьцаалуулахаар шийдвэрлэсэн байна.

"Лэндмн ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар нийт 800,000,000 ширхэг энгийн хувьцаа гаргасан, үүнээс "Анд системс" ХХК нь 600,000,000 ширхэг энгийн хувьцааг эзэмшиж байгаа ба 400,000,000 ширхэг энгийн хувьцааг барьцаалахаар шийдвэрлэсэн нь холбогдох шаардлагыг хангана гэж үзэв (Хавсралт 1.7, 9.1).

"Анд системс" ХХК-ийн хувьцаа барьцаалах, гэрээ байгуулах эрх олгох тухай шийдвэр (Хавсралт 1.9) нь Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нийцэж байна.

Нэгтгэн дүгнэвэл, Компанийн өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгох тухай шийдвэр нь хууль тогтоомжид нийцэж байна.

MDSKhanLex

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Компанийн дүрмийн 21.1-т тус Компанийн эрх бүхий албан тушаалтныг тодорхойлсон бөгөөд энэ нь Компанийн тухай хуулийн 84-р зүйлийн 84.2, 84.3 дахь заалтад "Компани өөрийн онцлогтоо тохируулан эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг компанийн дүрэмдээ заасан байна" гэж заасан шаардлагад нийцсэн байна. Иймд Компанийн тухай хууль болон Компанийн дүрэмд[1] үндэслэн тус Компанийн Эрх бүхий албан тушаалтан гэдэгт ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч, Санхүү үйл ажиллагааны газрын захирал, Бизнес хөгжлийн газрын захирал нарыг компанийн эрх бүхий албан тушаалтанд хамруулан авч үзлээ (Хавсралт 12.1).

ТУЗ-ийн гишүүдийг 2023 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 23/02 тоот тогтоол (Хавсралт 2.2)-оор улируулан сонгосон бөгөөд ТУЗ-ын дарга, хороодын бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар бүлэгт зааснаар Компанийн ТУЗ нь Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын, Аудитын хороотой байхаар зохицуулсан байна (Хавсралт 3.1). ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 22/06 тоот ТУЗ-ийн хурлын тогтоол (Хавсралт 2.1)-оор О.Болдбаатарыг ТУЗ-ийн даргаар, ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 22/08 тоот тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны даргаар Ж.Жаргалсүрэн, гишүүдээр С.Боргил, О.Болдбаатар нар, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны даргаар С.Энх-Амгалан, гишүүнээр С.Боргил, Д.Галхүү нар, Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Б.Иггэл, гишүүнээр С.Энх-Амгалан, В.Баярсайхан, Д.Галхүү, Ц.Ууганбаяр, Б.Хос-Эрдэнэ нар тус тус томилогдон ажиллаж (Хавсралт 2.34) байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т ТУЗ-ийн засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын, аудитын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн байна. Компанийн засаглалын кодексийн 2.2 дугаар зүйлд аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байх шаардлагыг тус тус хангаж байх бөгөөд ТУЗ-ийн аудитын хорооны дарга (Ж.Жаргалсүрэн), гишүүд (С.Боргил, О.Болдбаатар) нь санхүүгийн тайлагналын зохих мэдлэг, чадвартай байх шаардлагыг хангаж байна. ТУЗ-ийн аудитын хорооны дарга (Ж.Жаргалсүрэн) нь Монгол Улсын хууль тогтоомжид зааснаар Компанийн хөндлөнгийн аудит (Нийслэл Аудит ХХК, Эрнст энд янг монголия аудит ХХК, Монголын Үндэсний Тайлагнал Аудит ХХК)-д сүүлийн 3 жилийн хугацаанд ажиллаж байгаагүй байна. ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлагыг дараах хүснэгтээр харуулав:

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| Ердийн гишүүд: | | | |
| 1. | Очирсүрэнгийн Болдбаатар (Хавсралт 2.3) | 1999-2004 онд Турк Улсын Босфорус их сургуулийн Бизнесийн удирдлагын бакалавр;<br>2010 онд АНУ, олон улсын мэргэшсэн нягтлан бодогч; | 2004–2005 онд Турк Улсын Denge Denetim/Mazars-т аудитор;<br>2005–2006 онд Далайван Аудитад Ахлах аудитор; |

[1] Компанийн дүрмийн 21.1: Компанийн эрх бүхий албан тушаалтанд ТУЗ-ийн дарга, гишүүд, Гүйцэтгэх захирал, Дэд захирал, Ерөнхий нягтлан бодогч, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга болон тэдгээртэй адилтгах албан тушаалтан хамаарна.

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | 2014 онд Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, мэргэшсэн нягтлан бодогч;<br>2014 онд Мэргэшсэн нягтлан бодогчдын институт, мэргэшсэн аудитор. | 2006–2009 онд Эрнст энд Янг Монголд Ахлах аудитор;<br>2009–2010 онд Малайз Улсын KPMG-д Ахлах аудитор;<br>2010–2015 онд PwC Монголд Ахлах менежер;<br>2015–2016 онд Их Британи улсын Их Британид менежер;<br>2017–2019 онд Анд Глобалд компанид Захирал;<br>2017 оноос одоог хүртэл Анд ЭфЭсЖи компанид Гүйцэтгэх захирал;<br>2019.08.15-2021.07.30 хүртэл ЛэндМН ББСБ ХК-д Гүйцэтгэх захирал;<br>2021 онд ЛэндМН ББСБ ХК-д ТУЗ-ийн дарга. |
| 2. | Болдын Итгэл (Хавсралт 2.4) | 2008 онд АНУ-ын Жорж Мэсон Их Сургуулийн Санхүүгийн чиглэлээр бакалавр. | 2009-2010 онд Хаан банкинд Теллер, зээлийн мэргэжилтэн, харилцагчийн ажиллагааны менежер;<br>2010-2013 онд Ньюком Групп ХХК-д Хөрөнгө оруулалтын шинжээч, портфолио менежер;<br>2013-2018 онд "Новатерра" ХХК-д санхүүгийн менежер, гүйцэтгэх захирал, Гэйтвэй Девелопмент ХХК-д гүйцэтгэх захирал, санхүү эрхэлсэн захирал;<br>2018-2021 онд "Мобиком Корпораци" ХХК-д санхүү удирдлага, нягтлан бодох бүртгэлийн захирал, байгууллагын төлөвлөлтийн захирал;<br>2021-2023 онд "АНД Глобал Пти.Лтд"-д хөрөнгө оруулалт хариуцсан захирал;<br>2022-одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д ТУЗ-ийн ердийн гишүүн;<br>2022-одоог хүртэл "АНД Системс" ХХК-д ТУЗ-ийн гишүүн;<br>2023-одоог хүртэл "АНД Глобал Пти.Лтд"-д гадаад харилцаа хариуцсан дэд захирал. |
| 3. | Цэрэндоржийн Уугандалай (Хавсралт 2.5) | 2010 онд Болгар улсын Америкийн Их Сургуульд Бизнесийн удирдлага (Нягтлан | 2008 онд Марта Вайнъярд Хадгаламжийн банкинд теллер;<br>2009 онд Америкийн Нэгдсэн |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267208



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | бодох бүртгэл), Эдийн засгийн ухааны бакалавр. | Улс, Эдгартаун Үндэсний Банкинд нягтлан бодогч /даллага/;<br>2010-2018 онд Эм Си Эс Холдинг ХХК-д санхүүгийн ахлах ажилтан;<br>2018 оноос одоог хүртэл "АНД Глобал Пте.Лт.т"-д Санхүүгийн менежер/ Санхүү эрхэлсэн;<br>2022 оноос одоог хүртэл АНД Системс ХХК-д ТУЗ-ийн гишүүн;<br>2023 оноос одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д Гүйцэтгэх захирал;<br>2022 оноос одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д ТУЗ-ийн гишүүн. |
| 4. | Володъяагийн Баярсайхан (Хавсралт 2.6) | 2004 онд Турк улсын Измир хотын Ege их сургуулийг Компьютерийн инженер мэргэжлээр бакалавр;<br>2016 онд Вашингтоны, Сиэтл хотын, Вашингтоны их сургуулийн Фостер бизнесийн сургуулийг бүтээгдэхүүний маркетинг, Энтрепренершип мэргэжлээр бүтээгдэхүүний менежментийн магистр. | 2004–2006 онд Турк Улс, Истанбул, Yaz Информэйшн Системс компанид Програм хангамж хөгжүүлэгч;<br>2006–2007 онд ISC Монголиа/Е-империумд Төслийн менежер;<br>2007–2012 онд Синглтон ХХК-д үүсгэн байгуулагч болон Гүйцэтгэх захирал;<br>2012–2014 онд Бизнетворк.мн сайтыг үүсгэн байгуулагч болон Гүйцэтгэх захирал;<br>2015 онд АНУ, Вашингтон, Амазон компанид Ахлах бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн менежер;<br>2015–2016 онд АНУ, Вашингтон, Майкрософт ХХК-д MBA зөвлөх;<br>2016–2017 онд Dell EMC компанид Big data streaming & real-time analytics;<br>2017-2019 онд Анд Глобал, Үйл ажиллагаа хариуцсан захирал;<br>2019.11.01-с одоог хүртэл Томё Эдтек ХХК-д Ерөнхий захирал. |
| 5. | Баатархүүгийн Хос-Эрдэнэ (Хавсралт 2.7) | 2008-2009 онд Япон Улс, Токёогийн гадаад судлалын их сургууль, Япон хэлний бэлтгэл;<br>2009-2013 онд Япон Улс, Хитоцубаши их сургууль, Хөрөнгийн зах зээл, санхүү бакалавр; | 2014-2016 онд Япон дахь Швейцари Улсын хөрөнгө оруулалтын банк UBS Секьюритис компанид хөрөнгийн зах зээлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч;<br>2016-2018 онд Япон Улс, |

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | 2012-2014 онд Япон Улс, Хитоцубаши их сургууль, Бизнесийн удирдлагын магистр. | Мизухо банкны Байгууллагын судалгааны газарт бизнесийн шинжээч;<br>2018-2020 онд АНД Глобал Пти.Лтд, Хөрөнгө оруулалт хариуцсан захирал;<br>2020-одоог хүртэл АНД Глобал Пти.Лтд-д гүйцэтгэх захирал;<br>2021-одоог хүртэл АНД Системс ХХК-д гүйцэтгэх захирал;<br>2021-одоог хүртэл АНД Дэнеүд ХХК, ТУЗ-ийн дарга;<br>2022-одоог хүртэл ЛэндМН ББСБ ХК-д ТУЗ-ийн гишүүн. |
| 6. | Сэнгээгийн Энх-Амгалан (Хавсралт 2.8) | 1993-1997 онд МУИС-ийн Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад харилцааны бакалавр;<br>1999-2001 онд АНУ, Калифорни муж, Монтерейн Олон улс судлалын дээд сургуулийг Олон улсын бодлого судлал мэргэжлээр хүмүүнлэгийн ухааны магистр | 2004–2010 онд М-Си-Эс Группын охин компаниудад дэд захирал, гүйцэтгэх захирал<br>2010–2012 онд Mongolian Mining Corp ба Энержи ресурс ХХК-д Дэд ерөнхийлөгч<br>2012–2013 онд Клин Энержи ХХК-д Гүйцэтгэх захирал<br>2013–2015 онд Southgobi Sands & Southgobi Resource ХК-д Ерөнхийлөгч бөгөөд Гүйцэтгэх захирал<br>2015–2016 онд Эрдэнэс Монгол ХХК-ийн зөвлөх<br>2017 оноос 2021 онд Петровис ойл ХХК-ийн Ерөнхий захирал<br>2021 оны 03 сараас одоог хүртэл Мэргэн инвестмент ХХК-ийн захирал |
| Хараат бус гишүүд: | | | |
| 7. | Даваасамбуугийн Галхүү (Хавсралт 2.9) | 1993-1997 онд МУИС-ийн Эдийн засгийн дээд сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч бакалавр;<br>2005 онд Япон Улсын Кобе их сургуулийн Эдийн засгийн ухааны магистр. | 1997 – 2013 онд Жагар Интернэшнл ХХК, Гэрэл Интернэшнл ХХК-д нягтлан бодогч, Ерөнхий нягтлан бодогч;<br>2006 – 2007 онд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр/Даян дэлхийн байгаль хамгаалах сан Байгаль орчны яаманд Захиргаа, санхүү хариуцсан мэргэжилтэн;<br>2007-2011 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хэрэгжүүлж буй Дэлхийн Банкны төслүүдэд санхүүгийн |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5033754 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK LLC

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | | менежер/мониторингийн хянагч; 2006-2009 онд Актив Аудит ХХК-д аудитор; 2011-2012 онд Дэлхийн банк, Сангийн яамд дотоод аудитор, Монголбанкны Хяналтын хэлтсийн тэргүүлэх менежер, техникийн дотоод зөвлөх; 2012- одоог хүртэл ПрайсвотерхаусКуперс Аудит ХХК болон ПрайсвотерхаусКуперс Такс ТМЗ ХХК-д Туслах менежер, Аудитор. |
| 8. | Сүрэнхүүгийн Боргил (Хавсралт 2.10) | 1991-1995 онд Монгол Улсын Үндэсний Их Сургуульд санхүүч эдийн засагч мэргэжлээр эдийн засгийн бакалавр; 1999-2003 онд АНУ, Колорадогийн их сургуулийг Эдийн засгийн мэргэжлээр хүмүүнлэгийн ухааны магистр | 1995–1997 онд МУ, Сангийн яам, Санхүүгийн байгууллагуудын хэлтэс, Эдийн засагч 1997–1999 онд МУ, Сангийн яам, Төсвийн зарлагын хэлтсийн дарга 2003–2004 онд АНУ, Ваймонг муж, Шайенн, Community First National Bank, Зээлийн шинжээч 2004–2012 онд АНУ, Ваймонг муж, Жиллет, Жиллет банк, Дэд ерөнхийлөгч, Ерөнхийлөгч 2013–2015 онд МУ, УУХҮЯ, Эрдэнэс Оюу Толгой ХХК, Зөвлөх 2013–2015 онд МУ, Ирээдүйн өв сангийн тухай хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн 2015–2017 онд МУ, Сангийн яам, Зөвлөх 2017 оноос одоог хүртэл Сэргэлт Консалтинг Групп ХХК, Захирал |
| 9. | Жигдэнгийн Жаргалсүрэн (Хавсралт 2.11) | 1998 онд Мандах бүртгэл дээд сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалавр; 2000 онд Санхүү эдийн засгийн дээд сургуулийг Бизнесийн удирдлагын магистр; 2000 онд Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтыг Мэргэшсэн нягтлан бодогч; 2011 онд Англи улс, Лондон хот, Олон улсын мэргэшсэн нягтлан бодогчдын нийгэмлэгийг Олон | 1998-2003 онд Санхүү эдийн засгийн дээд сургуульд Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш; 2003-2005 онд "Далайван аудит" ХХК-д аудиторч; 2005-2015 онд "Далайван аудит" ХХК-д аудитын менежер; 2015-одоог хүртэл "Далайван аудит" ХХК-д Удирдлагын партнер |

14 - 55

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | улсын мэргэшсэн нягтлан бодогч;<br>2015 онд Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгийг Татварын мэргэшсэн зөвлөх | |

Компанийн засаглалын кодексийн 2 дугаар зарчимд заасны дагуу ТУЗ-ийн аудитын хорооны үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн аудитын хорооны бүрэлдэхүүний мэдээллийг нийтэд мэдээлэх буюу Компанийн цахим хуудаст байршуулахыг зөвлөж байна.

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| КОМПАНИЙН ТУЗ-ИЙН ГИШҮҮД, НАРИЙН БИЧГИЙН ДАРГАД ТАВИГДАХ ШААРДЛАГА | | | | | |
|---|---|---|---|---|---|
| № | Нэрс/Шаардлага | Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)* | Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8) | Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3) |
| 1. | О.Болдбаатар (ТУЗ-ийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2017.12.04-ний өдөр, Дугаар 0130848/ (Хавсралт 2.24) | Тийм |
| 2. | Б.Итгэл (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.04.04-ны өдөр, Дугаар 0730768/ (Хавсралт 2.25) | Тийм |
| 3. | В.Баярсайхан (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр, Дугаар 0520839/ (Хавсралт 2.26) | Тийм |
| 4. | Ц.Угтанбаяр (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.02.21-ний өдөр, Дугаар 0131874/ (Хавсралт 2.27) | Тийм |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 Д.1115267208
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5. | Б.Хос-Эрдэнэ (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.02.21-ний өдөр, Дугаар 0131873/ (Хавсралт 2.28) | Тийм |
| 6. | С.Энх-Амгалан (ТУЗ-ийн гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2019.02.24-ний өдөр, Дугаар 0520840/ (Хавсралт 2.29) | Тийм |
| 7. | С.Боргил (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.08.31-ний өдөр, Дугаар 0130985/ (Хавсралт 2.30) | Тийм |
| 8. | Ж.Жаргалсүрэн (ТУЗ-ийн хараат бус гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2018.04.13-ны өдөр, Дугаар 0230323/ (Хавсралт 2.31) | Тийм |
| 9. | Д.Гаахүү (ТУЗ-ийн хараат бус түр гишүүн) | Үгүй | Үгүй* | Тийм /2021.10.02-ны өдөр, Дугаар 0731306/ (Хавсралт 2.32) | Тийм |
| 10. | Б.Оюунболд (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.03.28-ны өдөр, Дугаар 0131951/ (Хавсралт 2.33) | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөллийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавих нэмэлт шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах нэмэлт шаардлага | | |
|---|---|---|
| № | Шаардлага | ТУЗ-ийн хараат бус гишүүдийн нэрс |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC

MDS KhanLex

| | | С.Боргил | Ж.Жаргалсайхан рэн | Д.Галхүү |
|---|---|---|---|---|
| 1. | Өөрөө эсхүл компанийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй байх (КтХ-ийн 79.1.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 2. | Өөрөө эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогчид ажил, албан тушаал эрхэлдэггүй, сүүлийн 3 жилийн хугацаанд аливаа ажил, албан тушаал эрхэлж байгаагүй байх (КтХ-ийн 79.1.2) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 3. | Төрийн үйлчилгээнийхээс бусад төрийн алба хашдаггүй байх (КтХ-ийн 79.1.3, 84.3.1) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 4. | Компанитай бизнесийн гэрээ хэлцэл байгуулаагүй байх, тийм холбоогүй байх (КтХ-ийн 79.1.4) | Тийм** | Тийм** | Тийм** |
| 5. | Компанид нэгдмэл сонирхолтой этгээд болж байгаагүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 6. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдэй зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 7. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдтэй ханган нийлүүлэгч ба харилцагч биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 8. | Компани эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдэй үйлчилгээ үзүүлэх гэрээ хийгээгүй байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 9. | Компанийн ТУЗ, гүйцэтгэх захирал болон гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, дотоод аудитын ажилтны нэгдмэл сонирхолтой этгээд биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |
| 10. | Хувьцаа эзэмшигч эсхүл түүний нэгдмэл сонирхолтой этгээдийн ойрын хамаатан биш байх | Тийм** | Тийм** | Тийм** |

***Компанийн тухай хуулийн 79.1.1-79.1.4 зүйл, Компанийн засаглалын кодекст заасан ТУЗ-ийн хараат бус гишүүнд тавигдах шаардлагын дагуу компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүд хангаж байгаа эсэхийг тэдний гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэж дүгнэв.*

Компанийн ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын мэргэжил, боловсрол, эрхэлж байсан\байгаа ажлын туршлага зэргийг үзвэл Компанийн үйл ажиллагаар

*17 - 55*

СЗХ
2023 он 08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ ...1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02





явуулахад шаардлагатай мэдлэг, туршлагатай, хууль болон Компанийн засаглалын журмаар тогтоосон шаардлагыг хангаж байна гэж дүгнэв.

**Компанийн бусад эрх бүхий албан тушаалтан**

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнууд болох Гүйцэтгэх захирал Б.Улвалыг ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын 22/31 тоот тогтоол (Хавсралт 2.12)-оор чөлөөлж, ТУЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн хурлын 22/32 тоот тогтоол (Хавсралт 2.13)-оор Ц.Ууганбаярыг 2023 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн томилсон байна. Компанийн гүйцэтгэх захирал оорчлогдсонийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2023 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн 05/12 тоот тогтоолоор зөвшөөрсөн (Хавсралт 2.14) бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Оюунболд нь ТУЗ-ийн 2022 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн хурлын 22/07 тоот тогтоол (Хавсралт 2.15)-оор томилж, Санхүү, үйл ажиллагааны газрын захирал М.Түвшинжаргал нь 2018 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 2018/82 тоот Гүйцэтгэх захирлын тушаал (Хавсралт 2.16)-аар. Бизнес хөгжлийн газрын захирал Д.Баасандорж нь 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдрийн Б-2023/03 тоот Гүйцэтгэх захирлын тушаал (Хавсралт 2.17)-аар, Ерөнхий нягтлан бодогч Г.Золжаргал нь 2021 оны 9 дүгээр сарын 8-ны өдрийн 2021/85 тоот Гүйцэтгэх захирлын тушаал (Хавсралт 2.18)-аар тус тус томилогдон ажиллаж байна.

*Компанийн бусад эрх бүхий албан тушаалтнуудын боловсрол, ажлын туршлагын мэдээлэл:*

| № | Нэр | Боловсрол | Ажлын туршлага |
|---|---|---|---|
| 1. | **Цэрэндоржийн Ууганбаяр** (Гүйцэтгэх захирал ) (Хавсралт 2.19) | 2010 онд Болгар улсын Америкийн Их Сургуульд Бизнесийн удирдлага (Нягтлан бодох бүртгэл), Эдийн засгийн ухааны бакалавр. | 2008 онд Марта Вайнярд Хадгаламжийн банкинд теллер;<br>2009 онд Америкийн Нэгдсэн Улс, Эдгартаун Үндэсний Банкинд нягтлан бодогч /дадлага/;<br>2010-2018 онд Эм Си Эс Холдинг ХХК-д санхүүгийн ахлах ажилтан;<br>2018 оноос одоог хүртэл "АНД Глобал Пти.Лтд", Санхүүгийн менежер/ Санхүү эрхэлсэн;<br>2022 оноос одоог хүртэл АНД Системс ХХК-д ТУЗ-ийн гишүүн;<br>2023 оноос одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д Гүйцэтгэх захирал;<br>2022 оноос одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д ТУЗ-ийн гишүүн. |
| 2. | **Батсүлдийн Оюунболд** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) (Хавсралт 2.20) | 2012-2018 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургууль БНСУ-ын KOOKMIN их сургуулийн хамтарсан эрх зүйн хөтөлбөр, эрх зүйн бакалавр; | 2017-2019 онд Өмгөөллийн "Цогт энд Нандин" ХХН-д туслах хуульч;<br>2019-одоог хүртэл "АНД Системс" ХХК-д ахлах хуулийн зөвлөх, хууль, эрх |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | | зүйн асуудал хариуцсан захирал; 2022-одоог хүртэл "ЛэндМН ББСБ" ХК-д ТУЗ-ийн нарийн бичгийн дарга. |
| 3. | **Махвалын Түвшинжаргал** (Санхүү, үйл ажиллагааны газрын захирал) (Хавсралт 2.21) | 1999 онд Монгол Улсын Техникийн Их сургуульд усан барилгын бакалавр; 2005 онд Санхүү эдийн засгийн дээд сургуульд бизнесийн удирдлагын бакалавр; 2013 онд Удирдлагын академид бизнесийн удирдлагын магистр. | 2001-2005 онд "Ус инженер" ХХК-д инженер, эдийн засагч, менежер; 2005.05-2005.11 онд "Дэлхийн зөн" олон улсын байгууллагад хяналтын инженер; 2006-2016 онд "Ньюфонд ББСБ" ХХК-д зээлийн ахлах мэргэжилтэн; 2016 оноос ЛэндМН ББСБ гүйцэтгэх захирал, Санхүү, үйл ажиллагааны газрын захирал. |
| 4. | **Даваасүрэнгийн Бавсандорж** (Бизнес хөгжлийн газрын захирал) (Хавсралт 2.22) | 2013-2017 онд АНУ-ын Ютагийн их сургуулийн Бизнесийн сургуульд Компьютер хангамжаар бакалавр. | 2012-2013 онд 3Е Сольюшн ХХК-д туслах менежер; 2014-2017 онд Юта их сургуулийн хөгжлийн төвд харилцагчийн менежер, ерөнхий менежер; 2018-2020 онд Эм Си Эс Холдинг ХХК-д бүтээгдэхүүний менежер; 2020-одоог хүртэл Асап Кэйр ХХК-д гүйцэтгэх захирал; 2021-одоог хүртэл Супер Ап ХХК-д гүйцэтгэх захирал; 2022-одоог хүртэл Анд Глобал Пти.ЛтД-д Бизнес хөгжлийн газрын захирал. |
| 5. | **Ганболдын Золжаргал** (Ерөнхий нягтлан) (Хавсралт 2.23) | 2008 онд Санхүү Эдийн засгийн Их Сургуулийн бизнес удирдлагын бакалавр. | 2008-2019 онд "ХасЛизинг" ХХК-ийн ахлах нягтлан бодогч |

Компанийн бусад эрх бүхий албан тушаалтны нар нь Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст заасан эрх бүхий албан тушаалтны шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах хүснэгтээр харуулав:

| КОМПАНИЙН БУСАД ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА |
|---|

СЭХ
он 2023 сар 08 11 өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ-02

MDSKhanLex

| № | Нэр/Шаардлага | Төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх | Ял шийтгэл эдэлж байгаа эсэх (КтХ-ийн 84.3.2)* | Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх (КтХ-ийн 75.8) | Хувь хүн байх (КтХ-ийн 77.3, 83.2, 83.3) |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Ц.Угтанбаяр** (ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.02.21-ний өдөр, Дугаар 0131874/ (Хавсралт 2.27) | Тийм |
| 2 | **Б.Оюунболд** (ТУЗ-ийн нарийн бичгийн дарга) | Үгүй | Үгүй* | Тийм /2022.03.28-ны өдөр, Дугаар 0131951/ (Хавсралт 2.33) | Тийм |
| 3 | **М.Түвшинжаргал** (Санхүү, үйл ажиллагааны захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 4 | **Д.Баасандорж** (Бизнес хөгжлийн газрын захирал) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |
| 5 | **Г.Золжаргал** (Ерөнхий нягтлан бодогч) | Үгүй | Үгүй* | Үгүй | Тийм |

**Монгол Улсын Хууль зүйн сайдын 2017 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн А/195 тоот тушаалын 6 дугаар зүйлд заасны дагуу Ял шийтгэлтэй эсэх лавлагааг өмгөөлөгчийн нөхөрлөлд олгодоггүй тул Компанийн тухай хуулийн 84.3.2-т заасан шийтгэл эдлээгүй байх шаардлагыг ТУЗ-ийн гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтнууд хангаж байгаа эсэхийг бидэнд гаргаж өгсөн мэдүүлэг, баталгааг үндэслэн дүгнэв.*

Компанийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 2-р сарын 7-ны өдрийн А-2023/04 тоот тушаалаар баталсан Компанийн зохион байгуулалтын шинэчилсэн бүтэц (Хавсралт 2.35)-ээс үзвэл Гүйцэтгэх захирлын дор Ерөнхийлөгч гэх албан тушаалыг оруулсан болövч Компанийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, Компанийн газар хэлтэс, албадын чиг үүргийг тодорхойлсон баримт бичигт түүний албан тушаалын чиг үүрэг тусгагдаагүй байгаа харгалзан Ерөнхийлөгчийг Компанийн эрх бүхий албан тушаалтан гэж үзээгүй болно (Хавсралт 12.1). Толгой компанийн санал болгосноор ажиллах Ерөнхийлөгч нь гадаадын хөрөнгө оруулалт татах, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ, технологи хөгжүүлэхэд зөвлөх чиг үүрэгтэй, компанийн үйл ажиллагааг удирдах, шийдвэр гаргахад оролцдоггүй болохыг Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT LLC

СЗХ
2023 08 11
сар өдөр
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28
БҮРТГЭВ



MDSKhanLex

Дүгнэвэл, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, бусад эрх бүхий албан тушаалтнууд нь хууль болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг хангаж байгаа бөгөөд тэдгээр нь Компанийг удирдах чадвар, дадлага туршлагатай гэж дүгнэв.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118257206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK

MDSKhanLex

Бид Үнэт цаас гаргагчийн нийт 65 журмын жагсаалт дотроос Компанийн үндсэн үйл ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн журмуудыг түүвэрлэн нийт 33 журмыг дараах ангиллын дагуу хянасан болно.

1. Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам
2. Зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам
3. Зээлээс бусад үйл ажиллагаатай холбоотой журам
4. Хөдөлмөрийн харилцаатай холбоотой дүрэм,журам
5. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх болон эрсдэлийн удирдлагатай холбоотой журам
6. Мэдээллийн ил тод, аюулгүй байдал, хяналттай холбоотой дүрэм, журам

***Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам:***

***Компанийн дүрэм.*** Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2018 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоолоор баталж, хамгийн сүүлд 2023 оны 4 дүгээр сарын 15-ны 23/04 тоот тогтоолоор нэмэлт, өөрчлөлт оруулсан "ЛэндМН ББСБ" ХК-ийн дүрэм (цаашид "Дүрэм" гэх)-ийг (Хавсралт 1.6) хүчин төгөлдөр мөрдөж байна. Дүрэм нь нийт 5 бүлэгтэй бөгөөд Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох, Компанийн хувь нийлүүлсэн болон өөрийн хөрөнгө, Компанийн удирдлага, хувьцаа эзэмшигч, хувьцаа эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөл, түүний дарга, нарийн бичгийн дарга, гишүүд, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, тэдгээрийн дарга, гишүүд, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, тэдний эрх, үүрэг хариуцлагыг тодорхойлох, Компанийн дотоод болон хөндлөнгийн аудит, Компанийн санхүүгийн үйл ажиллагаа, бүртгэл, тайлан, их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчил бүхий этгээдтэй хийх хэлцэл хийх, үнэт цаас худалдах, эргүүлэн авах, ногдол ашиг хуваарилан олгох, Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Үнэт цаас гаргагчийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйл, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох зохицуулалттай нийцсэн байна.

***ТУЗ-ийн үйл ажиллагааны журам.*** Компанийн ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг Компанийн засаглалын кодекст нийцүүлэх зорилгоор нийт 15 бүлэгтэй "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ыг 2018 оны 06 дугаар сарын 04-ны өдрийн 18/13 тоот тогтоолын хавсралт 1-ээр батлан (Хавсралт 3.1) мөрдөж байна. Тус журмаар ТУЗ-ийн гишүүдэд тавигдах шаардлага, гишүүдийн үүрэг хариуцлага, ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн нарийн бичгийн даргын бүрэн эрх, хариуцлага, ТУЗ-ийн хороодын чиг үүргийг тодорхойлж, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх, шалгаруулах, гишүүдийн үйл ажиллагаанд дүгнэлт өгөх, ТУЗ-ийн хурлыг зарлах, түүнд бэлтгэх, хуралдуулах, шийдвэр гаргах, шийдвэрийг мэдээлэх, биелэлтэд хяналт тавих, ТУЗ-ийн гишүүдийн идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхүйц цалин урамшуулал олгох, хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Компанийн дүрмийн 9.2, уг журмын 2.3-т ТУЗ нь 9 болон түүнээс дээш гишүүнтэй байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.2-т заасан хувьцаат компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй байх, мөн хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байна гэсэн шаардлагад нийцэж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын 10 дугаар бүлэгт ТУЗ нь Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин, урамшууллын хороо, Аудитын хороотой байхаар зохицуулсан нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т заасан хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх гэсэн шаардлагад нийцсэн байна.

ТУЗ-ийн үйл ажиллагааны журам нь Компанийн тухай хуулийн 76.1, 80.4, Компанийн засаглалын Кодекст заасан холбогдох шаардлагыг тус тус хангасан байна.

***Компанийн ногдол ашгийн бодлого.*** ТУЗ-өөс ногдол ашгийн бодлого, ногдол ашиг хуваарилах нөхцөл журмыг Компанийн тухай хууль, Монголын компанийн засаглалын Кодекст нийцүүлэн нийт 4 бүлэгтэй "Ногдол ашгийн бодлого"-ыг 2017 оны 12 дугаар сарын 1-ний өдрийн 17/02 тоот тогтоолын хавсралтаар батлан (Хавсралт 3.2) мөрдөж байна. Тус бодлогод ногдол ашгийг хуваарилах нөхцөл, ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр, ногдол ашиг хуваарилах, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулсан байна. ТУЗ-ийн 2017 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн "Ногдол ашгийн хязгаар тогтоох тухай" 17/04 тоот тогтоолоор "... тайлант үеийн аудитлагдсан цэвэр ашгийн 20-оос багагүй хувийг..." ногдол ашигт хуваарилна гэж зохицуулсан.

***Шүгэл үлээх журам.*** Гүйцэтгэх захирлын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 2021/04 тоот тушаалын Хавсралт 1-ээр Компанийн нэр төр, бүтээгдэхүүн үйлчилгээ, өмч хөрөнгө, үйл ажиллагаатай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, компанийн дотоод бодлого, журмын талаар ёс зүйн дүрэм зэргийг зөрчсөн ажилтан болон хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажиллаж байгаа ажилтнууд мэдээлэх буюу шүгэл үлээх, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэх, мэдээлэл өгсөн ажилтны нууцыг хадгалах, хамгаалахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор нийт 4 бүлэг, шүгэл үлээх журмын процесс зураглал бүхий 1 хавсралтаас бүрдсэн Шүгэл үлээх журмыг батлан (Хавсралт 3.3) мөрдүүлж байна. Энэ журмаар журмын зорилго, зохицуулах үйл ажиллагаа, хамрах хүрээ, мэдээллийг гаргах, түүний агуулга, мэдээллийг хүлээн авах, түүний мөрөөр ажиллах үйл явц, хариуцлагатай холбоотой харилцааны талаар зохицуулсан нь Компанийн засаглалын кодексийн зарчимтай нийцэж байна.

Дүгнэвэл, Компани нь СЗХ-ноос баталсан Компанийн засаглалын кодекст зааснаар "Компанийн засаглалын кодекс"-ийн зарчмын зүйл тус бүрээр үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайланг холбогдох маягтын дагуу гарган ажиллаж байна. Түүнчлэн, Монголын хөрөнгийн бирж (Хавсралт 10.8)-ээс ирүүлсэн албан бичигт "ЛэндМН ББСБ" ХК нь компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэн ажиллаж байна гэж дурджээ.

СЗХ-ны 2022 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Компанийн засаглалын кодексийг шинэчлэн баталсан бөгөөд Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэгдсэн 2022 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Шинэчилсэн кодексийн 1.2 (залгамж халааны бодлого), 1.4 (ТУЗ-д хүйсийн тэнцвэрийг хангах), 1.5 (чиглүүлэх сургалт), 2.1 (Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болоод төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байх), 2.3 (эрх бүхий албан тушаалтны цалин урамшууллын бодлого) 5.3 (байгаль орчин, нийгмийн хариуцлага, эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийж, хэрхэн удирдаж байгааг тайлбарлах)-д заасан шинэ нөхцөл, шаардлагыг харгалзан зохих бодлогын баримт бичгүүдийг баталж, хэрэгжүүлэх зэргээр кодексийн хэрэгжилтийг хангах талаар тусгай төлөвлөгөө гаргаж ажиллахыг Үнэт цаас гаргагчид зөвлөж байна.

***Зээлийн үйл ажиллагаатай холбоотой журам:***

***Зээлийн үйл ажиллагааны журам.*** Гүйцэтгэх захирлын 2022 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 2022/111 тоот тушаалын Хавсралт 1-ээр компанийн бүх төрлийн зээлийг авах хүсэлтэй иргэн болон хуулийн этгээдийн кредит скор болон зээлийн судалгаанд суурилан тогтоосон зээлийн эрхийн хүрээнд зээлийн бүтээгдэхүүний зориулалтын дагуу зээл олгох үйлчилгээг үзүүлэхтэй холбогдон үүсэх ерөнхий харилцааг зохицуулах зорилгоор нийт 15 бүлэг бүхий Зээлийн үйл ажиллагааны журмыг батлан (Хавсралт 3.4) мөрдүүлж байна. Энэхүү журмаар зээлийн бүтээгдэхүүний төрөл, ангилал, харилцагчийн бүртгэх, кредит скор тооцох, харилцагчтай гэрээ байгуулах, зээл олгох үйл ажиллагаа, зээлийн эргэн төлөлт, хяналт, авах арга хэмжээ, зээлийн гэрээнд өөрчлөлт оруулах нөхцөл, барьцаа хөрөнгөд тавигдах шаардлага, нөхцөл, зээлийн үйл ажиллагаанд хориглох зүйлс, зээлийн мэдээллийн сан, харилцагчийн хувийн мэдээлэл, түүний ашиглалт, нууцлал, аюулгүй байдал, хяналт хариуцлага зэрэгтэй холбоотой харилцааны талаар зохицуулсан байна.

2023.08.11 БҮРТГЭВ



2023-07-28 БҮРТГЭВ-02

MDSKhanLex

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 12-р сарын 23-ны өдрийн 711 тоот тогтоолоор Финтек зээлийн үйлчилгээ эрхэлж буй банк бус санхүүгийн байгууллагууд нь 2023 оны 6-р сарын 30-ны өдрийн дотор Банк бус санхүүгийн (финтек) зээлийн үйл ажиллагааны журмаа шинэчилж Хороонд бүртгүүлэхийг үүрэг болгосон. СЗХ-ны 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 7/2558 (Хавсралт 3.33) тоот албан бичгээр LendMN аппликэйшнийг холбогдох хууль, журмын шаардлага хангасан, мөн үйл ажиллагаа явуулах боломжтой финтек зээлийн бүтээгдэхүүнээр бүртгэснийг мэдэгдсэн байна.

***Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, лавлагаа авах үйл ажиллагааны журам.*** Зээлийн мэдээллийн тухай хууль, Монголбанкны зээлийн мэдээллийн сангийн журмын дагуу Зээлийн мэдээллийн санд харилцагчийн зээлийн мэдээллийг үнэн зөв, бодит тасралтгүй байдлаар нийлүүлэх, мөн харилцагчийн зээлийн мэдээллийн лавлагаа авах харилцааг зохицуулах зорилгоор нийт 3 бүлэг бүхий Зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, лавлагаа авах үйл ажиллагааны журмыг Гүйцэтгэх захирлын 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 2020/54а тоот тушаалын Хавсралт 1-ээр батлан (Хавсралт 3.5) мөрдүүлж байна. Энэ журмаар зээлийн мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх, лавлагаа авах, зээлийн мэдээллийн сан хариуцсан ажилтны үүрэг, хариуцлагын талаар зохицуулсан байна. Энэхүү журам нь Зээлийн мэдээллийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Хугацаа хэтэрсэн зээлтэй ажиллах, авлага барагдуулах журам.*** Зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрч болзошгүй болон хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг барагдуулах Компанийн чиг үүрэг бүхий газар, хэлтэс, алба, нэгжээс авч хэрэгжүүлэх арга хэмжээ, явуулах үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулах зорилгоор нийт 9 бүлэг бүхий Хугацаа хэтэрсэн зээлтэй ажиллах, авлага барагдуулах журмыг Гүйцэтгэх захирлын 2021 оны 4 дүгээр сарын 2-ний өдрийн 2021/31 тоот тушаалын Хавсралтаар батлан, мөн Гүйцэтгэх захирлын 2022 оны 12-р сарын 6-ны өдрийн 2022/279 тоот тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан (Хавсралт 3.6) мөрдүүлж байна. Энэхүү журмаар хугацаа хэтэрсэн зээлийн ангилал, авлага барагдуулах арга хэмжээ, хугацаа хэтэрсэн зээлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх, ажилтны үүрэг, бүртгэл мэдээлэл шинэчлэлт, хариуцлагын талаар зохицуулсан байна. Энэхүү журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Харилцагчийн гэрээг баталгаажуулах, хүлээн авах журам.*** Гүйцэтгэх захирлын 2021 оны 10-р сарын 5-ны өдрийн 2021/98 тоот тушаалын хавсралтаар харилцагчийн гэрээг баталгаажуулах, харилцагчийн зээлийн гэрээг бүрдүүлж, хүлээж авах үйл явцыг зохицуулах зорилгоор нийт 7 бүлэг бүхий Харилцагчийн гэрээг баталгаажуулах, хүлээн авах журмыг шинэчлэн батлан (Хавсралт 3.7) мөрдүүлж байна. Энэхүү журмаар түүний зорилго, хэрэглээ шаардлага, цахим зээлийн эрх нээх гэрээ бүртгэх, цахим зээлийн эрх нээх гэрээ хүлээлгэх хугацаа, хяналт хариуцлагын талаар зохицуулсан нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцэж байна.

***Инстоллмент зээлийн үйлчилгээний журам*** (Хавсралт 3.12). Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 дүгээр сарын 28-ний өдрийн 2020/13 тоот тушаалын хавсралтаар богино хугацааны зээлийн эрхийн болон шимтгэлийн түвшний өндөр шатанд хүрсэн найдвартай харилцагчийн богино, дунд хугацааны зээлийн хэрэгцээг хангаж зээлийн эрхийн хэмжээг нэмэгдүүлэх, зээлийн хугацааг сунгах, зээлийн эргэн төлөлтийн хэсэгчилж төлөх үйлчилгээг зохицуулах зорилгоор нийт 5 бүлэг, 3 хавсралт бүхий Инстоллмент зээлийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдөж байна.

**Зээлээс бусад үйл ажиллагаатай холбоотой журмууд**

Зээлээс бусад дотоод үйл ажиллагаандаа хүчин төгөлдөр мөрдөж байгаа факторинг, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга, итгэлцлийн үйлчилгээ, гадаад валютын арилжааны үйл ажиллагаанд хамаарах нийт 7 журмыг МДСХ-д ирүүлснийг хянав. Үүнд:



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ



RHINOS INVESTMENT ҮЦК

MDSKhanLex

| № | Журмын нэр | Огноо | Дугаар | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1. | Факторингийн үйлчилгээний журам (Хавсралт 3.8) | 2018.12.05 | 2018/184 | Гүйцэтгэх захирал |
| 2. | Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний журам (Хавсралт 3.9) | 2019.04.01 | 2019/80 | Гүйцэтгэх захирал |
| 3. | Цахим төлбөр тооцооны үйлчилгээний журам (Хавсралт 3.10) | 2018.10.19 | 2018/153, Хавсралт 1 | Гүйцэтгэх захирал |
| 4. | Итгэлцлийн үйлчилгээний журам (Хавсралт 3.11) | 2019.03.01 | 2019/44а | Гүйцэтгэх захирал |
| 5. | Гадаад валютын арилжааны журам (Хавсралт 3.13) | 2019.03.25 | 2019/60, Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |
| 6. | Цахим төлбөр тооцооны хэрэгсэл гаргах журам (Хавсралт 3.14) | 2017.10.18 | 2017/18 | Гүйцэтгэх захирал |
| 7. | Мөнгөн хөрөнгө, төлбөр тооцоо, тооллого хяналтын журам (Хавсралт 3.22) | 2021.01.29 | 2021/13 | Гүйцэтгэх захирал |

Факторингийн үйлчилгээний журамд факторингийн бүртгэлийн үйл ажиллагаа явуулахаар тусгасан нь СЗХ-ноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийг хөтлөх үлгэрчилсэн заавартай нийцэж байна.

Компанийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн дагуу цахим төлбөр тооцооны үйлчилгээний нөхцөл, үйлчилгээний шимтгэл, хураамжийн нөхцөл, гэрээ байгуулах, дуусгавар болгох нөхцөл, нягтлан бодох бүртгэл, тайлан мэдээ хөтлөлт, тоног төхөөрөмж, програм хангамж, аюулгүй байдал, эрсдэлийн хяналт, түүнтэй холбоотой эрх, үүрэг, хяналт хариуцлагатай холбоотой харилцааг зохицуулсан байна. Компани нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн хүрээнд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга хийх болон төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйл ажиллагаа эрхэлж байна. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар уг үйлчилгээг Лэнд хэтэвчээр дурдсан тусгай зөвшөөрлийн хүрээнд явуулахтай холбоотой Цахим төлбөр тооцооны үйлчилгээний журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 (төлбөр тооцооны хэрэгсэл гаргах), 7.1.6 (цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ), тухайн үед хүчин төгөлдөр мөрдөж байсан СЗХ-ны 2011 оны Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журамд[2] тус тус нийцсэн, уг тусгай зөвшөөрлүүдийг олгосон СЗХ-ны тусгай зөвшөөрөл хүчин төгөлдөр байна.

Дээрх журмуудын үндэслэх хэсэгт заасан хуулийн нэршлийг 2021 онд батлагдсан "Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг зээлийн үйл ажиллагааны тухай хууль" болгон өөрчлөх шаардлагатай. Эдгээр журмууд нь агуулгын хувьд Иргэний хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нийцсэн гэж үзэв.

***Хөдөлмөрийн харилцаатай холбоотой дүрэм, журам***

Үнэт цаас гаргагч нь хөдөлмөрийн харилцаатай холбоотой дараах 3 журмыг батлан мөрдөж байна. Эдгээр нь Хөдөлмөрийн тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль,

[2] Үндэсний төлбөрийн системийн тухай хууль шинээр батлагдаж 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүчин төгөлдөр болсон, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн А-45 дугаар тушаалаар "Цахим мөнгөний журам" батлагдсан зэрэгтэй холбогдуулан СЗХ-ны 2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 376 тоот тогтоолоор "Банк бус санхүүгийн цахим мөнгөний үйлчилгээний журам"-ыг хүчингүй болгосон. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5 (төлбөр тооцооны хэрэгсэл гаргах), 7.1.6 дахь заалт буюу "цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ" эрхлэх хуулийн заалт хүчин төгөлдөр хэвээр байх тул тус хуулийн заалт болон өөрийн баталсан журмын дагуу цахим төлбөр тооцооны үйлчилгээг Компани нь үргэлжлүүлж байгааг хууль бус гэж үзэх үндэслэлгүй болно. Үндэсний төлбөрийн системийн тухай хуулийг шинээр батлахдаа хүчин төгөлдөр үйлчилж буй хуультай уялдуулах, шилжилтийн үеийн горимыг тогтоогоогүй нь эрх зүйн харилцаанд оролцогчийн үйл ажиллагааг хангалтгүй болгосон гэж үзэж байна.

СЗХ 2023 .06. 11 он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28 БҮРТГЭВ-02

MDSKhanLex

Компанийн засаглалын кодексийн 8 дугаар зарчим, хавсралт 3-д заасан "Ёс зүйн дүрмийн үлгэрчилсэн загвар" агуулгатай нийцэн ба зөрчсөн заалт агуулаагүй байна.

| № | Журмын нэр | Огноо | Дугаар | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1. | Хөдөлмөрийн дотоод журам (Хавсралт 3.15) | 2023.01.17 | А-2023/01<br><br>Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |
| 2. | ЛэндМН ББСБ ХК-ийн ёс зүйн дүрэм (Хавсралт 3.16) | 2019.10.23 | 19/54 Хавсралт 1 | Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал |
| 3. | Ялгаварлал, дарамт, хүчирхийлэл, бэлгийн дарамтыг хориглох, урьдчилан сэргийлэх, шийдвэрлэх журам (Хавсралт 3.17) | 2022.08.24 | 2022/177<br><br>Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |

***Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх болон эрсдэлийн удирдлагатай холбоотой журам***

Компанийн үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, урьдчилан сэргийлэх, бууруулах, хянах замаар компанийн хүлээж болзошгүй хохирлыг бууруулах эрсдэлийн удирдлагын үр ашигтай тогтолцоог бий болгох, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх, сэжигтэй гүйлгээг илрүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулсан нийт 6 бодлогын баримт бичиг, журам батлан мөрдүүлж байгааг МДСХ-д ирүүлснийг бид хянасан. Үүнд:

| № | Журмын нэр | Огноо | Дугаар | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1. | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам (Хавсралт 3.18) | 2022.04.26 | 2022/91 Хавсралт 1 | Гүйцэтгэх захирал |
| 2. | Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр (Хавсралт 3.19) | 2020.06.04 | 2020/64 Хавсралт 3 | Гүйцэтгэх захирал |
| 3. | Эрсдэлийн удирдлагын бодлого (Хавсралт 3.20) | 2021.12.24 | 21/45 Хавсралт 1 | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 4. | Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам (Хавсралт 3.21) | 2022.12.05 | 2022/278 Хавсралт 1 | Гүйцэтгэх захирал |
| 5. | Зээл түүнтэй адилтгах актив ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах бодлого (Хавсралт 3.23) | 2021.12.23 | 21/46<br><br>Хавсралт №1 | Төлөөлөн удирдах зөвлөл |
| 6. | Харилцагчийг таньж мэдэх, төлбөр тооцооны эрсдэлийн үнэлгээ хийх, эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааны журам (Хавсралт 3.24) | 2019.03.22 | 2019/64<br><br>Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |

Бонд гаргах бэлтгэл ажлын хүрээнд МДСХ нь мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааны журам (Хавсралт 3.18) болон Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр (Хавсралт 3.19)-ийг хянаж, зарим нэг үл нийцлийг илрүүлж, зөвлөмж хүргүүлсний дагуу Үнэт цаас гаргагч нь журамдаа зохих өөрчлөлт оруулан



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT

бидэнд төслөөр ирүүлсэн. Журам, хөтөлбөрт оруулахаар төлөвлөсөн өөрчлөлт нь бидэнд ирүүлсэн төслөөр батлагдана гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй болно.

Хөтөлбөрийн 1.3-т зааснаар хөтөлбөрийг сайжруулах, хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, шаардлагатай арга хэмжээ авч ажиллах үүрэг бүхий ажилтан нь Компанийн хууль, хяналт нийцүүлэлт хариуцсан мэргэжилтээр Х.Одончимэг томилогдон ажиллаж (Хавсралт 3.18) байна.

Эдгээр бодлогын баримт бичиг, журам, заавар, аргачлал нь дээр тусгайлан дурдсанаас бусдаар Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4, 5, 9, 13, 14, 15 дугаар зүйл, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/26 дугаар тушаалаар баталсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд нийцэж байна.

***Мэдээллийн ил тод, аюулгүй байдал, хяналттай холбоотой дүрэм, журам***

Компаниас эрх бүхий байгууллагад болон хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид, олон нийтэд хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийн төрөл, хэлбэр, давтамж, мэдээллийн ил тод байдлыг хангах, нийтэд хүргэх, аюулгүй байдлыг хангах, дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой нийт 8 бодлогын баримт бичиг, журам батлан мөрдүүлж байгааг МДСХ-д ирүүлсний дагуу нийцлийг хянасан. Үүнд:

| № | Журмын нэр | Огноо | Дугаар | Баталсан |
|---|---|---|---|---|
| 1. | Дотоод аудитын дүрэм (Хавсралт 3.25) | 2021.02.05 | 21/01 Хавсралт | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 2. | Дотоод хяналтын бодлого (Хавсралт 3.26) | 2020.12.23 | 20/38 Хавсралт 1 | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 3. | Мэдээллийн ил тод байдлын тухай журам (Хавсралт 3.27) | 2022.11.16 | 2022/249 Хавсралт 1 | Гүйцэтгэх захирал |
| 4. | Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын бодлого (Хавсралт 3.28) | 2021.02.05 | 21/02 Хавсралт 1 | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| 5. | Биет бус мэдээллийг нөөцлөх, нөхөн сэргээх журам (Хавсралт 3.29) | 2022.08.24 | 2022/177 Хавсралт 1 | Гүйцэтгэх захирал |
| 6. | Зохицуулалтын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх журам (Хавсралт 3.30) | 2022.12.06 | 2022/283 Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |
| 7. | Харилцагчийн хүсэлт, гомдлын журам (Хавсралт 3.31) | 2022.01.31 | 2022/20 Хавсралт №1 | Гүйцэтгэх захирал |
| 8. | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг (Хавсралт 3.32) | 2022.04.19 | 22/16 Хавсралт №1 | Төлөөлөн удирдах зөвлөл |

Нэгтгэн дүгнэвэл, Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, СЗХ-ны баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн байна.

Бид Компанийн ирүүлсэн нийт 244 гэрээнээс Компанийн үндсэн үйл ажиллагаанд ач холбогдолтой гэж үзсэн гэрээнүүдийг түүвэрлэн нийт 89 гэрээ, гэрээний загварыг дараах ангиллын дагуу хянасан болно.

1. Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой загвар гэрээ
2. Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээ
3. Зээлийн гэрээ
4. Үнэт цаас гаргахтай холбоотой гэрээ, хэлцэл
5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл

***I. Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой загвар гэрээ:***

МДСХ нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасны дагуу дараах 11 гэрээний загвар баримт бичгүүдийг хянасан. Үүнд:

| № | Баримт бичгийн нэр | Огноо, Дугаар, тайлбар |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ (Хавсралт 4.11) | 2023.01.02, Цэрэндорж овогтой Угтанбаяр |
| 2. | Хөдөлмөрийн гэрээний загвар (Хавсралт 4.1) | - |
| 3. | Нууцлалын гэрээний загвар (хамтрагч байгууллагатай байгуулах) (Хавсралт 4.2) | - |
| 4. | Нууцлалын гэрээний загвар (ажилтантай байгуулах) (Хавсралт 4.3) | - |
| 5. | Эд хөрөнгийн бүрэн хариуцлагын гэрээний загвар (Хавсралт 4.4) | - |
| 6. | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний загвар (Хавсралт 4.5) | - |
| 7. | Цахим эрх нээх зээлийн гэрээний загвар (Хавсралт 4.6) | - |
| 8. | Зээлийн гэрээний загвар (Хавсралт 4.7) | - |
| 9. | Цахим төлбөр тооцооны гэрээний загвар (Хавсралт 4.8) | - |
| 10. | Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээний загвар (Фудициийн гэрээ) (Хавсралт 4.9) | - |
| 11. | Хамтран ажиллах гэрээний загвар (Хавсралт 4.10) | - |

***Хөдөлмөрийн гэрээний загвар.*** (Хавсралт 4.1) Компани нь ажилтнуудтайгаа байгуулдаг хөдөлмөрийн гэрээний загварт Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлд заасан гэрээнд тусгах гол нөхцөлүүд болох ажлын байрны буюу нэр, ажлын байрны тодорхойлтод заасан гүйцэтгэх ажил үүрэг, ажил гүйцэтгэх байршил, цалин хөлсний хэмжээ, хөдөлмөрийн нөхцөлийг тусгасан байна.

Хөдөлмөрийн гэрээний загварын 4.5.2-т "... Ажилтан ээлжийн амралтыг хэсэгчилсэн байдлаар эдлэх бол хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг хугацаа нь ажлын 10 өдөртэй тэнцүү байна" гэснийг Хөдөлмөрийн тухай хуулийн 99.8-т ажлын 10 өдрөөс доошгүй байхаар заасанд нийцүүлэх, мөн загварын 4.9.3-т ажилтан нь ажилтан ээлжийн амралттай ажилтны

үүргийг түр орлон гүйцэтгэсэн бол нэмэгдэл хөлс олгохгүй байхаар зохицуулсныг Хөдөлмөрийн тухай хуулийн 56.1, 56.2-т заасанд нийцүүлж, эзгүй байгаа ажилтны үүргийг түр орлон гүйцэтгүүлэх...тохиолдолд гүйцэтгэх ажил үүрэгт нь тохирох цалин хөлсийг нэмж олгохоор уг загварт өөрчлөлт оруулан хуулийн нийцтийг хангах нь зүйтэйг зөвлөв. Энэхүү үл нийцэл нь гэрээ байгуулагдсан эсэхийг үгүйсгэх, гэрээг хүчин төгөлдөр бусад тооцох нөхцөл болохгүй болохыг тэмдэглэж байна.

Зөвлөмжийн дагуу гэрээний загварт зохих өөрчлөлт оруулахаа Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 12.1).

***Нууцлалын гэрээний загвар.*** (Хавсралт 4.2) Компани нь уг гэрээгээр бусад компанитай бизнесийн хамтын ажиллагаа явуулах үед үүсэх эсхүл үүссэн аливаа нууцад хамаарах мэдээллийг хадгалах, бусдад задруулахгүй байхтай холбогдох харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулсан байх бөгөөд гэрээний үндэслэж буй хууль тогтоомжид Хувь хүний нууцын тухай хууль тусгагдсан байна. Хувь хүний нууцын тухай хууль нь 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай тухай хүчин төгөлдөр болсноор эрх зүйн үйлчилгээгүй болсон тул хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг гэрээний үндэслэл болгох нь зүйтэй байна. Энэхүү үл нийцэл нь гэрээний хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй болохыг тэмдэглэж байна.

***Гүйцэтгэх захиралтай байгуулсан хөлсөөр ажиллах гэрээ.*** Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12-р сарын 22-ны өдрийн хурлын 22/32 тоот тогтоол (Хавсралт 2.13)-оор Ц.Ууганбаярыг 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн гүйцэтгэх захирлаар томилсны дагуу ТУЗ-ийн дарга Болдбаатар нь гүйцэтгэх захиралтай 2023 оны 1-р сарын 2-ны өдөр Хөлсөөр ажиллах гэрээ (Хавсралт 4.11) байгуулсан байна. Гэрээгээр гүйцэтгэх захиралд тавигдах шаардлага, түүний чиг үүрэг, ТУЗ-ийн зөвшөөрөлтэйгээр шийдвэрлэх асуудлууд, цалин хөлс, ажиллах нөхцөлийг тодорхойлж, үл өрсөлдөх, нууц хадгалах, сонирхлын зөрчлөөс ангид байх, компанийн үнэт зүйл, нэр хүндийг хүндэтгэх, захирах захирагдах ёс баримтлах зэрэг үүрэг ногдуулж гэрээг дүгнэхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Гүйцэтгэх захирлын бичгийн дагуу гэрээний загварт өөрчлөлт оруулсан гэж үзсэний үндсэн дээр Компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа болон хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээ, гэрээний загвар нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна

***2. Компанийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой гэрээ:***

Энэ хэсэгт Компани үйл ажиллагаагаа явуулах үндсэн нөхцөлийг бүрдүүлж буй түрээсийн, програм хангамжийн болон томоохон түншүүдтэй байгуулсан хамтран ажиллах нийт 35 гэрээг хамруулав. Үүнд:

| № | Баримт бичгийн нэр | Гэрээний огноо, дугаар | Гэрээлэгч талууд |
|---|---|---|---|
| 1. | Түрээсийн гэрээ (Хавсралт 4.12) | 2018.10.23<br>2018/150 | Монгол Улсын иргэн ХХ |
| 2. | Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлт (Хавсралт 4.13) | 2022.01.10 | Монгол Улсын иргэн ХХ |
| 3. | Түрээсийн гэрээний нэмэлт гэрээ (Хавсралт 4.14) | 2022.01.24 | Монгол Улсын иргэн ХХ |
| 4. | Түрээсийн гэрээний нэмэлт өөрчлөлт (Хавсралт 4.15) | 2023.01.02 | Монгол Улсын иргэн ХХ |
| 5. | Ажлын байр түрээсийн гэрээ (Хавсралт 4.16) | 2023.04.14<br>МГ-23/25 | "Монкон Групп" ХХК |

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| 6. | Үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.17) | 2017.07.03<br>2017/20 | "АНД Системс" ХХК |
| 7. | Программ хангамж түрээсээр ашиглуулах, ашиглах гэрээ (Хавсралт 4.18) | 2017.01.02<br>L_002 | "АНД Системс" ХХК |
| 8. | Үйлчилгээний гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ (Хавсралт 4.19) | 2017.11.20<br>2017/51-17/10-2017/07 | "АНД Системс" ХХК<br>"АНД Системс Тех" ХХК |
| 9. | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ (Хавсралт 4.20) | 2017.07.03<br>2017/19 | "АНД Системс" ХХК |
| 10. | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ (Хавсралт 4.21) | 2017.11.20<br>2017/50-17/09-2017/06 | "АНД Системс" ХХК<br>"АНД Системс Тех" ХХК |
| 11. | Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн нэмэлт гэрээ (Хавсралт 4.22) | 2018.11.01<br>2018/263 | "АНД Системс" ХХК |
| 12. | Үйлчилгээ үзүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 4.23) | 2021.08.03<br>2021/37 | "АНД Системс Тех" ХХК<br>"АНД сольюшн" ХХК |
| 13. | Үйлчилгээ үзүүлэх гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах гэрээ (Хавсралт 4.24) | 2021.08.03<br>2021/38 | "АНД сольюшн" ХХК |
| 14. | Хоёрдогч өгөгдөл байршуулах гэрээ (Хавсралт 4.25) | 2021.08.06<br>2021/39 | "АНД Системс" ХХК |
| 15. | Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах гэрээ (Хавсралт 4.26) | 2021.01.05,<br>ХҮР/21-183 | "Үндэсний Дата Төв" УТҮГ |
| 16. | Төрийн мэдээлэл солилцооны систем ашиглах гэрээний нэмэлт өөрчлөлт (Хавсралт 4.27) | 2021.08.27<br>2021/01-1 | "Үндэсний Дата Төв" УТҮГ |
| 17. | Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем ашиглах гэрээ (Хавсралт 4.28) | 2022.02.18<br>2022/03 | "Үндэсний Дата Төв" УТҮГ |
| 18. | Корпорэйт гэйтвэй үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.29) | 2022.06.29<br>ДБХ/ КГВ_22/90 | "Голомт банк" ХХК |
| 19. | Программ болон эд хөрөнгө ашиглуулах гэрээ (Хавсралт 4.30) | 2022.08.15<br>2022/03 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК |
| 20. | Хэрэглэгчийн гэрээ (Хавсралт 4.31) | 2022.09.27<br>2022/105 | "Титан Си Ар Эй Зээлийн мэдээллийн сан" ХХК |
| 21. | Менежментийн тогтолцооны баталгаажуулалт болон магадлах аудит хийх, гэрчилгээ эзэмшүүлэх гэрээ (Хавсралт 4.32) | 2022.11.22<br>2022/120 | "МонСертф" ХХК<br>"QFS Certification Limited LLP" |
| 22. | Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 4.33) | 2022.11.01<br>М-22/145 | "Миг даатгал" ХХК |



ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ 5939754 ✆1118267206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTSK LLC УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| 23. | Бизнес цахим зээлийн үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээ (Хавсралт 4.34) | 2021.10.07<br>2021/62<br>В-21/039 | "Бетастар" ХХК |
| 24. | Бизнес цахим зээлийн үйлчилгээгээр хамтран ажиллах гэрээний нэмэлт өөрчлөлт (Хавсралт 4.35) | 2022.02.25<br>2021/62-01 | "Бетастар" ХХК |
| 25. | Худалдах, худалдан авах мастер гэрээ (Хавсралт 4.36) | 2023.03.28<br>23/07 | "Нэкст Дистрибьюшн" ХХК |
| 26. | Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.37) | 2020.02.19<br>AS20/27<br>2020/07 | "Анд Системс" ХХК |
| 27. | Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээ (Хавсралт 4.38) | 2022.04.19<br>ХА-22/12 | "Анд Системс" ХХК |
| 28. | Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээ (Хавсралт 4.39) | 2023.02.07<br>ХА-23/01 | "Анд Системс" ХХК |
| 29. | Зээл авахад зуучлах, репо зээлийн мастер гэрээ (Хавсралт 4.40) | 2022.06.02<br>2022/69 | "Мони маркет фанд" ХХК |
| 30. | Зээл олгоход зуучлах, репо зээлийн мастер гэрээ (Хавсралт 4.41) | 2022.06.02<br>2022/70 | "Мони маркет фанд" ХХК |
| 31. | Зарим зориулалтаар бүтээл ашиглах гэрээ (Хавсралт 4.42) | 2022.06.06<br>2022/71 | "Мони маркет фанд" ХХК |
| 32. | Репо зээл олгох мастер гэрээ (Хавсралт 4.43)<br>2023.01.16-ны өдрийн 23/01 тоот мэдэгдлээр репо зээлийн лимитыг шинэчлэн тогтоосон | 2022.06.09<br>2022/77 | "Мони маркет фанд" ХХК |
| 33. | Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 4.87) | 2023.04.13<br>01/23 | "Мирэ Эссет Секьюритис Монгол ҮЦК" |
| 34. | Итгэлцлийн үйлчилгээний мастер гэрээ (Хавсралт 4.88) | 2023.03.27<br>ИҮМГ 23/01 | "Анд Алтернатив Финанс" ХХК<br>"Анд ДЭНӨҮД" ХХК |
| 35. | Мэдээлэл солилцох, нууц хадгалах гэрээ (Хавсралт 4.89) | 2023.03.27<br>Г-23/09-I | "Анд Алтернатив Финанс" ХХК<br>"Анд ДЭНӨҮД" ХХК |

***Түрээсийн гэрээ.*** (Хавсралт 4.12) Компани нь Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж 34 хаягт байрлах барилгын 1, 6 давхрын нийт 449.9 мкв талбайг 5 жилийн хугацаатайгаар түрээслэх зорилгоор Монгол Улсын иргэн ХХ-тэй 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр №2018/150 тоот "Түрээсийн гэрээ"-г байгуулжээ. Энэхүү гэрээгээр талуудын эрх, үүрэг, хариуцлага, түрээсийн төлбөр, хугацаа, түрээсийн талбай хүлээлгэх, түрээсийн талбайн засвар тохижилт, сайжруулалт, эвдрэл гэмтэл, барьцаа, түрээсийн талбайг дахин түрээслүүлэх,

шилжүүлэх, гэрээг өөрчлөх, цуцлах, дуусгавар болох, гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх журам зэргийг зохицуулсан байна. Энэхүү гэрээнд 2022 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр (Хавсралт 4.13), 2022 оны 1 дүгээр сарын 24 (Хавсралт 4.14), 2023 оны 1-р сарын 2-ны өдөр (Хавсралт 4.15) тус тус нэмэлт, өөрчлөлт оруулж түрээсийн талбай, түрээсийн төлбөрийн хэмжээнд өөрчлөлт оруулсан. Энэхүү гэрээ нь одоогоор хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд нийцсэн байна. Эдгээр гэрээнүүд дээр улсын бүртгэгчийн бүртгэсэн тамга дарагдсан, Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын Эд Хөрөнгийн Бүртгэлийн Газрын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн лавлагаа (Хавсралт 7.10)-нд түрээсийн гэрээ бүртгэлтэй байгаа зэргээс үзвэл тус түрээсийн гэрээг Иргэний хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байна.

Энэхүү гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

*3. Зээлийн гэрээнүүд:*

Энэ хэсэгт Компанийн арилжааны банк болон Мони Маркет Фанд ХХК-аас авсан зээл, зээлийн эрх нээх 5 гэрээг авч хянав.

***Капитрон банк ХК болон "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр байгуулагдсан 3096-2021/163 тоот Зээлийн гэрээ /Зээлийн шугам/.*** (Хавсралт 4.44)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн шугамын эрхийн хэмжээ: 1,000,000,000 (нэг тэрбум) төгрөг
- Зээлийн зориулалт: Эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь
- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн нийт хүүний 20 хувь
- Зээлийн хугацаа: 24 сар
- Хариуцлага: Зээлдэгч, хамтран зээлдэгч, хамтран үүрэг гүйцэтгэгчийн Капитрон банк болон бусад банкан дахь бүхий л данс, цаашид шинээр нээлгэсэн аливаа данс дахь мөнгөн хөрөнгийг болон тухайн данслал орох хуулиар суутгахыг хориглоогүйгээс бусад орлогоос зээлийн үл маргах журмаар төлж барагдуулна
- Эргэн төлөлт: Зээлийн гэрээний хавсралт 1-т заасан хуваарийн дагуу үндсэн төлбөр, зээлийн хүү, ашиглаагүй зээлийн шимтгэлийг сар бүрийн 17-ны өдөр төлнө.

Гэрээнд зээл олгох нөхцөл, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, үүргийн биелэлтийг хангах арга хэлбэр, хариуцлага, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3096-2021/163 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Капитрон банктай 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр 3096-2021/163-1 тоот (Хавсралт 4.45) хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг байгуулжээ. Гэрээнд барьцааны зүйлийн үнэлгээг 2,000,000,000 төгрөг гэж заасан бөгөөд Барьцааны гэрээ нь Зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх хүртэл хугацаанд хүчинтэй байна.

***Капитрон банк ХК болон "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр байгуулагдсан 3096-2022/117 тоот Зээлийн гэрээ /Зээлийн шугам/.*** (Хавсралт 4.46)

Гэрээний мэдээлэл:

- Зээлийн шугамын эрхийн хэмжээ: 1,250,000 (нэг сая хоёр зуун тавин мянга) ам. доллар
- Зээлийн зориулалт: Эргэлтийн хөрөнгө
- Зээлийн хүү: жилийн XX хувь

MDSKhanLex

- Нэмэгдүүлсэн хүү: зээлийн нийт хүүний 20 хувь
- Зээлийн хугацаа: 12 сар
- Хариуцлага: гэрээний салшгүй хэсэг болох үүргийн гүйцэтгэлийг хангахтай холбогдуулан байгуулсан аливаа гэрээ, барьцаа, батлан даалтын гэрээнд заасан хөрөнгө, эх үүсвэрээс үл маргах журмаар төлж барагдуулна
- Эргэн төлөлт: Зээлийн гэрээний хавсралт 1-т заасан хуваарийн дагуу зээлийн хүү болон ашиглаагүй зээлийн шимтгэлийг сар бүрийн 08-ны өдөр төлнө.

Гэрээнд зээлийн шугамын нөхцөл, үндсэн хүү, нэмэгдүүлсэн хүүгийн хэмжээ, зээлийн хугацаа, зориулалт, зээл төлөх хэлбэр, эргэн төлөлтийн хуваарь, зээлдэгч болон зээлдүүлэгчийн эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, үүргийн биелэлтийг хангах арга хэлбэр, хариуцлага, гэрээ дуусгавар болох цуцлах нөхцөл, журам, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

3096-2022/117 тоот зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компани нь Капитрон банктай 2022 оны 09 дүгээр сарын 08-ны өдөр 3096-2022/117-1 тоот (Хавсралт 4.47) хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг байгуулжээ. Гэрээнд барьцааны зүйлийн үнэлгээг 8,000,000,000 төгрөг гэж заасан бөгөөд Барьцааны гэрээ нь Зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж дуусах хүртэл хугацаанд хүчинтэй байна.

***"Анд Системс" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХК нарын хооронд 2022 оны 8 дугаар сарын 24-ны өдөр байгуулагдсан 2022/111 тоот Санхүүжилтийн гэрээ.*** (Хавсралт 4.48)

Гэрээний мэдээлэл:

- Санхүүжилтийн дүн: 10,000,000,000 (арван тэрбум) төгрөгөөс хэтрэхгүй
- Санхүүжилтийн зориулалт: Компанийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд туслалцаа үзүүлэх зорилгоор шаардлагатай санхүүжилтийг олгох
- Санхүүжилтийн хүү: Санхүүжилт авах үеийн Монголбанкнаас зарласан бодлогын хүү ХХ хувь
- Санхүүжилтийн шугамын хугацаа: 12 сар
- Хариуцлага: гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Хөрөнгө оруулагчид учирсан хохирол, зардлыг барагдуулах
- Эргэн төлөлт: Авсан санхүүжилтийн дүн, эсхүл түүний үлдэгдлийг, хуримтлагдсан болович төлөгдөөгүй хүүгийн хамт 2023 оны 8 сарын 24-ны өдрийн дотор төлнө.

Гэрээнд санхүүжилтийн хэмжээ, хүү, санхүүжилтийн шугамын хугацаа, зориулалт, эргэн төлөх хугацаа, талуудын эрх, үүрэг, талуудын хүлээх хариуцлага, гэрээ дуусгавар болох цуцлах үндэслэл, давагдашгүй хүчин зүйл, маргаан шийдвэрлэх заалтуудыг тусгасан байх ба эдгээр нөхцөлүүд нь Иргэний хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

**Репо зээлийн гэрээнүүд:**

Үнэт цаас гаргагч нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар одоогоор хэвийн хэрэгжиж байгаа 2 репо зээлийн гэрээ, тэдгээр үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээг тус тус байгуулсан байна. МДСХ тасалбар болгон авсан өдрөөс хойш хийгдсэн дараах гэрээг онцгойлон авч мэдээллийг нэмж оруулж байна. Үүнд:

| Гэрээ байгуулагч | Зээлийн гэрээний огноо, дугаар | Зээлийн хугацаа | Зээлийн үнийн дүн /төгрөг | Барьцаа |
|---|---|---|---|---|

*33 - 55*

САХ 2023.08.11 өдөр
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-20

MDSKhanLex

| | | | | |
|---|---|---|---|---|
| Мони маркет фанд ХХК.<br><br>Туркойс Финанс ББСБ ХХК | 2023.05.04,<br><br>20230504-39-73/35-54 (Хавсралт 4.83) | 29 хоног | 200,000,000 | №В-20230504-39-73/35-54 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.84) |
| Мони маркет фанд ХХК,<br><br>Нэг инвеско ББСБ ХХК | 2023.05.18, 20230518-40-23/35-55<br><br>(Хавсралт 4.85) | 28 хоног | 300,000,000 | №В-20230518-40-23/35-55 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.86) |

Зээлийн мэдээллийн сангийн 2022 оны 05-р сарын 27-ний өдөр олгосон лавлагаанаас үзвэл, 2023 оны 12-р сарын 17-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 1,000,000,000 төгрөгийн зээлийн үлдэгдэл 1,000,000,000 төгрөг, 2022 оны 09-р сарын 09-ний өдөр авсан, 2023 оны 09-р сарын 08-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 1.250,000 ам.долларын зээлийн үлдэгдэл 750,000 ам.доллар, 2023 оны 05-р сарын 04-ний өдөр авсан, 2023 оны 06-р сарын 02-ны өдөр төлөгдөж дуусах нөхцөлтэй 197,442,978.20 төгрөгийн зээлийн үлдэгдэл 197,442,978.20 төгрөг бусад зээлийн үлдэгдэл 0 төгрөг (Хавсралт 11.4) байна.

Энэхүү гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж байгаа, эдгээр гэрээтэй холбоотой аливаа зөрчил бий болоогүй бөгөөд гэрээнүүд "хэвийн" хэрэгжиж байгаа талаар Компанийн Гүйцэтгэх захирал албан бичгээр мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).

Дээр дурдсан зээлтэй холбоотой гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзэв.

***4. Үнэт цаас гаргахтай холбоотой гэрээ, хэлцэл:***

Энэ хэсэгт Компани үнэт цаас гаргахтай холбоотой байгуулсан дүгнэлт гаргах өдрийн байдлаар хэрэгжиж буй гэрээнүүдийг авч үзлээ. Гэрээнүүдийг энэхүү дүгнэлт гаргахаас а) өмнөх хугацааны гэрээ болон б) Компани олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой гэрээ гэж ангилан 16 гэрээг дүгнэв.

***а. Дүгнэлт гаргахаас өмнөх хугацааны гэрээ***

| № | Баримт бичгийн нэр | Гэрээний огноо, дугаар | Гэрээлэгч талууд |
|---|---|---|---|
| 1. | Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.49) | 2021.06.30<br>2021/27 | "ҮЦТХТ" ХХК |
| 2. | Бондын гэрээ (Хавсралт 4.50) | 2021.10.08<br>2021/60 | "Өлзий энд ко капитал ҮЦК" ХХК |
| 3. | Хөрөнгийн биржид мэдээлэл нийлүүлэх гэрээ (Хавсралт 4.51) | 2022.07.03<br>2022/89 | "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| 4. | Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.52) | 2021.12.01<br>2021/79 | "ҮЦТХТ" ХХК |
| 5. | Үнэт цаасны хадгаламжийн болон үнэт цаастай холбогдолтой төлбөр гүйцэтгэх гэрээ (Хавсралт 4.53) | 2022.04.04 | "ҮЦТХТ" ХХК |
| 6. | Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.54) | 2022.05.20<br>2022/79 | "Райнос инвестмент ҮЦК" |
| 7. | Хэлцлийн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.55) | 2022.06.16<br>2022/80 | "Юнайтед айр файнэнс" ХХК |
| 8. | Барьцааны гэрээ (Хавсралт 4.56) | 2022.08.16<br>Г/2022/04 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК |
| 9. | Хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ (Хавсралт 4.57) | 2022.08.16<br>Г/2022/05 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК |
| 10. | Төлбөр цуглуулах, үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 4.58) | 2022.08.16<br>2022/96 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК<br>"Юнайтед Айр Файнэнс" ХХК |
| 11. | Захиргааны үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 4.59) | 2022.08.16<br>Г/2022/08 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК |
| 12. | Зээлийн эргэн төлөлтийн дансны барьцааны гэрээ (Хавсралт 4.60) | 2022.08.16<br>Г/2022/09 | "ЛэндМН Актив ТЗК" ХХК<br>"Юнайтед Айр Файнэнс" ХХК |

Дээрх гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***б. Компанийн олон нийтэд нээлттэй өрийн хэрэгсэл гаргахтай холбоотой гэрээ***

***Бондын гэрээ*** (Хавсралт 4.61). Энэхүү гэрээг нэг талаас Үнэт цаас гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн "Райнос Инвестмент ҮЦК" ГХО ХХК-ийн хооронд 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдөр бондын нөхцөл, төлбөрийг тооцоолох аргачлал, худалдах, худалдан авах нөхцөл, Бонд гаргагч хөрөнгө оруулагчдын өмнө үүрэх гүйцэтгэхтэй холбогдон үүсэх харилцаа зохицуулахаар байгуулсан байна. Энэхүү гэрээ нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 226 дугаар тогтоолоор батлагдсан "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 3.6, 3.7 дах зохицуулалтад нийцсэн байна.

***Хүүгийн барьцааны гурван талт гэрээ*** (Хавсралт 4.62). Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол (Хавсралт 1.8)-ын дагуу нэг талаас Үнэт цаас гаргагч, нөгөө талаас хөрөнгө оруулагчдын эрх ашгийг төлөөлөн "Райнос Инвестмент ҮЦК" ГХО ХХК болон барьцааны зүйлийн өмчлөгч "Анд Системс" ХХК нарын хооронд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр ХА-23/13 Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан энэхүү гэрээг байгуулсан байна.

Монголын Хөрөнгийн Биржийн 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн албан бичиг (Хавсралт 1.10)-т заасан сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг үндэслэн энэхүү гэрээний 2.4-д

барьцааны зүйлийн үнэлгээг "...2023 оны 6 сарын 23-ны өдрийн байдлаарх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон ба үүний дагуу нэгж хувьцааны үнэлгээ 34 төгрөг, нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ нь 13,600,000,000 төгрөг байна" хэмээн зохицуулсан нь СЗХ-ны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.7-д арилжаа эрхлэх байгууллагын сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзана гэж заасанд нийцсэн байна.

Мөн "Анд Системс" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлын 23/09 тоот тогтоол (Хавсралт 1.9)-оор өөрийн эзэмшиж буй, 13,600,000,000 төгрөгийн үнэлгээ бүхий "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцааг барьцаалахаар зөвшөөрсөн, гэрээ байгуулах эрхийг гүйцэтгэх захирал (Б.Хос-Эрдэнэ), Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол (Хавсралт 1.8)-оор барьцаа хөрөнгөтэй холбоотой гэрээ байгуулах эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосон байх тул Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журмыг баримталсан гэж дүгнэв.

Иймд, гус хувьцаа барьцаалах гурван талт гэрээ нь Иргэний хуулийн 156 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Үнэт цаас барьцаалах тухай журам, Өрийн хэрэгслийн бүртгэлийн журамд тус тус нийцсэн байна. Барьцаа хөрөнгийн үнэлгээний талаар бид дүгнэлт гаргаагүй болохыг тэмдэглэж байна.

***Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ*** (Хавсралт 4.63). "ЛэндМН ББСБ" ХК-ийн 2023 оны I дүгээр улирлын санхүүгийн тайлан, тэнцэл нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд аудит хийж, тайланд дүгнэлт гаргахтай холбоотой харилцааг "Нийслэл-аудит" ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр байгуулсан "Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ"-ээр зохицуулсан байна. Уг гэрээнд талуудын харилцан хүлээх үүрэг, хариуцлага, ажлын хүрээ, гүйцэтгэх хугацаа, хөлс, үр дүнг хүлээлгэн өгөх, гэрээг дуусгавар болгох журмыг тусгасан нь Аудитын тухай хуулийн 13-т заасан шаардлагад нийцсэн байна. Мөн Нийслэл аудит ХХК нь 2026 оны 4-р сарын 28-ны өдрийг хүртэл аудитын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл (Хавсралт 4.63)-тэй бөгөөд СЗХ-ны 2015 оны 4-р сарын 1-ний өдрийн 157 тоот тогтоолын дагуу[3] үнэт цаас гаргагчдад аудитын үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлтэй байна.

***Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ*** (Хавсралт 4.64). "ЛэндМН ББСБ" ХК-ийн олон нийтэд нээлттэй гаргах бондын төсөлд Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг үндсэн андеррайтер "Райнос Инвестмент ҮЦК" ГХО ХХК, туслах андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК болон "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК-тай 2023 оны 06-р сарын 27-ны өдөр байгуулсан гэрээгээр зохицуулсан байна. Гэрээ нь нийтлэг үндэслэл, андеррайтерийн үйлчилгээ, гэрээний хугацаа, үйлчилгээний төлбөр, талуудын эрх, үүрэг (үндсэн болон туслах андеррайтерын үүргийг тусад нь тодорхойлсон), дотоод мэдээлэл эзэмшигч, түүний үүрэг, маргаан шийдвэрлэх, бусад гэсэн 8 бүлгээс бүрдэх зохицуулалттай байна. Энэхүү гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.5 дахь хэсэгт заасан нөхцлийг хангасан, үндсэн андеррайтер нь СЗХ-ны 2021 оны 12-р сарын 8-ны өдрийн 558 дугаар тогтоол (Хавсралт 4.64)-оор, туслах андеррайтер "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК нь СЗХ-ны 2007 оны 4-р сарын 18-ны өдрийн 86 дугаар тогтоол (Хавсралт 4.64)-оор, туслах андеррайтер "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК нь СЗХ-ны 2007 оны 12-р сарын 06-ны 205 дугаар тогтоол (Хавсралт 4.64)-оор үнэт цаасны зохицуулалттай зах зээлд андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлдэг, Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06-р сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол (Хавсралт 1.8)-ын дагуу гэрээ байгуулсан нь аливаа хууль зүйн зөрчилгүй байна. Гэрээний 2 дугаар бүлэгт андеррайтерийн үйлчилгээний талаар тодорхойлсон нь андеррайтер бондын танилцуулга бэлдэх, хөрөнгө оруулагчид тухайн бондыг

[3] http://www.frc.mn/o/6730



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 № 1118287305



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ

танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах /Best Effort/ хэлбэрээр зохион байгуулахаар андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээр тохиролцсон байна.

Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээг "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК-ийг төлөөлж Б.Наранцацрал гарын үсэг зурсан байх бөгөөд СЗХ-ны даргын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 332 дугаар тушаал (Хавсралт 4.64)-аар "Тэнгэр Капитал ҮЦК" ХХК-ийн гүйцэтгэх захирлаар Б.Наранцацралыг томилохыг зөвшөөрсөн байх тул гэрээнд гарын үсэг зурах бүрэн эрхтэй байна. Энэхүү гэрээ нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

Дээрх гэрээнүүд нь холбогдох хууль тогтоомжийн зөрчилгүй байна.

***5. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ:***

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани нь сүүлийн 3 жилийн хугацаанд Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн (Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 8,000,000,000 төгрөг бөгөөд үүний 5 хувь нь 400,000,000 төгрөг) бүхий үүрэг хүлээсэн нийт 21 гэрээ байгуулсан. Тэдгээрээс 2021 оны 2 гэрээ, 2022 оны 12 гэрээ, 2023 оны 4 гэрээ буюу нийт 18 гэрээ тус тус хэвийн хэрэгжиж байна. Бусад 3 гэрээ нь бүрэн хэрэгжиж дууссан. (Хавсралт 12.1) Үүнд:

| № | Гэрээний дугаар | Гэрээний нэр | Үнийн дүн /төгрөг/ | Хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|
| 1. | ХИУГ 21/05 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.65) | 511,100,000 | Хэрэгжиж байгаа |
| 2. | ХИУГ 21/08 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.66) | 542,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 3. | ХИУГ 22/10 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.67) | $700,000<br><br>(2,432,990,000 төгрөг) | Хэрэгжиж байгаа |
| 4. | ХИУГ 22/16 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.68) | 500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 5. | ХИУГ 22/17 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.69) | 500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 6. | ХИУГ 22/19 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.70) | 500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 7. | ХИУГ 22/26 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.71) | $ 130,000<br><br>(451,841,000 төгрөг )[4] | Хэрэгжиж байгаа |
| 8. | ХИУГ 22/38 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.72) | 550,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 9. | ХИУГ 22/45 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.73) | 1,200,000,000 | Хэрэгжиж дууссан |
| 10. | ХИУГ 22/47 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.74) | 500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 11. | ХИУГ 22/52 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.75) | 600,000,000 | Хэрэгжиж байгаа |

[4] 2022.07.10-ны өдрийн ханшаар 409,510,200

MDSKhanLex

| | | | | |
|---|---|---|---|---|
| 12. | ХИУГ 22/58 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.76) | 600.000,000 | Хэрэгжиж дууссан |
| 13. | ХИУГ 22/62 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.77) | $ 1,000,000 (3,475,700.00 0 төгрөг)[5] | Хэрэгжиж байгаа |
| 14. | ХИУГ 22/63 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.78) | $ 1,000,000 (3,475,700.00 0 төгрөг) | Хэрэгжиж байгаа |
| 15. | ХИУГ 23/15 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.79) | 500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 16. | ХИУГ 23/16 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.80) | 1,500,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 17. | ХИУГ 23/20 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.81) | 1,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 18. | 23/18 | Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ (Хавсралт 4.82) | 400,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 19. | 2022/111 | Санхүүжилтийн гэрээ (Хавсралт 4.48) | 10,000,000,00 0 | Хэрэгжиж байгаа |
| 20. | 3096-2021/163 | Зээлийн гэрээ /Зээлийн шугам/ (Хавсралт 4.44) | 1,000,000,000 | Хэрэгжиж байгаа |
| 21. | 3096-2022/117 | Зээлийн гэрээ /Зээлийн шугам/ (Хавсралт 4.46) | $ 1,250,000<br><br>(4,024,975,00 0 төгрөг) | Хэрэгжиж байгаа |

**Дээр дурдсан гэрээнүүд нь Монгол Улсын хууль тогтоомж, СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд байгуулагдсан гэж үзэв.**

**Үнэт цаас гаргагчийн байгуулсан, түүний үйл ажиллагаанд голлох ач холбогдолтой дээр дурдсан гэрээ, гэрээний загвар нь хууль тогтоомжид нийцсэн байна.**

[5] 2022.12.14-ны өдрийн ханшаар 3.428.870,000

Хуулийн дүгнэлт гаргах явцад бид тус компанид албан ёсоор хандсанаар сүүлийн 3 жилд байгуулсан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй дор дурдсан хэлцлүүдийг ирүүлснийг хянав.

| № | Гэрээний нөгөө тал | Гэрээний нөхцөл | Их хэмжээний, сонирхлын зөрчилтэй алин болох | Хэрэгжсэн, хэрэгжиж буй эсэх |
|---|---|---|---|---|
| 1. | "Бүүминг Трейд" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 02 сарын 05-ны өдрийн 21/09 тоот тогтоолоор (Хавсралт 5.1) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Бүүминг Трейд" ХХК-тай зээл болон барьцааны гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 02 сарын 09-ний өдрийн ЗГ/202101 тоот Зээлийн гэрээ, ЗБ202101 тоот Үл хөдлөх хөрөнгө барьцаалах барьцаа (ипотек)-ны гэрээ (Хавсралт 5.2) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 2. | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК, "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 21/20 тоот тогтоолоор (Хавсралт 5.3) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-г хамтран ажиллах ерөнхий андеррайтераар сонгосон бөгөөд "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК болон "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 2021/13 тоот Андеррайтер болон зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.4) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 3. | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 21/21 тоот тогтоолоор (Хавсралт 5.5) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 20-ний өдрийн 2021/11 тоот Ажил гүйцэтгэх гэрээ (Хавсралт 5.6) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 4. | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 21/22 тоот тогтоолоор (Хавсралт 5.7) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 2021/12 тоот дугаартай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.8) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1116257206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. | "Ай Эн Мобайл Нэтворк" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 21/23 тоот тогтоолоор (Хавсралт 5.9) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Ай Эн Мобайл Нэтворк" ХХК-тай зээл болон зөвлөх үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 05 сарын 31-ний өдрийн 2021/17 тоот дугаартай Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.10) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 6. | "Дижитал Молл" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 05 сарын 20-ны өдрийн 21/24 тоот тогтоолоор (Хавсралт 5.11) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Дижитал Молл" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 07 сарын 01-ний өдөр 2021/32 тоот дугаартай Хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.12) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 7. | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 06 сарын 04-ний өдрийн 21/25 тоот тогтоолоор (Хавсралт 5.13) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд 2021 оны 06 сарын 04-ний өдрийн 2021/18 тоот дугаартай Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.14) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 8. | "АНД Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 07 сарын 30-ны өдрийн 21/27 тоот тогтоолоор (Хавсралт 5.15) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Системс" ХХК-тай Хоёрдогч өглөг байршуулах гэрээ 2021 оны 08 сарын 06-ны өдрийн 2021/39 тоот дугаартай Хоёрдогч өглөг байршуулах гэрээ (Хавсралт 4.25) байгуулсан. *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 9. | "АНД Системс Тех" ХХК, "АНД Сольюшнс Пти.Лтд" | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 07 сарын 30-ны өдрийн 21/28 тоот тогтоолоор (Хавсралт 5.16) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Системс Тех" ХХК болон АНД Сольюшнс Пти.Лтд" компанитай 2021 оны 08 сарын 03-ны өдрийн 2021/38 тоот Программ хангамжийн үйлчилгээний гэрээ (Software services agreement) (Хавсралт 4.23) байгуулсан. *(Дэлгэрэнгүй 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 10. | "АНД Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 08 сарын 11-ны өдрийн 21/34 тоот тогтоолоор (Хавсралт 5.17) Сонирхлын зөрчилтэй | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |

MDSKhanLex

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Супер Ап Хэтэвч" ХХК-ийг толгой компани болох АНД Системс ХХК-я худалдахыг зөвшөөрсөн бөгөөд 2021 оны 08 сарын 26 -ны өдөр Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ (Хавсралт 5.18) байгуулсан. | | |
| 11. | "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2021 оны 10 сарын 08-ны өдрийн 21/39 тоот тогтоолоор (Хавсралт 5.19) "Өлзий энд Ко Капитал ҮЦК" ХХК-тай андеррайтерийн гэрээ байгуулах эрх, 21/40 тоот тогтоолоор (Хавсралт 5.20) андеррайтерийн гэрээнд синдикат "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийг оролцуулан гурвалсан хэлбэрээр гэрээ байгуулах эрх олгосон бөгөөд ийнхүү Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу 2021 оны 10 сарын 08-ний өдрийн 2021/59 тоот дугаартай Андеррайтер болон Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ (Хавсралт 5.21) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 12. | "АНД Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04 сарын 19-ний өдрийн 22/13 тоот тогтоолоор (Хавсралт 5.22) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Системс" ХХК-тай 2020 оны 2 сарын 19-ний өдөр анх байгуулсан AS20/27, 2020/07 тоот дугаартай Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээ (Хавсралт 4.37)-ний хугацааг сунгаж 2022 оны 04 сарын 19-ний өдөр ХА-22/12 тоот дугаартай Менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт өөрчлөлтийн гэрээ (Хавсралт 4.38) байгуулсан. *(Дэлгэрэнгүйг дүгнэлтийн 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжсэн |
| 13. | "Томё Эд Тек" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04 сарын 19-ний өдрийн 22/14 тоот тогтоолоор (Хавсралт 5.23) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Томё Эд Тек" ХХК-тай 2022 оны 07 сарын 25-ны өдөр MX2022/196 LendPay" үйлчилгээнд хамтран ажиллах гэрээ (Хавсралт 5.24) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 14. | "АНД Сольюшнс Пти.Лтд" | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 04 сарын 19-ний өдрийн 22/15 тоот тогтоолоор (Хавсралт 5.25) эрх олгосны дагуу "АНД Сольюшнс Пти.Лтд" компанид зарим програм хангамжийг хязгаарлагдмал хүрээнд ашиглуулахаар болсон. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 15. | "Ондо Нэтворк" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 08 сарын 01-ний өдрийн 22/20 тоот тогтоолоор (Хавсралт 5.27) Сонирхлын зөрчилтэй | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

СЗХ
2023 .08. 11 өдөр
БҮРТГЭВ



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28

MDSKhanLex

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "Онцо Нэтворк" ХХК-тай 2022 оны 08 сарын 01-ний өдөр ИУГ 22/01, 2022/92 тоот дугаартай Интернэт үйлчилгээний гэрээ (Хавсралт 5.28) байгуулсан. | | |
| 16. | "АНД Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2022 оны 12 сарын 22-ны өдрийн 22/33 тоот тогтоолоор (Хавсралт 5.29) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Системс" ХХК-тай 2022 оны 08 сарын 24-ний өдөр 2022/111 тоот дугаартай Санхүүжилтийн гэрээ (Хавсралт 4.48) байгуулсан. *(Дэлгэрэнгүйг дүгнэлтийн 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 17. | "АНД Системс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 02 сарын 06-ны өдрийн 23/13 тоот тогтоолоор (Хавсралт 5.30) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Системс" ХХК-тай байгуулсан Менежментийн үйлчилгээний гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж, 2023 оны 02 сарын 07-ны өдөр ХА-23/01 тоот дугаартай Менежментийн үйлчилгээний гэрээний нэмэлт, өөрчлөлтийн гэрээ (Хавсралт 4.39) байгуулсан. *(Дэлгэрэнгүйг дүгнэлтийн 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 18. | "АНД Дэнөүд" ХХК, "АНД Алтернатив Финанс" ХХК | Компанийн ТУЗ-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн 23/16 тоот тогтоолоор (Хавсралт 5.26) Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу "АНД Дэнөүд" ХХК, "АНД Алтернатив Финанс" ХХК-тай 2023 оны 03 сарын 27-ны өдрийн ИУМГ 23/01 тоот дугаартай Итгэлцлийн үйлчилгээний мастер гэрээ (Хавсралт 4.88), Г-23/05-1 тоот дугаартай Мэдээлэл солилцох, нууц хадгалах гэрээ (Хавсралт 4.89) байгуулсан. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |
| 19. | "Анд системс" ХХК, "Райнос инвестмент ҮЦК" ХХК | "Анд Системс" ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хурлын 23/09 тоот тогтоол (Хавсралт 1.9), Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоол (Хавсралт 1.8)-оор Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгосны дагуу 2023 оны 06 сарын 27-ны өдөр ХА-23/13 тоот дугаартай Хувьцааны барьцааны гурван талт гэрээ (Хавсралт 4.62) байгуулсан *(Дэлгэрэнгүйг 4-р хэсгээс харна уу)* | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | Хэрэгжиж байгаа |

***Сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаар:***



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 2к1118267205



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK

MDSKhanLex

Бидэнд ирүүлсэн мэдээллээр Компани сүүлийн 3 жилд сонирхлын зөрчилтэй 19 хэлцэл хийсэн бөгөөд 8 нь бүрэн хэрэгжиж дууссан. Дүгнэлт гаргах өдрийн байдлаар ямар нэгэн зөрчил маргаан гараагүй байна. Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулахын өмнө Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журам болон Компанийн дүрэмд заасны дагуу ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж, зөвшөөрөл олгосон байна. Элгээр 19 хэлцлээс Дүгнэлт гаргах өдрийн байдлаар 11 хэлцэл нь хэвийн хэрэгжиж байгаа, бусад нь хэрэгжиж дууссан байна (Хавсралт 12.1).

***Их хэмжээний хэлцлийн талаар:***
Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн тайлангаар актив нь 76,858,757,000 төгрөг байна. Компанийн тухай хуулийн 87-д зааснаар их хэмжээний хэлцэл нь сүүлийн балансын активын нийт дүнгийн 25%-ийг дараах байдлаар тооцлоо.

| № | Санхүүгийн тайлан/ хэлцлийн хугацаа | Тухайн жилийн балансын актив (төгрөгөөр) | Тухайн жилийн балансын активын 25% (төгрөгөөр) | Гэрээ байгуулагдсан эсэх |
|---|---|---|---|---|
| 1. | 2019 оны жилийн эцэс (2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хойш байгуулсан хэлцэл) | 58,100,953,000 | 14,525,238,250 | Үгүй |
| 2. | 2020 оны жилийн эцэс (2021 оны хэлцэл) | 40,735,460,000 | 10,183,865,000 | Үгүй |
| 3. | 2021 оны жилийн эцэс (2022 оны хэлцэл) | 39,306,562,000 | 9,826,640,500 | Үгүй |
| 4. | 2022 оны жилийн эцэс (2023 оны 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэлх байгуулсан хэлцэл) | 76,858,757,000 | 19,214,689,200 | Үгүй |

Компани сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй болохыг Компанийн Гүйцэтгэх захирал бидэнд мэдэгдсэн болно. (Хавсралт 12.1)

Үнэт цаас гаргагч нь их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах талаар Компанийн тухай хуульд заасан журмыг мөрдөж ажилласан гэж дүгнэв.

СЗХ
2023 .08. 11
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -07- 28



"ЛэндМН ББСБ" ХК нь дүгнэлт гаргах өдрийн байдлаар Санхүүгийн Зохицуулах Хорооны 2015 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн 293 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх ТЗ101/493 тоот тусгай зөвшөөрөл, 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 193 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах болон цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 45 тоот тогтоолоор Факторингийн үйлчилгээ, Итгэлцлийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 128 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн гадаад валютын арилжааны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, 2020 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 107 тоот тогтоолоор Банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг (Хавсралт 6.1) тус тус авсан.

Зөвшөөрлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан 2023 оны 01 сарын 06-ны өдөр Банк бус санхүүгийн байгууллагын тухай хуулийн 7.1.10-д заасан "хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх" үйл ажиллагаа хассан. Үүний дагуу Компанийн дүрэм, Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа дахь үйл ажиллагаанаас "хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх" үйл ажиллагааг хассан боловч Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд зохих өөрчлөлтийг тусгаагүй байв.

Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл нь Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2.1.1 хэсэгт заасны дагуу эрх бүхий этгээд болох Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгогдсон байх бөгөөд Компанид Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1.2.2.7-д заасан банк бус санхүүгийн гадаад валютын арилжаа эрхлэх, 8.1.2.2.8-д заасан банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ эрхлэх, 8.1.2.2.9-д заасан банк бус санхүүгийн зээл олгох үйл ажиллагаа эрхлэх, 8.1.2.2.10-д заасан банк бус санхүүгийн цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх, 8.1.2.2.11-д заасан банк бус санхүүгийн факторингийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлүүд, 8.2.2.2.30-д заасан банк бус санхүүгийн төлбөр тооцооны хэрэгсэл гаргах энгийн зөвшөөрлийг тус тус авсан байна. Эдгээр нь Зөвшөөрлийн тухай хууль, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9.1 дэх хэсэгт заасан банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгоход тавигдах шаардлагад нийцсэн гэж үзлээ (Хавсралт 6.1).

"ЛэндМН ББСБ" ХК-ийн СЗХ-оос авсан дээр дурдсан тусгай зөвшөөрлүүд нь хүчинтэй эсэх, тэдгээрийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох нөхцөл байдал үүссэн эсэх талаар СЗХ-ноос лавлагаа... 

**_Домэйн нэр._** Компанийн www.lend.mn домэйн нэр нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчинтэй байна (Хавсралт 6.5, Хавсралт 12.1).

**_Барааны тэмдэг._** Компанийн нэр дээр 2017 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн анхдагч огноотой, 40-0018383 тоот улсын бүртгэлийн дугаар, 201800613 тоот гэрчилгээний дугаартай 2027 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр хүртэл хүчинтэй барааны тэмдгийн гэрчилгээ (Хавсралт 6.2) авсан байна:

Ангилал 36: Санхүүгийн үйлчилгээ



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5038764 ☎1119287208

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

MDS KhanLex

lendmn

Оюуны өмчийн газрын аж үйлдвэрийн өмчийн мэдээллийн сан /https://publish.ipom.mn/wopublish-search/public/home?6/ (Хавсралт 6.3), зохиогчийн эрхийн хайлтын систем /http://copyright.ipom.mn/ (Хавсралт 6.4)-с тус тус хайлт хийхэд "ЛэндМН ББСБ" ХК-ийн нэр дээр эрхийн хамгаалалт хийгдсэн шинэ бүтээл, ашигтай загвар, зохиогчийн эрхийн аливаа бүтээл байхгүй, эрхийн хамгаалалт хийгдсэн хүчинтэй барааны тэмдэг 1 байгаа бөгөөд Компанийн нэр дээр байх дээрх барааны тэмдгийн өмчлөх, эзэмших эрх нь Дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр бөгөөд хугацаа дуусах, цуцлагдах, барьцаалагдах зэргээр эрхээ хэрэгжүүлэхэд нь бодитой нөлөөлж болох, эсхүл бусдын эрхээр хязгаарлагдсан нөхцөл илрээгүй болно.

Компани нь "LendMN" /application, core system/ бүтээлийг 2017 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн 2017/19 тоот "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ" (Хавсралт 4.20) болон 2017 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн 1_002 тоот "LendMN" Программ хангамж, түрээсээр ашиглуулах, ашиглах гэрээ (Хавсралт 4.18)-г шинэчилсэн гэрээ болох 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/20 тоот "Үйлчилгээний гэрээ" (Хавсралт 4.19)-г тус тус "Анд Системс" ХХК-тай байгуулж ашигладаг бөгөөд мөн "LendMN" аппликейшн, түүний системийг ашиглах, түүнтэй холбогдон гарах нэвтрүүлэлтийн ажил, хэрэглэгчид хүргэх, дагаллах засвар үйлчилгээг авах, мэдээллийн нууцлал, системийг төлбөр тооцоо хийх зэрэг үйлчилгээг авдаг.

"Анд Системс" ХХК нь "Анд Системс Тех" ХХК-д "LendMN" /application, core system/ бүтээлийн өмчлөх эрхийг шилжүүлэн өгсөн. Улмаар "Анд Системс" ХХК, "Анд Системс Тех" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХХК нар "Үйлчилгээний гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ" (Хавсралт 4.19) болон "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээний эрх үүрэг шилжүүлэх гэрээ" (Хавсралт 4.21)-г тус тус 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан.

Дээрх 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 2017/19 тоот "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн гэрээ"-ний 12.1-т Бүтээл ашиглагч нь Бүтээл өмчлөгчийн бүтээсэн бусад бүтээлийг тэргүүн ээлжид ашиглах эрхтэй гэж заасны дагуу Компани нь "Анд Системс Тех" ХХК-тай 2018 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн 2018/263 тоот "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрх (лиценз)-ийн нэмэлт гэрээ" (Хавсралт 4.22)-г байгуулсан.

Түүнчлэн "Анд Системс Тех" ХХК нь өөрийн өмчилдөг "LendMN" /application, core system/ бүтээлийн төхөөрөмжийн 1/FAAS төхөөрөмж ашиглах лиценз 2/ FAAS төхөөрөмжийн эзэд лицензийн эрхийг аливаа хязгаарлалтгүйгээр 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Анд солюшнс Пти.Лтд компанитай байгуулсан "Мастер үйлчилгээний гэрээ"-гээр шилжүүлжээ. Ийнхүү "Анд Системс Тех" ХХК-тай 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдөр байгуулсан "Үйлчилгээний гэрээ" болон "Зохиогчийн эрх ашиглуулах онцгой эрхийн гэрээ"-д тус тус өөрчлөлт оруулахаар 2021 оны 08 дугаар сарын 03 ны өдрийн 2021/38 тоот "Программ хангамжийн үйлчилгээний гэрээ (Software services agreement)"-г 50 жилийн хугацаатай "Анд солюшнс Пти.Лтд" компанитай байгуулжээ. Уг гэрээгээр Компани программ хангамж нийлүүлэх, программ хангамжийн одоогийн болон ирээдүйн хөгжүүлэлт, тогтмол техникийн үйлчилгээ авах, харин төлбөр төлөхтэй холбоотой харилцааг зохицуулсан байна.

Дээр дурдсаны дагуу Компанийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээх зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой нөлөөлж болохуйц нөхцөл бий болоогүй байна.



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UBK

MDSKhanLex

***Хувьцаа:***

**Компани нь дараах компанийн хувьцааг эзэмшдэг ба аливаа өөр үнэт цаас эзэмшдэггүй болохыг тус Компанийн Гүйцэтгэх захирал албан ёсоор бидэнд мэдэгдсэн болно (Хавсралт 12.1).Үүнд:**

| ОХИН КОМПАНИ | | | |
|---|---|---|---|
| **№** | **Хувьцаа эзэмшигчдийн нэрс** | **Эзэмших хувь** | **Зээлийн гэрээний дагуу барьцаалагдсан эсэх** |
| 1. | **"ЛэндМН Актив ТЗК" ХХК**<br><br>**/РД: 6888895, 2022 оны 08-р сарын 14-ний өдрийн Компанийн дүрэм, 000259538 тоот Улсын бүртгэлийн гэрчилгээ/**<br><br>**(Хавсралт 7.2, 7.3)** | **100%** | - |

**Өрийн хэрэгсэл:**

**Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбооны 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 190 тоот албан бичиг (Хавсралт 10.9)-т тусгаснаар Компани нь МҮЦАЭХ-ны биржийн бус зах зээлд өрийн хэрэгсэл гаргаж байгаагүй байна.**

**Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гаргасан 01/1000 тоот албан бичиг (Хавсралт 7.1)-т тусгаснаар "ЛэндМН ББСБ" ХК нь 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар дараах өрийн хэрэгсэл гаргасан ба дараах үнэт цаасыг эзэмшиж байна:**

| № | Үнэт цаасны төрөл | Хэлбэр | Нийт дүн | Дуусах огноо | Гэрээний хэрэгжилт |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Бонд** | **Нээлттэй** | **5 тэрбум** | **2023.06.30** | **Өр төлбөргүй** |
| 2 | **Бонд /транч-1/** | **Нээлттэй** | **2,5 тэрбум** | **2023.12.02** | **Өр төлбөргүй** |
| 3 | **Бонд /транч-2/** | **Нээлттэй** | **3,1 тэрбум** | **2024.04.03** | **Өр төлбөргүй** |

**ҮЦТХТ-ийн албан бичгийн хавсралт дахь "Өр төлбөргүй" гэснийг тухайн өрийн хэрэгслийн дагуу төлөх хугацаа хэтэрсэн төлбөргүй гэж ойлгов.**

***Үнэт цаас гаргагчийн барьцаанд байгаа хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө*** **(Хавсралт 7.4)**

| № | Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр | Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн нэр төрөл, дугаар | Зээлийн Гэрээний дагуу Барьцаалагдсан эсэх |
|---|---|---|---|
| 1. | **"ЛэндМН ББСБ" ХК-ийн дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө** | **Ирээдүйд болон дансаар,борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө** | **Нэг инвеско ББСБ ХХК, Мони Маркет Фандтай байгуулсан 20230518-40-23/35-55 тоот репо зээлийн гэрээний дагуу** |

MDSKhanLex

| | | | |
|---|---|---|---|
| | | | №B-20230518-40-23/35-55 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.85, 4.86) |
| 2. | "ЛэндМН ББСБ" ХК-ийн дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө | Ирээдүйд болон дансаар болон борлуулалтаас орж ирэх мөнгөн хөрөнгө | Мони Маркет Фанд, Туркойс Финанс ББСБ ХХК-тай байгуулсан 20230504-39-73/35-54 тоот репо зээлийн гэрээний дагуу №B-20230504-39-73/35-54 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.83, 4.84) |
| 3. | Авлага/төлбөрийн бусад эрхүүд | Автомашины зээл | "ЛэндМН Актив ТЗК" ХХК-тай байгуулсан 2022 оны 09-р сарын 13-ны өдрийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ, түүний нэмэлт өөрчлөлтөөр 285 ширхэг автомашин (Хавсралт 7.5, 7.6) барьцаалсан. |
| 4. | Авлага/төлбөрийн бусад эрхүүд | Хэвийн ангилалтай автомашины зээл | "ЛэндМН Актив ТЗК" ХХК-тай байгуулсан 2022 оны 09-р сарын 13-ны өдрийн Г/2022/10 тоот хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний дагуу Г/2022/11 тоот фидуцийн барьцааны гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт (Хавсралт 7.7, 7.8) -өөр 285 ширхэг автомашины барьцааны гэрээ |
| 5. | Авлага/төлбөрийн бусад эрхүүд | ББСБ-ын актив, ЛэндМН ББСБ ХК Зээлийн багц | Капитрон банктай байгуулсан 2022 оны 09 сарын 08-ны өдрийн 3096-2022/117 тоот зээлийн гэрээний дагуу 3096-2022/117-1 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.46, 4.47) |
| 6. | Зээлийн багц | Зээл авсан болон авч буй иргэдийн зээлийн багц | Капитрон банктай байгуулсан 2021 оны 12 сарын 17-ны өдрийн 3096-2021/163 тоот зээлийн гэрээний дагуу 3096-2021/163-1 тоот хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны гэрээ (Хавсралт 4.44, 4.45) |

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар дээр дурдсан хөдлөх эд хөрөнгө, эргэлтийн хөрөнгө, ирээдүйд орж ирэх мөнгөн хөрөнгө нь дээрх гэрээний дагуу барьцаалагдсан байна.

*Тээврийн хэрэгсэл.* Компани нь 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар нийт 409 тээврийн хэрэгслийг өмчилдөг (Хавсралт 7.9) бөгөөд "ЛэндМН Актив ТЗК" ХХК-тай байгуулсан 2022 оны 09-р сарын 13-ны өдрийн хөрөнгө худалдах, худалдан авах гэрээгээр 285 ширхэг автомашин барьцаалагдсан (Хавсралт 7.5, 7.6) байна. Үүнээс Компанийн өөрийн өмчлөлийн 2 тээврийн хэрэгсэл (Хавсралт 7.11, 7.12), бусад нь фидуцийн гэрээний дагуу өмчилж байна.

*Газар эзэмших эрх.* Компанийн гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 12.1)-ээс үзвэл Компани нь аливаа газар эзэмших эрх эзэмшдэггүй болно.

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28

MDSKhanLex

***Үл хөдлөх эд хөрөнгө.*** Компанийн гүйцэтгэх захирлын албан бичиг (Хавсралт 12.1) болон Улсын Бүртгэлийн Ерөнхий Газрын 2023 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн лавлагаа (Хавсралт 7.10)-аар Компани нь аливаа үл хөдлөх хөрөнгө эзэмшдэггүй байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT LLC

MDSKhanLex

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1-д заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3-т заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж Санхүүгийн Зохицуулах Хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 11 дүгээр зүйлийн 11.14.8-д үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх гэж тус тус заасны дагуу МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд ил болсон мэдээлэл, төрийн болон эрх бүхий байгууллага, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

МДСХ нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий дараах мэдээлэл Үнэт цаас гаргагч, төрийн болон бусад эрх бүхий байгууллагаас гаргуулж авсан баримт материалтай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзээ. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үүсгэн байгуулагдсан огноо, оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхэлж байгаа үйл ажиллагаа;
- Үнэт цаас гаргагч хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, улсын бүртгэлд бүртгэсэн огноо;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, түүнд хувьцаа эзэмшигч нарын эзлэх хувь, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ;
- Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдийн тухай;
- Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх хувьцааны тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;
- Үнэт цаас гаргах шийдвэр /үнэт цаасны тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, нийтэд санал болгох үнэ, нөхцөл, татан төвлөрүүлэх хөрөнгийн зориулалт г.м/;
- Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлагын баг, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод, эрх бүхий албан тушаалтны мэдээлэл;
- Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй тусгай зөвшөөрөл;
- Нээлттэй хүрээнд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүрэг, Үнэт цаас гаргагчийн эрх үүрэг;
- Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай мэдээлэл;
- Компанийн эрх бүхий байгууллагаар батлуулсан ногдол ашгийн бодлого;
- Тухайн үнэт цаасыг нээлттэй хүрээнд санал болгох ажиллагаанд оролцож байгаа зохицуулалттай этгээд, мэргэжлийн үйлчилгээ үзүүлж буй (үндсэн андеррайтер, аудит, хууль, үнэлгээний байгууллага) этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай талаарх;
- Үнэт цаас гаргагч болон мэргэжлийн үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээдүүдийн хооронд үүсэж болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх талаар гаргасан мэдэгдэл.

Дээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, бүтээгдэхүүн, үйлчилгээ, ээлжих зэрэглэл, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үндсэн чиглэлд хамаарах зах зээлд эзэлж буй байр суурь, өрсөлдөгч байгууллагуудын тухай мэдээлэл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн судалгаа, төлөвлөгөө зэрэгт агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, санхүүгийн төсөөлөл, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, түүхэн замнал, ололт, амжилт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт

болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, үнэлгээ, Үнэт цаас гаргаж хуримтлуулсан хөрөнгийг зарцуулах бизнесийн төлөвлөгөө, дунд хугацааны бизнес төлөвлөгөөний тойм, үнэт цаасыг анхдагч зах зээлд байршуулах, захиалга авах, худалдах, арилжих нөхцөл, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө зэрэг мэдээлэлд МДСХ дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгасан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хууль зүйн хувьд хүчин төгөлдөр байна гэж дүгнэв.

MDSKhanLex

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газраас 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 23900002002534 тоот Компанийн хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа (Хавсралт 1.7)-г судалсан. Түүнчлэн бид энэхүү дүгнэлтийг гаргахдаа 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн байдлаарх тархалтын судалгаа (Хавсралт 9.1)-г гаргуулан авч судалсан. Тархалтын судалгаа болон хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзвэл Компанийн саналын эрхтэй энгийн хувьцааны 75 хувийг "Анд Системс" ГХО ХХК, үлдэх хувьцааг Компанийн бусад хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна. ("ЛэндМН ББСБ" ХК нь өөрийн нийт хувьцааны 7.587 хувь буюу 60,698,317 ширхэг хувьцааг халаасалсан байна.) (Хавсралт 9.1)

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанийн нийт энгийн хувьцааны 75 хувийг эзэмшиж байгаа Монгол Улсын хуулийн этгээд "Анд Системс" ГХО ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2021 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн ХЭ-21/11 тоот шийдвэрээр шинэчлэн баталсан дүрэм (Хавсралт 9.2, 9.3)-ийн 8.1-д заасны дагуу дээрх компанийн хувьцааг Сингапур улсын хуулийн этгээд "Анд Эф Эс Жи" ПиТиИ ЭлТиДи 100 хувь эзэмшиж байна.

Сингапур улсын хуулийн этгээд болох "Анд Эф Эс Жи" ПиТиИ ЭлТиДи-ийн хувьцааг мөн Сингапур улсын хуулийн этгээд "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи (Хавсралт 9.4, 9.5) 100 хувь эзэмшиж байна.

Харин "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн энгийн хувьцааг нийт 10 этгээд хуваан эзэмшиж байна. Үүнээс нийт хувьцааны 67.24 хувийг 9 хувьцаа эзэмшигч хуваан эзэмшиж байх буюу хамгийн багадаа 1.82 хувийг, хамгийн ихдээ 23.39 хувийг холбогдох хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Эдгээр 9 хувьцаа эзэмшигч нарыг нэгдмэл сонирхолтой этгээдүүд биш гэж үзвэл үлдэх 32.76 хувийг Сингапур улсын хуулийн этгээд "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи дангаар эзэмшиж байна. (Хавсралт 9.6, 9.7)

"Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн хувьцааг нийт 15 хувь хүн эзэмшиж байгаагаас 10 хувьцаа эзэмшигч тус бүр 1 хувийн хувьцааг, 1 хувьцаа эзэмшигч 10 хувийн хувьцааг тус тус эзэмшиж байна. Харин үлдэх 80 хувийг 4 хувьцаа эзэмшигч тэнцүү хэмжээгээр хуваан эзэмшиж байна.

Ийнхүү "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн дийлэнх хувьцаа буюу 80 хувийн хувьцааг доор дурдсан хувьцаа эзэмшигчид /хувь хүмүүс/ тус бүр тэнцүү хэмжээгээр эзэмшиж байна. (Хавсралт 9.8) Үүнд:

| № | Овог, нэр | Эзэмшиж буй хувь |
|---|---|---|
| 1 | Чинбаатарын Анар | 20% |
| 2 | Үүсэгийн Отгонбаяр | 20% |
| 3 | Очирсүрэнгийн Болдбаатар | 20% |
| 4 | Пүрэвсүрэнгийн Отгонбаяр | 20% |

Иргэний хуулийн 26.4-т: "Хуулийн этгээд удирдах байгууллагаараа дамжуулан иргэний эрх зүйн харилцаанд орно" гэж заасан тул бид эдгээр компаниудын хувьцаа эзэмшигч, ТУЗ, Гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж, шийдвэр гаргахад хамгийн нөлөө бүхий хувь хүн (хүмүүс) Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв. Ингэхдээ Компанийн тухай хуулийн компанийн нэгдлийн талаар зохицуулсан 6 дугаар зүйл, нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон 99.1-д дурдсан зохицуулалтыг анхааралдаа авсан болно.

Дээрх бүх дүн шинжилгээний үндсэн дээр Дүгнэлт гаргах өдрийн байдлаар,

СЗХ
2023.08.17
БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28





- "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн 20 хувийг эзэмшигч, "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн дарга, "Анд Эф Эс Жи" ПиТиИ ЭлТиДи-ийн Гүйцэтгэх захирал, "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн Захирал Очирсүрэнгийн Болдбаатар;
- "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн 20 хувийг эзэмшигч, "Анд Глобал" ПиТиИ ЭлТиДи-ийн Захирал Чинбаатарын Анар;
- "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн 20 хувийг эзэмшигч Пүрэвсүрэнгийн Отгонбаяр;
- "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн 20 хувийг эзэмшигч Үүеэгийн Отгонбаяр;

нар нь хамтдаа "ЛэндМН ББСБ" ХК-ийн жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч байна гэж үзэв.

*Эцсийн өмчлөгч*

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 10.1.14 дэх заалт, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар аливаа хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө бүртгүүлсэн байх үүрэгтэй. Мөн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4.1.1-т "эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг ойлгоно гэж заасан.

Хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаанаас үзэхэд, "Иро Консалтинг Сингапур" ПиТиИ ЭлТиДи-ийн тус бүрдээ 20 хувийг эзэмшигч Үүеэгийн Отгонбаяр, Чинбаатарын Анар, Очирсүрэнгийн Болдбаатар, Пүрэвсүрэнгийн Отгонбаяр нарыг тус компанийн эцсийн өмчлөгчөөр 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдөр улсын бүртгэлд бүртгэсэн байна. (Хавсралт 1.7) Энэ нь бидний дээр тодорхойлсон Үнэт цаас гаргагчийн "хяналтын жинхэнэ хэрэгжүүлэгч"-тэй ижил байна.

Энэхүү Дүгнэлт нь бусад хүчин зүйлийн нөлөөгөөр өөрчлөгдөх боломжтойг дурдаж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

СЗХ 2023 .08. 11 он сар өдөр БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -07- 28





*Эрүүгийн хэрэг*

Цагдаагийн ерөнхий ерөнхий газрын Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдөр 13б/1626 (Хавсралт 10.1) тоот албан бичигт заасныг "Лэндмн ББСБ" ХК-ийг эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх болон эрүүгийн хэрэгт шалгагдаж байсан эсэх талаар цагдаагийн байгууллагын мэдээллийн сангаас шалгахад мэдээлэл бүртгэгдээгүй байна" гэжээ.

*Иргэний хэрэг*

Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гаргасан 1/1576 тоот албан бичиг (Хавсралт 10.2)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн байдлаар Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Баянгол дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Хан-Уул дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн иргэний хэрэгт тус тус хариуцагчаар оролцож байгаагүй болохыг тодорхойлсон байна.

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын 2023 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 4/952 тоот Тодорхойлолт (Хавсралт 10.3)-д тусгаснаар тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт Үнэт цаас гаргагч нь 2023 оны 5 дугаар сарын 18-ний өдрийн байдлаар нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын дэргэдэх Улаанбаатар үндэсний ба олон улсын арилжааны арбитрын 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн А-23/48 тоот Тодорхойлолт (Хавсралт 10.4)-д дурдсанаар Компани нь тодорхойлолт гаргах өдрийг хүртэл арбитрын хэрэг маргаанд нэхэмжлэгч, хариуцагч, гуравдагч этгээдээр оролцоогүй байна.

*Захиргааны хэрэг*

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн тамгын газраас 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гаргасан 1010 тоот албан бичиг (Хавсралт 10.5)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэхэмжлэгч болон гуравдагч этгээдээр сүүлийн 3 жилийн хугацаанд оролцож байгаагүй байна.

*Тухайн компанийн эрхэлдэг үйл ажиллагаатай холбоотойгоор хийсэн хууль зүйн нэмэлт судалгаа, шинжилгээ*

Бид Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, СЗХ-ны болон МХБ-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын зохицуулалтаас гадна хөрөнгө оруулагчид шийдвэр гаргахад ач холбогдолтой гэж үзэн зарим хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, тус Компанитай холбоотой дараах нөхцөл байдлуудыг тогтоосон болно. Үүнд:

- Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас 2023 оны 5 дугаар сарын 17-ны өдөр гаргасан 03-04/763 тоот албан бичиг (Хавсралт 10.6)-т тусгаснаар Шударга өрсөлдөөн,



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039751 1118257206



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ҮЦК

хэрэглэгчийн төлөө газраас Өрсөлдөөний тухай хуулийн 15.1.6-д заасны дагуу Үнэт цаас гаргагчийг зах зээлд давамгай байдалтай аж ахуй эрхлэгчээр тогтоогоогүй бөгөөд Үнэт цаас гаргагчид Өрсөлдөөний тухай хуулийг зөрчсөн гэх үндэслэлээр сүүлийн 5 жилд захиргааны шийтгэл оногдуулж байгаагүй байна.

- "Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо"-ноос 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гаргасан 2023/053 тоот албан бичиг (Хавсралт 10.7)-т тусгаснаар Үнэт цаас гаргагч нь "Монголын Банк Бус Санхүүгийн Байгууллагуудын Холбоо"-ны гишүүн бөгөөд гишүүний ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэл гаргаж, хариуцлага хүлээж байгаагүй байна.
- Монголын хөрөнгийн биржийн 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гаргасан 01/336 тоот албан бичиг (Хавсралт 10.8)-т тусгаснаар Компани нь МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам, Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн ил тод байдлын журам болон бүртгэлийн гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, компанийн засаглалын кодексийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа, аливаа төлбөрийн үлдэгдэлгүй талаар мэдэгдсэн байна.
- Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр гаргасан 9/2371 тоот хариу хүргүүлэх тухай албан бичиг (Хавсралт 10.10)-т тусгаснаар ЛэндМН ББСБ ХК-д 2015 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн 293 тоот тогтоолоор банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосон ба СЗХ-ны даргын 2016 оны 236 дугаар тушаалаар тус ББСБ-ын нэрийг "Дуусашгүй ундарга ББСБ" байсныг "ЛэндМН ББСБ" болгон өөрчилснийг зөвшөөрсөн. Компани нь тайлан мэдээг хугацаанд нь ирүүлдэг ба 2023 оны 1-р улирлын байдлаар хангаж ажиллавал зохих зохистой харьцааг бүрэн хангаж ажилласан. Компанийн үйл ажиллагаанд СЗХ-ны даргын 2020 оны 160 дугаар тушаалаар баталсан удирдамжийн хүрээнд газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэсэн бөгөөд шалгалтаар илэрсэн зөрчилд Улсын байцаагчийн албан шаардлагаар хугацаатай үүрэг даалгаврыг өгсөн ба биелэлтийг хугацаанд нь бүрэн ирүүлж, зөрчлийг арилгаж ажилласан. СЗХ-ны даргын 2022 оны 236 дугаар тушаалаар батлагдсан "Компанийн засаглалын кодекс"-ийн хэрэгжилтийг зохион байгуулах удирдамжийн дагуу "ЛэндМН ББСБ" ХК-ийн кодексийн хэрэгжилтийн тайланд 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар хийсэн үнэлгээгээр 83.3 хувь буюу "дунд засаглалтай, цаашид сайжруулах шаардлагатай" гэж дүгнэгдсэн бөгөөд СЗХ-оос 2023 оны 02 дугаар улиралд багтаан хэрэгжилтийн тайланг ирүүлэх үүрэг, даалгаврыг өгсөн. Компани нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг тогтмол ирүүлдэг бөгөөд 2022 оны жилийн эцсийн эрсдэлийн үнэлгээ "бага" буюу 2.9 байгаа талаар тус албан бичигт дурджээ.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч нь иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар оролцоогүй байна (Хавсралт 12.1).

Үнэт цаас гаргагч нь сүүлийн 3 жилийн хугацаанд аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй байна.



ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5033754 1118237205
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTSK
УЛААНБААТАР ХОТ

MDSKhanLex

Компани нь 2023 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн Монголын татварын албаны тодорхойлолтоор татварын байгууллагад 661,788.74 төгрөгийн илүү төлөлттэй, 6,204,961.86 төгрөгийн дутуу төлөлттэй байна (Хавсралт 11.1).

Компани нь 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар Гаалийн байгууллагад татварын өргүй (Хавсралт 12.1), 2023 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн байдлаар Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоор нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй (Хавсралт 11.2) байна.

Компани нь 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар арилжааны банкинд зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн өргүй байна (Хавсралт 11.4).

Түүнчлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Шийдвэр гүйцэтгэх албанаас 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдөр гаргасан 0001286 тоот Тодорхойлолт (Хавсралт 11.5)-д "ЛэндМН ББСБ" ХК нь шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдэд өр төлбөргүй байна.

Дүгнэлт гаргах өдрийн байдлаар Компанид гааль, нийгмийн даатгал, татварын дутуу төлөлттэй холбоотой нөхөн татвар, торгууль, алданги ногдуулаагүй, шүүхийн шийдвэрийн дагуу төлөх аливаа өр төлбөргүй байна (Хавсралт 12.1).

ХҮНДЭТГЭСЭН,

"ӨМГӨӨЛЛИЙН ЭМ ДИ ЭС ЭНД ХААНЛЕКС" ХХН-ИЙН

ГИШҮҮН, ХУУЛЬЧ

Д.ДҮГЭРЖАВ

## 5.4 БУСАД

**"АНД СИСТЕМС" ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр № 23/09 Улаанбаатар хот

**Хувьцаа барьцаалах, гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16, 76.1.17 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.7 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.1, 88 дугаар зүйлийн 88.1, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам", "АНД Системс" ХХК (цаашид "**Компани**")-ийн дүрмийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.6 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 23.4 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "**ТУЗ**" )-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит бус хурлын санал хуралтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. **Компанийн охин компани болох "ЛэндМН ББСБ" ХК нь Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй бонд (цаашид "Лэнд Бонд") гаргахаар ажиллаж буй бөгөөд Лэнд Бонд болон түүний хүүг эргэн төлөх үүргийн гүйцэтгэлийг барьцаагаар баталгаажуулах шаардлага үүссэн болохыг дурдсугай.**

2. **Энэхүү тогтоолын 1-т заасантай холбогдуулан "ЛэндМН ББСБ" ХК-аас гаргаж буй 9,500,000,000 (есөн тэрбум таван зуун сая) хүртэлх төгрөгийн үнийн дүнтэй Лэнд Бондын үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Компанийн эзэмшиж буй, 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцохад 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг хувьцааг "Райнос Инвестмент ҮЦК" ХХК, "ЛэндМН ББСБ" ХК-тай гурван талт "Хувьцааны барьцааны гэрээ" байгуулж, Лэнд Бондын үндсэн болон хүүгийн төлбөр төлөгдөж дуусах хүртэл хугацаагаар барьцаалуулахаар шийдвэрлэсүгэй.**

3. **"Райнос Инвестмент ҮЦК" ХХК болон "ЛэндМН ББСБ" ХК-тай байгуулж буй "Хувьцааны барьцааны гурван талт гэрээ"-ний үндсэн нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар батлсугай.**

4. **Энэхүү тогтоолын 3-т заасан нөхцөлийн дагуу "Хувьцааны барьцааны гурван талт гэрээ" байгуулж, тус гэрээнд гарын үсэг зурах, тус гэрээний хугацаанд хувьцааг тусгаарлуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Б.Хос-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.**

5. **Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллах, хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Хос-Эрдэнэ)-д даалгасугай.**

6. **Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Компанийн ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 23/05 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.**

**ТУЗ-ИЙН ДАРГА**

**Ц.ҮҮГАНБАЯР**

“АНД Системс” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
23/09 тоот тогтоолын хавсралт

БАРЬЦААНЫ ҮНДСЭН НӨХЦӨЛ

| | |
|---|---|
| **Барьцааны зүйл** | **“АНД Системс” ХХК-ийн эзэмшлийн “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа** |
| **Барьцааны зүйлийн үнэлгээ** | **Монголын Хөрөнгийн Биржийн албан ёсны мэдээнд тусгагдсан “ЛэндМН ББСБ” ХК-ийн хувьцаа (LEND)-ны 6 сарын жигнэсэн дундаж ханшийн 70% (далан хувь)-аар тооцох** |
| **Барьцааны зүйлийн хэмжээ** | **“ЛэндМН ББСБ” ХК-ийн нийт гаргасан хувьцааны 50 хувиас хэтрэхгүй буюу 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг хувьцаанаас хэтрэхгүй** |
| **Барьцааны гэрээний хугацаа** | **Лэнд Бонд болон түүний хүүг бүрэн эргэн төлөх хүртэл хугацаанд буюу Лэнд Бондын гэрээтэй нэгэн ижил хугацаанд** |
| **Бусад нөхцөл** | **Барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буурч, Лэнд Бондын үндсэн төлбөрийн зээл үнэлгээний харьцаа (Loan to Value) үзүүлэлт 70% (далан хувь)-аас хэтэрсэн тохиолдолд шаардлагатай хэмжээгээр хувьцаа нэмж барьцаалах** |

**~oOo~**

СЗХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28

**ХУВЬЦААНЫ БАРЬЦААНЫ ГУРВАН ТАЛТ ГЭРЭЭ**

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр | Дугаар 2023/44 ХА-23/13 | Улаанбаатар хот

Энэхүү Хувьцааны барьцааны гурван талт гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-г:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сэнтрал тауэр 13 давхар, 1308б тоот албан ёсны хаягтай "Райнос инвестмент ҮЦК" ХХК (РД: 6481299) (цаашид "Барьцаалагч" эсвэл "Андеррайтер" гэх),

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 4-р барилга, (Монкос тауэр), 601 тоот албан ёсны хаягтай "Анд системс" ХХК (РД: 6005861) (цаашид "Барьцаалуулагч" гэх), болон

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-34, Сувд төв, 1,2 тоот албан ёсны хаягтай "ЛэндМН ББСБ" ХК (РД: 5039754) (цаашид "Үүрэг гүйцэтгэгч" эсвэл "Үнэт цаас гаргагч" гэх) нар

Иргэний хуулийн 153 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.3, 7 дугаар зүйлийн 7.1 болон холбогдох бусад хууль, дүрэм, журмыг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Андеррайтер болон Үүрэг гүйцэтгэгчийн хооронд 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан 2023/42 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" (цаашид "Андеррайтерийн гэрээ" гэх)-нд дурдсаны дагуу Үүрэг гүйцэтгэгчийн нийтэд санал болгон гаргах өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргийн биелэлтийг хангахтай холбогдуулан энэхүү Хувьцаа барьцааны гурван талт гэрээг байгуулав.

**Хоёр. Барьцааны нөхцөл**

2.1. Үүрэг гүйцэтгэгч буюу Үнэт цаас гаргагч нийтэд санал болгон гаргах Өрийн хэрэгслийн үндсэн болон хүүгийн төлбөр төлөх үүргээ бүрэн болон хэсэгчлэн биелүүлээгүй тохиолдолд Гэрээний 2.2-т заасан барьцааны зүйл болох хувьцаагаар Барьцаалагчийн шаардлагыг хангана.

2.2. **Барьцааны зүйл:** "ЛэндМН ББСБ " ХК-ийн Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй нийт 800,000,000 ширхэг энгийн хувьцааг бүртгүүлэн бөгөөд нийтэд санал болгон Монголын хөрөнгийн бирж дээр гаргах нийт 9,500,000,000 хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий өрийн хэрэгслийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Барьцаалуулагчийн эзэмшиж буй, 2023 оны 06 сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцоход 13,600,000,000 төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 ширхэг хувьцаа (цаашид "Барьцааны зүйл" гэх)-г Үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүргийн баталгаа болгож, Барьцаалагчид барьцаалуулахыг зөвшөөрч, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн хурлын 23/09 тоот шийдвэрийг хууль тогтоомжийн дагуу гаргасан болно.

2.3. **Барьцаагаар хангагдах шаардлага:** Үүрэг гүйцэтгэгчийн гаргах өрийн хэрэгслийн үндсэн төлбөрийн эргэн төлөлт, хүү, алданги, Барьцааны зүйлийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх шүүхийн зардал, Барьцааны зүйлийг хадгалуулахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотойгоор шимтгэл, татвар хураамж, төлбөр болон үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбоотой Барьцаалагчид учирсан бусад бүх хохирлын нийлбэрээр тодорхойлогдоно.

2.4. Барьцааны зүйлийн үнэлгээг Санхүүгийн Зохицуулах Хорооны "Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам"-ын 2.7 дахь хэсэгт заасны дагуу 2023 оны 06 сарын 23-ны өдрийн байдлаарх сүүлийн 6

МОНГОЛ УЛС 138
ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

1

сарын жигнэсэн дундаж ханшаар тооцсон ба үүний дагуу нэгж хувьцааны үнэлгээ 34 төгрөг, нийт барьцаа хөрөнгийн үнэлгээ нь *13,600,000,000* төгрөг байна.

2.5. Үүрэг гүйцэтгэгч нь Андеррайтерийн гэрээ болон өрийн хэрэгслийн дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлж, өрийн хэрэгслийн үндсэн төлбөр, хүү, алданги болон Андеррайтерийн гэрээтэй холбоотой бий болсон бусад төлбөр бүрэн төлөгдөж дуусах хүртэл хугацаанд Барьцаалагчийн барьцааны эрх хүчинтэй байна.

2.6. Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс Үүрэг гүйцэтгэгч буюу Үнэт цаас гаргагчийн нээлттэй хүрээнд гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэхийг зөвшөөрсөн тогтоол гаргасан тохиолдолд Барьцаалагч нь энэхүү Гэрээний дагуу үүссэн барьцааны эрхийг баталгаажуулах зорилгоор хөдлөх эд хөрөнгийн болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийг үйлдэж, бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын цахим мэдээллийн санд бүртгүүлэх ба Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 382 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Үнэт цаасыг барьцаалах тухай журам"-д заасны дагуу ҮЦТХТ-д бүртгүүлж тусгаарлуулна.

2.7. Барьцааны мэдэгдлийг цахим мэдээллийн санд бүртгүүлэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, барьцааны мэдэгдлийн анхны бүртгэлийн хугацааг сунгах, барьцааны мэдэгдлийг цуцлахтай холбоотой гарсан зардлыг Үүрэг гүйцэтгэгч хариуцна. Хэрэв Барьцаалагч нь зохих хураамж, шимтгэлийг төлж, барьцааны мэдэгдлийг бүртгүүлсэн бол бүртгүүлэхэд гарсан зардлыг нэхэмжлэл хүргүүлсний үндсэн дээр Үүрэг гүйцэтгэгчээс шаардах эрхтэй байна.

2.8. Энэхүү Гэрээний хугацаанд Барьцаалуулагч нь Барьцаалагчийн зөвшөөрөлгүйгээр Барьцааны зүйлийг худалдах, бэлэглэх, давхар барьцаалах болон аливаа бусад хэлбэрээр гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

2.9. Барьцаалуулагч нь Барьцааны зүйлтэй холбоотой гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, эсхүл гуравдагч этгээдтэй хэлцэл хийх тохиолдолд энэ тухай Барьцаалагчид мэдэгдэж, зөвшөөрөл авна.

2.10. Барьцаалагч нь Барьцааны зүйлтэй холбоотой шаардлагатай баримт материалуудтай танилцах зэргээр хяналт тавих бүрэн эрхтэй бөгөөд Үүрэг гүйцэтгэгч болон Барьцаалуулагч нь түүнд энэхүү хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөхцөлийг бүрдүүлнэ.

2.11. Барьцаалуулагч нь хувьцаа барьцаалах үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр саад тотгор учруулсан эсвэл Барьцааны зүйлтэй холбоотой худал мэдээлэл өгсөн бол энэхүү Гэрээг ноцтой зөрчсөн гэж үзэх ба учирсан хохирлыг Үүрэг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

2.12. Барьцааны зүйлийн зах зээлийн үнэлгээ буурч, өрийн хэрэгслийн үндсэн төлбөрийн зээл-үнэлгээний харьцаа (LTV) үзүүлэлт 70 хувиас хэтэрсэн тохиолдолд Барьцаалуулагч нь тус харьцаа үзүүлэлтийг 70 хувиас хэтрэхгүй байхаар тооцоолон энэ гэрээнд заасан нөхцөл журмын дагуу нэмж хувьцаа барьцаалах үүрэг хүлээнэ.

**Гурав. Барьцааны эрх хэрэгжүүлэх**

3.1. Үүрэг гүйцэтгэгч нь Бондын танилцуулгад дурдсан хугацаанд өрийн хэрэгслийн үндсэн төлбөр болон хүүг төлж барагдуулсан бол Барьцаалагч нь барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлөх тухай ҮЦТХТ-д албан бичгээр мэдэгдэж, Барьцааны зүйлийг тусгаарлалтаас чөлөөлүүлж, хөдлөх эд хөрөнгийн барьцааны цахим бүртгэлээс хасах арга хэмжээ авна.

3.2. Үүрэг гүйцэтгэгч нь Бондын танилцуулгад дурдсан өрийн хэрэгслээр хүлээсэн үүргээ болон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 158 дугаар зүйлийн 158.4, "Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль"-ийн зургадугаар бүлэгт заасныг үндэслэн өрийн хэрэгсэл эзэмшигчдийн эрх ашгийн үүднээс Барьцааны зүйлийг МХБ-ээр дамжуулан ил маргах журмаар арилжаалах

СЗХ 2023.08.11 БҮРТГЭВ
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28

замаар арилжин өрийн хэрэгслээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангуулах, нөхөн төлүүлэх эрх Барьцаалагчид үүснэ.

3.3. Барьцааны эрх хэрэгжүүлэх үндэслэл бүрдсэн тохиолдолд Барьцаалагч нь Үүрэг гүйцэтгэгчид барьцааны шаардлагыг хангах тухай мэдэгдэл-шаардлагыг Барьцаалуулагчид энэ гэрээний 5.5-д заасан хаяг болон цахим хаягаар бичгээр хүргүүлнэ.

3.4. Энэхүү Гэрээний 3.3-т заасан мэдэгдлийг хүлээн авмагц Барьцаалуулагч нь Барьцааны зүйл болох энэхүү Гэрээний 2.2-т заасан хэмжээний хувьцааг түгжээрлалтаас чөлөөлж, захиран зарцуулах эрхийг Барьцаалагчид олгох хүсэлтийг ҮЦТХТ-д ажлын нэг хоногт багтаан албан бичгээр хүргүүлнэ.

3.5. Барьцаалагч нь энэхүү Гэрээний 3.4-т заасныг эрх олгогдсоны дагуу Барьцааны зүйл болох хувьцааг арилжин борлуулж, өрийн хэрэгсэл эзэмшигчдийн төлбөрийг барагдуулах арга хэмжээг авна. Өрийн хэрэгсэл эзэмшигчийн төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн хувьцааг Барьцаалуулагчийн өмчлөлд хэвээр бүртгэх тухай мэдэгдлийг Барьцаалагч нь ҮЦТХТ-д албан бичгээр хүргүүлнэ.

**Дөрөв. Бусад зүйл**

4.1. **Энэхүү Гэрээ нь талуудын бүрэн эрхт төлөөлөгч нар гарын үсэг зурж, тамга даран баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.**
4.2. **Энэхүү Гэрээ нь Барьцааны хугацаанд хүчин төгөлдөр ба Үүрэг гүйцэтгэгчийн хүлээх үүрэг бүрэн биелэгдсэнээр дуусгавар болно.**
4.3. **Барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаас бусад энэхүү Гэрээтэй холбоотой маргаан бий болсон тохиолдолд талууд харилцан тохиролцож эвлэрлийн журмаар шийдвэрлэхийг эрмэлзэх бөгөөд ийнхүү шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхээр хянан шийдвэрлүүлнэ.**
4.4. **Энэхүү Гэрээнд шууд заагаагүй аливаа асуудлыг Монгол Улсын дагаж мөрдөж буй хууль тогтоомжоор зохицуулна.**
4.5. **Гэрээг Монгол хэл дээр, ижил хүчинтэй 5 хувь үйлдэх ба Барьцаалагчид 1 хувь, Үүрэг гүйцэтгэгчид 1 хувь, Барьцаалуулагчид 1 хувь, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд 1 хувь, Санхүүгийн Зохицуулах Хороонд 1 хувь тус тус хадгалагдана.**
4.6. **Гэрээний нөхцөл, болзол болон үйлчилгээний цар хүрээг засварлах, өөрчлөх болон үүнтэй холбоотойгоор Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд гагцхүү бичгээр үйлдэн Талууд гарын үсэг зурж баталгаажуулна.**

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

| | |
|---|---|
| **Барьцаалагч тал:**<br>**"Райнос инвестмент ҮЦК" ХХК-ийн Хөрөнгө оруулалт хариуцсан захирал/ Дэд захирал**<br>Н.ЦЭВЭГМИД | **Барьцаалуулагч тал:**<br>"Анд системс" ХХК-ийн Гүйцэтгэх Захирал<br>Б.ХОС-ЭРДЭНЭ |
| **Үүрэг гүйцэтгэгч:**<br>"ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх Захирал<br>Ц.ҮҮГАНБАЯР | |

2023 он 06 сар 28 өдөр Бүртгэлийн № ...
Нийслэлийн тойргийн нотариатч
П.Гэрэлмаа би энэхүү үйлдлийн
үнэн зөвийг гэрчлэв
Нотариатч ..........

3

СЗХ
2023 .08. 11 өдөр
БҮРТГЭВ

lendmn



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-07-28
БҮРТГЭВ-02

**"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 06 дугаар сарын 27-ны өдөр — № 23/20 — Улаанбаатар хот

**Үнэт цаас нийтэд санал болгон гаргах, түүний нөхцөлийг тогтоох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дэх хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.2, 41.3 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.2, 80.4 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 226 тоот "Компанийн өрийн хэрэгслийн бүртгэх журам", "ЛэндМН ББСБ" ХК (цаашид "Компани" )-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид "ТУЗ")-ийн 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 23/11 тоот тогтоолоор батлагдсан "Компанийн 2023 оны эх үүсвэрийн төлөвлөгөө", Компанийн ТУЗ-ийн 2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн ээлжээ хурлын санал хураалтын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 95,000 (ерэн таван мянга) хүртэлх ширхэг, нийт 9,500,000,000 (есөн тэрбум таван зуун сая) хүртэлх төгрөгийн үнийн дүн бүхий Компанийн өрийн хэрэгсэл (цаашид "Лэнд Бонд")-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар гаргасугай.
2. Нийтэд санал болгох Лэнд Бондын хэмжээ, төрөл, хугацаа, хүүгийн хэмжээ, хүү төлөх хугацаа, үнэт цаасны болон бусад нөхцөлийг энэхүү тогтоолын Хавсралтаар баталсугай.
3. Компанийн Лэнд Бондын эргэн төлөлтөд Компанийн толгой компани болох "АНД Системс" ХХК нь өөрийн эзэмшиж буй, 2023 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөрх сүүлийн 6 сарын жигнэсэн дундаж ханшаар тооцоход 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцааг барьцаалж, баталгаа гаргаж буйг дурдсугай.
4. Лэнд Бондын үндсэн андеррайтераар "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ийг, хуулийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээр "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийг, аудитораар "Нийслэл Аудит" ХХК-ийг тус тус сонгож, холбогдох гэрээг байгуулан ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
5. Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргах үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулахад шаардлагатай арга хэмжээг авах, шаардлагатай зөвшөөрөл, баримт бичгийг бүрдүүлэх, бусад арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
6. Энэхүү тогтоол батлагдсантай холбоотойгоор Компанийн ТУЗ-ийн 2023 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн хурлын 23/17 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.
7. Лэнд Бондыг нийтэд санал болгон гаргахтай холбоотой судалгаа шинжилгээ хийх, тэдгээрийн үйл явц, үр дүн болон хэрэгжилтийн талаар Компанийн ТУЗ-д тухай бүр танилцуулахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.

**ТУЗ-ИЙН ДАРГА**

**О.БОЛДБААТАР**

ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ‖ 1118257208

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ
5039754 ‖ 1118257208

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT

СЗХ 2023.08.11 БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-07-28 БҮРТГЭВ-02

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн
23/20 тоот тогтоолын хавсралт

**НИЙТЭД САНАЛ БОЛГОХ ҮНЭТ ЦААСНЫ НӨХЦӨЛ**

| | | |
|---|---|---|
| 1. | Үнэт цаас | Нээлттэй арилжаалах өрийн хэрэгсэл "Лэнд Бонд" |
| 2. | Арилжаа эрхлэх байгууллага | Монголын хөрөнгийн бирж |
| 3. | Лэнд Бондын нэрлэсэн үнэ | 100,000 (нэг зуун мянга) төгрөг |
| 4. | Тоо ширхэг | 95,000 (ерэн таван мянга) хүртэлх ширхэг |
| 5. | Олон нийтэд санал болгох нийт дүн | 9,500,000,000 (есөн тэрбум таван зуун сая) хүртэлх төгрөг |
| 6. | Хүү (жилийн буюу 365 хоног) | 18.0%- 18.5% (Гүйцэтгэх захирал үндсэн андеррайтертай зөвшилцөж тогтооно) |
| 7. | Бондын төрөл | Энгийн хүүтэй бонд |
| 8. | Лэнд Бондын хугацаа | 24 (хорин дөрөв) сар |
| 9. | Хүү төлөгдөх давтамж | Улирал тутамд |
| 10. | Үндсэн төлбөр төлөх хугацаа | Лэнд Бондын хугацааны эцэст (24 сарын дараа) |
| 11. | Лэнд Бондын барьцаа/Баталгаа | "АНД Системс" ХХК-ийн эзэмшиж буй 13,600,000,000 (арван гурван тэрбум зургаан зуун сая) төгрөгийн үнэлгээ бүхий 400,000,000 (дөрвөн зуун сая) ширхэг "ЛэндМН ББСБ" ХК-ийн хувьцаа |
| 12. | Татан төвлөрүүлсэн хөрөнгийг зарцуулах зориулалт | Үнэт цаас гаргагчийн зээлийн үйл ажиллагаар санхүүжүүлнэ |
| 13. | Нийтэд санал болгон гаргах хугацаа | 2023 оны III улирал (Зохицуулагч байгууллагаас шалтгаалан өөрчлөгдөх боломжтой) |
| 14. | Лэнд Бондын хадгалалт, төлбөр тооцоо | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв |
| 15. | Үндсэн андеррайтер | "Райнос Инвестмент ҮЦК" ХХК |
| 16. | Туслах андеррайтер | Гүйцэтгэх захирал нь үндсэн андеррайтер "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-тай харилцан тохиролцож, нэмэлтээр туслах андеррайтер ажиллуулж болно |

~oOo~

ЛЭНДМН ББСБ ХК УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК





# ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

ХАРААТ БУС ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН "ҮОУС 2022, СТОУС 13-ыг баримтлав"

**ҮЙЛЧЛҮҮЛЭГЧ:** ЛЭНДМН ББСБ ХК

**ҮНЭЛГЭЭЧИН:** ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ ХХК

Сүхбаатар дүүрэг 8-р хороо,
Сүхбаатарын талбай 20/6
Эрдэм тауэр, 1004 тоот
Утас: +976 7000 5000

Цахим хуудас: www.geregepartners.mn
Цахим хаяг: ganbaatar@geregepartners.mn

2023.06.30-НЫ ӨДРИЙН БАЙДЛААРХ ҮНЭЛГЭЭ

**Улаанбаатар хот**
**2023 оны 08 сарын 07 өдөр**

ЛэндМН ББСБ ХК-ийн Удирдлагад

Чингэлтэй Дүүрэг 3-р Хороо
Жуулчны гудамж-34, Сувд төв 1,2 тоот
Улаанбаатар, Монгол улс

2023 оны 08-р сарын 07-ны өдөр

Хүндэт Танаа,

**ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ**

Танай компанитай 2023 оны 8-р сарын 3-ны өдөр байгуулсан ГЭ-08/23 тоот "Хөрөнгийн үнэлгээний ажил гүйцэтгэх гэрээ"-ний дагуу бид "ЛэндМН ББСБ" ХК-ийн үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн үнэлгээг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар хийж гүйцэтгэн үнэлгээний ажлын тайланг хүргүүлж байна.

Энэхүү тайланг зөвхөн "ЛэндМН ББСБ" ХК болон тус компанитай холбоотой компаниудын дотоод хэрэгцээнд, санхүүгийн тайлагналын зориулалтаар боловсруулсан ба үнэлгээний үр дүнг өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.

Хөрөнгийн бодит үнэ цэнийг тооцоолоход Үйлчлүүлэгчээс авсан мэдээлэл болон өөрсдийн хийсэн шинжилгээ, дүгнэлтийг ашиглав.

Та бүхэн энэхүү тайлантай холбоотой аливаа санал болон асуулт байвал бидэнтэй холбоо барина уу.

Хүндэтгэсэн,

Д. Ганбаатар, Мэргэшсэн үнэлгээчин
Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн Гүйцэтгэх Захирал

СЗХ 2023 ... БҮРТГЭВ №51

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ БҮРТГЭВ

АГУУЛГА


1. ЕРӨНХИЙ ТОЙМ ... 4
2. АШИГЛАЛТЫН НӨХЦҮЛҮҮД ... 8
3. ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ ... 9
   Макро эдийн засгийн төлөв байдал ... 9
4. ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ ... 10
   Тээврийн хэрэгслийн мэдээлэл ... 10
   Бусад хөрөнгийн мэдээлэл ... 10
5. ҮНЭЛГЭЭ ... 11
   Үнэлгээнд ашигласан хандлага, арга ... 11
   Тээврийн хэрэгслийн үнэлгээ ... 11
      Харьцуулсан хөрөнгүүд ... 12
      Харьцуулсан хөрөнгүүдийн эх сурвалж ... 13
      Ашигласан тохируулгууд ... 14
      Харьцуулсан тооцоолол ... 15
   Бусад хөрөнгийн үнэлгээ ... 16
6. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН ... 18
7. ХАВСРАЛТУУД ... 19




ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTsK LLC УЛААНБААТАР ХОТ

СЭХ
2023.08.11
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
2023-08-07

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд ........ 9
Хүснэгт 2: Үнэлгээнд ашигласан аргууд ........ 11
Хүснэгт 5: Тээврийн хэрэгслийн үнэлгээний үр дүн ........ 16
Хүснэгт 6: Бусад хөрөнгийн үнэлгээний үр дүн ........ 18
Хүснэгт 7: Үнэлгээний үр дүн ........ 18

**ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт ........ 9



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1116267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

## 1. ЕРӨНХИЙ ТОЙМ

| | |
|---|---|
| **Тайлангийн өдөр** | 2023 оны 8-р сарын 07-ны өдөр |
| **Үнэлгээнд хамрагдсан Хөрөнгө** | - Тээврийн хэрэгсэл: 2ш<br>- Техник хэрэгсэл: 314ш<br>- Тавилга эд хогшил: 212 ш<br>- Түрээсийн сайжруулалт: 3ш<br>- Биет бус хөрөнгө: 2 төрөл |
| **Үйлчлүүлэгч** | ЛэндМН ББСБ ХК<br>Хаяг: Чингэлтэй Дүүрэг 3-р Хороо<br>Жуулчны гудамж-34, Сөүл төв 1,2 тоот<br>Улаанбаатар, Монгол улс |
| **Хөрөнгө эзэмшигч** | ЛэндМН ББСБ ХК |
| **Үнэлгээний өдөр** | 2023 оны 6-р сарын 30-ны өдөр |
| **Ажлын заавар** | Үнэлгээний өдрөөр хөрөнгийн бодит үнэ цэнийг санхүүгийн тайлагналын зориулалтаар тооцоолох |
| **Тайлангийн зорилго, зориулагдсан хэрэглээ** | Энэхүү үнэлгээний тайланг санхүүгийн тайлагналын зориулалтаар Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компаниудын дотоод хэрэгцээнд зориулан хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний үр дүнг үүнээс өөр зорилгоор эсхүл бусад этгээд өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй бөгөөд зориулалтгүй болохыг онцолж байна.<br><br>Тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ҮОУС 2022-ийн *зах зээлийн үнэ цэнэ* нь СТОУС 13-д тодорхойлсон *бодит үнэ цэнийн* шаардлагыг хангана гэж үздэг. Энэхүү үнэлгээний ажилд СТОУС-д тодорхойлсон *бодит үнэ цэнэ* нь ҮОУС 2022-д тодорхойлсон *зах зээлийн үнэ цэнийн* дүнтэй ижил утгатай болно. |
| **Үнэ цэнийн суурь** | Бодит үнэ цэнэ |
| **Тооцоолсон бодит үнэ цэнэ** | Нийт үнэ цэнэ: 1,103,666,560 (Нэг тэрбум нэг зуун гурван сая зургаан зуун жаран зургаан мянга таван зуун тавин мянга)-н төгрөг. Үүнээс<br><br>- Тээврийн хэрэгсэл: 154,250,000 төгрөг<br>- Техник хэрэгсэл: 224,561,079 төгрөг |

СЗХ
ОН САР ӨДӨР
БҮРТГЭВ
№

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

- Тавилга эд хогшил: 90,826,103 төгрөг
- Түрээсийн сайжруулалт: 103,701,862 төгрөг
- Биет бус хөрөнгө: 530,327,516 төгрөг

Бидний үнэлгээ нь дараах мэдээлэлд тулгуурласан болно. Үүнд:

- Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл;
- Зах зээлийн судалгаанаас боловсруулсан мэдээлэл;
- Бидний тооцоолол, таамаглал болон салбарын талаарх мэдлэг зэрэг багтана.

Бид Үйлчлүүлэгчээс ирүүлсэн мэдээлэл, бичиг баримтын алдаа болон дутуу зүйлд хариуцлага хүлээхгүй болно.

**Үнэлгээний хандлага, арга**

Зах зээлийн хандлагын Нийтэд арилжаалагддаг жиших зүйлсийн арга, Үлдэгдлийн арга

**Мэргэжлийн стандартын нийцэл**

- Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)
- Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС) 2022

СТОУС-д бодит үнэ цэнийг хэмжилтийн өдөр зах зээл дээрх оролцогч талуудын хооронд зохих журмын дагуу хийгдсэн ажил гүйлгээгээр хөрөнгөө борлуулснаар хүлээн авч болох эсвэл үүссэн өрөндөө төлж болох үнэ гэж тодорхойлсон байдаг. Иймд бид бодит үнэ цэнийг тодорхойлохдоо тухайн обьектийн ашиглалт, зах зээлийн мэдээллийн хүрэлцээтэй байдал зэрэгт тулгуурлаж зах зээлийн харьцуулалтын аргыг ашигласан.

**Ерөнхий таамаглал**

<u>Дансны бүрдэл</u>: Үнэлгээнд хамрагдсан хөрөнгүүдийн шинж чанар болон байрлалд үндэслэн үнэлэгдэж буй хөрөнгө нь бусад хөрөнгүүдтэй нэгтгэгдсэн эсэх нь хөрөнгийн үнэ цэнэд нөлөөлөх бодит нөлөөлөл багатай гэж үзлээ. Иймд эдгээр хөрөнгүүдийг нэгтгэгдээгүй буюу бие даасан байдлаар үнэлсэн болно.

<u>Тасралтгүй байдал</u>: Хөрөнгө нь цаашид бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх ба хөрөнгийн одоогийн ашиглалт нь өөрчлөгдөхгүй гэж үзэв. Өөрөөр хэлбэл, хөрөнгөд тохиромжтой засвар үйлчилгээ болон хамгаалалтыг хийж одоогийн байдал, зорилгоор ашиглах нөхцлийг бүрдүүлнэ.

**Тусгай таамаглал**

Байхгүй.

**Үзлэг, шалгалт, баримтын хадгалалт**

Хөрөнгийн биет үзлэгийг 2023.08.04 -ны өдөр хийж гүйцэтгэсэн. Үнэлгээнд шаардагдах нэмэлт мэдээллийг



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

Үйлчлүүлэгчээс асуулга, маягт бөглүүлэх байдлаар гаргуулж авсан болно.

| | |
|---|---|
| **Үнэлгээний Олон Улсын Стандартаас гажсан эсэх** | Гажаагүй |
| **Үнэлгээчид** | Үнэлгээчид нь энэ төрлийн үнэлгээг зааврын дагуу гүйцэтгэх туршлагатай, мэдлэг чадвартай гэдгийг баталж байна. Д.Гантулга нь Мэргэшсэн Үнэлгээчдийн Роял Институтын (RICS) гишүүн, Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн ТУЗ-ийн дарга бөгөөд тус компанийн бизнесийн болон хөрөнгийн үнэлгээний ажлуудыг удирдан хяналт тавьж ажилладаг. Д.Ганбаатар нь тус компанийн гүйцэтгэх захирал бөгөөд тус үнэлгээний ажлыг удирдан ажиллаж, үнэлгээний тайланг бэлтгэсэн болно. Гантулга, Ганбаатар нар нь Монгол улсын мэргэшсэн үнэлгээчид бөгөөд тасралтгүй 10 жилээс дээш хугацаанд үнэлгээний ажил гүйцэтгэн ажиллаж байна. Үнэлгээчний сертификатын хуулбарыг Хавсралт 4-д үзүүлэв. |
| **Ашиг сонирхлын зөрчил** | Энэ ажлыг хийж гүйцэтгэхэд бидэнд аливаа сонирхлын зөрчил байхгүй болно. Үүгээр манай компани болон манай багийн гишүүн тус бүр энэхүү үнэлгээний ажилд ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил байхгүй гэдгээ баталж байна. |
| **Тайлангийн хэрэглэгч / Нууцлал** | Энэхүү тайлан нь зөвхөн Үйлчлүүлэгч болон түүнтэй холбоотой компанид зориулж дээр дурдсан зориулалтаар бэлтгэгдсэн бөгөөд гуравдагч этгээдийн өмнө нийт болон хэсэгчилсэн агуулгын талаар хариуцлага хүлээхгүй болно. |
| **Тайлангийн хэрэглээ** | Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд энэхүү тайланг бүтнээр эсвэл хэсэгчлэн тараахыг хориглоно.<br><br>Урьдчилсан зөвшилцөж, бичгээр тохиролцоогүй тохиолдолд Үйлчлүүлэгч компани болон тус компанитай холбоотой бусад компани нь олон нийтэд гаргах аливаа баримт, мэдээлэл, мэдэгдэлд энэхүү үнэлгээний ажилтай холбоотойгоор Гэрэгэ Эстимэйт ХХК-ийн нэрийг дурдахыг хориглоно.<br><br>Энэхүү тайланг хөрөнгийн үнэлгээний чиглэлээр тодорхой мэдлэг, мэдээлэлтэй хүмүүс ашиглахад зориулж бэлтгэв. Үнэлгээний үр дүнгийн талаар аливаа санал, дүгнэлт гаргахын өмнө энэхүү тайланг бүхлээр нь уншиж танилцахыг зөвлөж байна. Энэхүү тайлантай холбоотой тайлбар авах, тодруулга хийх шаардлага |

СЗХ
2023 оны 11 сарын 1 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023-08-07
ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ
...-02

гарсан тохиолдолд бидэнтэй холбоо барихыг хүсч байна.

| | |
|---|---|
| **Мэргэжлийн хариуцлагын даатгал** | Үнэлгээчид нь Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдсан болно. |
| **Бусад** | Тайланг Монгол хэл дээр бэлтгэв. Тайланг бусад хэл дээр орчуулах, ашиглах үед гарч болзошгүй аливаа алдаа, зөрүүг Үнэлгээчид хариуцахгүйг анхаарна уу. Тайланг Үйлчлүүлэгчид цаасан болон электрон хэлбэрээр (pdf) хүлээлгэн өгөв. |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ
9019120763 6481299

СЭХ
2023 . 08 . 11 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023-08-07
БҮРТГЭВ-02



## 2. АШИГЛАЛТЫН НӨХЦЛҮҮД

Мэдээллийн найдвартай байдал: Энэхүү үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхэд Үйлчлүүлэгч компаниас гарган өгсөн тоон болон чанарын мэдээллийг ашигласан болно. Бид эдгээр мэдээллийн үнэн зөв байдал болон дотоод зөрчилдөөнтэй эсэхэд тойм шинжилгээ хийсэн боловч аудитын эсвэл хараат бус шалгалт, дүгнэлт хийлгээгүй болно. Үнэлгээний үр дүнгийн нарийвчлал нь мэдээллийн чанар, бүрэн бүтэн байдалтай шууд хамааралтай. Иймд энэ тайланд алдаатай мэдээлэл орсон бол бидэнд мэдэгдэхийг хүсье. Нэмэлт мэдээлэлд үндэслэн тайланг засварлан өөрчлөх боломжтой.

Хязгаарлагдмал байдал: Хөрөнгийн үнэлгээний аливаа тооцооллын нарийвчлал нь хязгаарлагдмал байдаг. Энэ нь худалдагч болон худалдан авагчийн хувийн сонирхол, сэтгэл ханамжаас хамаарч хөрөнгийн үнэ тогтдогтой холбоотой юм. Цаашилбал, хөрөнгийн үнэ нь ирээдүйд болох зарим үйл явдал, тухайлбал хууль хяналтын байгууллагын болон шүүхийн шийдвэр, инфляцийн өөрчлөлт болон эдийн засгийн шийдвэрүүдээс хамаардаг онцлогтой болно.

Энэхүү ажилд хэрэглэсэн үнэлгээний аргачлал, таамаглалууд нь үнэлгээний ажлын зорилготой нийцэх ба үнэлгээний үр дүн нь үнэлгээнд ашигласан мэдээллүүдийн хүрээнд харьцангуй бодит тооцоолсон гэж үзэж байна.

Үнэлгээнд хамрагдсан хөрөнгөтэй холбоотой аливаа өр төлбөрийг, тухайлбал тухайн хөрөнгүүд нь зээлийн барьцаанд тавигдсан эсэх, үндсэн хөрөнгийн төлөгдөөгүй татвар байгаа эсэх талаар энэхүү тооцоонд оруулаагүй болно.

Тооцооны аргачлалаас хамаарч тайлангийн зарим үзүүлбэр болон хүснэгтэд орсон тоон үзүүлэлтүүд нь нарийвчлал өндөртэй гарсан болно. Иймд тайланд орсон үнэлгээний үзүүлэлтүүдийг бүхэлчилсэнтэй холбоотойгоор үр дүн бага хэмжээгээр зөрж болохыг анхаарна уу.

Бидний хэрэглэсэн нарийвчилсан таамаглалууд болон бусад хязгаарлалтууд нь тайлангийн зохих бүлгүүдэд дурдагдсан болно. Энэ бүлэг нь тайлангийн зөвхөн нэг бүрэлдэхүүн хэсэг ба аливаа бүлгийг дангаар авч үзэн дүгнэлт гаргах нь буруу зөрүүтэй ойлголтод хүргэх боломжтой тул тайланг бүхэлд нь үзэж судлахыг зөвлөж байна.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

## 3. ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

### Макро эдийн засгийн төлөв байдал

**Дотоодын эдийн засаг**

2022 оноос өмнөх арван жилд Монгол улсын Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ийн бодит өсөлтийн дундаж 4.41% байсан ба 2012 онд хамгийн өндөр буюу 12.3%, 2020 онд -4.6% хүрч буурч байсан. ДНБ-ийн нэрлэсэн дүнгээр 2021 онд 43.5 их наяд төгрөг байсан бол 2022 онд өсөж 52.9 их наяд төгрөг болсон. 2022 онд ДНБ-ний бодит өсөлт 4.8% байсан.[1]

Зураг 1: Монгол Улсын бодит ДНБ-ний жилийн өсөлт




Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн үнэлгээний өдрийн байдлаарх бодит дүнг дараах хүснэгтэд харуулав[2].

Хүснэгт 1: Монгол Улсын эдийн засгийн гол үзүүлэлтүүд

| Үзүүлэлт | Нэгж | Дүн |
|---|---|---|
| ДНБ өсөлт | % | 7.9 |
| Ажилгүйдлийн хувь | % | 6.6 |
| Инфляцийн хувь | % | 11.3 |
| Зээлийн хүү | % | 13.0 |
| Худалдааны тэнцэл | US$ mln | 159 |
| ДНБ-д эзлэх төсвийн алдагдал | % | -11.5 |
| ДНБ-д эзлэх Засгийн газрын өр | % | 60 |

2022 оны ДНБ-ний өсөлтийн бүрэлдэхүүнийг зарим салбараар авч үзвэл уул уурхай болон олборлолт -11.9%-иар буурч, санхүү болон даатгалын үйл ажиллагаа 1.3%-иар өсөж, барилга 7.9%-иар, тээвэр агуулахын үйл ажиллагаа 3.0% тус тус өсжээ. "Trading economics" байгууллагын судалгаагаар 2023 онд Монгол Улсын ДНБ-ний бодит өсөлт 6% байхаар таамаглажээ.[3]

[1] Монголын статистикийн үндэсний хороо, www.1212.mn
[2] https://tradingeconomics.com/mongolia/forecast
[3] https://tradingeconomics.com/mongolia/gdp-growth-annual

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-07
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 4. ХӨРӨНГИЙН МЭДЭЭЛЭЛ

### Тээврийн хэрэгслийн мэдээлэл

| 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ | ТХ-1 | ТХ-2 |
|---|---|---|
| Эзэмшигч | ЛэндМН ББСБ | ЛэндМН ББСБ |
| Улсын дугаар | 0830 УБО | 2039 УАВ |
| Марк | TOYOTA Pruis 30 | Volkswagen Touareg |
| Ангилал | Б | Б |
| Даацын мэдээлэл | 1625 кг | 715 кг |
| Арлын дугаар | ZVW305057939 | WVGZZZCRZKD030818 |
| Моторын багтаамж | B 1797 | B 2995 |
| Өнгө | Сувдан цагаан | Бор |
| Км заалт | 175,375 | 58,258 |
| Үйлдвэрлэсэн огноо | 2010 | 2019 |
| Монголд ашиглаж эхэлсэн огноо | 11/30/2016 | 6/23/2019 |
| Нэмэлт тоноглол, бусад | - | - |
| 2. АШИГЛАЛТЫН БАЙДАЛ | | |
| Хөдөлгүүр | Хэвийн | Хэвийн |
| Явах эд анги | Хэвийн | Хэвийн |
| Арал кузов | Хойд буфер бага зэрэг зурагдсан | Хэвийн |
| Жолооны механизм, тоормозны систем | Хэвийн | Хэвийн |
| Цахилгаан тоног төхөөрөмж | Хэвийн | Хэвийн |
| Хүч дамжуулах эд анги | Хэвийн | Хэвийн |
| Бусад | Хэвийн | Хэвийн |
| 3. Хөрөнгийн дансны мэдээлэл | | |
| Худалдан авсан огноо | 2016/12/1 | 2020/2/1 |
| Худалдан авсан үнэ, төг | 16,760,000 | 181,000,000 |
| Үлдэгдэл өртөг | 5,591,405 | 117,726,800 |

### Бусад хөрөнгийн мэдээлэл

| Хөрөнгө | Тоо хэмжээ | Анхны өртөг, төг | Үлдэх өртөг, төг |
|---|---|---|---|
| Техник хэрэгсэл | 314 | 405,210,971 | 108,999,199 |
| Тавилга эд хогшил | 212 | 110,567,226 | 70,882,181 |
| Түрээсийн сайжруулалт | 3 | 217,278,584 | 52,470,605 |
| Биет бус хөрөнгө | 4 | 456,094,073 | 378,357,839 |

Үнэлгээнд хамрагдсан хөрөнгүүдийн фото зургийг Хавсралт 2-д түүвэрлэн, бусад хөрөнгийн дэлгэрэнгүй задаргааг Хавсралт 3-д үзүүлэв.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5030754 ш.1118207206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-07

СЗХ
2023.08.11 өдөр
БҮРТГЭВ
№ 11

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

## 5. ҮНЭЛГЭЭ

### Үнэлгээнд ашигласан хандлага, арга

Үнэлгээний ажлын зорилго, ажлын даалгаврын дагуу сонгосон үнэлгээний үнэ цэнийн суурь нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 13 (СТОУС 13)-д тодорхойлсон *Бодит үнэ цэнэ*-ийн суурь болно. Энэхүү үнэлгээний ажилд тооцоолсон *Бодит үнэ цэнэ* нь Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС)-д тодорхойлсон *Зах зээлийн үнэ цэнэ*-ийг мөн илэрхийлнэ.

Үнэлгээний хөрөнгийг эзэмшигч байгууллага ашигладаг бөгөөд түрээслүүлж байсан болон хойшид түрээслүүлэх төлөвлөгөө байхгүй талаар бидэнд мэдэгдсэн. Хөрөнгө нь түрээслэгдэж байгаа болон түрээслэгдэх боломжтой тохиолдолд хөрөнгийн үнэ цэнийг тооцоход орлогын хандлагын аргыг ихэвчлэн хэрэглэдэг.

Иймд зах зээлийн болон өртгийн хандлагын аргуудыг ашиглан дараах байдлаар үнэлгээг хийж гүйцэтгэв.

Хүснэгт 2: Үнэлгээнд ашигласан аргууд

| Хөрөнгийн ангилал | Үнэлгээнд ашигласан арга |
|---|---|
| 1. Тээврийн хэрэгсэл | Зах зээлийн хандлагын арга |
| 2. Бусад хөрөнгө | Өртгийн хандлага, орлуулалтын өртгийн арга |

### Тээврийн хэрэгслийн үнэлгээ

Тээврийн хэрэгслийн үнэ цэнийг зах зээлийн харьцуулалтын аргын нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн аргыг ашиглан тооцоолов.

Нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн аргын гол алхамууд нь дараах байдалтай байна:

(а) холбогдох зах зээлд оролцогчдын ашиглах үнэлгээний жишиг нотлох зүйлийг тодорхойлох
(б) нийтэд арилжаалагддаг холбогдох жишиг зүйлсийг тодорхойлох ба тэдгээр ажил гүйлгээний хувьд үнэлгээний гол хэмжигдэхүүнүүдийг тооцоолох
(в) нийтэд арилжаалагддаг жишиг зүйлс ба үнэлж буй хөрөнгийн хооронд тоо хэмжээ, чанарын ижил төсөөтэй ба ялгаатай талуудын зохих зэрэгцүүлсэн шинжилгээг гүйцэтгэх
(г) үнэлж буй хөрөнгө ба нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн хооронд ялгаатай талуудыг харгалзан тусгахын тулд үнэлгээний хэмжигдэхүүнүүдэд аливаа шаардлагатай тохируулгыг хийх
(д) үнэлгээний тохируулсан хэмжигдэхүүнүүдийг үнэлж буй хөрөнгөнд хэрэглэх
(е) хэрэв үнэлгээний олон хэмжигдэхүүнүүдийг ашигласан бол үнэ цэнийн үзүүлэлтүүдийг жинлэх.

Холбогдох зах зээлд оролцогчдын ашиглах үнэлгээний жишиг нотлох зүйл, нийтэд арилжаалагддаг холбогдох жишиг зүйлсийг тодорхойлоходоо тээврийн хэрэгсэл идэвхитэй арилжаалагддаг www.unegui.mn сайт болон автохудалдааны зуучлалын мэдээллийг ашиглав.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 07

СЗХ
2023 08 11
БҮРТГЭВ
№ 11

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

### Харьцуулсан хөрөнгүүд

0830 УБО

| Үзүүлэлт | Харьцуулах хөрөнгө1 | Харьцуулах хөрөнгө2 | Харьцуулах хөрөнгө3 |
|---|---|---|---|
| Марк, загвар | Toyota Pruis 30 | Toyota Pruis 30 | Toyota Pruis 30 |
| Үйлдвэрлэсэн он | 2010 | 2010 | 2010 |
| Импортолсон он | 2016 | 2016 | 2016 |
| Ашиглалтын байдал | Хэвийн | Хэвийн | Хэвийн |
| Өнгө | Сувдан цагаан | Сувдан цагаан | Цайвар цэнхэр |
| Гадаад үзэмж | Хэвийн | Хэвийн | Хэвийн |
| Гүйлт, км | 155,000 | 274,000 | 285,000 |
| Нэмэлт | - | - | - |
| Хөдөлгүүр, хурдны хайрцаг | Хайбрид, автомат | Хайбрид, автомат | Хайбрид, автомат |
| Байрлал | Улаанбаатар | Улаанбаатар | Улаанбаатар |
| Зарлагдсан үнэ, төг | 15,000,000 | 15,000,000 | 14,000,000 |
| Эх сурвалж | https://www.unegui.mn | https://www.unegui.mn | https://www.unegui.mn |
| Огноо | 2023.07 | 2023.07 | 2023.07 |

2039 УАВ

| Үзүүлэлт | Харьцуулах хөрөнгө1 | Харьцуулах хөрөнгө2 |
|---|---|---|
| Марк, загвар | Volkswagen Touareg | Volkswagen Touareg |
| Үйлдвэрлэсэн он | 2019 | 2019 |
| Импортолсон он | 2019 | 2020 |
| Ашиглалтын байдал | Хэвийн | Хэвийн |
| Өнгө | Gold metallic | Хөх |
| Гадаад үзэмж | Хэвийн | Хэвийн |
| Гүйлт, км | 45,000 | 27,000 |
| Нэмэлт | - | - |
| Хөдөлгүүр, хурдны хайрцаг | Бензин 2995 cc, автомат | Бензин 2995 cc, автомат |
| Байрлал | Улаанбаатар | Улаанбаатар |
| Зарлагдсан үнэ, төг | 170,000,000 | 190,000,000 |
| Эх сурвалж | UA automotives | https://www.unegui.mn |
| Огноо | 2023.07 | 2023.07 |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -09- 07

СЗХ
2023.09.11 өдөр
БҮРТГЭВ
№ 1

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

**Харьцуулсан хөрөнгүүдийн эх сурвалж**

0830 УБО

Харьцуулах хөрөнгө 1




https://www.unegui.mn/adv/7494145_toyota-prius-30-2010-2016/

Харьцуулах хөрөнгө 2




https://www.unegui.mn/adv/7427897_toyota-prius-30-2010-2016/

Харьцуулах хөрөнгө 3




https://www.unegui.mn/adv/7468181_toyota-prius-30-2010-2016/



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

2039УАВ

Харьцуулах хөрөнгө 1




https://www.facebook.com/ua.automotive/posts/pfbid02GrxseaEfYcxk7P5aeuUb89tox4636UQ2ThzU9hePMkd

Харьцуулах хөрөнгө 2




https://www.unegui.mn/adv/7481573_volkswagen-touareg-2019-2020/

**Ашигласан тохируулгууд**

Хэлцэл бууруулах хувь: зарын үнэд лавлагаа, судалгаа хийсний үндсэн дээр 10% хүртэл бууруулав.
*Марк загвар:* Үнэлэгдэж буй хөрөнгүүдтэй ижил загварын хөрөнгө сонгож 1.00-р тохируулав.
*Үйлдвэрлэсэн он:* Тээврийн хэрэгслүүдийн ашиглагдах хугацаа дунджаар 20 жил гэж үзэн үйлдвэрлэсэн оны зөрүүг жилийн 5%-иар тохируулав.
*Импортолсон он:* Монгол улсын замын байдал:2.5%, хүйтний нэмэгдэл: 2.5 %-иар тооцон импортолсон оны зөрүүг жилийн 5%-иар тохируулав.
*Гүйлт:* ҮХ, ХХ-үүдийн жилийн дундаж гүйлтийн зөрүү хувьд 10%-ийн ач холбогдол өгч тохируулав.
*Өнгө үзэмж:* Гадаад өнгө үзэмж, зөв зүүнээс арилгах зардлыг харгалзан 5% хүртэл тохируулав.

СЭХ 2023 08 сар 11 өдөр БҮРТГЭВ №11
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-08-07 БҮРТГЭВ-02

### Харьцуулсан тооцоолол

0830 УБО

| № | | Үзүүлэлт | Тооцоолол | XX-1 | XX-2 | XX-3 |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | | Зарахаар зарлагдсан үнэ, төг | 1 | 15,000,000 | 15,000,000 | 14,000,000 |
| 2 | | Зарлагдсан үнэд хийсэн тохируулга, хув | 2 | 3% | 5% | 5% |
| 3 | | Худалдсан эсвэл худалдах боломжит | 3=1-1*2 | 14,550,000 | 14,250,000 | 13,300,000 |
| 4 | Тохируулгын хүчин зүйлүүд | Марк, загвар | 4.1 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Үйлдвэрлэсэн он | 4.2 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Импортолсон он | 4.3 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Ашиглалтын байдал | 4.4 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Түлш | 4.5 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Гүйлт | 4.6 | 0.99 | 1.04 | 1.04 |
| | | Өнгө, гадаад үзэмж, дотор салон | 4.7 | 0.98 | 0.98 | 1.02 |
| | | Хөдөлгүүр, хурдны хайрцаг | 4.8 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Байрлал | 4.9 | 1.00 | 1.00 | 1.00 |
| | | Үнэлгээний өдөр | 4.10 | 1.00 | 1.00 | 1.00 |
| 5 | | Тохируулсан үнэ, төг | 5=П4i*3 | 14,116,410 | 14,523,600 | 14,108,640 |
| 6 | | **Дундаж үнэ** | 6=average5i | | | 14,249,550 |
| 7 | | **Бүхэлчилсэн дүн** | 8 | | | 14,250,000 |

2039 УАВ

| № | | Үзүүлэлт | Тооцоолол | XX-1 | XX-2 |
|---|---|---|---|---|---|
| 1 | | Зарахаар зарлагдсан үнэ, төг | 1 | 170,000,000 | 190,000,000 |
| 2 | | Зарлагдсан үнэд хийсэн тохируулга, хув | 2 | 10.0% | 10.0% |
| 3 | | Худалдсан эсвэл худалдах боломжит | 3=1-1*2 | 153,000,000 | 171,000,000 |
| 4 | Тохируулгын хүчин зүйлүүд | Марк, загвар | 4.1 | 1.00 | 1.00 |
| | | Үйлдвэрлэсэн он | 4.2 | 1.00 | 1.00 |
| | | Импортолсон он | 4.3 | 1.00 | 0.95 |
| | | Ашиглалтын байдал | 4.4 | 1.00 | 1.00 |
| | | Түлш | 4.5 | 1.00 | 1.00 |
| | | Гүйлт | 4.6 | 0.98 | 0.90 |
| | | Өнгө, гадаад үзэмж, дотор салон | 4.7 | 0.95 | 0.95 |
| | | Хөдөлгүүр, хурдны хайрцаг | 4.8 | 1.00 | 1.00 |
| | | Байрлал | 4.9 | 1.00 | 1.00 |
| | | Үнэлгээний өдөр | 4.10 | 1.00 | 1.00 |
| 5 | | Тохируулсан үнэ, төг | 5=П4i*3 | 142,443,000 | 138,894,750 |
| 6 | | **Дундаж үнэ** | 7=Σ5i*6i | | 140,668,875 |
| 8 | | **Бүхэлчилсэн дүн** | 8 | | 140,000,000 |



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT ÜTsK LLC УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -08- 07

СЭХ 2023.08. 11 өдөр БҮРТГЭВ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

Хүснэгт 3: Тээврийн хэрэгслийн үнэлгээний үр дүн

| № | Улсын дугаар | Тооцоолсон үнэ цэнэ, төг |
|---|---|---|
| 1 | 0830 УБО | 14,250,000 |
| 2 | 2039 УАВ | 140,000,000 |
| | Нийт | **154,250,000** |

### Бусад хөрөнгийн үнэлгээ

Бусад хөрөнгүүдэд тавилга, компьютер дагалдах хэрэгсэл, цахилгаан хэрэгсэлт программ хангамж зэргийг хамруулав.

Эдгээр хөрөнгүүдийг хэрэглэгчид ихэвчлэн шинээр худалдан авч ашиглаад дуусдаг бөгөөд хоёрдогч зах зээлийн буюу ашиглаж байсан хуучин хөрөнгүүдийн бодит худалдаа бараг байхгүй гэж болно. Харин онлайнаар зарахаар зарлагдсан мэдээллүүд байдаг бөгөөд тэдгээр хөрөнгүүдийн марк загвар, хүчин чадал зэрэг үнэ цэнэд нөлөөлөх хүчин зүйлүүдийг тодорхойлж харьцуулсан шинжилгээ хийхэд тодорхойгүй байдал ихтэй байна.

Иймд бусад хөрөнгийн үнэлгээнд өртгийн хандлагын орлуулалтын өртгийн аргыг ашиглав.

Эдгээр хүчин зүйлийг харгалзан бусад хөрөнгийг Өртгийн хандлагын Орлуулалтын өртгийн аргаар үнэлэхдээ дараах таамаглал, аргачлалыг ашиглав. Үүнд:

- Хөрөнгүүдийг анх худалдан авахдаа тухайн үеийн зах зээлийн үнээр худалдан авсан гэж үзсэн. Ингэхдээ 2022 оны 4-р улирлын аудитлагдсан санхүүгийн тайланд үндэслэв. 2023 онд худалдан авсан зарим томоохон хөрөнгийн худалдан авсан баримт, худалдан авах гэрээ зэргийг шалгаж баталгаажуулсан.
- Худалдан авалт хийснээс хойшхи үнийн өөрчлөлтөөр тохируулж үнэлгээний өдрийн байдлаарх анх худалдан авах үеийн шинж чанар бүхий хөрөнгийн зах зээлийн үнийг тооцоолов.
- Үнийн өөрчлөлтөөр тохируулсан орлуулах өртөг нь зах зээлийн мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхийг түүвэрлэн шалгасан.
- Энэ үнээс элэгдлийн тохируулга хийн (эдийн засгийн хоцрогдол, үүрэг ажиллагааны болон биет элэгдэл) зах зээлийн үнэ цэнийг тооцоолов.
- Хөрөнгүүдийн ашиглах норматив хугацаа, ашигласан жил цаашид ашиглах хугацааг тодорхойлж шулуун шугамын аргаар биет элэгдлийг тооцоолов.
- Үнэлгээний өдрийн байдлаар хөрөнгүүдэд эдийн засгийн болон үүрэг ажиллагааны элэгдэл хоцрогдол байхгүй гэж үзэв.

#### Үнийн өсөлтийн итгэлцүүр

Үнийн өсөлтийн итгэлцүүр тооцохдоо хөрөнгүүдийг ижил төстэй байдлаар 3 бүлэгт ангилан үндэсний статистикийн газраас бэлтгэн гаргадаг тухайн ангилалд тохирох бүлгийн үнийн өөрчлөлтийн индексүүд[4] болон долларын ханшийн өөрчлөлтийг ашиглав.

[4] https://1212.mn/



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTSK LLC УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 07
СЗХ
2023 .08. 11
БҮРТГЭВ
ГЭРЭГЭ

**Хөрөнгүүдийн үнийн итгэлцүүр тооцох ангилал**

*Компьютер, цахилгаан бараа бусад:* Тавилга тоног төхөөрөмжөөс бусад үндсэн хөрөнгүүд нь компьютер, дагалдах хэрэгсэл, цахилгаан хэрэгсэл гэх мэт дотоодод үйлдвэрлэдэггүй 100% импортын бүтээгдэхүүнүүд байна. Бидний ажиглалтаар импортын бүтээгдэхүүний дотоод зах зээлийн үнийн бүтцийг авч үзвэл гадаад үйлдвэрлэгчийн үнэ, гааль, НӨАТ зэрэг гадаад валютаас хамаарах өртөг 60%, түрээс, цалин хөлс, ашиг гэх мэт дотоодод хамаарах өртөг 40%-г эзэлж байна. Мөн импортын бараа бүтээгдэхүүний гэрээний үнийг аль улсаас үл хамааран ихэнхдээ долларaap тооцож байна. Иймд тавилга, тоног төхөөрөмжөөс бусад үндсэн хөрөнгийн үнийн өсөлтийн индекс тооцохдоо долларын ханшийн өөрчлөлтөд 60%, хэрэглээний үнийн индексд 40%-ийн ач холбогдол өгч тооцоолов.

*Тавилга:* Гэр ахуйн тавилга барааны үнийн индексээр тооцов.

*Түрээсийн сайжруулалт:* Барилга угсралтын ажлын ерөнхий индексээр тооцов

**Хөрөнгүүдийн ашиглах норматив хугацаа**

Хөрөнгүүдийн ашиглах норматив хугацааг Сангийн сайдын 2018.08.07-ны өдрийн 207-р тушаал, 5-р хавсралтаар баталсан Хөрөнгийн үнэлгээнд баримтлах үл хөдлөх ба хөдлөх хөрөнгийн хөрөнгийн ашиглалтын норматив хугацаар баримтлан тодорхойлж ашигласан хугацааг хасан цаашид ашиглах хугацааг тооцоолов. Ашиглах хугацаа дууссан боловч ашиглагдаж байгаа хөрөнгүүдийн хувьд цаашид ашиглах хугацааг 1 жилээр авав.

| Хөрөнгийн ангилал | Ашиглах норматив хугацаа, жил | Үндэслэл |
|---|---|---|
| Компьютер, технологийн хэрэгсэл -1 | 5 | 144-Тооцоолон бодох техник хэрэгсэл, 134 |
| Тавилга эд хогшил -2 | 10 | 156- Тавилга эд хогшил |
| Цахилгаан төхөөрөмж - 3 | 6 | 138, 143 |
| Түрээсийн сайжруулалт -4 | 5 | Зах зээлийн мэдээлэл |

**Программ хангамжийн үнэлгээ**

Үйлчлүүлэгч нь 2021 оны 08 сарын 03-ны өдрийн гэрээгээр 2071 оны 08 сарын 03 хүртэл хугацаагаар LendMN v2.0 программын лиценцийг, эзэмшдэг бөгөөд нь LendMN v2.0 программын лиценцийн эрхийн үнэ болон сайжруулалт, ашиглалтын төлберийг доллараар тооцохоор гэрээнд тусгасан байна. Иймд тус лиценцийн орлуулах өртгийг тооцохдоо гэрээний үнийн үнэлгээний өдрийн байдлаарх долларын ханшаар тооцож гэрээ байгуулсан өдрөөс хойш 50 жилээр шулуун шугамын аргаар элэгдлийн тохируулга хийж бодит үнэ цэнийг тооцоолов.

Үйлчлүүлэгч нь Спинел 6.0 санхүүгийн программыг хэвийн ашиглаж байгаа бөгөөд ойрын үед шинэчлэх төлөвлөгөөгүй байгаа талаар мэдэгдсэн. Үнэлгээний өдрийн байдлаар тус программын зах зээлийн үнэ үйлчлүүлэгчийн гэрээний үнээс материаллаг зөрүүгүй байна. иймд тус программын үнэлгээг гэрээний үнээр тооцов.

Бусад хөрөнгийн ангилал болон дэлгэрэнгүй тооцооллыг Хавсралт 3-д үзүүлэв.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 07
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 .08 сар 11 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

Хүснэгт 4: Бусад хөрөнгийн үнэлгээний үр дүн

| Хөрөнгийн ангилал | Тоо хэмжээ, ш | Тооцоолсон үнэ цэнэ, төг |
|---|---|---|
| Техник хэрэгсэл | 314 | 224,561,079 |
| Тавилга эд хогшил | 212 | 90,826,103 |
| Түрээсийн сайжруулалт | 3 | 103,701,862 |
| Биет бус хөрөнгө | 4 | 530,327,516 |

## 6. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Үнэлгээний ажлын зорилго, ажлын зааврын дагуу үнэлгээнд хамрагдсан хөрөнгүүдийн бодит үнэ цэнийг 2023 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 1,103,666,560 (Нэг тэрбум нэг зуун гурван сая зургаан зуун жаран зургаан мянга таван зуун тавин мянга)-н төгрөг гэж тооцоолов.

Хүснэгт 5: Үнэлгээний үр дүн

| № | Хөрөнгүүд | Тооцоолсон бодит үнэ цэнэ, төгрөгөөр |
|---|---|---|
| 1 | Тээврийн хэрэгсэл | 154,250,000 |
| 2 | Техник хэрэгсэл | 224,561,079 |
| 3 | Тавилга эд хогшил | 90,826,103 |
| 4 | Түрээсийн сайжруулалт | 103,701,862 |
| 5 | Биет бус хөрөнгө | 530,327,516 |
| | Нийт | 1,103,666,560 |



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 дх 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK LLC
УЛААНБААТАР ХОТ

2023.08.11
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-08-07
БҮРТГЭВ-02



## 7. ХАВСРАЛТУУД

ХАВСРАЛТ 1: Тодорхойлолт ба аргачлал
ХАВСРАЛТ 2: Хөрөнгийн фото зургууд
ХАВСРАЛТ 3: Бусад хөрөнгийн үнэлгээний дэлгэрэнгүй тооцоолол /Файлаар/
ХАВСРАЛТ 4: Үнэлгээчдийн сертификатын хуулбарууд



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTsK LLC
УЛААНБААТАР ХОТ
9019120763 6481299

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-08-07 БҮРТГЭВ-02

СЗХ 2023 08 сар 11 өдөр БҮРТГЭВ № 11



## ХАВСРАЛТ 1: ТОДОРХОЙЛОЛТ БА ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ

### Тодорхойлолтууд

Үнэлгээний зарим нэр томьёог өөр өөр утгаар ойлгож болох талтай байдаг. Ийм нөхцөл байдал үүсэхээс зайлсхийх зорилгоор үнэлгээнд хэрэглэсэн зарим нэр томьёог Үнэлгээний Олон Улсын Стандарт (ҮОУС), RICS мэргэжлийн олон улсын стандарт ("Улаан ном") болон Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д тодорхойлсны дагуу дараах байдлаар үзүүлэв.

Идэвхитэй зах зээл (СТОУС 13) – Үнийн мэдээллээр тогтмол хангахад хүрэлцэхүйц давтамж, дүнгээр хөрөнгө, өр төлбөрийн арилжаа хийгддэг зах зээл.

Үнэ цэн (ҮОУС 2022) – ҮОУС 104 Үнэ Цэнийн Суурьууд - д заасан үнэ цэнийн суурьудын аль нэгэнд нийцүүлэн тухайн тооцоолсон дүнгийн талаар үнэлгээчний гаргасан шууд тунгаалтын илэрхийлэл.

Үнэ цэнийн суурь (ҮОУС 2022) – Тухайн тайлагнах үнэ цэнийг үндэслэн гаргах суурь урьдчилсан нөхцөлүүд.

Өртгийн хандлага (ҮОУС 2022) – Зохисгүй хугацаа, тохиромжтой бус байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлс нь хамааралтай биш л бол худалдан авагч нь худалдан авсан эсвэл барьж байгуулсан эсэхээс үл хамааран ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг олж бэлтгэх өртгөөс илүү дүнг тухайн хөрөнгийн хувьд төлөхгүй гэсэн эдийн засгийн зарчмыг баримтлан өртгийн хандлага нь үнэ цэнийн үзүүлэлтийг тооцон гаргадаг.

Хүлээгдэж буй мөнгөн гүйлгээ (СТОУС 13) – Боломжит ирээдүйн мөнгөн гүйлгээг магадлалаар жинлэсэн дундаж (өөрөөр хэлбэл тархалтын дундаж дүн).

Бодит үнэ цэн (СТОУС 13) – Хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөө тооцох үнэ юм.

Хамгийн сайн ашиглалт (СТОУС 13) – Хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө буюу бүлэг хөрөнгө, өр төлбөр (бизнесийн хувьд)-ийн үнэ цэнийг дээд түвшинд байлгах зах зээлд оролцогчдын санхүүгийн бүс хөрөнгө ашиглалт.

Орлогын хандлага (СТОУС 13) – Ирээдүйн дүнгүүд (жишээлбэл: мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүн)-ийг өнөөгийн ганц дүн (өөрөөр хэлбэл хорогдуулан)-д хөрвүүлдэг үнэлгээний арга, хандлага. Бодит үнэ цэнийг хэмжихдээ ирээдүйн дүнгүүдийн талаарх зах зээлийн өнөөгийн таамаглалаар илэрхийлсэн үнэ цэнд суурилна.

Орц-мэдээлэл (СТОУС 13) – Энэ нь хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг хэлэх бөгөөд үүнд дараах эрсдэлийн таамаглал багтана:

(a) Бодит үнэ цэнийг хэмжихэд хэрэглэсэн үнэлгээний тодорхой арга аргачлалаас шалтгаалан үүссэн эрсдэл (тухайлбал, үнэ тогтоох загвар); ба

(b) Үнэлгээний арга, аргачлалын дагуу ашиглагдаж буй орц мэдээллээс шалтгаалан үүссэн эрсдэл.

Орц мэдээлэл нь бэлэн олдоцтой буюу ажиглагдах эсвэл үл ажиглагдах байж болно.

Хөрөнгө оруулалтын зориулалттай өмч (Улаан ном 2020) – Доорх (a), (б)-оос бусад зорилгоор капиталын үнэ цэнийг өсгөх, эсвэл түрээсийн орлого олох, эсвэл аль алиных нь зорилгоор эзэмшиж буй өмч (газар, барилга, эсвэл барилгын хэсэг, эсвэл аль аль нь

(a) бараа үйлчилгээний үйлдвэрлэлт, нийлүүлэлт болон захиргааны зорилгоор ашиглаж байгаа эсвэл

(b) бизнесийн хэвийн нөхцөлд худалдан борлуулах зориулалттай.

Нэгдүгээр түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Аж ахуйн нэгжийн хэмжилт хийж буй өдрөөр ашиглах боломжтой, ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн жишиг (тохируулаагүй ) үнэ.

Хоёрдугаар түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Хөрөнгө, өр төлбөртэй холбоотой шууд ба шууд бусаар гаргаж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшинд багтсан жишиг үнээс бусад орц мэдээлэл.

Гуравдугаар түвшний орц-мэдээлэл (СТОУС 13) – Хөрөнгө ба өр төлбөрийн талаарх үл ажиглагдах орц мэдээлэл.

Зах зээлийн хандлага (ҮОУС 2022) – Тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох (өөрөөр хэлбэл төсөөтэй) хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтээр хангадаг.

Зах зээлээр баталгаажсан мэдээлэл (СТОУС 13) – Корреляци болон бусад аргын тусламжтайгаар зах зээлд бэлэн байгаа мэдээллээр баталгаажсан буюу түүнээс гаргаж авсан орц мэдээлэл.

Зах зээлийн түрээсийн төлбөр (ҮОУС 2022) – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа түрээслүүлэгч ба түрээслэгчийн хооронд харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр зохих түрээсийн нөхцөлийн дагуу үл хөдлөх хөрөнгийн хувь оролцоог түрээслэвэл зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.

Зах зээлийн үнэ цэн (ҮОУС 2022) – Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө буюу өр төлбөрийг арилжвал зохино гэж үг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн.



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ

RHINOS INVESTMENT ҮЦК LLC УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 07
БҮРТГЭВ-02

2023 .08. 11



Бэлэн олдох орц мэдээлэл [СТОУС 13] – Тодорхой үйл явдал, ажил гүйлгээний талаар олон нийтэд нээлттэй байгаа мэдээлэл гэх мэт зах зээлийн тоон мэдээг ашиглан боловсруулсан орц мэдээллийг хэлэх бөгөөд үүнд хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохын тулд зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалыг тусгана.
Үндсэн зах зээл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийг хамарсан хамгийн өндөр дүнтэй болон хамгийн олон арилжаа хийгдсэн зах зээл юм.
Үл хөдлөх өмчийн хувь оролцоо [ҮОУС 2022] – Газар ба барилгын өмчлөл, хяналт, ашиглалт буюу эзэмшлийн эрх.
Тусгай төсөөллүүд [Улаан ном 2022] – Үнэлгээний өдрөөр бий болсон нөхцөл байдлаас ялгаатай нөхцөл байдлыг авч үзэж буй төсөөлөл эсвэл үнэлгээний өдөр зах зээлийн жирийн оролцогч хийхгүй байх үйлдэл.
Тусгай үнэ цэн [Улаан ном 2022] – Хөрөнгийн хувийн шинж чанарыг тусгаж байдаг, зөвхөн тусгай худалдан авагчдад бий болох үнэ цэн.
Өргөжилтийн хэмнэлтийн үнэ цэн [ҮОУС 2022] – Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө эсвэл хувь оролцоог нэгтгэн нийлүүлсэн бөгөөд уг нэгдсэн үнэ цэн нь тэдгээрийн тус тусын үнэ цэнүүдийн нийлбэрээс илүү байх зөрүү үр дүн.
Худалдах зориулалт бүхий өмч [Улаан ном 2022] – Тухайн бизнесийн арилжаалагдах боломжийг өмчийн үнэ цэн нь илэрхийлж байдаг тусгай бизнест зориулагдсан үл хөдлөх өмчийн аливаа төрөл.
Эрсдэлийн шагнал [СТОУС 13]– Зах зээлд оролцогчид хөрөнгө, өр төлбөрийн мөнгөн гүйлгээний тодорхой байдлаас шалтгаалан үүсэх эрсдэлийг хүлээсний эцэст хүртэх ашиг. Үүнийг мөн "эрсдэлийн залруулга" хэмээн нэрлэдэг.
Тооцооны нэгж [СТОУС 13 ] – Хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхийн тулд уг хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэх буюу задлан жижигрүүлэх СТОУС-ын хэмжүүр.
Үл ажиглагдах орц мэдээлэл [СТОУС 13] – Хөрөнгө, өр төлбөрийн үнийг тогтоохдоо зах зээлд оролцогчдын гаргасан таамаглалын талаарх боломжит хамгийн сайн мэдээллийг ашиглан боловсруулсан буюу зах зээлд бэлэн байдаггүй орц мэдээлэл.
Үнэлгээний өдөр [Улаан ном 2022]– Үнэлгээчний үнэлгээний дүгнэлт гаргасан өдөр.
Үнэлгээний тайлангийн өдөр [Улаан ном 2022] – Үнэлгээний тайланд гарын үсэг зурсан өдөр.

**Бодит болон зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолт**

*СТОУС 13 Бодит Үнэ Цэнийн Хэмжилт*-д *Бодит үнэ цэн* гэдэгт хэмжилт хийж буй өдөр зах зээлд оролцогчдын хооронд байнга хийгдэх ажил гүйлгээгээр хөрөнгийг худалдсанаар хүлээн авах буюу өр төлбөрөөр тооцох үнэ гэж тодорхойлсон. Энэхүү тодорхойлолт нь ҮОУС-д *Бодит үнэ цэн*-ийг тодорхойлсноос ялгаатай бөгөөд тэрхүү тодорхойлолтыг санхүүгийн тайлагналаас бусад зорилгоор нийтлэг хэрэглэдэг.
СТОУС-д тодорхойлсон *бодит үнэ цэн* нь ҮОУС-д тодорхойлсон *зах зээлийн үнэ цэн*-ийн ойлголттой ерөнхийдөө нийцдэг. Иймд тооцооны нэгжийн тайлбар, эсвэл борлуулалтын хориг гэх мэт нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад багтсан тусгайлсан таамаглалуудыг харгалзан авч үзсэн тохиолдолд ихэнх практик ажилд ҮОУС-ийн *зах зээлийн үнэ цэн* нь СТОУС 13-д тодорхойлсон *бодит үнэ цэн*-ийн шаардлагыг хангана гэж үздэг.
*Зах зээлийн үнэ цэн* гэдэгт хариуцлагатай, мэдээлэл тооцоотой, ямар нэг шахалтгүйгээр хандсан, арилжаанд бэлэн байгаа худалдагч, худалдан авагчийн хооронд зохих маркетинг хийсний дараах холбоогүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө болон өр төлбөрийг солилцож болох, тухайн үнэлгээний өдрөөр тооцоолсон дүнг ойлгоно.
*Зах зээлийн үнэ цэн* нь хөрөнгийн хамгийн сайн ашиглалтыг тусгасан байна. Хамгийн сайн ашиглалт гэдэг нь тухайн хөрөнгийн хүчин чадал ашиглалтыг дээд хэмжээнд байлгах биет байдлаараа боломжтой, хууль ёсоор зөвшөөрөгдсөн, санхүүгийн хувьд биелэгдэх ашиглалтыг хэлнэ. Хөрөнгийн одоогийн ашиглалт эсвэл өөр хувилбарт ашиглалтын аль нь ч хамгийн сайн ашиглалт байж болно. Энэ нь зах зээлийн оролцогч хөрөнгийн үнийг тооцоолохдоо өөртөө төсөөлж байгаа тэр ашиглалтаар тодорхойлогдоно.

**Үнэлгээний арга зүй**

Үнэлгээнд хэрэглэдэг үндсэн гурван хандлагын тодорхойлолт, тайлбарыг доор үзүүлэв. Эдгээр хандлагууд нь үнийн тэнцвэр, үр ашгийн хүлээлт, орлуулалт зэрэг эдийн засгийн зарчмуудад тулгуурладаг. Үнэлгээний үндсэн хандлагууд:

(а) Зах зээлийн хандлага,
(б) Орлогын хандлага,
(в) Өртгийн хандлага.

Үнэлгээний эдгээр үндсэн хандлага бүр нь хэрэглээний өөр өөр нарийвчилсан аргуудтай байдаг.
ҮОУС 2020-ын 105 Үнэлгээний хандлага болон аргууд бүлэгт зааснаар хөрөнгийн хувьд үнэлгээний хандлага болон аргуудыг сонгох зорилго нь тухайн нөхцөл байдалд хамгийн тохиромжтой аргыг олох явдал байдаг.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 ☎ 1118267208

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ҮЦК LLC
УЛААНБААТАР ХОТ

Боломжит нөхцөл байдал бүрд тохирох нэг арга гэж байдаггүй. Сонголтын процесст наад зах нь дараах хүчин зүйлсийг харгалзан авч үзвэл зохино:

(а) үнэлгээний гэрээт ажлын нөхцөлүүд болон зорилгоор тодорхойлогдох үнэ цэнийн тохиромжтой суурь (сууриуд) ба үнэ цэнийн урьдчилсан нөхцөл (нөхцөлүүд),
(б) үнэлгээний боломжит хандлагууд ба аргуудын тус тусын давуу ба сул талууд,
(в) хөрөнгийн шинж чанарыг харгалзан үзсэнээр тогтоосон арга тус бүрийн тохиромжтой байдал ба хамаарах зах зээлд оролцогчдын ашиглах хандлагууд буюу аргууд, ба
(г) тухайн аргыг (аргуудыг) хэрэглэхэд шаардлагатай найдвартай мэдээллийн бэлэн, олдоцтой байдал.

Хөрөнгийн үнэлгээний хувьд, ялангуяа үнэлгээчин нь тухайн үнэлгээний гэрээт ажлын бодит байдал ба нөхцөл байдлуудыг харгалзан үзсэнээр нэг аргыг үнэн зөв бөгөөд найдвартай гэдэгт өндөр түвшний итгэлтэй байгаа тохиолдолд нэгээс олон арга ашиглахыг үнэлгээчнээс шаарддаггүй. Гэвч ялангуяа нэг аргын хувьд бодит баримтын буюу ажиглалтын хангалттай орцууд байхгүй тохиолдолд үнэлгээчин нь найдвартай дүгнэлт гаргахын тулд олон хандлагууд ба аргуудын хэрэглээг, мөн түүнчлэн үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахдаа харгалзан үзвэл зохистой ба ашиглаж болох нэгээс олон хандлага буюу аргыг авч үзвэл зохино. Нэгээс олон хандлага ба аргыг эсвэл нэг хандлагын хүрээн дэх олон аргуудыг ашигласан тохиолдолд тэдгээр олон хандлагууд ба/буюу аргуудад үндэслэсэн үнэ цэнийн дүгнэлт нь үл үндэслэлтэй байвал зохистой бөгөөд үнэлгээчин нь тэдгээр өөр өөр үнэ цэнүүдийг дундажлахгүйгээр, харин шинжилж, тохируулах замаар нэг дүгнэлтэд хүргэсэн үйл явцаа үнэлгээний тайланд тусган илэрхийлбэл зохино.

Өөр өөр хандлагууд ба/буюу аргууд нь үнэ цэнийн ихээхэн ялгаатай үзүүлэлтүүдийг гаргах тохиолдолд үнэ цэнийн хоёр буюу хэд хэдэн ялгаатай үзүүлэлтүүдийг хялбархнаар дундажлан жинлэх нь ерөнхийдөө тохиромжтой биш тул үнэлгээчин нь яагаад уг үнэ цэнийн үзүүлэлтүүд өөр өөр байгааг ойлгохын тулд горимуудыг гүйцэтгэвэл зохино. Ийм тохиолдолд тэдгээр хандлагууд/аргуудын нэг нь үнэ цэнийн илүү сайн буюу найдвартай үзүүлэлтээр хангах эсэхийг тодорхойлохын тулд үнэлгээчин нь дээр дурдсан удирдамжийг дахин харгалзан үзвэл зохино.

Үнэлгээчин нь гурван хандлагуудын хувьд холбогдох зах зээлийн ажиглалтын мэдээллийн хэрэглээг хамгийн их байлгавал зохино. Үнэлгээнд ашигласан орцууд болон төсөөллүүдийн эх сурвалжаас үл хамааран үнэлгээчин нь тэдгээр орцууд ба төсөөллүүдийг, түүнчлэн үнэлгээний зорилгод тэдгээрийн тохиромжтой байдлыг үнэлэхийн тулд зохих шинжилгээг гүйцэтгэх ёстой.

**Зах зээлийн хандлага**

*Зах зээлийн хандлага* нь тухайн хөрөнгийг үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа ижил буюу жишиж болох хөрөнгүүдтэй харьцуулсанаар үнэ цэнийн үзүүлэлтийг тодорхойлдог.

Дараах нөхцөл байдалд зах зээлийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино:

(а) Тухайн үнэ цэнийн суурийн дагуу харгалзан үзэхэд тохиромжтой тийм ажил гүйлгээгээр уг үнэлж буй хөрөнгийг саяхан борлуулсан байх,
(б) Үнэлж буй хөрөнгийг эсвэл түүнтэй ихээхэн ижил төсөөтэй хөрөнгийг нийтэд идэвхтэй арилжаалдаг байх,
(в) Ихээхэн ижил төстэй хөрөнгийн хувьд байнга эсвэл сүүлийн үед гарсан ажиглаж болох ажил гүйлгээнүүд байх.

Зах зээлийн хандлагыг ашиглах эсвэл жигнэхдээ илүү ач холбогдол өгөх хэрэгтэй тохиолдлыг дээр дурдсан. Зах зээлийн хандлагыг ашиглах, жигнэхдээ илүү ач холбогдол өгч болох нэмэлт тохиолдлуудыг доор дурдав. Доор дурдсан тохиолдолд зах зээлийн хандлагыг ашиглаж байгаа тохиолдолд үнэлгээчин нь зах зээлийн хандлагыг ашиглан тодорхойлсон үнэ цэнийг бататгах зорилгоор өөр хандлагыг ашиглан үнэлэх, мөн жигнэж болох эсэхийг бодолцох хэрэгтэй. Үүнд:

(а) Зах зээл дэх хэлбэлзэл болон идэвхийн түвшинийг харгалзан үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь ойрын хугацаанд арилжаанд ороогүй бол
(б) Үнэлгээний хөрөнгө эсвэл ижил төстэй хөрөнгө нь олон нийтэд нээлттэй борлогддог, гэхдээ идэвхитэй биш бол
(в) Зах зээлийн мэдээллийн олдоцтой, гэвч харьцуулж буй хөрөнгө нь үнэлгээний хөрөнгөөс мэдэгдэхүйц ялгаатай, их хэмжээгээр тохируулга хийх шаардлагатай бол
(г) Ойрын хугацааны арилжааны мэдээлэл нь найдвартай биш бол
(д) Хөрөнгийн үнэ цэнийг тодорхойлох чухал бүрэлдэхүүн хэсэг нь түүний нөхөн сэргээх өртөг эсвэл орлого бүрдүүлэх чадвар бус зах зээл дээр хүрч болох үнэ бол

*Жиших ажил гүйлгээний арга*

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 07
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 он 08 сар 11 өдөр
БҮРТГЭВ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

Зэрэгцүүлэх ажил гүйлгээний арга гэж бас нэрлэгдэх жишиг ажил гүйлгээний арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй хөрөнгөтэй холбоотойгоор гарсан ажил гүйлгээнүүдийн талаарх мэдээллийг ашигладаг.

*Нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн арга*

Нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн арга нь үнэ цэнийн үзүүлэлтийг гаргахын тулд үнэлж буй хөрөнгөтэй ижил буюу төсөөтэй, нийтэд арилжаалагддаг жишиг зүйлсийн талаарх мэдээллийг ашигладаг.

**Орлогын хандлага**

*Орлогын хандлага* гэдэгт тухайн хөрөнгийн өмчлөлөөс олохоор тооцоолсон эсвэл олсон мөнгөн урсгалд үндэслэн үнэ цэнийг тогтоодог ерөнхий зарчимтай олон аргуудыг багтаан үзэж болно.

Дараах нөхцлүүд биелж байвал орлогын хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

(а) Хөрөнгийн орлого олох чадвар нь оролцогчийн талаас авч үзэхэд хөрөнгийн үнэ цэнд нөлөөлөх маш чухал элемент байх
(б) Үнэлж буй хөрөнгийн хувьд түүний ирээдүйн орлогын дүн ба хугацааны талаар ул үндэслэлтэй прогнозыг хийх боломжтой, харин холбогдох зах зээлийн жишиг хөрөнгө цөөхөн байх

*Хорогдуулсан мөнгөн гүйлгээний арга*

Энэ аргын дагуу, тухайн прогнозчилсон мөнгөн гүйлгээг үнэлгээний өдөр рүү буцаан хорогдуулах бөгөөд үр дүн нь уг хөрөнгийн өнөөгийн үнэ цэн болно.
Хорогдуулсан мөнгөн урсгалын аргаар хөрөнгийн өнөөгийн үнэ цэнийг тогтооход дараах элементүүдийг авч үзэх шаардлагатай. Үүнд:

(а) Түрээсийн ирээдүйн мөнгөн гүйлгээг тооцоолох
(б) Тухайн мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг илэрхийлэх мөнгөн гүйлгээний дүн болон цаг хугацаанд гарч болзошгүй өөрчлөлтийн талаарх дүгнэлт
(в) Хөрөнгө эзэмшигч талд цаг хугацааны хувьд тодорхойгүй байдал үүсдэггүй бөгөөд гэрээ зөрчигдөх эрсдэл тулгарахгүй бол үргэлжлэх хугацаа ба дуусгавар өдөр нь мөнгөн зарлагын гүйлгээний хугацаанд эрсдэлгүй мөнгөн хөрөнгийн хүүгийн хувь хэмжээ (өөрөөр хэлбэл эрсдэлгүй хүүний түвшин)-ээр илэрхийлэгдсэн мөнгөний цаг хугацааны үнэ цэн
(г) Мөнгөн гүйлгээтэй хамааралтай үүсэх тодорхойгүй байдлыг давж гарах үнэ (өөрөөр хэлбэл эрсдлийн шагнал)
(д) Тухайн нөхцөл байдалд зах зээлд оролцогчдын анхаарч үзэх бусад хүчин зүйлс зэрэг орно.

*Орлогын капиталжуулалтын арга*

Урт хугацаанд ашиглах буюу тодорхой бус ашиглалтын хугацаатай хөрөнгийн зарим нөхцөл байдалд хорогдуулсан мөнгөн гүйлгээ нь төсөөлөгдсөн тодорхой хугацааны эцэс дэх уг хөрөнгийн үнэ цэнийг илэрхийлэх терминал үнэ цэнийг багтаасан байж болно. Зарим нөхцөл байдалд төсөөлөгдсөн тодорхой хугацаагүйгээр зөвхөн терминал үнэ цэнийг ашигласнаар хөрөнгийн үнэ цэнийг тооцоолж болдог бөгөөд үүнийг орлогын капиталжуулалтын арга гэдэг.

**Өртгийн хандлага**

Энэ хандлага нь худалдан авагч үнэлэгдэж буй хөрөнгөд төлөх үнэ нь (цаг хугацаа, тохиромжгүй байдал, эрсдэл болон бусад хүчин зүйлийг эс тооцвол) тэнцүү чанартай хөрөнгийг худалдан авах эсвэл барьж байгуулах зардлаас илүүгүй байна гэсэн зарчимд үндэслэнэ.

Дараах нөхцөл байдлуудад өртгийн хандлагыг хэрэглэх ба мэдэгдэхүйц ач холбогдол өгвөл зохино.

(а) Оролцогчид нь зохицуулалтын буюу хуулийн саад хязгаарлалтгүйгээр үнэлж буй хөрөнгөтэй бараг ижил хэрэгцээт чанар бүхий хөрөнгийг дахин бий болгох боломжтой байх бөгөөд үнэлж буй хөрөнгийг нэн даруй ашиглах боломжит байдлын төлөө мэдэгдэхүйц урамшуулал төлөхгүйгээр тухайн хөрөнгийг маш хурдан дахин бий болгох боломжтой байх
(б) Хөрөнгө нь орлогыг шууд бий болгодоггүй бөгөөд тухайн хөрөнгийн өвөрмөц онцлог нь орлогын хандлага эсвэл зах зээлийн хандлагыг ашиглах ямар ч боломжгүй болгодог байх



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -08- 0 7
БҮРТГЭВ-02

СЗХ
2023 .08 11 өдөр
БҮРТГЭВ
№ 1

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

(в) Хэрэглэж буй үнэ цэнийн суурь нь орлуулалтын үнэ цэн гэх мэт орлуулалтын эртэгт үндсэндээ суурилсан байх

**Орц мэдээлэл болон таамаглалууд**
Үнэлгээнд ашигласан үндсэн таамаглалуудыг доор үзүүлэв.

Тооцооны нэгж: Үнэлгээнд хамрагдсан хөрөнгүүдийн шинж чанар болон байрлалд үндэслэн үнэлэгдэж буй хөрөнгө нь бусад хөрөнгүүдтэй нэгтгэгдсэн эсэх нь хөрөнгийн үнэ цэнд нөлөөлөх бодит нөлөөлөл багатай гэж үзлээ. Иймд эдгээр хөрөнгүүдийг нэгтгэгдээгүй буюу бие даасан байдлаар үнэлсэн болно.

Тасралтгүй байдал: Хөрөнгө нь цаашид бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдэнэ гэж үзэв. Цаашлаад ашиглалтанд орсон үл хөдлөх хөрөнгүүдэд зохих урсгал засвар, арчилгаа хийж хэвийн нөхцлөөр ашиглана гэж үзэв.

Тасралтгүй байдал: Хөрөнгө нь цаашид бизнесийн үйл ажиллагаанд хэрэглэгдэнэ гэж үзэв. Цаашлаад ашиглалтанд орсон үл хөдлөх хөрөнгүүдэд зохих урсгал засвар, арчилгаа хийж хэвийн нөхцлөөр ашиглана гэж үзэв.



ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ
5039754 1118267206

RHINOS ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTSK LLC
УЛААНБААТАР ХОТ
9019120763 6481299

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-07
БҮРТГЭВ-02

СЗХ
2023.08.11
БҮРТГЭВ

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

ХАВСРАЛТ 2: ХӨРӨНГИЙН ЗУРАГ

*Pruis-30: 0830 УБО*





Wolkswagon toureg5 2039 УАВ





*Сувд төв дэх оффис*







ЛЭНДМН ББСБ ХК
lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT UTsK LLC
УЛААНБААТАР ХОТ









*Суед төв дэх оффис*









СЭХ 2023.08.11 өдөр БҮРТГЭВ
2023-08-07 БҮРТГЭВ-02



**ХАВСРАЛТ 3: БУСАД ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ ТООЦООЛОЛ**

*Хавсралт 3_Үндсэн хөрөнгийн үнэлгээ.xlsx файлаар хавсаргав.*



ЛЭНДМН ББСБ ХК lendmn УЛААНБААТАР ХОТ 5039754 1118267206
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК RHINOS INVESTMENT UTsK LLC УЛААНБААТАР ХОТ

ХАВСРАЛТ 4: ҮНЭЛГЭЭЧДИЙН СЕРТИФИКАТЫН ХУУЛБАРУУД

Gantulga Donorov

on

31 October 2018

WAS ELECTED A PROFESSIONAL MEMBER OF
THE ROYAL INSTITUTION OF CHARTERED SURVEYORS

6824290
MEMBERSHIP NUMBER

PRESIDENT OF RICS

RICS

СЗХ
2023 08 11
БҮРТГЭВ
№ 31

2023-08-07
БҮРТГЭВ-02

ГЭРЭГЭ ЭСТИМЭЙТ

МОНГОЛ УЛС
ХУГАЦААГҮЙ ЭРХТЭЙ ҮНЭЛГЭЭЧНИЙ

# ГЭРЧИЛГЭЭ

№ 91100154



Ургийн овог: Хошууд

Эцэг(эх)-ийн нэр: Доноров

Нэр: Гантулга

Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан тул Хөрөнгийн үнэлгээчний эрхийг хугацаагүйгээр олгов.

Энэхүү гэрчилгээг эзэмшигч нь зөвхөн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрхтэй бөгөөд хөрөнгийн үнэлгээчинд хамаарах бүрэн эрхийг эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Гэрчилгээ олгосон шийдвэр:
**Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах Зөвлөлийн 20.23 оны ..5 сарын ..12-ний өдрийн ...10. тоот тогтоол**

Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн

Удирдах зөвлөлийн дарга, Тэргүүн /Г БАЯНМӨНХ/

Гүйцэтгэх Захирал /Б ЭНХБОЛД/

Улаанбаатар хот



lendmn
УЛААНБААТАР ХОТ

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK LLC
УЛААНБААТАР ХОТ

МОНГОЛ УЛС
## ХУГАЦААГҮЙ ЭРХТЭЙ ҮНЭЛГЭЭЧНИЙ
# ГЭРЧИЛГЭЭ

№ 101200168



Ургийн овог: Хошууд

Эцэг(эх)-ийн нэр: Доноров

Нэр: Ганбаатар

Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасан бүх шаардлагыг хангасан тул Хөрөнгийн үнэлгээчний эрхийг хугацаагүйгээр олгов.

Энэхүү гэрчилгээг эзэмшигч нь зөвхөн үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ хийх эрхтэй бөгөөд хөрөнгийн үнэлгээчинд хамаарах бүрэн эрхийг эдэлж, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Гэрчилгээ олгосон шийдвэр:
**Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Удирдах Зөвлөлийн 20 23 оны 5 сарын 12-ний өдрийн 10 тоот тогтоол**

Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн

Удирдах зөвлөлийн дарга, Тэргүүн /Г.БАЯНМӨНХ/

Гүйцэтгэх Захирал /Б.ЭНХБОЛД/

Улаанбаатар хот

MDSKhanLex

Утас:
Факс:
Олон улс:
2023.08.10 Д-23/177

**"ЛЭНДМН ББСБ" ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ, ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ ТАНАА**

ХУУЛЬ ЗҮЙН НЭМЭЛТ ДҮГНЭЛТ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Энэхүү дүгнэлт нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д заасны дагуу "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ээс 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн Д-23/169 тоот албан бичгээр хүргүүлсэн "ЛэндМН ББСБ ХК-иас өрийн хэрэгсэл гарган нийтэд санал болгохтой холбогдуулан бэлтгэсэн хууль зүйн дүгнэлт" (цаашид "**Хууль зүйн дүгнэлт**" гэх)-ийн салшгүй хэсэг болно.

Санхүүгийн Зохицуулах Хорооноос "ЛэндМН ББСБ" ХК-д холбогдуулан 2023 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 5/2838 тоот "Хариу хүргүүлэх тухай" албан бичиг (Хавсралт 1.1)-ээр "ЛэндМН ББСБ" ХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 дугаар тогтоолоор нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 95,000 ширхэг хүртэл өрийн хэрэгслийг гаргахаар шийдвэрлэсэн ба тус шийдвэрт өрийн хэрэгслийн нөхцөлийг нарийвчлан тогтоох эрхийг гүйцэтгэх захиралд олгоогүй боловч гүйцэтгэх захирлын 2023 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн А-2023/28 дугаар тушаалаар өрийн хэрэгслийн нөхцөлийг нарийвчлан тогтоож, нийт 90,000 ширхэг өрийн хэрэгсэл гаргахаар шийдвэрлэсэн нь ТУЗ-ийн бүрэн эрхийг зөрчсөн гэж үзжээ. Үүний дагуу "ЛэндМН ББСБ" ХК нь үнэт цаас гаргах тухай шийдвэрийг өөрчлөн баталсан тул "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН нь тус шийдвэртэй холбогдуулан энэхүү нэмэлт дүгнэлтийг гаргаж байна.

Энэхүү нэмэлт дүгнэлтэд ашигласан нэр томьёо нь Хууль зүйн дүгнэлтэд тодорхойлсонтой ижил болно.

***Нэг. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулсан шийдвэр нь холбогдох хууль, журамд нийцсэн эсэх талаар***

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хурлын "Нийтэд санал болгон гаргах буй үнэт цаасны нөхцөлийг баталгаажуулах тухай" 23/22 тоот тогтоол (Хавсралт 1.3)-оор Компанийн нийтэд санал болгон гаргах үнэт цаасны тоо ширхэг, нийт үнийн дүн өөрчилж, үнэт цаасны нөхцөлийг шинэчлэн тогтоосон байна. Тухайлбал:

1. **Компанийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 90,000 (ерэн мянга) ширхэг, нийт 9,000,000,000.00 (есөн тэрбум) төгрөгийн үнийн дүн бүхий Компанийн өрийн хэрэгсэл (цаашид "Лэнд Бонд")-ийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгон арилжаалахаар шийдвэрлэжээ.**

ЛЭНДМН ББСБ ХК
УЛААНБААТАР ХОТ



РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК

2. Компанийн ТУЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 23/20 тоот тогтоолын хавсралтыг хүчингүй болгохоор шийдвэрлэж, үнэт цаасны нөхцөлийг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар шинэчлэн тогтоож Өөрчлөлт орсон нөхцөлийг тодорхойлбол:

| | |
|---|---|
| Тоо ширхэг | 90,000 (ерэн мянга) ширхэг |
| Олон нийтэд санал болгох нийт дүн | 9,000,000,000 (есөн тэрбум) төгрөг |
| Хүү (жилийн буюу 365 хоног) | 18.0% (арван найман хувь) |

байх ба үнэт цаасны бусад нөхцөл хэвээр байна.

Мөн Компанийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн А-2023/30 тоот шийдвэр хүчингүй болгох тухай тушаал (Хавсралт 1-2)-аар Лэнд Бондын тоо ширхэг, нийт үнийн дүн, хүүгийн хувь хэмжээг тогтоосон 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-2023/28 тоот тушаалыг хүчингүй болгосон нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна.

"ЛэндМН ББСБ" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн хурлын "Нийтэд санал болгон гаргах буй үнэт цаасны нөхцөлийг баталгаажуулах тухай" 23/22 тоот тогтоол Компанийн тухай хуулийн 4.3 дахь хэсэг, 41.2, 41.3 дахь хэсэг, 42.1 дэх хэсэг, 55.8 дахь хэсэг, 76.1.5, 76.1.18 дахь заалт, 80.7 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5.1.2 дахь заалт, 6.1 дэх хэсэг, 16 дугаар зүйл, Компанийн дүрмийн 9.6.2 дахь заалтад тус тус нийцсэн байна.

***Хоёр. Үнэт цаасны нөхцөлд өөрчлөлт оруулах шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Үнэт цаасны танилцуулгад өөрчлөлт оруулсан нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны эрх ашигт нийцсэн эсэх, өөрчлөлтийг оруулсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв эсэх талаар.***

Компанийн ТУЗ-ийн 2023 оны 7 дугаар сарын 24-ний өдрийн 23/22 тоот тогтоолын дагуу Бондын танилцуулгад бондын тоо ширхэг, нийт үнийн дүн, хүүгийн хэмжээнд өөрчлөлт оруулж, гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-2023/28 тоот тушаалын талаарх мэдээллийг хассан байна. Энэхүү өөрчлөлт нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчийн хууль ёсны эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй бөгөөд өөрчлөлт оруулсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв болно.

Жич: "Өмгөөллийн Эм Ди Эс энд Хаанлекс" ХХН-ийн 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн Хууль зүйн дүгнэлт дэх "ЛэндМН ББСБ" ХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн А-2023/28 тоот тушаалд холбогдох хэсгийн дүгнэлтийг хүчингүй болгож байна.

НӨХӨРЛӨЛИЙН ГИШҮҮН, ХУУЛЬЧ     Д.ДҮГЭРЖАВ